



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мэндбаярын МАНДХАЙ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-33, Факс: 32-70-16
E-mail: mandkhai@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.19 № 41X-03/7531
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.МАНДХАЙ

Б.БЕЙСЕН

Ж.ЧИНБҮРЭН


Р.СЭДДОРЖ

С.ЛҮНДЭГ

Р.БАТБОЛД

А.УНДРАА

000151

 М.НАРАНТУЯА-НАРА
 П.САЙНЗОРИГ
 Ж.АЛДАРЖАВХЛАН
Д.ҮҮРИЙНТУЯА
Р.СЭДДОРЖ
Г.ГАНБААТАР
У.ОТГОНБАЯР
П.БАТЧИМЭГ
Л.ЭНХНАСАН
 М.ГАНХҮЛЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мэндбаярын МАНДХАЙ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-33, Факс: 32-70-16
E-mail: mandkhai@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.06.16 № чух-03/7403
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу Хүнсний тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хүнсний тухай хуулийн төсөл, үзэл баримтлалтай холбоотой дараах хуулийн төсөл, холбогдох тайлан, судалгаануудыг хавсаргав. Үүнд:

1. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
2. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл;
3. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн товч танилцуулга;
4. Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгэний тайлан;
5. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан;
6. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоолол;
7. Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой дагалдах хуулийн төсөл.

Хавсралт ¹³⁶ хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



М.МАНДХАЙ

000146

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



М.МАНДХАЙ

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Хүн бүр эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол хүнсээр хангагдах эрхтэй. Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” (1948), “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пактад (1966): “Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй”, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрхтэй” гэж тус тус заажээ.

Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн дээр дурдсан эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийнхээ хүрээнд хүнсний аюулгүй байдлын бодлого, түүнийг хангах арга замыг тодорхойлж, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудыг тус тус баталж, эрх зүйн орчны шинэчлэл хийсэн. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ” хэмээн хүнсний аюулгүй байдлыг хангах стратегийг тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д “Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана” гэж заасан ба 2021-2030 онд хүрэх үр дүнг “4.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ” гэж, 2021-2040 онд хүрэх үр дүнг “3.баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгонэрүүл хүнсний хэрэглээтэй болно” гэж тус тус тодорхойлжээ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3-т “Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр” тусгасан.

Дээр дурдсан хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгох, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан

сайжруулах, баталгаатай, эрүүл ахуйн шаардлага хангасан, тэжээллэг эрүүл хүнсний хэрэглээтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

1.2.Практик шаардлага

Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хүнсний хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэл, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, хүнсний баталгаат байдалд тавих хяналт, тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай нь тогтоогдсон.

Иймд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах асуудлыг тусгах шаардлагатай байна. Үүнд:

1.Олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн “хүн бүр . . . зохистой хоол хүнсээр хангагдах эрх”, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрх”-ийн хангах агуулгын хүрээнд “Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол, хүнсээ сонгон хэрэглэх эрх”, түүнтэй холбоотой зохицуулалтыг тодорхой тусгана.

2.“Food security” болон “food safety” гэсэн англи нэр томъёог монгол хэлэнд аль алиныг нь “хүнсний аюулгүй байдал” хэмээн буруу хэрэглэснээс төөрөгдөл үүсэж, хууль хэрэглээнд хүндрэл учруулж байна. Иймд хуульд хэрэглэсэн зарим нэр томъёоны хэл зүй, найруулга, үг сонголтыг оновчтой болгох зорилгоор “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны зааг ялгааг тодорхой болгох, зарим нэр томъёог өөрчилж, зарим нэр томъёог шинээр нэмж тайлбарлана, үүнтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

3.Дэлхийн улс орнууд, нийгмийн бүх салбарууд “Нэг дэлхий, нэг эрүүл мэнд” үзэл санаан дор нэгдэж, байгаль орчин, нийгмийн эрүүл мэндэд учирч байгаа аюулыг багасгахын төлөө хамтын хүчин чармайлт гаргаж байна. Энэхүү олон улсын чиг хандлагад нийцүүлэн “хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлын харилцан шүтэлцээг хангах” зарчим, үүнтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

4.Хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа урт удаан хугацаанд хангагдаагүйгээс үүдэн хүн амын дунд халдварт бус өвчлөл буурахгүй, цаашлаад Монгол Улс элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд дээгүүрт орж байна. 2017, 2023 онд хийсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний 5, 6 дугаар судалгааны дүнг харьцуулахад хүн амын дундах хоол тэжээлийн дутал буураагүй байгаа нь зохистой хооллох мэдлэг, дадал дутмаг, хоол, хүнсний хяналтгүй хэрэглээтэй холбоотой. Мөн шим тэжээлгүй хоол хүнсийг хэрэглэснээс хүн ам давхар дарамтад өртөж, тэдний амьдралын чанарт нь сөргөөр нөлөөлж байгааг үндэсний судалгааны дүн харуулж байна. Эндээс үзэхэд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд улсын хэмжээнд хэрэгжүүлсэн хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүнтэй болж чадаагүй байна.

Иймд дээр дурдсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалыг эш үндэс болгон төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэл, зарчим, түүний хэрэгжилтийг хангах тогтолцоог гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоотой уялдуулан тусгана.

5.Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр салбарын хүний нөөц дутагдалтай, одоо байгаа хүний нөөцийн мэдлэг, ур чадвар хангалтгүй байгаа нь тогтоогдсон. Иймд хүнсний салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, мэргэжилтэн бэлтгэх, давтах сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, тогтвор суурьшилтай ажиллуулахтай холбогдсон харилцааг тусгана.

6.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох энгийн зөвшөөрөл олгохдоо тусгай зөвшөөрлийн нэгэн адил сонгон шалгаруулалт явуулж, гомдол гаргах хугацааг ажлын 2 өдрөөр тогтоосон нь бизнес эрхлэгчдийн эрхийг хязгаарласан төдийгүй төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалаа урвуулан ашиглах, авлигад өртөх эрсдэлийг бий болгохоор байна. Иймд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлэн өөрчилнө.

7.Хүнсний сүлжээнд хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг хамааруулан хуульчилсан боловч тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон харилцаа зохицуулалтгүй үлджээ. Иймд зохицуулагдаагүй харилцааг нэмж зохицуулна.

8.Монгол Улсын хэмжээнд хүнсний хангамж, бодит хэрэглээ ба хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгаа, хүнсний чанар, хүнсний баталгаат байдал, шим тэжээлийн тоон үзүүлэлт хангалтгүй байна. Иймд хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд дээр дурдсан асуудлаар тандалт судалгаа хийж, үр дүнг төрийн бодлогод тусгах зорилгоор эрдэм шинжилгээний байгууллага, түүний чиг үүргийг тусгана.

9.Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд хамгийн үнэтэй, хамгийн чанаргүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байгаа нь хүнсний хангамжийн нэг хэсэг болсон хүүхдийн хүнсний хангамж, ханган нийлүүлэлтийн асуудал нь хүнсний болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дунд зохицуулалтгүй орхигдсонтой холбоотой. Иймд цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн асуудлыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцахаар төсөлд тусгана. Мөн хүнсний хангамжийг тодорхойлохдоо эн тэргүүнд цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн асуудлыг тусгах, түүнийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга баталж, хэрэгжүүлж, үр дүнг нь тооцож байхаар тусгана.

10.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлснээ баталгаажуулах эсэхээ өөрөө сонгохоор хуульд заасан, холбогдох төрийн байгууллагууд баталгаажуулалтын талаар нөлөөллийн ажлыг дорвитой хийгээгүй, баталгаажуулалтын байгууллага хоёрхон байсантай холбоотой баталгаажуулалт илт хангалтгүй байгаа нь тогтоогдсон². Иймд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг дээшлүүлж, хүнсний баталгаат байдлыг хангах зорилгоор зөвхөн стандартын урьтал нөхцөл болсон зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулахыг үүрэг болгоно.

² Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.2025 он

11.Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх зарчмын хэрэгжилт хангалтгүй, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох тогтолцоо бүрдээгүй, зах зээл дээрх хуурамч хүнсний бүтээгдэхүүн болон зөрчлийн талаарх мэдээлэл хэрэглэгчдэд ил тод биш байгаа нь тогтоогдсон. Энэ нь хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан байхгүй байгаатай холбоотой юм. Иймд “иргэдийн мэдэх эрх” болон “хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх” зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор салбарын мэдээллийн нэгдсэн сан бий болгохтой холбогдсон зохицуулалтыг нэмж тусгана.

1.3.Зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгана:

- “хүнсний сүлжээ” гэсэн нэр томъёог өөрчлөн найруулах, “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, “худалдаа” гэсэн нэр томъёог нэмж тайлбарлах;

- “хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэртэй байдлын харилцан шүтэлцээг хангах”, “хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа шинжлэх ухаанд үндэслэсэн байх” зарчим, холбогдох зохицуулалт;

- хүнсний аюулгүй байдлыг хангах цогц бодлогын чиглэл, уг бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоо, гүйцэтгэлийн удирдлага, тэдгээртэй холбогдох зохицуулалт;

- салбарын хүний нөөцийн удирдлага, мэргэшүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, журмаар зохицуулах харилцааны хүрээ;

- хүнсний сүлжээн дэх зохицуулагдаагүй тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны зохицуулалт;

- хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо, цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлсэн, үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг нийлүүлсэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх;

- стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох зохицуулалт;

- тандалт судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, түүний чиг үүрэг;

- зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо, түүнтэй холбогдох ялгамжтай зохицуулалт;

- мэдээллийн нэгдсэн сан, түүнтэй холбогдох зохицуулалт;

- зохистой, тэнцвэртэй хооллолтын сургалт сурталчилгаа.

Хууль батлагдсаны дараа үүсэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1.Хүнсний аюулгүй байдлын бодлого шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлогдож, түүний хэрэгжилтийг дэмжих тогтолцоо бүрдсэнээр хууль үр дүнтэй зохистой хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

2.Хүнсний бүх сүлжээний үе шат бүрд хамаарах үйл ажиллагаа иж бүрэн зохицуулагдаж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид өөрийн үйл ажиллагаанд хамаарах стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлснээр хүнсний баталгаат байдал хангагдах нөхцөл бүрдэн хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

3.Хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой болсноор хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшиж, өөрийн эрүүл мэндээ хамгаалах боломж бүрдэнэ. Ингэснээр халдварт бус, түүнчлэн хоол, хүнснээс шалтгаалсан халдварт өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна.

4.Хүнсний аюулгүй байдлын бодлогын чиглэл бүрээр зорилт, арга хэмжээний бодитой төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт сайжирч, хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаат байдал сайжирна.

5.Хүнсний салбарын хүний нөөцийг чадавхжуулж, мэргэшүүлснээр хүнсний сүлжээ дэх үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэх нөхцөл бүрдэж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.

6.Хүнсний хангамж, хүртээмж сайжируулснаар хүн бүр шим тэжээллэг, баталгаатай хүнс сонгох хэрэглэх боломж нэмэгдэнэ.

Хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.

1.Хүнсний тухай хуульд “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны зааг ялгааг тодорхой болгосонтой холбоотой Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, уг хуулийн зүйл, заалт дахь томъёоллын “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан. Гэвч Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.12 дахь хэсэгт хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана гэж, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болохоор заасан. Харин хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахдаа хуулийн нэрийг өөрчлөх талаар тодорхой зохицуулалт байхгүй.

Иймд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Засгийн газрын санал, дүгнэлтийн хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуулийн нэрийг өөрчлөх, уг хуулийн зүйл, заалт дахь томъёоллын “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн бичвэрийг өөрчлөхөөр тусгав.

2.Хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулж, хуулийн 6.16 дугаар зүйлийн гарчиг “Органик хүнсний тухай хууль зөрчих” гэснийг “Органик бүтээгдэхүүний тухай хууль тогтоомж зөрчих” гэж, 6.15 дугаар зүйлийн гарчиг “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих” гэснийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай хууль зөрчих” гэж, тус тус өөрчлөхөөр тусгав.

Баяжуулсан хүнсний тухай хууль батлагдсанаар Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль хүчингүй болсон боловч Зөрчлийн тухай хуулийн “Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай хууль зөрчих” гэсэн гарчиг бүхий 6.13 дугаар зүйл хүчин төгөлдөр хэвээр байх тул уг заалтыг хүчингүй болгохоор тусгав.

3.Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 зүйлд заасан “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн нэрийг “Хүнсний баталгаат байдлыг хангах тухай” гэж өрчлөлт оруулахаар холбогдох хуулийн төслийг боловсруулав.

4.Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөлд нэр томъёог өөрчилсөнтэй холбоотойгоор салбарын хууль тогтоомж дахь “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “хүнсний баталгаат байдал” гэж, “тэжээлийн аюулгүй байдал” гэснийг “тэжээлийн баталгаат байдал” гэж өөрчлөхөөр шаардлага бий болсон. Иймд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик бүтээгдэхүүний тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай /шинэчилсэн найруулга/ хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

Дээр дурдсан холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

-оОо-



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН М.МАНДХАЙ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.06.06 № НХ/1636
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Танаас санаачлан боловсруулсан Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.УЧРАЛ

100255009846

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“10.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгаас санаачлан боловсруулсан Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгаас санаачлан боловсруулсан Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах үндэслэлээр дэмжих боломжгүй саналыг төсөл санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хүнсний тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолтод “хүнсний баталгаат байдал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасныг” гэсэн 3.1.14 дэх заалт нэмэхээр тусгасан нь Хүнсний тухай хуулийн 3.1.2, 3.1.3, 3.1.4-т заасантай, мөн “хүнсний эрүүл ахуй”, “хүнсний сүлжээ” гэсэн нэр томъёог өөрчлөн найруулж байгаа нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6 дахь заалттай, мөн хуулийн төсөлд тусгасан хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий “Эрдэм шинжилгээний байгууллага”-ын чиг үүрэг нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан “Үндэсний лавлагаа лаборатори”-ийн чиг үүрэгтэй, мөн хуулийн төсөлд тусгасан “төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогын чиглэл” нь Хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “хүнсний аюулгүй байдлыг хангах зарчим”-тай агуулгын хувьд тус тус давхцаж байна.

Өөрөөр хэлбэл, эдгээр зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.5, 29.1.7-д заасан шаардлагад нийцэхгүй байна.


2.Хуулийн төслийн 13^{1.1}-д “хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” байхаар заасан байна. Хүнсний сүлжээнд чанар, аюулгүй байдлыг хянах одоогийн тогтолцоог сайжруулахад шинээр байгууллага байгуулах замаар шийдвэрлэх нь оновчтой эсэх талаар дахин судалж, үндэслэл, үр дүн, үр нөлөөг тооцох шаардлагатай байна.

Мөн Улсын Их Хурлын 2024 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 13 дугаар тогтоолын Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид “Хүнсний баталгаат байдалд хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” байхаар, Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө, 2025 оны Төсвийн тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн баримт бичигт тус тус тусгагдаагүй тул энэ бүтцийг шинээр бий болгох асуудлыг дэмжих боломжгүй байна.

Түүнчлэн, Хүнс, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулалт, тохирлын үнэлгээ хийх, хяналт тавихтай холбогдсон харилцааг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулж байх тул төсөлд тусгасан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт”-тай холбоотой зохицуулалтыг дээр дурдсан хуулиудын зохицуулалттай давхардуулахгүйгээр уялдуулж боловсруулах нь зүйтэй;

3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “6.12.Гадаадын тусламжаар авах хүнс нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан байна.” гэсэн нь Хүнсний тухай хуулийн 6.12 дахь хэсэгт “Засгийн газар Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 3.1.9-д зааснаас бусад зориулалтын бүтээгдэхүүнийг хандив, тусламжаар авахыг хориглоно.” гэж заасантай зөрчилдөж байна.

4.Хүнсний тухай хуулийн нэр томъёо, зохицуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.3 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулж, холбогдох тооцоо, судалгаа хийсэн байна.” гэж заасны дагуу Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.15, 3.1.16 дахь заалт:

3.1.15. “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж технологийн зөв урсгалаар зохион байгуулагдсан зориулалтын байранд мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан техник, тоног төхөөрөмж, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан түүхий эд, туслах материал, бэлэн бүтээгдэхүүн ашиглаж, жор, технологийн дагуу хоол бэлтгэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг;

3.1.16. “Эрдэм шинжилгээний байгууллага” гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.15-д заасныг.”

2/3¹ дүгээр зүйл:

“3¹ дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдал

3¹.1. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар хүнсний аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн.

3¹.2. Хүнсний аюулгүй байдал гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, баталгаат хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг ойлгоно.

3¹.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол, хүнс сонгон хэрэглэх эрхтэй”

3/4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6 дахь заалт:

“4.1.5. хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа шинжлэх ухаанд үндэслэсэн байх;

4.1.6. хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлын харилцан шүтэлцээг хангах.”

4/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, 4.4 дэх хэсэг:

“4.2.Төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах цогц бодлогын чиглэлийг баримтална:

4.2.1.хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах;

4.2.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгаат байдлыг хангах;

4.2.3.шим тэжээллэг, чанартай хоол хүнсийг сонгон хэрэглэх боломжийг бүрдүүлэх, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

4.2.4.хүнсний салбарын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх.

4.3.Энэ хуулийн 4.2-т заасан хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг энэ хуулийн 13.1.5, 13.1.6-д заасан тандалт, судалгааны үр дүн, зураглалд үндэслэн тодорхойлно.

4.4.Энэ хуулийн 4.2.4-т заасан бодлогыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага боловсруулж хэрэгжүүлнэ.”

5/4¹ дүгээр зүйл:

“4¹ дүгээр зүйл.Хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоо

4¹.1.Хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоо нь дараах дэд тогтолцоотой байна:

4¹.1.1.удирдлага, зохион байгуулалтын;

4¹.1.2.салбарын эрх зүйн;

4¹.1.3.хүний нөөцийн удирдлагын;

4¹.1.4.эрсдэлийн удирдлагын;

4¹.1.5.хяналтын;

4¹.1.6.мэдээллийн.

4¹.2.Энэ хуулийн 4¹.1.1-д заасан тогтолцоонд захиргааны болон мэргэжлийн удирдлага, зохион байгуулах, зохицуулах үйл ажиллагаа хамаарна.

4¹.3.Энэ хуулийн 4¹.1.2-т заасан тогтолцоонд хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, захиргааны хэм хэмжээний актаас гадна баримт бичгийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг төлөвлөх, төсөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, эргэн мэдээлэх, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, харилцаанд оролцогч талуудын үйл ажиллагааны уялдаа холбоо хамаарна.

4¹.4.Энэ хуулийн 4¹.1.3-т заасан тогтолцоонд хүний нөөцийн эрэлт, хэрэгцээг танадан судлах, сонгон шалгаруулах, нөөц бүрдүүлэх, томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал хамаарна.

4^{1.5}.Энэ хуулийн 4^{1.1.4}-т заасан тогтолцоонд бодлого, хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үйл ажиллагаа хамаарна.

4^{1.6}.Энэ хуулийн 4^{1.1.5}-д заасан тогтолцоонд төрийн, олон нийтийн болон дотоод хяналт хамаарна.

4^{1.7}.Энэ хуулийн 4^{1.1.6}-д заасан тогтолцоонд хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалах үйл ажиллагаа хамаарна.”

4^{1.8}.Төрөөс энэ хуулийн 4^{1.1}-д заасан хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтийг хангах зорилгод чиглэсэн гүйцэтгэлийн удирдлага, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлнэ.

4^{1.9}.Энэ хуулийн 4^{1.1}-д заасан хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангахад чиглэсэн чиг үүрэгт хамаарах асуудлыг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны, нутгийн захиргааны байгууллага, газар, хэлтэс, алба, тэдгээрийн албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгана.

6/4² дугаар зүйл:

4² дугаар зүйл.Салбарын хүний нөөцийн удирдлага

4^{2.1}.Салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн хэмжээнд хэмжээнд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

4^{2.2}.Энэ хуулийн 4^{2.1}-д заасан байгууллага, албан тушаалтан хүний нөөц бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх чиглэлээр боловсролын асуудал эрхэлтсэн төрийн захиргааны төв байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, лаборатори болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

4^{2.3}.Энэ хуулийн 4^{2.2}-т заасан бодлого, арга хэмжээнд нийцүүлэн хүний нөөцийн хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлж болно.

4^{2.4}.Хүнсний салбарын дээд боловсролтой мэргэжилтэнг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох журам, гэрчилгээний загварыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4^{2.5}.Энэ хуулийн 4^{2.4}-т заасан журамд дараах харилцааг тусгана:

4^{2.5.1}.мэргэжилтний зэргийн төрөл, хэлбэр, хугацаа;

4^{2.5.2}.мэргэшүүлэх зэрэг олгох мэргэжлийн чиглэл, үйл ажиллагааны хүрээ, түүнд тавих шаардлага;

4^{2.5.3}.сургалт, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт;

4².5.4.мэргэшсэн, эрдмийн цол, зэрэгтэй, туршлагатай гишүүдээс бүрдсэн Ажлын хэсэг, түүний чиг үүрэг;

4².5.5.мэргэшүүлэх давтан сургалтын багц цаг, давтан сургалтын хөтөлбөр, давтамж;

4².5.6.мэргэшлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

4².7.Энэ хуулийн 4².4-т заасан журамд заасан шаардлага, болзлыг хангасан мэргэжилтэн хүсэлтээ хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4².8.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 4².5-д заасан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

4².9.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүний нөөцийг тогтвортой ажиллуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

7/5 дугаар зүйлийн 5.5-5.8 дахь хэсэг:

“5.5.Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хүнсний хангамж бүрдүүлнэ.

5.6.Хүн бүрийн эдийн засгийн боломж, газар зүйн байршил, нас, биеийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон хүнсийг тогтмол, хангалттай хэмжээнд авах боломжийг бүрдүүлэх замаар хүнсийг хүртээмжтэй байлгана.

5.7.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хүнсний хангамжийг тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх балчир хүүхдийн хоол тэжээл болон цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг тусгана.

5.8.Энэ хуулийн 5.5-т заасан цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.”

8/5² дугаар зүйл:

“5² дугаар зүйл.Хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо

5².1.Хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо нь бэлтгэн нийлүүлсэн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах, сав баглаа боодолд хяналт тавих, хадгалах, захиалгын дагуу хуваарилах, удирдлагын менежмент хийх, тээвэрлэх, түгээх үйл ажиллагаанаас бүрдэнэ.

5².2.Энэ хуулийн 5².1-д заасан тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг төрийн болон хувийн хэвшлийн хуулийн этгээд хэрэгжүүлж болно.

5².3.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тухайн шатны Засаг дарга төрийн болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хоол үйлдвэрлэлийн хүнсний ханган нийлүүлэлтийн нэгдсэн төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцно.

Тайлбар: Энэ хуулийн 5².3-т заасан хоол үйлдвэрлэлд эмнэлэг, сувилал, ясли, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр зэрэг боловсрол, сургалтын байгууллага, цэргийн болон хорих ангийн хоол үйлдвэрлэл хамаарна.”

9/6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг:

“6.1.Улирлын онцлог, үнийн хэлбэлзэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүнсний нөөцийг бүрдүүлнэ.”

8 дугаар зүйлийн 8.1.8 дэх заалт:

“8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлсэн, үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг нийлүүлсэн;”

10/10 дугаар зүйлийн 10.4, 10.5, 10.6 дэх хэсэг:

“10.4.Хүнсний чиглэлийн дараах үйл ажиллагаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө.

10.4.1.хүнсний анхан шатны болон боловсруулах үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, худалдаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалт;

10.4.2.хүнсний сав баглаа, боодол, туслах материалд хамаарах стандарт.

10.5.Хүнсний худалдаанд экспорт, импорт, онлайн болон бусад бүх хэлбэрийн худалдаа, хүнсний хүргэлт, хадгалалт, шошго, хэрэглэгчид мэдээлэл хүргэх үйл ажиллагаа хамаарна.

10.6.Энэ хуулийн 10.1.3-т заасан ажлыг Барилгын тухай хуульд заасны дагуу дагуу хийж гүйцэтгэнэ.”

11/13 дугаар зүйлийн 13.1.5, 13.1.6 дахь заалт:

“13.1.5.хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгаа;

13.1.6.хүнсний баталгаат байдал, шим тэжээл, молекул биологи, хүнсний нэмэлт, баяжуулах, зохицуулах үйлчлэлтэй хүнсний тандалт судалгаа.”

12/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:

13.4.Хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл дэх мал, амьтан, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн хяналтыг Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулна.”

13/13² дүгээр зүйл:

“13² дүгээр зүйл.Эрдэм шинжилгээний байгууллага

13².1.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар эрдэм шинжилгээний байгууллагыг төрийн, хувийн, хамтарсан өмчийн хэлбэрээр байгуулж болно.

13².2.Энэ хуулийн 13².1-д заасан байгууллагад шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, төв, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага хамаарна.

13².3.Эрдэм шинжилгээний байгууллага нь хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13².3.1.Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын судалгаа явуулж, нөхцөл байдлыг үнэлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

13².3.2.хүнсний шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр үйлдвэрлэлийн технологийн туршилт, судалгаа явуулах, мониторинг хийх;

13².3.3.хүн амын эрүүл мэндийг дэмжихэд чиглэгдсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, ноу-хауг судалж, нутагшуулах талаар санал, зөвлөмж боловсруулах;

13².3.5.уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, инновац шингэсэн бүтээгдэхүүнийг бий болгох, хэрэглээнд нэвтрүүлэх;

13².3..6.өндөр хөгжилтэй орны хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн шинэ технологийг нэвтрүүлэх талаар зөвлөмж гаргах;

13².3.7.хүнсний салбарын мэргэжилтэн болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, чадавхжуулахад нь дэмжлэг үзүүлэх;

13².3.8.шим тэжээллэг, баталгаат хүнсийг сонгон хэрэглэх, зохистой хооллох талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;

13².3.9.энэ хуулийн 13.1.1, 13.1.5, 13.1.6-д заасан тандалт судалгааг таван жил тутамд явуулж, үр дүнг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд тайлагнах, холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх;

13².3.10.үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, улсын, нутгийн захиргааны байгууллагын болон иргэн, хуулийн этгээдийн захиалгаар судалгаа хөгжүүлэлтийн бусад ажил гүйцэтгэх;

13².3.11. хуульд заасан бусад.

13².4.Энэ хуулийн 13².1.10-т заасан төсөл, судалгаа хөгжүүлэлтийн ажлын санхүүжилтийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар зохицуулна.”

14/17¹ дүгээр зүйл:

“17¹ дүгээр зүйл.Мэдээллийн нэгдсэн сан

17¹.1.Хүнсний салбарын мэдээллийн санд дараах мэдээллээс бүрдэнэ:

17¹.1.1.салбарын хүний нөөцийн бүртгэл;

17¹.1.2.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн;

17¹.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл;

17¹.1.4.газар тариалан, малын бэлчээр, оторлох газрын бүртгэл;

17¹.1.5.хүн амын болон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах ус хангамжийн бүртгэл;

17¹.1.6.хүнсний техник, тоног төхөөрөмж, технологийн бүртгэл;

17¹.1.7.хүнсний нөөцийн бүртгэл;

17¹.1.8.хүнсний эрэлт, нийлүүлэлтийн статистик;

17¹.1.9.хяналт шалгалтын үйл ажиллагааны тайлан;

17¹.1.10.ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн;

17¹.1.11.импорт, экспортын зөвшөөрлийн;

17¹.1.12.итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын;

17¹.1.13.хүнсний сорилын лабораторийн шинжилгээний дүн

17¹.1.14.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17¹.2.Мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх энэ хуулийн 17¹.1-д заасан мэдээллийн төрөл, гаргуулан авах хэлбэр, хугацаа, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах, боловсруулах, хадгалах, хамгаалах эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.

17¹.3.Энэ хуулийн 17¹.1-д заасан мэдээллийг хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцогч төрийн байгууллага цахим хэлбэрээр солилцож үйл ажиллагаандаа ашиглана.

15/18 дугаар зүйлийн 18.5.6, 18.5.7 дахь заалт:

“18.5.6.Энэ хуулийн 5.5-т заасан бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох чиглэл өгөх;

18.5.7.Энэ хуульд заасан бусад асуудлыг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж гаргах.”

2 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “тодорхойлох” гэсний дараа “, бүрдүүлэх” гэж, 5.2 дахь

хэсгийн “хангамжийг” гэсний дараа “улсын хэмжээнд” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “нөөц” гэсний дараа “бүрдүүлэх” гэж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлсан” гэж гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5¹ дүгээр зүйл:

“5¹ дүгээр зүйл. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох

5¹.1. Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодод үйлдвэрлэсэн хүнсээр нэн тэргүүнд хангах, уг хэрэгцээг хангах боломжгүй тохиолдолд стратегийн хүнсийг импортлоно.

5¹.2. Энэ хуулийн 5¹.1-д заасан хүнсний хэрэгцээнээс илүү гарсан дотоодод үйлдвэрлэсэн стратегийн хүнсийг экспортолж болно.

5¹.3. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 5¹.1, 5¹.2-т заасан экспорт, импортын урьдчилсан тооцоо судалгаанд үндэслэн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулна.

5¹.4. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 5¹.1-д заасан Засгийн газрын гишүүний саналыг дараах цагалбарын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хүргүүлэх ажлыг зохион байгуулна:

5¹.4.1. сүүний тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор;

5¹.4.2. малын махны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор;

5¹.4.3. гурил, тарианы үр, хүнсний улаан буудай, ундны усны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор.

5¹.5. Энэ хуулийн 5¹.3-т заасны дагуу ирүүлсэн Засгийн газрын гишүүний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

5¹.5.1. тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг бүхэлд нь дэмжих, эсхүл хүнсний нэр төрлийг өөрчлөх, тоо хэмжээг бууруулах;

5¹.5.2. тухайн жилд стратегийн хүнсийг экспортлох, импортлох хугацааг хойшлуулах.

5¹.5.3. хүн амын хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээнд хязгаар тогтоохгүй байх;

5¹.5.4. тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй, импортлохгүй байх;

5^{1.6}.Энэ хуулийн 5^{1.3}-т заасан Хүнсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт хэлбэртэй байна.

5^{1.7}.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг үндэслэн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтооно.

5^{1.8}.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.5-д заасны дагуу тогтоосон тоо хэмжээнд багтаан стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна.

5^{1.9}.Зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд дараах баримт бичгийг хавсарган хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ:

5^{1.9.1}.экспортлох, эсхүл импортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг заасан албан бичиг;

5^{1.9.2}.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

5^{1.9.3}.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрийн байртай болохыг нотолсон гэрчилгээ;

5^{1.9.4}.экспортлогч, импортлогч улсын үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай харилцан тохиролцсон байх;

5^{1.9.5}.шаардлагатай тохиолдолд импортлогч орны мал эмнэлэг, хорио цээрийн албаны эрх бүхий байгууллагын итгэмжлэл.

5^{1.10}.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийн хугацаа шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жил байна.

5^{1.11}.Энэ хуулийн 5^{1.9}-д заасны дагуу ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хянан шалгах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох эсэхийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

2/10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт:

“10.1.4.хүнсний сүлжээний өөрт хамаарах үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулсан байх;”

3/17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг:

“17.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4-т заасан зохистой дадлыг нэвтрүүлснээ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулалт хийлгэнэ.

17.2.Энэ хуулийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу баталгаажуулалт хийлгэсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн мэдээллийг тухайн итгэмжлэгдсэн байгууллага нийтэд мэдээлж, мэдээллийн санд оруулна.

17.3.Энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулж болно.

17.4.Энэ хуулийн 17.3-д заасны дагуу баталгаажуулалт хийлгэсэн байгуулагад энэ хуулийн 17.1 дэх заалт хамаарахгүй.”

4 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх “аюулгүй хүнсээр” гэснийг “баталгаат хүнсээр” гэж, эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “ аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 3.1.4 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 3.1.11 дэх “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 3.1.13 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, “4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, 4.1 дэх хэсгийн “заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” ГЭСНИЙГ “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсгийн “харилцааг хуулиар” гэснийг “холбогдох хуулиар” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 10.1.5 дахь заалтын “10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 10.2.1 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 10.2.3 дахь заалтын “түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын” гэснийг “хүнсний баталгаат байдлын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 13 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 13.1 дэх хэсгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шимт байдал, хуурамч хүнсэнд” гэж, 13.1.4 дэх заалтын “тохиолдолд энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж, 13.3 дахь хэсгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 14 дүгээр зүйлийн гарчгийн, 14.1 дэх хэсэг, 14.1.3, 14.1.4 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 15 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр 4.1.1, 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Манай улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (1948), “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пактад (1966): “Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх”, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрх”-ийг онцлон заажээ.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.4.2.1-т “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”²-ын Зорилт 2.5-д “Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана” гэж, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай”³ Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3-т “Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж тус тус заасан нь уг хуулийн төслийг боловсруулах үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурал 2012 онд баталсан Хүнсний тухай (Шинэчилсэн найруулга) хууль⁴-ийг баталж, энэ хуулиар хүнсний хангамж, хүртээмж, хүнсний шим тэжээллэг байдал, хүнсний баталгаатай байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахаар заасан. Гэвч тухайн цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн хүнсний хангамжийн асуудалд түлхүү анхаарч, хүнсний сүлжээний баталгаат байдал, хүн амын хүнсний бодит хэрэглээтэй холбоотой зарим зохицуулалт орхигдуулжээ.

Хүнсний тухай хуулийн зохицуулалтын хувьд хэрэгжилт хангалтгүй⁵ байгааг дараах тоон баримтууд харуулж байна. Үүнд:

1.Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн 54 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, 46 хувь нь импортын хамааралтай байгаа нь хүнсний хангамж тогтвортгүй, эрсдэлтэй түвшинд байна.

2.Хүнсний хүртээмж нь газар зүйн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа бөгөөд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, ургамлын тосыг улсын дунджаас давж, хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, өндөг, цөцгийн тос, сахар чихэрлэг хүнсийг улсын дунджаас давж хэрэглэж байна.

3.Хүнсний хүртээмжтэй байдал нь хүн амын дундах ядуурал, амьжиргааны түвшин, ажилгүйдэл, цалин, орлогын хэмжээ, төрийн хөнгөлөлт, дэмжлэгээс шууд хамааралтай. Статистикийн мэдээгээр ядуурлын хамралтын түвшин 2016 онд 29.6 хувь, 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувьтай байсан бол 2022 оны байдлаар 27.1 хувь болж буурсан байна. Хэдийгээр ядуурлын түвшин буурсан ч ядууралд ойрхон байгаа хүмүүс аливаа сөрөг хямрал (эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт) үүсэхэд эргээд

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

⁴ 1995 онд Хүнсний тухай хууль баталж, 1999, 2012 онд Хүнсний тухай (Шинэчилсэн найруулга) -ыг баталжээ.

⁵ Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний нэгдсэн дүн 32.5 хувь байна.

ядууралд өртөх эрсдэлтэй, эдгээр хүмүүсийн хувьд хүнс хүртэх боломж маш хангалтгүй байна.

4.2017, 2023 онд хийсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал” Үндэсний 5, 6 дугаар судалгааны дүнг харьцуулахад хүн амын дундах хоол тэжээлийн дутал буураагүй байгаа нь зохистой хооллох мэдлэг, дадал дутмаг, хоол, хүнсний хяналтгүй хэрэглээтэй холбоотой. Шим тэжээлгүй хоол хүнсийг хэрэглэснээс таргалах өвчлөх зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байна. Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын болон хяналтын тогтолцоо оновчгүй байгаатай холбоотой. Мөн хүнсний сүлжээн дэх тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, түгээлт, хүнсний шимт байдал, хүнсний зохистой хэрэглээтэй холбоотой харилцааг дутуу зохицуулагдсан нь нөлөөлсөн.

Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохистой болгох зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах харилцааг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

1.Үндэсний аюулгүй байдлын нэг бүрдэл болох хүнсний аюулгүй байдлын ойлголтыг дэлгэрүүлэхээс гадна “Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаат хоол, хүнсээ сонгон хэрэглэх эрх”, түүнтэй холбоотой зохицуулалтыг тусгасан болно.

2.Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуульд туссан “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёотой холбоотой төөрөгдлийг арилгаж, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх зорилгоор “хүнсний аюулгүй байдал” ойлголтыг дэлгэрүүлэн тусгав. Хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалд үндэслэн “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршлийг “хүнсний баталгаат байдал” гэж өөрчлөв. Ингэхдээ Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний нэр томъёоны тайлбар” нэртэй салбарын журамласан толийг эш үндэс болгов.

Мөн хуульд хэрэглэсэн нэр томъёоны хэл зүй, найруулга, үг сонголтыг оновчтой болгох, хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэхэд ойлгомжтой байлгах зорилгоор “хүнсний сүлжээ” гэсэн нэр томъёог өөрчлөн найруулж, “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, “хүнсний худалдаа” гэсэн нэр томъёог нэмж, холбогдох хуульд эшлэл татсан болно.

4. Мөн хоол хүнснээс гаралтай халдварт бус өвчлөлийг бууруулах зорилгоор “нэг дэлхий, нэг эрүүл мэнд” үзэл санааны хүрээнд “хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлын харилцан шүтэлцээг хангах” зарчмыг нэмж тусгав.

5.Хүнсний аюулгүй байдлыг хангах⁶ төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүнтэй болгох зорилгоор төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэл, шинжлэх ухаанд үндэслэх зарчим, бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоог гүйцэтгэлийн удирдлагатай уялдуулан иж бүрэн тусгалаа. Хүнсний аюулгүй байдлыг хангах цогц бодлогын чиглэлийг хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдал, хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгаат байдал, шим тэжээллэг, чанартай хоол хүнсийг сонгон хэрэглэх боломж, зөв зохистой хэрэглээ, хүнсний салбарын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэж тодорхойлов. Энэхүү бодлогыг тандалт,

⁶ 2002 онд НҮБ-ын Дэлхийн хүнсний бага хурлаар “Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүнсний хангамж, хүртээмж, хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдал ба шимт байдал, хүнсний тогтвортой байдал гэсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ” гэж томъёолжээ.

судалгааны үр дүн, зураглалд үндэслэн тодорхойлохоор зааснаас гадна эрдэм шинжилгээний байгууллага, түүний чиг үүргийг тусгав.

6.Хүнсний салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор их дээд сургууль, мэргэжлийн болон политехникийн боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хүний нөөц бэлтгэх, давтах сургах, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон харилцааг тусгав.

7.Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн асуудлыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцахаар чиг үүргийг тодорхой болгов. Улсын болон орон нутгийн хэмжээнд хүнсний хангамжийг тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх балчир хүүхдийн хоол тэжээл болон цэцэрлэг, сургуулийн хүнсний нөөцийн бүрдүүлэлт, ханган нийлүүлэлтийн асуудлыг тусгана.

Хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагааг нь төрийн болон хувийн хэвшлийн хуулийн этгээд хэрэгжүүлэхээр тусгав. Мөн тухайн шатны Засаг дарга цэцэрлэг, сургуулийн хүнсний ханган нийлүүлэлтийн нэгдсэн төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцно. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлсэн, үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг нийлүүлсэн хуулийн этгээдийг дэмжлэгт хамруулахаар тусгав.

8.Хүнсний сүлжээнд зохицуулагдаагүй үлдсэн тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой харилцааг нэмж тусгасан болно. Тухайлбал, хүнсний анхан шатны болон боловсруулах үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, худалдаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг, хүнсний сав баглаа, боодол, туслах материалд хамаарах стандартыг мөрдөхөөр заасан.

9.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох энгийн зөвшөөрөл олгох журмыг Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөн найруулав. Хүнсний аюулгүй байдлын зөвлөл тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх Засгийн газрын гишүүний саналыг хэлэлцээд уг саналыг бүхэлд нь дэмжих, эсхүл хүнсний нэр төрлийг өөрчлөх, тоо хэмжээг бууруулах, эсхүл тухайн жилд хүнс экспортлох, импортлох хугацааг хойшлуулах, түүнчлэн хүн амын хүнсний хангамж, үнийн түвшнийг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээнд хязгаар тогтоохгүй байх, тухайн жилийн мал төллөх болон ургац хураах цаг хугацаанд стратегийн хүнсийг экспортлохгүй, импортлохгүй байх шийдвэр гаргаж байхаар тусгалаа.

10.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг дээшлүүлж, хүнсний баталгаат байдлыг хангах зорилгоор зөвхөн стандартын урьтал нөхцөл болсон зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулахыг үүрэг болгоно. Харин хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ баталгаажуулахыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч өөрөө шийдвэрлэхээр үлдээсэн болно.

11.Хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор салбарын мэдээллийн нэгдсэн сан бий болгож, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, ашиглах, хадгалах, хамгаалахтай холбогдсон журмыг Засгийн газар батлахаар тусгалаа.

Энэ хууль батлагдсанаар хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо цогц байдлаар бүрдэж, улмаар хуулийн хэрэгжилт үр дүнтэй болсноор хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, хүнсний импорт, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна. Ингэснээр хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна. Мөн хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаат байдал сайжирна.

Мөн төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

-oOo-

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”¹-ын 3.4.2 дахь заалт, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”²-ын Зорилт 2.5, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай”³ Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3 дахь заалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайланд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нь импортоос хамааралтай, хүртээмж нь газар зүйн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа, ядуурлын түвшин буурсан ч ядууралд ойрхон байгаа хүмүүс аливаа сөрөг хямрал (эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт) үүсэхэд эргээд ядууралд өртөх эрсдэлтэй байгааг дурджээ.

Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохистой болгох зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, дараах харилцааг зохицуулахаар тусгасан болно. Үүнд:

1. Онолын үзэл баримтлалыг эш үндэс болгон шинжлэх ухаанд үндэслэсэн хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжилтийг нь дэмжих тогтолцоо, түүнтэй холбогдох зохицуулалтыг иж бүрэн тусгана. Мөн хоол хүнснээс гаралтай халдварт бус өвчлөл бууруулах зорилгоор “хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах” зарчмыг тусгалаа.

2. Хүнсний тухай хуульд хүнсний сүлжээнээс зохицуулагдаагүй үлдсэн байсан тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаа, түгээлттэй холбогдсон харилцааг тусгав.

3. Хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх шаардлагын үүднээс хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалд үндэслэн зарим нэр томъёог өөрчилж, шинэ нэр томъёог нэмж тайлбарласан.

4. Улсын болон орон нутгийн хэмжээнд хүнсний хангамжийг тодорхойлохдоо эн тэргүүнд хүүхдийн хоол, хүнсний нөөцийг бүрдүүлэх асуудлыг тусгахаас гадна сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэлтийг дэмжихээр тусгав.

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

5.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох энгийн зөвшөөрлийг олгохдоо тусгай зөвшөөрлийн нэгэн адилд сонгон шалгаруулалт явуулдаг байсныг өөрчилж, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэв.

6.Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвортой ажиллуулах зорилгоор мэргэшлийн сургалт, мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон харилцааг тусгана.

7.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадлыг хэрэгжүүлснээ үндэсний баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулахыг үүрэг болгов.

9.Хүнсний чиглэлийн эрдэм шинжилгээ судалгааны ажлыг дэмжиж, хүнсний сүлжээний бүх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, хүнсний зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгаа хийхэд эрдэм шинжилгээний байгууллагын оролцоог чухалчилж, эрдэм шинжилгээний байгууллага, түүний чиг үүрэгтэй холбогдсон зохицуулалтыг тусгасан.

10.Үндсэн хуульд заасан “иргэдийн мэдэх эрх”, Хүнсний тухай хуульд заасан “хүнсний талаарх мэдээлэл үнэн зөв, ил тод, бодитой байх” зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор салбарын мэдээллийн нэгдсэн сан бий болгохтой холбогдсон зохицуулалтыг нэмж тусгана.

Энэ хууль батлагдсанаар хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, гадаад, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна. Ингэснээр хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна. Мөн хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаат байдал сайжирна.

Төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

-оОо-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн доор дурдсан зүйл, заалтыг өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 4.14, 4.1.6 дахь заалт:

“4.1.4.хүнсний баталгаат байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй, чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхыг;”

4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, түгээх, худалдаа эрхлэх, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг;”

2 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 2 зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 3.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “аюулгүй байдал” гэснийг “баталгаат байдал” гэж, 4.1.13 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 4.1.19, 4.1.20, 4.1.21 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 5 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1, 5.1.2, 5.1.3 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 7 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 7.3 дахь хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “аюулгүй байдалтай” гэснийг “баталгаат байдалтай” гэж, дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ” гэснийг “БАТАЛГААТ БАЙДЛЫГ” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан” гэснийг “Хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан” гэж, 15.2.1 дэх заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 15.3 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, 16.1.1 дэх заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 17 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, мөн зүйлийн 17.1 дэх хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 17.1.3 дахь заалтын “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 17.2 дахь хэсгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18 дугаар зүйлийн гарчгийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж, 18.1 дэх хэсгийн “Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 18.1 дэх хэсгийн “аюулгүй байдалд” гэснийг “баталгаат байдалд” гэж, 18.1.5 дахь заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “тэжээлийн аюулгүй байдлыг” гэснийг “тэжээлийн баталгаат байдлыг” гэж “бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдлыг” гэж, 27 дугаар зүйлийн 27.10, 27.15 дахь хэсэг, 29.1.2 дахь заалтын “бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдлыг” гэж, 30 дугаар зүйлийн 30.2.1, 30.2.2 дахь заалтын “түүхий эдийн аюулгүй байдлыг” гэснийг “түүхий эдийн баталгаат байдлыг” гэж, 30.21 дэх хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдлыг” гэж, 31 дүгээр зүйлийн 31.8.1 дэх заалтын “аюулгүй байдлын” гэснийг “баталгаат байдлын” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2.4 дэх заалт, 34.3.3 дахь заалтын “хүнсний аюулгүй байдлыг” гэснийг “хүнсний баталгаат байдлыг” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтын “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн “аюулгүй байдлыг” гэснийг “баталгаат байдлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 7.4.1 дэх заалтын "аюулгүй байдлыг" гэснийг "баталгаат байдлыг" гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтын "аюулгүй байдал" гэснийг "баталгаат байдал" гэж, 10 дугаар зүйлийн 10.3.2, 10.4.6, 10.7.2 дахь заалтын заалтын "аюулгүй байдлыг" гэснийг "баталгаат байдлыг" гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 6.16 дугаар зүйлийн гарчгийн “Органик хүнсний тухай” гэснийг “Органик бүтээгдэхүүний тухай” гэж, 6.15 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж, 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж тус тус өөрчилсүгэй

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 6.13 дугаар зүйлийг хүчингүй болгосугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нялх, балчир хүүхдийн хүнсний хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3 дахь заалт, 5.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Органик бүтээгдэхүүний тухай /шинэчилсэн найруулга/
хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “хүнсний
аюулгүй байдлын” гэснийг “хүнсний баталгаат байдлын” гэж, 14 дүгээр зүйлийн
14.2.2 дахь заалтын “бүтээгдэхүүний аюулгүй байдлыг” гэснийг “бүтээгдэхүүний
баталгаат байдлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.5.1, 5.5.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.2.5 дахь заалтын “хүнсний аюулгүй байдал” гэснийг “хүнсний баталгаат байдал” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийн “хүнсний аюулгүй байдлыг” гэснийг “хүнсний баталгаат байдлыг” тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД, УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “хүнсний аюулгүй байдлыг” гэснийг “хүнсний баталгаат байдлыг” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Д.ЭНХМАА

Төрийн бодлогын шинжлэх ухааны доктор (Sc.D)

Техникийн ухааны доктор (Ph.D)

Ж.ТУЯАЦЭЦЭГ

Техникийн ухааны доктор (Ph.D), дэд профессор

Я.ХИШИГТ

Хуульчдын холбооны гишүүн, хуульч

АГУУЛГА

УДИРТГАЛ	6
НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	9
1.1. Үнэлгээ хийх үндэслэл	9
1.2. Үнэлгээний хүрээ	9
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	10
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	11
1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн томъёолол	12
1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга зүй	14
ХОЁР. ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	15
2.1. “Хүнсний хангамж” бүлгийн хэрэгжилтийн байдал	17
2.3. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлагын хэрэгжилтийн байдал	45
2.4. Хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт	62
2.5. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт	98
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	101
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	105

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- 1 дүгээр зураг. Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, мянган тонн, 2023 он
- 2 дугаар зураг. Нэг хүнд хоногт ногдох илчлэг, килокалориар
- 3 дугаар зураг. Нэг хүнд хоногт ногдох илчлэг, бүтээгдэхүүнээр, килокалориар
- 4 дүгээр зураг. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны түвшин, хувиар
- 5 дугаар зураг. Ундны усны эрүүл аюулгүй байдал, хүн амын эзлэх хувь, 2023 он
- 6 дугаар зураг. Хүнсний холбогдолтой нийт болон олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн стандартын тоо
- 7 дугаар зураг. Лабораторийн шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин, 2023 он
- 8 дугаар зураг. Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн зөрчил, салбараар, дүнд эзлэх хувиар
- 9 дүгээр зураг. Хяналт, шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн хувь, салбараар
- 10 дугаар зураг. Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчил
- 11 дүгээр зураг. Хяналт, шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн хувь, салбараар
- 12 дугаар зураг. Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын бүтэц зохион байгуулалт, 2022 он
- 13 дугаар зураг. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын бүтэц зохион байгуулалт, 2023 он
- 14 дүгээр зураг. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын бүтэц, зохион байгуулалт, 2025 он
- 15 дугаар зураг. Засгийн газрын түвшинд хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны өнөөгийн байдал
- 16 дугаар зураг. Тохирлын үнэлгээнд хамрагдсан ААНБ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- 1 дүгээр хүснэгт. Экспорт, импортын барааны гүйцэтгэл, сая ам.доллар
- 2 дугаар хүснэгт. Хүнсний баталгаа алдагдсан өрх, асуултаар, өрхөд эзлэх хувь
- 3 дугаар хүснэгт. Хүнсний баталгаат байдлын тархалт, өрхөөр, хүн амаар
- 4 дүгээр хүснэгт. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн мэдээ /2024.07.31/
- 5 дугаар хүснэгт. Малын гоц халдварт өвчний мэдээлэл, 2023 он
- 6 дугаар хүснэгт. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэр
- 7 дугаар хүснэгт. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадавх
- 8 дугаар хүснэгт. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээ
- 9 дүгээр хүснэгт. Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн ААНБ, иргэдийн тоо
- 10 дугаар хүснэгт. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэр

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.2-т “Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөл болон холбогдох дүрэм, журмыг боловсруулах”, 1.1.3-т “Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 126 дугаарт хүнс тээвэрлэх, хадгалах, худалдах, хүнсний сүлжээнд зохицуулагдаагүй үйлдвэрлэл, үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулсан хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөх гэж тус тус заасан.

2012 онд Монгол Улсын Их Хурлаас Хүнсний тухай хууль¹-ийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан 13 жилийн хугацаанд тус хуульд нийт 9 удаа өөрчлөлт оржээ. Эдгээр өөрчлөлтүүд нь цаг үеийн шинжтэй үүссэн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийгдсэн бөгөөд энэ нь хүнсний хангамж, аюулгүй байдлыг цогц байдлаар хангахтай холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэгдээгүй байна.

Өнгөрсөн хугацаанд дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдал, цар тахал, тээвэр логистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэргээс шалтгаалсан хүнсний хангамж, аюулгүй байдлын асуудал улс орон бүрийн нэн тулгамдсан сорилт боллоо. Цаашлаад дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилтод томоохон эрсдэл учруулаад байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтний өмнө хүнд сорилтыг бий болгож байгаа бөгөөд тэр дундаа хөдөө аж ахуйн салбарт хүчтэй нөлөөлж байгаагийн зэрэгцээ дэлхий нийтэд эрчимтэй өсөн нэмэгдэж буй хүн амыг хүнс, тэжээлээр хүртээмжтэй, тогтвортой хангах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах нь тулгамдаж буй асуудал болж байгаа. Өөрөөр хэлбэл байгалийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглан өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг тогтвортой хангах шаардлага үүсэж байна.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хөдөө аж ахуйгаас бэлтгэдэг нь дэлхий нийтийн жишиг болсон бөгөөд энэхүү хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амын хүнсний хангамж, хүртээмж, хэрэглээ, хооллолтын дэглэм, чанарт нөлөөлдөг. Хүнсний үйлдвэрт ургамал, амьтны гаралтай хүнсний түүхий эдийн чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, технологийн дагуу боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн

¹Монгол Улсын Их Хурал 2002 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2002 оны №23 дугаарт нийтлэгдсэн.

үйлдвэрлэдэг. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тээвэрлэж хэрэглэгчид хүргэнэ. Хүн ам олонтой зарим хот суурин газарт хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэн хүргэхийн тулд хол зам туулах шаардлага тулгарч улмаар хүнсний чанарт сөргөөр нөлөөлөх нь цөөнгүй. Хот суурин газрын хүн амын хувьд дэлгүүр, худалдааны төв, нийтийн хоолны үйлчилгээний газраас олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн сонгох, худалдан авах, хэрэглэх өргөн боломжтой бол алслагдсан газарт амьдардаг иргэдэд ийм боломж хомс байдаг.

Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн эхэн үед хүнс, хөдөө аж ахуйн салбар хямралд ноцтой өртсөн боловч өнөөдрийн байдлаар хувьчлагдсан томоохон хүнсний үйлдвэрийн үйл ажиллагаа жигдэрч, мөн шинээр үүссэн үйлдвэрүүдийн цар хүрээ, чадавх дээшилсээр байна. Харин өнөөдрийг хүртэл хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, мал эмнэлэг, хоол үйлдвэрлэл, хүнсний худалдаа, үйлчилгээ, тээвэр логистик, хүний нөөц, хэрэглэгчид буюу хүнсний сүлжээнд оролцогчдыг тус тусад авч үзсэнээс нэгдсэн бодлогогүй, уялдаа холбоогүй үйл ажиллагаа явуулж байгаа нь хүнсний аюулгүй байдлыг цогцоор нь харах, шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, хяналтын үйл ажиллагааг тогтолцооны түвшинд явуулж чадахгүй байна.

Дээр дурдсан асуудлуудыг шийдэх хүнсний аюулгүй байдлыг хангах сайн засаглал бий болоогүй, удирдлагын тогтолцоог зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүйгээс Монгол Улсад хэрэгжиж буй одоогийн хууль тогтоомж, салбарын бодлого, стандартын хэрэгжилт хангалтгүй түвшинд байна. Тухайлбал, Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор² баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд шинээр бий болсон харилцааг зохицуулах, хүнсний аюулгүй байдлыг хангахад тавих төрийн хяналт, шалгалтын үйл явц, тогтолцоог боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрх, үүргийг шинэ түвшинд тодорхойлох” зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар заасан боловч тухайн үед хуулийн шинэчлэлийг хийж чадаагүй болно.

Иймд Хүнсний тухай хуульд “хүнсний аюулгүй байдлыг хангах”-тай холбоотой зохицуулалтыг хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр тодорхойлох, мөн хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны зохицуулалтыг зайлшгүй тусгах цаг үеийн хэрэгцээ шаардлага бий болсон гэж үзэж байна.

Мөн хүнсний аюулгүй байдлыг хүнсний сүлжээнд бүхэлд нь хангах хүрээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хүнс тээвэрлэх, хадгалах, худалдах, хоол үйлдвэрлэх, үйлчлэхтэй холбоотой хуулийн зохицуулалт хангалтгүй байгаа учир Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх шаардлагатай байна.

²Монгол Улсын Их Хурал 2017 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2017 оны №10 дугаарт нийтлэгдсэн.

Энэхүү үнэлгээний зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн³ 14 дүгээр зүйлийн 14.1-д “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.”, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг энэ хуулийн 12.1.6-д заасан аргачлалын дагуу хийнэ.” гэж, 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж тус тус заасны дагуу Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлэхэд оршино.

Үнэлгээний зорилго

Хүнсний тухай хуулийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар хүнсний хангамж, аюулгүй байдал алдагдаж хүн амын дунд хоол, хүнсний хомсдолд өртсөн байдал, хоолны хордлого, халдварт өвчин гарсан тохиолдол, давтамж, түүний шалтгаан, улмаар хүн амын эрүүл мэндэд хохирол учруулсан байдлыг судлан тогтоож, хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, энэ нь нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлох, үүн дээр үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх явдал юм.

Үнэлгээ хийхэд баримталсан зарчим

Үнэлгээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглах замаар хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэв.

Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасны дагуу дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

³Монгол Улсын Их Хурал 2015 онд баталж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл

Хүнсний тухай хуульд үнэлгээ хийх шалтгаан нь энэ хуулийн зохицуулалтаар хүнсний аюулгүй байдлыг цогц байдлаар хангахтай холбоотой харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хүнсний сүлжээнд хүнсний салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг тогтоох замаар хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох юм.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Их хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3-т “Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан нь үнэлгээ хийх шалтгаан юм.

1.2. Үнэлгээний хүрээ

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээг хийх бөгөөд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, хуулийн зорилгыг хангахад чиглэсэн хүнсний хангамж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлага, хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалт, хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл гэсэн 5 бүлэг, 16 зүйл, нийт 96 заалтаар үнэлгээний хүрээг сонголоо.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2019-2024 оны хоорондох Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх статистикийн болон албаны мэдээллийг цуглуулав. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагуудтай уулзалт ярилцлага⁴ хийж, холбогдох тоо баримт, судалгааны бүтээл зэргийг судалж Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлэхэд шаардлагатай мэдээллийг нэмж тусган нэгтгэн дүн шинжилгээг хийв.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь үнэлэх бөгөөд үнэлэх шаардлагатай зүйл, хэсгийг дараах хүснэгтээр үзүүлбэл:

⁴Үнэлгээний тайлангийн хавсралтад ярилцлагын аргаар авсан судалгааны тайланг хавсаргав.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг
1	Хоёрдугаар бүлэг. Хүнсний хангамж	5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох 6 дугаар зүйл. Хүнсний нөөц 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах
2	Гуравдугаар бүлэг. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлага	10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага
3	Дөрөвдүгээр бүлэг. Хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалт	12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг 16 дугаар зүйл. Бүртгэл 17 дугаар зүйл. Баталгаажуулалт
4	Тавдугаар бүлэг. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл	18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл 18.5. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах дараах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгосон.

Зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал, бусад үр дагавар гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгож авсан болно. Үүнд:

1. *“Зорилгод хүрсэн түвшин”* шалгуур үзүүлэлт нь хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх юм.

2. *“Практикт нийцэж байгаа байдал”* шалгуур үзүүлэлт нь хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж үнэлэх юм.

3. *“Бусад үр дагавар”* шалгуур үзүүлэлт нь урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй үр дагавар байгаа эсэхийг үнэлэх юм.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх хэсэг, заалт	Шалгуур үзүүлэлт
1	Хоёрдугаар бүлэг. Хүнсний хангамж	5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох 6 дугаар зүйл. Хүнсний нөөц 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах	Хуулийн зорилгод хүрсэн байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.
2	Гуравдугаар бүлэг. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлага	10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа эсэх.
3	Дөрөвдүгээр бүлэг. Хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалт	12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг 16 дугаар зүйл. Бүртгэл 17 дугаар зүйл. Баталгаажуулалт	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
4	Тавдугаар бүлэг. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл	18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл 18.5. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаа дээр үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Хүнсний тухай хуулийн холбогдох зүйл,хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо

баримт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистикийн болон албаны мэдээлэл, судалгааны бүтээл зэрэг байна.

Хүнсний тухай хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

д/д	Үнэлэх зүйл	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох 6 дугаар зүйл. Хүнсний нөөц 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах	Хуулийн зорилгод хүрсэн байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах
2	10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа эсэх.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах
3	12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг 16 дугаар зүйл. Бүртгэл 17 дугаар зүйл. Баталгаажуулалт	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнөх болон эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах
4	18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл 18.5. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш

1.5. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн томьёолол

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхмууд нь томьёолсон шалгуур үзүүлэлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур томьёолол
1	5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох	Хуулийн зорилгод хүрсэн	Хүчин төгөлдөр үйлчилж	- Хүнсний хангамжийг бүрдүүлэх хуулийн

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

	6 дугаар зүйл. Хүнсний нөөц 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах	байдал ба хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх? - Хүнсний шим тэжээлийн зохистой байдал хангагдсан эсэх? - Энэхүү хуулийн хүрээнд батлахаар заасан дүрэм, журам, зааврууд бүрэн батлагдсан эсэх, батлагдаагүй байгаа бол түүний шалтгаан?
2	10 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа эсэх.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд хуулиар тогтоосон ерөнхий шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Дотоодын хүнсний үйлдвэрлэлд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадсан эсэх? - Импортын хүнсний хяналтын тогтолцоог боловсронгуй болгож чадсан эсэх? - Энэхүү хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа эсэх буюу практикт нийцэж байна уу?
3	12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг 16 дугаар зүйл. Бүртгэл 17 дугаар зүйл. Баталгаажуулалт	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнөх болон эхэлснээс хойших Тодорхой тохиолдол судлах	- Хуулийн хэрэгжилтэд төр бүрэн хяналт тавьж чадаж буй эсэх? - Хэрэглэгч баталгаатай хүнсийг хэрэглэж чадаж байгаа эсэх? - Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлсон байдал нь практикт нийцэж буй эсэх? - Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэгийг төр хэр хүлээн зөвшөөрдөг вэ? - Хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх хуулийн зохицуулалт нь хуулийн

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

				зорилгыг хангаж байгаа эсэх?
4	18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл 18.5. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг	Хуулийн зорилгод хүрч хууль хэрэгжсэн байдал.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл байгуулснаар хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн чиг үүрэг, тогтолцоо нь оновчтой эсэх?

1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулах арга зүй

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Үнэлгээ хийхэд шаардагдах мэдээллийг цуглуулахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газар, Нийслэл, аймаг, салбарын хяналтын газруудаас хуулийн хэрэгжилттэй холбоотой тайлан, статистикийн тоон мэдээлэл, танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, салбарын хууль тогтоомжийн эмхэтгэл, салбарын эрдэмтэн судлаачдын бүтээл, ном туурвил, хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээлэл зэрэг мэдээллийг эх сурвалж болгон ашигласан.

- **Холбогдох субъектүүдтэй уулзаж, мэдээлэл авах:** Хуулийн хэрэгжилтийн талаар үнэн бодитой мэдээлэл цуглуулах, уг хуулийн үйлчлэлд оролцогч субъектүүдээс тэнцвэртэй мэдээлэл авах зорилгоор салбарын мэргэжилтэн, эрдэмтэдтэй ганцаарчилсан ярилцлага хийх, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдлага, салбарын хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийхээс гадна орон нутагт ажиллаж хуулийн хэрэгжилтэд оролцогч субъектүүдтэй уулзалт, ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулсан.

- **Цуглуулсан анхны тоон мэдээлэл үнэлгээ хийхэд шаардлага хангах эсэхэд дүн шинжилгээ хийж, сайжруулах:** Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг үнэн зөв, бодит, эргэлзээгүй, статистикийн тоон мэдээтэйгээр зохион байгуулахын тулд хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, холбогдох хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас анх ирүүлсэн тоон мэдээлэлд дүн шинжилгээг хийж, зөрүүтэй, эргэлзээтэй, тодорхойгүй мөн бүртгэлд огт байхгүй зэрэг тоон мэдээллийг шинээр бүртгэлжүүлэх, засч залруулах, ойлголтын зөрүүг арилгах, нэр томъёоллыг жигдлэх, нэгдсэн ойлголтод хүрэх, нэгтгэх зорилгоор Хүнсний тухай хуулийн заалт тус бүр дээр албаны болон статистикийн тоо ба чанарын мэдээллийг цуглуулах хүснэгтийг боловсруулан, хүснэгтийн дагуу мэдээлэл цуглуулж, мэдээллийг сайжруулан, боловсруулж үнэлгээнд ашигласан.

ХОЁР. ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Хүнсний тухай хууль нь хүнсний хангамж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлага, хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалт, хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан 5 бүлэг 20 зүйлтэй батлагдсан.

Хуулийн хэрэгжилтийг 4 бүлэг 14 зүйл, 96 заалтын хүрээнд гаргаж, нэгтгэн дүгнэхэд өнөөгийн хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцооны гажуудлаас үүдэн энэ хуулийн хэрэгжилт, хуулийн үзэл баримтлалд анх дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадахгүй байна гэж дүгнэж байна. Иймд **хуулийн хэрэгжилт 32.5 хувьтай байна.**

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг гаргахад шаардлагатай суурь өгөгдөл, мэдээллийг Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээ болон холбогдох төрийн захиргааны байгууллагын албаны мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.

УИХ-аас 2012 онд баталж 13 дах жилдээ хэрэгжиж буй Хүнсний тухай хуулийг хүнсний салбарын суурь хууль гэж үздэг. Энэ хуулиар хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүний хэсгээс хүнсний хангамж, хүнсний баталгаат байдал буюу хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн харилцааг зохицуулсан байна. Харин хүнсний хүртээмж, хүнсний хэрэглээ ба шимт байдал, хүнсний аюулгүй байдлыг тогтвортой хангахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгаагүй байна. Мөн хүнсний аюулгүй байдлыг хүнсний сүлжээнд бүхэлд нь хангах хүрээнд хүнс тээвэрлэх, хадгалах, худалдах, хоол үйлдвэрлэхтэй холбоотой хуулийн зохицуулалт хангалтгүй туссан байна гэж дүгнэж байна.

Хүнсний тухай хуулийг дагаж нэг зөвлөмж хэмжээ, нэг жагсаалт, 5 журам, нэг дүрэм дагаж гарсныг дараах хүснэгтэд харуулав.

1 дүгээр хүснэгт. Хүнсний тухай хуулийг дагаж гарсан хууль, дүрэм, журам бусад баримт бичгийн жагсаалт

№	Захиргааны хэм хэмжээний актын		Агуулга
	Баталсан арга хэлбэр	Огноо, Дугаар	
1.	ЭМ-ийн Сайдын тушаал	2017.02.23 А/74	5.1.Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай
2.	Засгийн газрын тогтоол	2023.09.13, №344	6.2.Журам батлах тухай, (Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам)
3.	ХХААХҮ-ийн Сайд	2013.02.28 А/33	8.4. Жагсаалт батлах тухай
4.	Засгийн газрын тогтоол	2020.09.30, №130	8.5.Журам батлах тухай, (Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

			аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам)
5.	Засгийн газрын тогтоол	2011.11.09 №311	12.2. Нийтлэг журам батлах тухай (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)
6.	ХХААХҮ-ийн сайд	2019.12.30 А-515	16.2. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам батлах тухай
7.	Засгийн газрын тогтоол	2013.03.02	18.4.Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн дүрэм
8.	ХХААХҮ-ийн сайд	2023.01.06 №5	“Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ыг журмыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулснаар хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.
9	УИХ	2018.5.03	Баяжуулсан хүнсний тухай хууль батлагдсан
10	УИХ	2012.12.20	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль батлагдсан
11	УИХ	2024.01.17	Органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдсан.

Хүнсний тухай хуульд заасан зарим хууль мөн хүнс, эрүүл мэнд, нийгмийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдах журам, аргачлал, жагсаалтууд хууль батлагдсанаас хойших 13 жилийн хугацаанд батлагдаагүй байгааг доорх хүснэгтэд харуулав.

2 дугаар хүснэгт. Хуулийг дагаж гараагүй хууль, журам бусад баримт бичгийн жагсаалт

№	Захиргааны хэм хэмжээний актын		Агуулга
	Батлагдах арга хэлбэр	Хуулийн заалт	
1.	ХХААХҮ-ийн сайд	Энэ хуулийн 8.4.-д заасан жагсаалтыг батлах	Өргөн хэрэглээний хүнсний жагсаалт батлах
2.	Эрүүл мэндийн сайд	Батлуулаагүй.	9.1.3.шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журам батлах.
3.	ХНХ-ийн сайд	Энэ хуулийн 6.6.-д заасан хүн амын эмзэг бүлгийг тодорхойлох аргачлал боловсруулах	Эмзэг хүн амын бодит хэрэглээ болон шим тэжээлийн байдлын судалгаа хийгддэггүй байна.
4.	УИХ	Энэ хуулийн 9.3.-д зааснаар дагаж гарах хууль	Хүнсний найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулаагүй. Хууль батлагдаагүй.
5	ХХААХҮ-ийн сайд	Энэ хуулийн 17.1.-д заасан жагсаалтыг батлах	Магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага болон баталгаажуулалт авсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн жагсаалтыг гаргаагүй байна.

Иймд Хүнсний тухай хуульд “хүнсний аюулгүй байдлыг хангах”-тай холбоотой зохицуулалтыг тусгахдаа хүнсний хангамж хүртээмж, хүнсний хэрэглээ ба шимт байдал, хүнсний баталгаат байдал, хүнсний тогтвортой байдал гэсэн хүнсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж, улмаар хүнсний аюулгүй байдлыг хүнсний сүлжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, тогтолцоогоор хангах зохицуулалтыг зайлшгүй тусгах цаг үеийн хэрэгцээ шаардлага бий болсон байна.

2.1. “Хүнсний хангамж” бүлгийн хэрэгжилтийн байдал

УИХ-аас 2012 онд баталсан Хүнсний тухай хуульд хүнсний хангамжийг тодорхойлж хүнсний нөөцийг бүрдүүлэх, хувиргасан амьд организмаас гаралтай хүнс, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал олгохтой холбоотой харилцааг зохицуулахаар энэ хуулийн “Хүнсний хангамж” бүлэгт тусгасан. Харин стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын зохицуулалтыг энэхүү хуульд 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр нэмэлтээр оруулсан байна.

Хүнсний хангамжийн үзүүлэлтийг хүнсний нийлүүлэлт, хэрэглээний данс болон хүнсний хангамжийн түвшингээр тодорхойлдог. Хүнсний хангамж, хүртээмж нь өөр хоорондоо харилцан нягт холбоотой хүнсний аюулгүй байдлыг тодорхойлдог бүрэлдэхүүн хэсэг юм.

Хүнсний тухай хуульд хүнсний хангамжийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-5.4 дэх заалтад тусгагдсан бол хүнсний хүртээмж буюу хүнсийг газар зүйн байршлаас үл хамааран иргэдэд түгээх, хувь хүнд хүнс хүртэх боломжийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалт хангалтгүй туссан байна гэж үзлээ. Иймд энэ хуульд хүнсний хүртээмж, хүртэмжтэй холбоотой зохицуулагдаагүй заалтыг нэмэж оруулах ёстой.

УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол гарч, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах дунд хугацааны бодлогын хэрэгжилтийн үр дүнгээр сүүлийн 2 жилд хүнсний хангамжийн түвшин дээшилж эерэг үзүүлэлт гарч эхэлсэн хэдий хүнсний аюулгүй байдлыг хангах онолын үзэл баримтлалын хүрээнд Хүнсний тухай хуулийн 2 дугаар бүлэгт хүнсний аюулгүй байдлыг хангах зарим бүрэлдэхүүн тусгагдаагүй байсан тул энэ хуулийн хоёрдугаар бүлгийн хэрэгжилт 50 хувьтай үнэлэгдсэн.

Хуулийн хэрэгжилтэд шинжилгээ хийх ажлын хүрээнд Монгол Улсын хүнсний хангамжийн талаарх статистикийн үзүүлэлтэд үндэслэн шинжилгээ хийлээ. Хүнсний хангамжийн өнөөгийн бодит нөхцөл байдалтай танилцах хүрээнд холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн төлөөлөлтэй ялангуяа дотоодын үйлдвэрлэгч болон хүнс импортлогч нартай уулзах уулзалтыг зохион байгуулж, тулгамдаж буй асуудал, хүнсний

хангамжийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрхэн хамтран ажиллах талаар харилцан ярилцаж, санал солилцлоо.

Хүнсний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5-9 дүгээр зүйлийн хэрэгжилтэд шинжилгээ хийсэн. Үүнд:

Үнэлэх хэсэг Хүнсний тухай хуулийн	- 5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлж, баталгаат байдлыг хангана. - 6 дугаар зүйл. Хүнсний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна. - 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэлжүүлж эхэлсэн байна. - 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн ямар үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг, урамшууллыг үзүүлэхийг тодорхой болгож хэрэгжилтийг хангаж ажиллана. - 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангаж хүн амын дундах халдварт бус өвчлөлийг бууруулах бодлоготой үр дүнг уялдуулж үнэлдэг болно.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Хуульд тодорхойлсон хүнсний хангамжийг бүрдүүлэх удирдлага, зохион байгуулалт үр дүнтэй, оновчтой байж чадаж байна уу? - Хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлж чадсан эсэх? - Хүнсний хангамжийг бүрдүүлэх хуулийн зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх? - Хүнсний шим тэжээлийн зохистой байдал хангагдсан эсэх? - Энэхүү хуулийн хүрээнд батлахаар заасан дүрэм, журам, зааврууд бүрэн батлагдсан эсэх, батлагдаагүй байгаа бол түүний шалтгаан?

• Хүнсний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйл. Хүнсний хангамжийг тодорхойлох

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.2-т “Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна” гэж заасны дагуу Засгийн газраас дотоодын хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байгаа боловч импортын хамаарлын түвшин 2024 оны жилийн эцсийн байдлаар ойролцоогоор 46 хувьтай байгаа нь **хүнсний хангамжийн бие даасан байдал эрсдэлтэй түвшинд байгаа нь энэ хуулийн зорилго бүрэн хангагдах боломж бүрдээгүй байна.**

Хүнсний тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлд заасны дагуу “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны А-74 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г үндэслэн Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Монгол Улсын **хүнсний нийт хангамжийг 79 хувийг л тодорхойлж** байна. Үлдсэн 21 хувьд нь хүнсний давс, цай, хүнсний боловсруулах үйлдвэрийн түүхий эд болох импортын сүү, шингэн сүү зэрэг багтана. Мөн транс тосны агууламжтай хүнсний тос, хувиргасан амьд организмаас гаралтай хүнс, хуурамч хүнс зэргийг бүртгэж, тодорхойлж, шинжлэн тогтоож чадахгүй байна. Хангаж байгаа хүнс нь баталгаатай гэдгийг баталгаажуулж чадахгүй байна.

Одоо мөрдөгдөж буй хүн амын хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг тооцох аргачлалыг Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд”-ийг тооцох аргачлалтай нийцүүлэн дахин боловсруулж 2025 онд “Жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г шинэчлэн тогтоосноор мэдээллийн суурь өгөгдлийн үнэн зөв, бодит байдлыг хангах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийг өгч байна.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол буюу Монгол Улсын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах дунд хугацааны төрийн бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд, 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэ бодлогын үр дүнг анх зорьсон зорилтод суурь түвшин, хугацаатай нь харьцуулахад хүлээгдэж буй үр дүн хангалтгүй түвшинд байна гэж үзэж байна. Тухайлбал, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; “тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор шинээр 200.0 мянган гектар хүртэл атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 1.1 сая гектарт хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 5000 гектараар нэмэгдүүлэх, тариалангийн газрыг улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах;” “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх” зэрэг **заалтыг огт хэрэгжүүлээгүй** буюу **хэрэгжилт “0” үнэлгээтэй** байна. Эдгээр заалтууд огт хэрэгжээгүйтэй холбоотойгоор хүүхдийн хоол, хүнсний хангамжийн тогтолцоо мөн хүнс үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлээгүй байна.

Манай улсын нийт **хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт** 2023 онд 698.4 сая америк доллар болж өмнөх оноос 82.8 сая америк доллароор (10.6 хувь) буурсан бол **экспорт** 134.0 сая америк доллароор (7 дахин) өссөн байна.

1 дүгээр хүснэгт. Экспорт, импортын барааны гүйцэтгэл, сая ам.доллар

Хүнсний бүтээгдэхүүн	бэлэн	23.7	157.7	7 ¹	781.1	698.4	-10.6
-------------------------	-------	------	-------	----------------	-------	-------	-------

¹ -дахин их. Эх үүсвэр: ҮСХ, ГЕГ

Манай улсын 2023 онд нийт аж үйлдвэрт боловсруулсан сүү 54.7 сая литр болж, өмнөх оноос 8.5 сая литр (18.5 хувь)-ээр өссөн дүн гарсан боловч боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн тодорхой хувийг импортын хуурай сүү эзэлж байгааг хүнсний хангамжийн импортын хамаарлын түвшнийг тооцоход харгалзан үзэх нь зүйтэй юм.

Хүнсний хэрэглээний гол үзүүлэлт бол хүнсний хүртээмж юм. Хүнсний хангамж нь өрхийн түвшинд хангагдсан эсэхийг өрхийн хүнсний хүртээмжээр тодорхойлдог.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр ямар нэг байдлаар хүнсний дутагдалд орсон гэж хариулсан өрх 2022 онд нийт өрхийн 8.0 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 4.2 нэгж хувиар буурсан байна.

2 дугаар хүснэгт. Хүнсний баталгаа алдагдсан өрх, асуултаар, өрхөд эзлэх хувь

Асуулт	2020		2021		2022	
	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
Судалгаанд хамрагдсан нийт өрх	100.0	16 460	100.0	11 199	100.0	23 560
Ямар нэг байдлаар хүнсний дутагдалд орсон гэж хариулсан өрх	13.2	2 168	12.2	1 367	8.0	1 889
Мөнгө, санхүүгээс хамаарч хоол хүнсний дутагдалд ордог буюу "Тийм" гэж хариулсан өрхүүдийн хувьд						
Санаа зовох	73.5	1 594	86.5	1 182	77.6	1 466
Эрүүл, шим тэжээлтэй хоол хүнс идэх боломжгүй	52.5	1 138	46.9	641	52.2	987
Цөөн хэдхэн нэр төрлийн хоол хүнс хэрэглэсэн	63.7	1 382	59.3	810	58.2	1 099
Ердийн үед иддэг хоолоо идэж чадахгүй	24.8	538	23.9	327	25.6	483
Бага хэмжээгээр хэрэглэсэн	23.0	498	26.6	363	25.1	475
Огт хоол хүнсгүй болсон	6.4	139	4.4	60	9.6	182
Өлсөж байсан боловч хоол идэж чадаагүй	9.0	196	14.4	197	14.0	265
Бүтэн өдрийн турш хоол идэлгүйгээр явах	10.5	228	8.1	111	11.5	218

Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтээр хоол хүнс хүрэлцээгүй болох байх гэж санаа зовсон өрх 2021 онд 86.5 хувь байсан нь 2022 онд 77.6 хувь болж 8.9 нэгж хувиар буурсан байна. Харин эрүүл шим тэжээлтэй хоол хүнс идэх боломжгүй

гэж хариулсан өрх 2021 онд 46.9 хувь байсан бол 2022 онд 52.2 хувь болж 5.3 нэгж хувиар, огт хоол хүнсгүй болсон гэж хариулсан өрх 2021 онд 4.4 хувь байсан бол 2022 онд 9.6 хувь болж, 5.2 нэгж хувиар тус тус өссөн байна. Эндээс цөөн нэр төрлийн хоол хүнс хэрэглэх, эрүүл, шим, тэжээлтэй хоол хүнс хэрэглэхгүй байх, хоол, хүнс хүрэлцэхгүй байхад санаа зовох байдал нь бусад тохиолдлоос илүү түгээмэл тохиолддог болохыг харуулж байна.


2022 оны байдлаар, сүүлийн 12 сард хүнсний дутагдалд ордог гэж хариулсан өрхүүдийн 9.6 хувь нь огт хоол, хүнсгүй болсон, 14.0 хувь нь өлсөж байсан боловч хоол идэж чадаагүй, 11.5 хувь нь бүтэн өдрийн турш хоол идэлгүйгээр явсан гэж хариулт өгсөн. Эндээс хэдийгээр хүнсний баталгаат байдал алдагдаагүй хэдий ч өлсөж байгаа, өлссөн ч идэх хоол хүнсгүй байгаа, бүтэн өдрийн турш өлсгөлөн явах тохиолдлууд өрхийн хувьд гарсаар байна гэж үзэж болно. Тухайлбал, 2022 оны судалгааны үр дүнд, дунд болон хүнд хэлбэрийн ХББА-д өртсөн байдал нийт хүн амд 4.78 хувь, өрхийн 4.29 хувь байна. Харин хүнд хэлбэрийн ХББА-д өртсөн байдал нийт хүн амын 0.73 хувь, өрхийн 0.66 хувьтай байна.

3 дугаар хүснэгт. Хүнсний баталгаат байдлын тархалт, өрхөөр, хүн амаар

	Улсын дундаж					
	2020		2021		2022	
	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам
Дунд болон хүнд хэлбэрийн ХББА-тай	5.86	6.77	5.14	5.08	4.29	4.78
Стандарт алдаа	(0.68)	(0.86)	(0.69)	(0.76)	(0.5)	(0.61)
Хүнд хэлбэрийн ХББА-тай	0.23	0.25	0.54	0.48	0.66	0.73
Стандарт алдаа	(0.09)	(0.11)	(0.22)	(0.22)	(0.16)	(0.19)

Дунд болон хүнд хэлбэрийн ХББА-д өртсөн хүн амын эзлэх хувь хотод 2021 онд 5.15 байсан бол 2022 онд 5.73 болж өссөн байна. Харин дунд болон хүнд хэлбэрийн ХББА-д өртсөн хүн амын эзлэх хувь хөдөөд 2021 онд 4.96 байсан бол 2022 онд 2.82 болж буурсан байна. Хотын хүн амын хүнсний аюулгүй байдалд өртөх магадлал хөдөөгийнхөөс өндөр байна.

1 дүгээр зураг. Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ, мянган тонн, 2023 он



Жишсэн нэг хүн хоногт дунджаар малын мах 298.1 грамм, сүүн бүтээгдэхүүн 191.5 грамм, гурил 153.2 грамм, гурилан бүтээгдэхүүн 166.7 грамм, сүү 141.8 грамм, төмс 84.4 грамм, хүнсний ногоо 79.1 грамм, төрөл бүрийн будаа 67.2 грамм, сахар, чихрийн

зүйл 42.6 грамм, жимс, жимсгэнэ 31.3 грамм, өндөг 18.7 грамм, ургамлын тос 17.3 грамм, шувууны мах 6.3 грамм, цөцгийн тос 4.8 грамм, загас 0.5 грамм, буурцагт ургамал 0.1 грамм тус тус хэрэглэж байна.

2023 оны байдлаар өрхийн түвшинд малын мах, гурил, төрөл бүрийн будаа, өндөг, ургамлын тос, цөцгийн тос, сахар, чихрийн зүйлийн хүртээмж хангагдсан хэвээр байна. Харин хүнсний бусад бүтээгдэхүүний **хүртээмж хангалтгүй байна.**

Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний түүхий эдийн 68 хувийг хүнсэнд, 9 хувийг боловсруулсан хүнсэнд, 5 хувийг тэжээлд, 5 хувийг үйлдвэрийн хэрэглээнд, 3 хувийг дараа жилийн үрэнд, 2 хувийг хаягдалд, 8 хувийг дараа жилийн хэрэглээнд хадгалж, хэрэглэж байна.

2023 онд жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээг улсын дундаж бодит хэрэглээтэй харьцуулахад малын мах 2.5 дахин, сүүн бүтээгдэхүүн 6 хувь, гурил 53 хувь, төрөл бүрийн будаа 34 хувь, сахар, чихрийн зүйл 29 хувиар илүү хэрэглэж байна. Харин загас 98 хувь, шувууны мах 84 хувь, сүү 11 хувь, гурилан бүтээгдэхүүн 7 хувь, төмс 30 хувь, хүнсний ногоо 70 хувь, буурцагт ургамал 100 хувь, жимс, жимсгэнэ 84 хувь, өндөг 6 хувь, ургамлын тос 25 хувь, цөцгийн тос 52 хувиар **зохистой хэрэглээнээс бага буюу хангалтгүй байна.**

Хүнсний тухай хуулийн 5.3.-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 5.1-д заасны дагуу баталсан зохистой хэмжээг үндэслэн нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний хангамжийг тодорхойлж, хангамжаа бүрдүүлсэн гэсэн мэдээ өгсөн боловч бодит байдал дээр хүнсний хангамжаа үнэхээр тооцдог, тооцож чаддаг, түүнийг бүрдүүлж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн ямар ч мэдээлэл байхгүй байгаа тул хангалттай гэж үнэлэх боломжгүй юм.

Харин Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан мэдээнээс дурдахад нийт хангамжийг нийслэлийн үйлдвэрлэлээс, орон нутгаас, импортоос гэсэн эх үүсвэрээс хангасан байна. Аймаг, орон нутгийн хүн амын хэрэгцээнээс үндэслэн хангамжийн тооцооллыг гаргахад малын мах, гурил 100 хувь, гурилан бүтээгдэхүүн 85.0, өндөг 84.3, сүү 80.6, төмс 74.8, сүүн бүтээгдэхүүн 64.1, хүнсний ногоо 34.2, шувууны мах 4.6, цөцгийн тос 4.3 хувь тус тус байна. Төрөл бүрийн будаа, буурцагт ургамал, загасны мах, элсэн чихэр нь импортоос шууд хамааралтай хэвээрээ байна. Мөн 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 314 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн засаг даргын 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/1147 дугаар захирамжийг баталсан байна. Энэ захирамжаар хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй байлгах талаар авах арга хэмжээг тодорхойлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна гэжээ. Эндээс харахад аймаг, орон нутагт хүнсний хангамжийг бүрдүүлж байгаа хэдий ч хяналтын тогтолцоо байхгүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хэвтээ тогтолцоонд хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй байна. Иймд аймаг, орон нутагт хүнсний хангамжийн тооцоо

бодох, түүнийг тодорхойлох, бүрдүүлэхтэй холбоотой төрийн үйл хэрэгт нэгдсэн тогтолцоогоор дамжин хянах үйл ажиллагааг явуулах хэрэгтэй гэсэн дүгнэлтийг өгч байна.

Энэ хуулийн 5.4.-д “хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүрэгт аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хүнсний асуудал хариуцсан төрийн байгууллагын нэгж, сум, тосгонд хүнсний асуудал хариуцсан алба хаагч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог нийт 1000 гаруй алба хаагчид ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд хүнсний болон бусад хүнс, хөдөө аж ахуйн холбогдолтой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хангамж хариуцсан чиг үүргийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газарт Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс, Газар тариалан, Мал аж ахуйн хэлтэс, хүнсний зах, худалдааны төв, агуулах, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн асуудал хариуцсан чиг үүргийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газар, хүнсний аюулгүй байдлыг хангуулах хяналтын чиг үүргийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтэс, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хяналтыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар, хүнсний эрүүл ахуйн хяналтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцан ажиллаж байна. Мөн Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс ажиллаж байна.

Аймаг, орон нутагт хүнсний асуудал хариуцсан алба хаагчийн орон тоо бүрэн гүйцэт байж чадахгүй байна. Учир нь энэ албан тушаалд ажиллах сонирхолтой иргэн байвч төрийн алба хаагчийн шаардлагыг хангаж, төрийн албаны шалгалтад тэнцэж энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр ажиллаж чадах хүн дутагдалтай байгааг анхаарах хэрэгтэй байна. Ялангуяа Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад орон нутагт амьдардаг иргэдийн эрүүл мэндэд асуудал их үүсэж байгаа тул хүнсний аюулгүй байдлыг хангах хэвтээ тогтолцоог бэхжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна гэж дүгнэлээ.

- **Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам**

Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор батлуулсан. Харин уг журмыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулснаар хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулж байна.

Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлд “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журмын хэрэгжилт”-ийг хангах хүрээнд Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөс тогтоосон тоо хэмжээнд багтаан стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгон ажилладаг. Сонгон шалгаруулалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 18 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг зохион байгуулдаг байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ХХААХҮЯ, ГЕГ, МХЕГ, ШӨХТГ болон үйлдвэрлэгчдийн төлөөлөл мэргэжлийн холбоодын төлөөлөл орж ажилладаг. Уг зөвшөөрлийг олгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний саналыг боловсруулан Хүнсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвлөмжөөр тогтоодог. Гэвч энэхүү хүнсний экспортлох, импортлох зөвшөөрлийг ААН авахын тулд багаггүй хүндрэл бэрхшээл, хүнд сурталтай тулдаг гэж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн зүгээс ярьж байна. Тухайлбал, махны экспортын зөвшөөрлийг ААН-д олгохын тулд тухайн экспортлогч орноос нь мэргэжлийн шинжээчид ирж манай хүнсний үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцан, үйл ажиллагаа нь эрүүл ахуйн болон үйлдвэрлэлд тавигдах стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гараад, уг дүгнэлт дээр үндэслэн экспортын зөвшөөрөл олгохоор журамласан боловч зөвшөөрөл олгохын өмнө салбарын яамнаас аль үйлдвэрт зөвшөөрөл олгохыг шийдсэн жагсаалт гаргаж байгаа нь мэргэжлийн удирдлагаар бус захиргааны удирдлагаар энэ заалтын хэрэгжилт хангагдаж байна гэж үзэхээр байна. Иймд энэ зөрчлийг арилгахын тулд аливаа зөвшөөрөл лиценз дэмжлэг, урамшуулал, татааст хамрагдахын тулд тавигдаж буй шаардлагын хүрээнд мэдээллээ цахим системд оруулаад, цахимаар хариугаа авах, хамгийн гол нь цахимд хамрагдсан бүх ААН-ийн мэдээлэл ил тод байх шаардлагатай. Мөн хүсэлт гаргасан ААН-үүдийн түүхий эд, бүтээгдэхүүний шинжилгээний хариунууд нийтэд ил тод, нээлттэй байж, шударга ёсны зарчмыг хангах учиртай.

2023 оны 01 дүгээр сард энэ журмыг бүхэлд нь Хүнсний тухай хуульд нэмэлтээр оруулсан нь хүнсний хангамжийн бүлэгт нийцэхгүй зохицуулалт болсон байна. Учир нь хүнсний хангамжид нь дотоодын хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн болон импортын хүнсний бүтээгдэхүүний хамаарал их нөлөөлдөг. Хүнсний нөөц бүрдүүлэлтэд стратегийн хүнсний зөвхөн импортын тоо хэмжээ шууд хамааралтай, харин стратегийн хүнсний экспортын тоо хэмжээ нь хүнсний хангамжид нөлөөлөхүйц хэмжээний хамааралтай байж чадахгүй юм.

Хуульд нэмэлт оруулсан энэхүү журмын зохицуулалт нь хүнсний нэр төрлөөс хамааран 3 өөр янзаар тодорхойлогдсон нь бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдсан, мэдээлэл олж авах аж ахуйн нэгжийг төөрөгдүүлсэн, энэ хуульд тусгах шаардлагагүй процессыг нэмж оруулсан байна. Тухайлбал, хүнсийг

экспортлох, импортлох зөвшөөрлийг зарим тохиолдолд Стратегийн Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл эсвэл Засгийн газрын гишүүн эсвэл ХХААХҮЯ-наас олгохоор тусгагдсан байгаа нь үл ойлголцол, мэдээллийн үнэн зөв, ойлгомжтой байдал алдагдсан гэж үзэж байна. **Энэ заалтыг хасах саналтай байна.** Өмнө нь тусгагдсан заалтын хүрээнд Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олголтыг цахимжуулах замаар зохицуулж болно гэж дүгнэж байна.

- **Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйл. Хүнсний нөөц**

2010 онд УИХ-аар баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.3-т “Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг баталгаажуулах урт хугацааны тогтвортой гэрээ байгуулах, гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана” гэж заасны дагуу 2012 онд Хүнсний тухай хуульд хүнсний нөөц бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д заасны дагуу хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлэх ажлыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцаж байна. Гэхдээ улсын хэмжээнд энэ заалтын **хэрэгжилт хангалтгүй хяналтгүй явагдаж** байна. Тодруулбал стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмын хүрээнд нийслэлийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг л зөвхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Харин бусад стратегийн хүнсний улирлын нөөцийн хувьд бүрдүүлэх ажил огт хийгдэхгүй байгаа бөгөөд хувийн хэвшлийн агуулахын үлдэгдлээр өнөөдөр тооцож байна.

Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.-д “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 314 дүгээр тогтоолоор Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай журмыг шинэчлэн баталсан. Энэ журамд Засгийн газраас улирлын нөөцийг нь бүрдүүлэх шаардлагатай стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч Хүнсний тухай хуульд хүнсний сүлжээнээс **хүнсний тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаатай** холбоотой харилцаа орхигдсон. Энэ нь хүнсний хангамж, нөөц бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд шууд хамааралтай юм. Иймд хүнсний сүлжээн дэх зохицуулалтгүй үлдсэн харилцааг тодорхой хэмжээгээр хуулиар зохицуулах шаардлагатай байна. Иймд энэ заалтын хүрээнд дээрх зохицуулагдаагүй үйл ажиллагааг журамд тусгах нь зүйтэй гэж дүгнэсэн.

Улсын хэмжээнд хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2024 оны байдлаар тооцож үзвэл, нийслэлийн хэмжээнд жилд 58.3 мянган тонн малын мах, 19.4 мянган тонн шувууны мах, 77.7 мянган тонн сүү, 87.5 мянган тонн

сүүн бүтээгдэхүүн, 48.6 мянган тонн гурил, 87.5 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 24.3 тонн будаа, 58.3 мянган тонн төмс, 126.3 мянган тонн хүнсний ногоо, 97.2 мянган тонн жимс, жимсгэнэ, 9.7 мянган тонн өндөг, 11.2 мянган тонн ургамлын тос, 4.8 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна.

Хүнсний тухай хуулийн 6.3-6.4. дэх заалтад “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу нийслэл, аймаг орон нутаг өөрийн хамаарах хүрээнд хангамж, улирлын нөөцөө тодорхойлж байна.

Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн хүн амын хаврын улирлын махны нөөц бүрдүүлэх, худалдан борлуулах асуудлыг 2023 оны нийслэлийн Засаг дарга хариуцан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу махны нөөц бүрдүүлэх арга хэмжээг арилжааны банкны эх үүсвэрээр, зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх замаар зохион байгуулан ажиллаж байна. 2022-2023 онд улирлын нөөц бүрдүүлэх хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож 7858 тонн мах бэлтгэж, 5363.9 тонн мах борлуулсан, 2023-2024 онд 6198 тонн мах бэлтгэн, 6050.4 тонн мах борлуулсан, 2024-2025 онд 6000 тонн мах бэлтгэж, худалдаанд гаргаад борлуулалт хийгдэж байна.

Нийслэлийн хэмжээнд хүнсний болон бусад хүнс, хөдөө аж ахуйн холбогдолтой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хангамж хариуцсан чиг үүргийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газарт Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс, Газар тариалан, Мал аж ахуйн хэлтэс, хүнсний зах, худалдааны төв, агуулах, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн асуудал хариуцсан чиг үүргийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний газар, хүнсний аюулгүй байдлыг хангуулах хяналтын чиг үүргийг Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтэс, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хяналтыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар, хүнсний эрүүл ахуйн хяналтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар хариуцан ажиллаж байна. Мөн Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын тамгын газарт Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд мал төхөөрөх 43 үйлдвэр бүртгэлтэй байгаа бөгөөд жилд дунджаар 112.3 мян.тн мах боловсруулах хүчин чадалтай боловч хүчин чадлынхаа 17-18 хувийг ашиглаж байна. Нийслэлийн жишсэн хүн амын малын махны хэрэгцээ жилд 58.3 мянган тонн шаардлагатай боловч бодит хэрэглээ 124.9 мян.тн буюу 220.83 хувиар давуулан хэрэглэж байна. Нийслэлийн махны хангамжийн 8 хувийг дотоодын үйлдвэрээс, 92 хувийг орон нутгаас хангаж байна. Дотоодын үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал нь зах зээлд нийлүүлэгдэж байгаа нийт махыг боловсруулах боломжтой боловч түүхий эдийн нийлүүлэлт, эргэлтийн хөрөнгө, улирлын байдал

болон уламжлалт аргаар бэлтгэсэн махыг хэрэглэгчид түлхүү хэрэглэж байгаагаас шалтгаан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байгаа нь хуулийн энэ заалтын хэрэгжилт бүрэн хэрэгжих нөхцөл бүрдээгүй байна гэж үзэж байна.

Нийслэлд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 41 үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж, хүчин чадлынхаа 71 орчим хувийг ашиглаж байна.

Ундны сүүний хангамж 84.27 хувь байгаа бөгөөд нийслэлийн жишсэн хүн амын сүүний хэрэгцээ 77.7 мянган тонн байна. Импортоор нийлүүлэгдэх хувь 0 байгаа боловч хот орчимд хөдөө аж ахуйгаас нийлүүлэгдэж байгаа сүү нь бүрэн хангалттай байж чадахгүй байна.

Нийслэлийн жишсэн хүн амын гурилын жилийн хэрэгцээ 48.6 мянган тонн бөгөөд хангамж 100 хувь хангалттай байна. Нийт 6 үйлдвэр үйл ажиллагаагаа явуулж, нийт хүчин чадлынхаа 73 орчим хувийг ашиглаж байна.

Энэ хуулийн 6.5.-д “Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Засгийн газрын 314 дүгээр тогтоолыг үндэслэн Нийслэлийн засаг даргын 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/1147 дугаар захирамжийг баталсан. Энэ захирамжаар хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй байлгах талаар авах арга хэмжээг тодорхойлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэвч энэ заалтын хэрэгжилт 50 хүрэхгүй хувьтай байна. Учир нь:

Дотоодын үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал нь зах зээлд нийлүүлэгдэж байгаа нийт махыг боловсруулах боломжтой боловч түүхий эдийн нийлүүлэлт, эргэлтийн хөрөнгө, улирлын байдал болон уламжлалт аргаар бэлтгэсэн махыг хэрэглэгчид түлхүү хэрэглэж байгаагаас шалтгаан хүчин чадлаа бүрэн ашиглаж чадахгүй байна.

Ундны сүүний хангамж 84.27 хувь байгаа бөгөөд нийслэлийн жишсэн хүн амын сүүний хэрэгцээ 77.7 мянган тонн байна. Импортоор нийлүүлэгдэх хувь 0 байгаа боловч хот орчимд хөдөө аж ахуйгаас нийлүүлэгдэж байгаа сүү нь бүрэн хангалттай байж чадахгүй байна.

Хүнсний хангамжийн бүрдүүлэлт хангалттай түвшинд байгаа хэдий ч хүнсний хүртээмжийн баталгаат байдлын бодлого, түүний хэрэгжилтэд анхаарал муу хандуулж байгааг 2023 оны Хүн амын хоол тэжээлийн VI судалгааны дүн илтгэж байна.

Хүн амын хүнсний хүртээмжийн бодлогыг тухайн шатны Засаг дарга нар боловсруулж, энэ чиглэлээр цаашид арга хэмжээг авах шаардлагатай байна. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн хүн амын хаврын улирлын махны нөөц бүрдүүлэх, худалдан борлуулах асуудлыг нийслэлийн Засаг дарга хариуцан ажиллаж байна. Тодруулбал, нийслэлийн хүн амын хаврын улирлын махны нөөц бүрдүүлэх

ажлыг зохион байгуулан хийж байна. Харин бусад стратегийн хүнсний улирлын нөөцийн хувьд бүрдүүлэх ажил огт хийгдэхгүй байгаа бөгөөд хувийн хэвшлийн агуулахын үлдэгдлээр өнөөдөр тооцож байна.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.-д тусгагдсан “Хүн амын эмзэг бүлгийг тодорхойлох аргачлал гаргаж, судалгаа хийх, тэдний хүнсний хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг дурьдвал:

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйл “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх” үйлчилгээг Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Аргачлал батлах тухай” 2023 оны А/64,А/04 хамтарсан тушаалын дагуу Өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн зорилтот бүлгийн өрх, иргэнийг сонгон үйлчилгээ, тусламжид хамруулан ажиллаж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн" гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ гэж заасны дагуу Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Дээрх хуульд заасан өрхийн гишүүнийг бүртгэн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамруулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2021 оны А/103 дугаар тушаалаар нийслэлд 292,5 ба түүнээс доош, аймагт 310,0 бүхий босго онооноос доогуур нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны байдлаар тус үйлчилгээнд 17,054 өрхийн 46,301 насанд хүрсэн иргэн, 43,810 хүүхэд хамрагдаж 13,5 тэрбум төгрөгийг олгосон. НӨАТ-ын баримт олгодог кассын систем хөгжүүлэлт хийсэн зах, худалдааны төв, хүнсний дэлгүүрүүдээр дамжуулан 10 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

“Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-ыг журмыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулснаар хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулж байна. Хуульд нэмэлт оруулсан дээрх заалтыг хасах саналтай байна. Харин **Хүнсний тухай хуулийн 6.7-6.8 дахь заалтыг хэвээр** үлдээн хэрэгжилтийг хангах хүрээнд Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олголтыг цахимжуулах замаар зохицуулж болно гэж дүгнэж байна.

Хамгийн эхэнд хүнсний экспорт, импортын зөвшөөрөл олгохыг цахимжуулж цахимд оруулсан ААН-ийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай байна. Тухайлбал махны экспортын зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ХХААХҮЯ дунд нь хяналт хийх замаар ААН-ийн бүртгэлийг нээлттэй байлгахгүй, зах зээлийн өрсөлдөөний журмаар ААН-үүд мэдээллээ харилцан солилцох нөхцөл бүрдэхгүй, хяналт тавих боломжгүй байгаа нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд саад учруулж байна гэж дүгнэлээ. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр аж ахуйн нэгжид экспортын зөвшөөрөл олгож байгааг халж, зах зээлийн журмаар техникийн зохицуулалтад нийцсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ижил үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудын мэдээллийг цахимжуулах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид ААНБ-ын мэдээлэл нээлттэй байх ёстой.

Энэ хуулийн 6.9.-д “зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулна” гэж заасан боловч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгохдоо тэмдэгтийн хураамж авах тухай зохицуулалт тусгагдаагүй байна.

Хүнсний тухай хуулийн 6.10-д заасны дагуу хүнсний улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг “Улсын нөөцийн тухай” хуулиар Засгийн газар, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга зохицуулалтыг хариуцан ажиллаж байна. Гэвч улсын хүнсний нөөцийн бүрдүүлэлтэд тавих хяналт сул, улсын нөөцийн агуулах, зоорины нөхцөл байдал стандартын шаардлагыг бүрэн хангадаггүй. Цаашид стандартын шаардлагыг хангасан улсын нөөцийн агуулах, зоорины бэлэн байдлыг хангах шаардлагатай гэж дүгнээд **хэрэгжилт 50 хувьтай үнэлэгдлээ.**

Хүнсний хангамжийг тогтвортой байлгах зорилгоор Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг томоохон хүнсний үйлдвэр, хүнсний зах, худалдааны төв, хүнсний дэлгүүр, сүлжээ дэлгүүр, импортын агуулах нийт 376 аж ахуйн нэгжээс гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний болон түүхий эдийн нөөцийн судалгааг долоо хоног бүр авч, ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажиллаж байна.

2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар нийслэлд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн малын махны 36 хоногийн, гурилын 169 хоногийн, төрөл бүрийн будааны 262 хоногийн, хуурай сүүний 48 хоногийн, өндөгний 5 хоногийн, ургамлын тосны 55 хоногийн, төмсний 90 хоногийн, хүнсний ногооны 23 хоногийн, элсэн чихрийн 369 хоногийн, давсны 60 хоногийн, савласан цэвэр ус, гурилан бүтээгдэхүүний тус бүр 1 хоногийн нөөцтэй тус тус байна.

Нийслэлийн “Хүнсээр хангах алба” нь нийслэлийн хэмжээнд тохиолдож болзошгүй байгалийн гамшиг, газар хөдлөлт, аюулт үзэгдэл болон техникийн

холбогдолтой ослын үед голомтод ажиллаж байгаа шуурхай бүлэг, аврагчид, нэрвэгдэгсдийг хоол хүнсээр хангах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд зохион байгуулах болон гүйцэтгэх үед гарах харилцааг зохицуулах зорилгоор “Болзошгүй гамшгийн үед хүнсний бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ”-г 2 жилийн хугацаатай байгуулан, сунгалтыг хийн ажиллаж байна.

Хуулийн 6.12-д тусгагдсан Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 3.1.9-д зааснаас бусад зориулалтын бүтээгдэхүүнийг хандав тусламжаар авахыг хориглоно гэсэн заалтын хэрэгжилтийн хүрээнд хууль батлагдаж, хэрэгжсэнээс хойших хугацаанд ямар нэг арга хэмжээг зохион байгуулаагүй тул үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

Гэхдээ тав хүртэлх насны хүүхэдтэй нийт өрхийн 75.2 хувь ХББ хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай, 18.9 хувь ХББ дунд зэрэг алдагдсан, 2.7 хувь ХББ хүнд буюу ноцтой алдагдсан байгааг энэхүү судалгаагаар тогтоосон. Хүн амын хоол тэжээл, өрхийн ХББ-ын үзүүлэлтүүд бүс нутгийн түвшинд ихээхэн ялгаатай байгааг судалгаагаар тогтоосон бөгөөд хамгийн муу үзүүлэлт Хангай, Баруун бүс, Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхөд илэрсэн болно. Хүнсний хомсдолын үед эмзэг бүлгийн өрхийн өртөмтгий байдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлдэг болох нь нэгэнт батлагдсан, нийгмийн эмзэг давхаргад чиглэсэн ХББ, хоол тэжээлийн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий нийгмийн хамгааллын хөтөлбөрийг (жиш: хүнсний талон) цаашид шинэчлэн сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, ялангуяа 5 хүртэлх насны хүүхэдтэй ядуу өрхийг хамруулахад онцгой анхаарах шаардлагатай байна. Монгол улсад элбэг тохиолддог улирлын чанартай хүнсний хомсдол, байгалийн гамшигт үзэгдлийн үед эмзэг бүлгийн хүн амыг хамгаалахад энэ төрлийн нийгмийн хамгааллын арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй болно.

Хяналт шалгалтаар улсын хэмжээнд “Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас” хяналтын хуудсаар “бага” эрсдэлтэй дүгнэгдсэн 24 газарт дүгнэлт гаргасан байна. (цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд 10, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлд 14 дүгнэлт) их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3 газарт шаардлага хангаагүй дүгнэлт гарсан байна.

- **Хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнс**

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 14.1-д Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална гэж заасны дагуу “Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, бүртгэх журам”-ыг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй,

хөнгөн үйлдвэрийн сайд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2020 оны А/602/А/393/А/689 дугаар тушаалаар баталсан байна.

Харин энэ хуулийн 7.2.-д заасны дагуу ХХААХҮЯ-нд хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэж эхэлсэн боловч зах зээл дээр байгаа нийт хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг бүртгэж хараахан чадахгүй байна. Хуулийн энэ заалтын хэрэгжилт 50 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүнсний тухай хуулийн 7.3.-д "Хувиргасан амьд организмаас гаралтай импортын хүнсний талаар хүнсний хяналтыг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага /цаашид "хяналтын байгууллага" гэх/ болон биоаюулгүй байдлын асуудал эрхэлсэн байгууллага цахим хэлбэрээр нийтэд мэдээлнэ" гэж тусгагдсан заалтын хэрэгжилт хангалтгүй буюу зогсонги байдалтай байна. Учир нь МХЕГ-ын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ХХААХҮЯ-ны харьяа салбарын хяналтын газар шилжсэнтэй холбоотойгоор энэ чиг үүргийн хяналт, бүртгэлийн ажил орхигдсон байна. Энэ заалтын хүрээнд салбарын хяналтын газрын ХХААХҮЯ-нд шилжүүлснээс хойш энэ чиглэлийн хяналтын үйл ажиллагааг явуулаагүй тул холбогдох мэдээлэл байхгүй болно.

Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.-д заасан "Гадаадын зээл, тусламжаар хувиргасан амьд организмаас гаралтай хүнс авахыг хориглоно" гэсэн заалт хэрэгжих нөхцөл хууль батлагдаж, хэрэгжсэнээс хойших хугацаанд бүрдээгүй байна. Энэ чиглэлээр ямар нэг арга хэмжээг зохион байгуулаагүй тул үнэлгээнд оруулж тооцоогүй болно.

- **Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал**

2023 оноос өмнөх хугацаанд Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу ХХААХҮЯ-наас буудайн урамшуулал, мах бэлтгэх, нөөцлөх арга хэмжээг Засгийн газрын тогтоол, холбогдох тэмдэглэлийн хүрээнд зохион байгуулдаг. Тухайлбал, стратегийн хүнсний үйлдвэрлэлд урамшуулал олгох ажлын хүрээнд хүн амын өвөл, хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан мах бэлтгэх, нөөцлөх арга хэмжээнд 2013-2018 онд нийт 40.42 тэрбум, үүнээс 2013 онд 11.39, 2014 онд 9.5, 2016 онд 14.49, 2017 онд 2.73, 2018 онд 2.29 тэрбум төгрөгийг зарцуулж байсан. Харин улаан буудайн урамшуулалд 2013-2019 онд нийт 104.3 тэрбум төгрөг, үүнээс 2013 онд 12.98, 2014 онд 25.29, 2015 онд 24.72, 2016 онд 5.59, 2017 онд 14.96, 2018 онд 7.8, 2019 онд 12.93 тэрбум төгрөг зарцуулсан байсан байна. Үйл ажиллагааг нь дэмжих, урамшуулал олгох хүрээнд 2012 оноос ХХААХҮЯ-аас аж ахуй нэгжүүдийг арилжааны банкны зээлийн хүүгийн хөнгөлөлтөд мөн хамруулж байсан боловч эдгээр дэмжлэг, урамшуулал нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд дорвитой дэмжлэг болж чадаагүй юм.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А-33 дугаар тушаалаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний импортын хүнсний жагсаалт болон дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний импортын хүнсийг тодорхойлох аргачлалыг тус тус баталсан боловч аргачлалыг Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-37 тоот тушаалаар цуцалсан байна. Харин жагсаалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Цаашид аргачлалыг дахин батлах шаардлагатай гэж үзэж байна.

Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох талаар холбогдох журмын төслийг 2013 онд боловсруулж Засгийн газарт хүргүүлсэн ч тухайн үед дэмжлэг авч чадаагүй юм.

Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд улаан буудайн урамшуулал олгох, үр, шатахуун, бордооны дэмжлэг үзүүлдэг боловч хураан авсан ургацад мөнгөн урамшуулал олгодоггүй байсан байна.

Засгийн газрын 2017 оны 223, 268 дугаар тогтоолоор баталсан “Жимс жимсгэнэ, “Хүнсний ногоо “үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд төмс, хүнсний ногооны үр, жимс жимсгэнийн суулгацыг тариалан эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгон дэмжиж байсан. Мөн татвар, тарифын бодлогоор дэмжиж дотоодод ургуулсан хүнсний ногоог НӨАТ-аас чөлөөлж, орлогын албан татвараас 50 хувь хөнгөлөх, хүлэмжийн тоног төхөөрөмжийн импортыг НӨАТ-аас чөлөөлөх, хүнсний ногооны импортын татварыг 5-аас 20 хувь болгож нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлж байсан байна.

Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд оройн 22:00 цагаас өглөөний 6:00 цагийн хооронд өвлийн хүлэмжийн цахилгааны хэрэглээний дээд хязгаарыг 1 м2 талбай тутамд 0.768 квт/цагаар тооцон урамшуулж, төлбөрөөс 100 хувь чөлөөлөх зохицуулалтыг хэрэгжүүлж байсан. Түүнчлэн мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно гэсэн хуулийн заалтыг зохицуулах журам гараагүй тул урамшуулал олгодоггүй байсан.

Урамшууллын талаар ХХААХҮЯ хариуцан ажиллаж байна. Хүнсний ногооны 10 төрөлд нэг тонн тутамд 100 мянган төгрөгийн урамшууллыг олгож байгаа. plant.mofa.gov.mn бүртгэлтэй иргэн аж ахуйн нэгж худалдан борлуулсан е-баримтаа баталгаажуулж авдаг. Үүнд нийслэлийн харьяа иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол, 2023 оны 363 дугаар тогтоолоор "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын

шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан. Тус журмын хэрэгжилтийг хангуулахад дийлэнх оролцоо Төрийн захиргааны төв байгууллагат төвлөрч, орон нутгийн байгууллага нь сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт орох байдлаар хязгаарлагдаж байгаа нь оролцоо маш бага байна. Тус журмын дагуу нийслэлийн хэмжээнд 2022-2023 онд нийт 1663 фермер эрхлэгч, 4.1 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж 2 тэрбум 77 сая төгрөг, 2023-2024 онд нийт 569 иргэн, аж ахуйн нэгж, 5.8 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж 5.8 тэрбум төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна.

Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагааны бүх чиглэлийг дэмжих зорилгын хүрээнд хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах дунд хугацааны бодлогыг 2022 онд УИХ-аас 36 дугаар тогтоолоор баталсан байна. Энэ хүрээнд дараах зорилт, арга хэмжээг тогтоол, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусган холбогдох төрийн байгууллагын зүгээс 2023 оноос эхлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрийг дэмжих зээлд нийт 889 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид, 1067 иргэн хамрагдсан байна. 2023 оны байдлаар нийт 832.7 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийг дэмжих зээл олгосноос эргэлтийн хөрөнгийн зээлд 408 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зээлд 424.7 тэрбум төгрөг байна. Үүнээс хүнсний үйлдвэрт 561.7 тэрбум төгрөг, газар тариалангийн үйлдвэрлэлд 216.8 тэрбум төгрөг, мал аж ахуйн салбарт 54.2 тэрбум төгрөг олгогдсон байна.

2024 оны 7 дугаар сарын 31-ны байдлаар хүнс болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл болон хөрөнгө оруулалтын зээлийн талаарх тоон мэдээллийг дараах хүснэгтүүдээс харж болно.

4 дүгээр хүснэгт. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн мэдээ /2024.07.31/

	Эх үүсвэр	Олгосон		Батлагдсан		Судалж буй		Эх үүсвэр ашиглалт
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	
Эргэлтийн хөрөнгийн зээл	200.0	166.91	939	184.96	946	39.6	138	92.5%
Газар тариалан								
Газар тариалангийн үйлдвэрлэл	80.0	87.57	481	89.73	482	17.4	73	112.2%
Хүнсний ногооны үйлдвэрлэл	26.0	20.04	400	20.67	400	3.3	31	79.5%
Хүнсний үйлдвэрлэл								
Хүнсний боловсруулах үйлдвэр эргэлтийн хөрөнгө	91.5	57.79	53	73.05	59	16.7	29	79.8%
Мал аж ахуйн үйлдвэрлэл								
Тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авах	1.5	1.32	5	1.32	5	2.2	5	100.0%
Зөгийн балны импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх	1.0	-	-	-	-	-	-	0.0%

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

	Эх үүсвэр	Олгосон		Батлагдсан		Судалж буй		Эх үүсвэр ашиглалт
		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	
Хөрөнгө оруулалтын зээл	309.3	141.63	187	190.26	195	78.1	79	61.5%
Газар тариалан								
Анхан шатны үр үржүүлгийн төв, үтрэм байгуулахыг дэмжих	8.0	5.34	11	5.34	11	1.2	2	66.8%
Хүлэмжийн аж ахуй байгуулах	7.0	1.22	3	1.22	3	5.9	8	17.5%
Зоогийн аж ахуй байгуулах	24.8	20.18	22	24.76	26	18.8	18	99.8%
Хүнсний болон хүнсний зориулалтын сав, баглаа боодлын үйлдвэрлэл								
Ногоо, жимс, жимсгэнийн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	6.0	3.25	2	3.25	2	2.0	1	54.2%
Хүүхдийн сүү, сүүн тэжээл боловсруулах үйлдвэр байгуулах	11.0	4.33	4	13.44	5	0.1	1	122.2%
Хүүхдэд зориулсан бэлэн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах	18.0	10.15	7	15.74	8	2.4	3	87.4%
Орон нутгт сургууль, цэцэрлэгийн хүүхдэд зориулан хүнсний үйлдвэр байгуулах	9.0	10.61	11	10.68	11	0.3	1	118.7%
Хүнсний давс боловсруулах	2.0	-	-	-	-	0.2	2	0.0%
Хүнс, газар тариалангийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	98.5	44.56	101	67.96	102	23.8	27	69.0%
Мал аж ахуйн үйлдвэрлэл								
Тахианы аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	35.0	19.42	6	24.97	6	3.0	1.0	71.3%
Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	60.0	6.19	7	6.54	8	0.8	2.0	0.0%
Махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын зээл	25.0	7.55	8	7.55	8	14.7	12.0	0.0%
Мал, амьтны гоц халдварт өвчний эсрэг вакцин, бэлдмэлийн дэвшилтэт үйлдвэрлэлийг нэвтрүүлэх	5.0	-	-	-	-	5.0	1.0	0.0%

Хүүгийн дэмжлэгт 26.4 тэрбум төгрөг, бордоо, техникийн дэмжлэгт 6.8 тэрбум төгрөгийг тус тус зориулсан байна.

УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл олголтын үр дүнд 12227 ажлын байр нэмэгдэж, 1155 шинэ ажлын байр бий болсон нь бодит эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

Хүнсний тухай хуулийн 8.1.1.-д “Стратегийн хүнсний үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлнэ” гэж заасны дагуу УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 2024 онд нийт 400.5 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр батлагдаж, үүнээс 377.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Үүнээс: Газар тариалангийн чиглэлээр 936 иргэн, аж ахуйн нэгжид 148.0 тэрбум төгрөг, Мал аж ахуйн чиглэлээр 25 иргэн, аж ахуйн нэгжид 45.0 тэрбум төгрөг, Хүнсний боловсруулах болон сав баглаа боодлын үйлдвэрлэлийн чиглэлээр 204 аж ахуйн нэгжид 183.0 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 5-6 хувийн хүүтэй 24-60 сарын хугацаатай зээл олгох гэрээг 10 банкттай байгуулсан. Махны үхрийн аж ахуй эрхэлж буй 5 компани 6.74, тахианы аж ахуй эрхэлж буй 6 компани 24.97 нийт 31,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг авсан. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд 5117 хоршооны 18195 малчинд 616.3 тэрбум төгрөгийн зээл олгосон. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2024 онд усалгаатай тариалангийн талбайн хэмжээ 68.0 мянган га талбайд үргэсэн байна.

Энэ хуулийн 8.1.2.-д заасны дагуу дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний импортод урамшуулал, дэмжлэг олгогдоогүй тул хэрэгжилт огт хэрэгжээгүй гэж үнэллээ.

Энэ хуулийн 8.1.3. дахь заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар "тэжээл болон органик хүнсний" гэснийг "тэжээлийн" гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./ гэж өөрчлөлт орсон тул хэрэгжилт гарахгүй болно.

Харин Хүнсний тухай хуулийн 8.1.4.-д заасан хүний бие махбодыг бүхэлд нь, эсхүл тодорхой эрхтний үйл ажиллагааг дэмжих шаардлагатай бодис, илчлэгийг нөхөх үйлчилгээ бүхий биологийн идэвхт бодис, баяжуулсан, ашигтай бичил биетэн агуулсан зохицуулах үйлчилгээтэй хүнсний үйлдвэрлэлд төрийн дэмжлэг, урамшуулал олгогдоогүй буюу энэ заалт огт хэрэгжээгүй болно.

Үүний үр дагавар нь манай улсын хүн ам хоол, хүнснээс хоногт авах ёстой шимт бодисоо авч чадахгүй, зөвхөн нүүрс усны хэрэглээ өндөр болсон, хүн амын дунд хүнсний зөв, зохистой хэрэглээ төлөвшөөгүй, амьдралынхаа туршид буруу, эрүүл бус, зохисгүй хооллосны уршгаар өнөөдөр хүн амын элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд тэргүүлэх болсон.

Хүнсний тухай хуулийн 8.1.5.-д “үйл ажиллагаандаа зохистой дадал, энэ хуулийн 10.2.1-д заасан хяналтыг нэвтрүүлсэн” бол төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлж болно гэж заасан боловч улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг нэвтрүүлж, түүнийг баталгаажуулсан нэг л ААН байгаа нь маш хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх баталгаажуулалтын тогтолцоо байхгүй байгаа тул энэ заалтын хүрээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж урамшуулалд хамруулаагүй байна. Иймд хэрэгжилт огт биелээгүй болно. Энэ тогтолцоог бүрдүүлэх гэж салбарын яамнаас ямар ч арга хэмжээ аваагүй байна.

Хүнсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал байдаг. Тэгвэл манай улсын хувьд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Өнөөдрийн байдлаар хүнсний салбарт нийт 200 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй, зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулдаг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тоо улсын хэмжээнд зөвхөн нэг байгаа зэрэг тоон үзүүлэлтүүд нь хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл, шалтгаан болж байгааг илтгэж байна.

Мөн хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг илэрхийлдэг гол үзүүлэлт бол хүнсний аюулгүйн үзүүлэлтүүд байдаг. Тэгвэл монгол улс хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн шинжилж чадахгүй байгааг онцгойлон анхаарч хүнсний хяналтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх үүний хажуугаар хүний нөөцийн бодлогоор эдгээр асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Мөн “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь **энэ хуулийн 8.1.7-д заасан** дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал олгохоор заасан заалттай давхцаж байна. Иймд УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж байгаа. Гэхдээ хангалтай хэмжээнд дэмжлэг аваагүй байна.

Энэ хуулийн 8.2-д “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд олгох урамшуулалтай холбогдсон харилцааг Тариалангийн тухай хуулиар зохицуулна” гэж заасан. Мөн тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд урамшууллыг УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд газар тариалангийн чиглэлээр 936 иргэн, аж ахуйн нэгжид 148.0 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг олгосон. Нийт 12,9 тэрбум төгрөгөөр 2606 ширхэг хүлэмжийг худалдан авч, зуны хүлэмжийн тариалалтыг 12,4 га, өвлийн хүлэмжийн тариалалтыг 0,3 га талбайгаар нэмэгдүүлсэн байна Хүнсний салбарт төрөөс хамгийн дэмжлэг, урамшуулалд хамрагдаж түүний үр шимээр үйл ажиллагаа нь тэлж байгаа салбар бол газар тариалангийн салбар боловч хүнсний шим тэжээлийг зохистой байдлаар хадгалах бодлого хүнсний хангамжийн бодлоготой огт уялдахгүй байна.

Хүнсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн бол хүнсний хэрэглээ ба шимт байдал юм. Хоол, хүнсний зохисгүй хэрэглээнээс үүдэн хүн амын дунд амин дэм, эрдэс бодисын дутал өндөр, таргалалт, илүүдэл жин ихтэй, улмаар шимт бодисын давхар дарамтад өртсөн зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байгаа. Иргэд зөвхөн үр тарианы гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг сонголтгүйгээр хэрэглэх бодлогыг салбарын яамнаас Атрын I-IV аян зохион байгуулах хүртлээ явж иржээ. Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүдэд гурил, гурилан бүтээгдэхүүнээс гадна хүнсний 14 нэр төрлийн бүтээгдэхүүн байдаг. Хүнсний нэр төрлийг олон болгох, түүнийг зохистой хэрэглээнд оруулах шим тэжээлийг зохистой байдлаар хадгалах бодлого хүнсний хангамжийн бодлоготой огт уялдахгүй байна гэж дүгнэлээ. Иймд хүнсний хангамжийн бодлогоо дээр дурдсан 16 нэр төрлөөр төлөвлөж хэрэгжүүлэхийг анхаарах хэрэгтэй байна.

Хот, хөдөөгийн өрхийн хүнсний хэрэглээнд хоногийн нийт илчлэгийн хэрэглээний 74.5-83.2 хувийг “үр тариа”, “мах”, “сүүн” бүтээгдэхүүн эзэлж байна. Үүнээс үр тарианы бүлгийн бүтээгдэхүүн хоногийн илчлэгийн дийлэнх буюу 55-57 хувийг хангаж байна. Энэ байдлаар маш олон жил манай хүн амын хүнсний хэрэглээний бодлого хэрэгжсэн одоог хүртэл хэрэгжиж байгаа тул хүн амын дунд эрдэс, амин дэмийн дутал өндөр, нөгөө талаас таргалалт илүүдэл жингийн харьцаа өндөр байна. Энэ 2 үзүүлэлт өнөөдөр зэрэгцэн оршиж байгаа монголын хүн амд хоол тэжээлийн давхар дарамт учирсныг илтгэж байна. Иймд салбарын яамны зүгээс зөвхөн газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмждэг бодлогоо хязгаарлаж, улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах гэсэн үндсэн суурь бодлоготойгоо

нийцүүлэх шаардлагатай байгааг анхаарах хэрэгтэй байна. Эндээс харахад салбарын яаманд мэргэжлийн удирдлага алдагдсан байна гэж үзэж болохоор байна.

Ийм ч учраас хүнсний салбарын бодлого төлөвлөлт нь нэгдмэл, цогц байдлаар тодорхойлогдоогүй, уян хатан байж чадаагүй, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь харилцан уялдаа холбоогүй, мэдээллийн нэг урсгалгүйгээс үл ойлголцол, цаг алдах байдал их гардаг, төрийн залгамж халаа тодорхой хэмжээнд алдагдсан, бодлогын хэрэгжилтэд бүх талын оролцоог хангаагүй зэрэг бодлогын үндсэн зарчмуудыг баримтлаагүйтэй холбоотойгоор тайлбарлаж байна.

Хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа удаан хугацаандаа хангагдаагүйгээс үүдэн хүн амын дунд халдварт бус өвчлөл буурахгүй байгаа, цаашлаад монгол улс хорт хавдрын өвчлөл, нас баралтаар дэлхийд дээгүүрт орж байна. ялангуяа элэг, ходоодны хорт хавдрын өвчлөл, нас баралтын эрэмбээр 1 дүгээрт орж байгааг анхааран хүнсний хангамжийн бодлогыг хүнсний баталгаат байдал, шим тэжээлийг зохистой хадгалах болон хүнсний хэрэглээ, тэр дундаа хүн амыг хоол хүнсээ зөв сонгох, хэрэглэх, уламжлалт хоол хүнсний соёл дадлыг сурталчлах, салбарын хүний нөөцийн бодлоготой уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг нийцүүлэн хангахад анхаарах хэрэгтэй байна.

Хүнсний тухай хуулийн 8.3.-д “Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно” гэж заасан.

Энэ хүрээнд МУ-ын Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол, 2023 оны 363 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам” батлагдсан. Тус журмын хэрэгжилтийг хангуулахад дийлэнх оролцоо Төрийн захиргааны төв байгууллагат төвлөрч, орон нутгийн байгууллага нь сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт орох байдлаар хязгаарлагдаж байгаа нь оролцоо маш бага байна. Мөн нийслэлийн хэмжээнд 2022-2023 онд нийт 1663 фермер эрхлэгч, 4.1 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж 2 тэрбум 77 сая төгрөг, 2023-2024 онд нийт 569 иргэн, аж ахуйн нэгж, 5.8 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж 5.8 тэрбум төгрөгийн урамшуулалд хамрагдсан байна.

Хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтолцоо бүрэн бүрдээгүйтэй холбон тайлбарлаж байна. Тодруулбал, дотоодод тариалсан улаанбуудай, төмс, хүнсний ногоо, мах, сүү зэрэг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүнсний сүлжээгээр өөр хоорондоо шилждэг технологийн хувьд харилцан хамааралтай үйл явцад тухайн ААН-ийн үйлдвэрлэж, эсвэл тариалж, эсвэл маллаж байгаа хүнс, хөдөө аж ахуйн түүхий эдийн чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байдал их чухал үүрэгтэй юм. Тэгэхээр өмнөх бүлгүүдэд дурдсан өнөөх л

бүртгэл мэдээллийн, хяналтын, мэргэжлийн удирдлагын тогтолцооны асуудал тулгарч байна. Иймд энэ заалтын хэрэгжилт хангалттай байж чадахгүй байна.

Энэ хуулийн 8.4.-д “өргөн хэрэглээний хүнсний жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн боловч өнөөдрийн хүртэл импортын өргөн хэрэглээний хүнсний жагсаалтыг гаргаагүй тул энэ заалт огт хэрэгжээгүй гэж дүгнэлээ. Яам газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих бодлогоос өөр бусад хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлээгүй 13 жил болсон байна гэж үзэхээр байна.

Хүнсний тухай хуулийн 8.5.-д “хуульд заасан зарим хүнсний үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг, урамшууллын хэлбэр, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн №130 дугаар тогтоолоор Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам батлагдсан байна. Хуулийн энэ заалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн мэдээлэл салбарын яамнаас ирүүлээгүй байна.

• **Хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйл. Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах**

Хүнсний нийлүүлэлт, хэрэглээний дансыг байгуулж, нэг хүнд хоногт ногдох хүнсний илчлэгийг тооцоолоход 2023 онд **2936 килокалори** байна. 2014-2019 оны хооронд манай улсын нэг хүний хоногт авсан дундаж илчлэг дэлхийн дунджаас бага байсан бол 2020 оноос хойш дэлхийн дундажтай ойролцоо байна. Хоногийн дундаж илчлэгийн 60.5 хувь нь ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 39.5 хувь нь амьтны гаралтай бүтээгдэхүүнээс бүрдэж байна.


2 дугаар зураг. Нэг хүнд хоногт ногдох илчлэг, килокалориар



Нэг хүний өдөрт хүртэж буй илчлэгийг ургамлын гаралтай бүтээгдэхүүний төрлөөр задлан харахад, үр тарианы гаралтай бүтээгдэхүүнээс 982 ккал, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүнээс 280 ккал, ургамлын тосны бүтээгдэхүүнээс 185 ккал, хүнсний

ногооноос 71 ккал, төмс, цардуулын гаралтай бүтээгдэхүүнээс 67 ккал илчлэг хүртэж байна. Харин малын гаралтай бүтээгдэхүүний хувьд өдөрт нэг хүн дунджаар махнаас 788 ккал, өөх тосноос 180 ккал, сүү сүүн бүтээгдэхүүнээс 157 ккал, өндөгнөөс 25 ккал, дотор мах, дайвар бүтээгдэхүүнээс 10 ккал тус тус хэрэглэж байна.

3 дугаар зураг. Нэг хүнд хоногт ногдох илчлэг, бүтээгдэхүүнээр, килокалориар



Улсын дунджаар нэг хүнд хоногт ногдох өөх тосны хэмжээ 2023 онд 132 грамм байгаагаас 30 хувийг нь ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 70 хувийг нь малын гаралтай бүтээгдэхүүний өөх тос бүрдүүлж байна. Нэг хүнд хоногт ногдох өөх тосны хэмжээ дэлхийн дундаж 2022 онд 87 грамм байсантай харьцуулахад манай улсын дундаж 52 хувиар их хэрэглээтэй байна.

Харин нэг хүнд хоногт ногдох уургийн хэмжээ 2023 онд 97 грамм байгаагаас 34 хувийг нь ургамлын гаралтай бүтээгдэхүүн, 66 хувийг нь малын гаралтай бүтээгдэхүүний уураг бүрдүүлж байна. Дэлхийн дундажтай харьцуулахад нэг хүнд хоногт ногдох уургийн хэмжээ 5 хувиар их байна.

Хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах заалтын хэрэгжилтийн хүрээнд хүн амын хоол тэжээлийн үндэсний хэмжээний судалгааг таван жил тутамд гаргаж, дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх; дээрх судалгаанд үндэслэн хүн амын зохистой хооллолт болон эрүүл хүнсний талаар зөвлөмж гаргаж, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах заалтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

Энэ хуулийн 9.1.1.-д заасны дагуу Монгол Улсад 1992, 1999, 2004, 2010, 2016, 2023 онуудад Хүн амын хоол тэжээлийн үндэсний 6 удаагийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Гэвч эдгээр бүх судалгаанууд хуульд заасан хугацаандаа хийгдэж

чадаагүй нь судалгааг явуулах төсөв санхүүгийн хүндрэл бэрхшээл учирдагтай холбоотой. Судалгааны арга зүйн хувьд өөрчлөлт орсон тул судалгааны дүнг өөр хооронд нь харьцуулах боломжгүй юм.

Цаашид дээр дурдсан судалгаанаас гадна Монгол Улсын хүнсний хангамж, хүн амын бодит хэрэглээ, хүнсний баталгаат байдлын судалгаа, хүнсний найрлагын судалгаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн байдал, хүнсэн дэх тэсвэржсэн бичил биетний нөлөөлөл зэрэг **судалгаануудын санхүүжилтийг төсөвт суулгах**, мөн хуульд заасан хугацаанд нь хүнсний эрдэм шинжилгээ судалгааны байгууллагад захиалан өгч, судалгааны ажлыг гүйцэтгүүлдэг болох хэрэгтэй.

“Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V дугаар судалгааг 2016-2017 онд нийслэлийн 8 дүүрэг, 21 аймгийн 94 сумын сургуулийн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, өрхийн нийт 9554 хүн амыг хамруулан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хийж гүйцэтгэсэн. Судалгаанд хамрагдан өрхийн аж байдал, уураг илчлэг дутагдал, эх хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдийн бичил тэжээлийн хэрэглээ, төмөр дутлын цус багадалт, иод дутал, тураал, таргалалт, давсны хэрэглээ, А болон Д амин дутал, хүнсний буруу хэрэглээ зэргээр нарийвчлан гаргасан байна.

2017 онд хийгдсэн “Хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний V судалгаа”-ны зарим үр дүнтэй харьцуулан жишиж, ахиц дэвшил, алдаа дутагдлыг илрүүлж, холбогдох дүн шинжилгээ хийв. Өнөөдөр Монгол Улс хоол тэжээлийн дутал болон илүүдлээс үүдэлтэй “хоол тэжээлээс хамааралт эмгэг”-ийн гурван давхар дарамттай тулгарсан хэвээр байна.

Судалгааны дүнгээс харахад хүн амын дундах халдварт бус өвчлөл, хүн амын амин дэм, эрдсийн дутлын хэмжээ болон таргалалт, илүүдэл жингийн хувь хэмжээнд нөлөөлсөн эерэг өөрчлөлт бодитоор харагдахгүй байна. Энэ нь хүн амын эрүүл мэндийг дэмжих бодлого, үүн дотроо хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын зорилго, зорилтууд мөн бодлогын хэрэгжилт, түүний хяналтын үйл явц хангалтгүй явагдсантай холбоотойгоор хувь хүний эрүүл мэндэд учирч буй сөрөг үр дагаврууд бий болсоор байна гэж үзэж байна.

“Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI дугаар судалгааны аргачлалыг шинэчлэн баталж, аргачлалын дагуу судалгааг 2023-2024 онд зохион байгуулж хийсэн байна. Энэ VI судалгааны үндсэн ач холбогдол нь хоол тэжээлийн бүхий л үзүүлэлтийг бүс нутаг, хүн амын байршил, нас, хүйсээр харьцуулан үнэлж, **хооллолтын чанарт анх удаа үнэлгээ өгсөнд оршино**.

“Монгол улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаагаар хоол тэжээлээс хамааралт эмгэгт өртөмтгий хүн амын бүлэг болох хүүхэд, эмэгтэйчүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдлыг үнэлж, үндэсний болон бүс нутгийн түвшинд төлөөлөх чадвартай тоон үзүүлэлтүүдийг гаргасан болно. Мөн

судалгааны явцад 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн аж байдлын түвшин, ариун цэвэр, усан хангамж, хүнсний баталгаат байдлыг үнэлж, өрхийн гишүүдийн хооллолт, хоол тэжээлийн байдалд хэрхэн нөлөөлж байгааг судалсан юм.

Хуулийн 9.1.2.-д заасны дагуу Эрүүл мэндийн яам болон Боловсролын яамнаас эрүүл зөв хооллох, мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг сүүлийн 10 гаруй жил тасралтгүй зохион байгуулж байгаа боловч хангалттай үр дүнд хүрч чадахгүй байна гэж дүгнэж байна.

Тухайлбал 2019-2020 онд давхардсан тоогоор 21 аймгийн 117,026 иргэдэд 2,068 удаагийн сургалт, сурталчилгаагаар хүргэж, 235 төрлийн 33,213 гарын авлага тараагдсан байна. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдалтай холбоотой 20 орчим инфографик мэдээлэл бэлтгэн олон нийтийн сүлжээгээр, телевизийн 5 сувгаар нэвтрүүлэг болгон, 30 секундийн шторк бэлтгэн түгээж байгаа хэдий ч бодит байдал дээр хэрэглэгчдийн зүгээс хоол хүнсээ зөв сонгож, зохистой хэрэглэх дадал хараахан суугаагүй байна гэж дүгнээд энэ хуулийн заалтын хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн.


БСШУС-ын сайдын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/467 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангид хэрэгжүүлэх эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн агуулгыг нийгмийн хэрэгцээ; орон нутаг, сургуулийн онцлог; суралцагчдад тулгамдаж буй асуудалд суурилан i) хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй, ii) хооллолт ба хөдөлгөөн, iii) сэтгэцийн эрүүл мэнд, iv) хорт зуршил, v) бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, vi) осол гэмтэл гэсэн 6 бүлэг агуулгатай боловсруулсан болно.

Хүүхдийн хоол, хүнсний хангамж, хүртээмж, шим тэжээллэг байдал, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, сайн туршлагыг хуваалцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан талуудын хамтын ажиллагааны олон талт оролцоо, манлайллыг дэмжих зорилготой “Хүүхдийн хоол анхаарах асуудал” уриан дор нэгдсэн “Хүүхдийн хоол” хэлэлцүүлгийг Нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, дүүргийн боловсролын хэлтэс, эрүүл мэндийн газар, хүнс, хөдөө аж ахуйн газар болон сургуулийн захирлууд, цэцэрлэгийн эрхлэгч нар, эцэг эхийн төлөөлөл, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд буюу нийт 70 хүнийг хамруулан зохион байгуулсан байна.

Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд заасан Хяналтын зөвлөл нь анги, хооллох танхимын хооллох нөхцөл, ариун цэврийн шаардлагыг хангаж байгаа эсэх талаар хяналт тавих; батлагдсан хоолны цэсийн дагуу үйлчилгээ үзүүлж байгаа эсэхийг хянах; хооллох соёл, хоолны шим тэжээлийн талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад сургуулийн удирдлагад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

2023/2024 оны хичээлийн жилд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналтын үйл ажиллагааг дараах зургаас харахад маш сайн түвшинд 101 (13 хувь), дунд зэргийн 646 (81 хувь), хангалтгүй 51 (8 хувь) сургуулийн орон тооны бус хяналтын зөвлөл явуулж байгаагаас харахад **цаашид хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах**, гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, үдийн хоолны хяналтыг тогтмол тавьдаг болох **шаардлагатай** гэж үзэж байна.

4 дүгээр зураг. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны түвшин, хувиар



Хувийн өмчийн сургуулиудад хяналтын зөвлөл байгуулж, үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ “Хяналтын алба” шинэ нэгжийг байгуулж, захирлын тушаалаар хянан шалгах тухай удирдамжийг батлуулан, сургуулийн хэмжээнд хүүхдийн үдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт шинжилгээг улирал тутамд явуулдаг сайн жишээ байна. Ихэнх хувийн сургуульд хоолзүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч нар ажилладаг ба хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага дор явуулж байна.

Хяналтын зөвлөлийн төлөөлөл болох эцэг эхийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, сургуультай байгуулсан хамтын ажиллагааг өргөтгөх замаар үдийн хоолны цэс, түүний мөрдөх байдалд хөндлөнгийн хяналтыг тавих, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний журам, хяналтын хуудсыг боловсруулахад оролцох, түүний хэрэгжилтэд мөн хяналт тавих, сургуулийн захирлын тушаалаар баталсан дотоод хяналтын удирдамжаар хичээлийн жилд хамгийн багадаа нэг удаа хяналт шалгалтын хуудасны дагуу сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, тайланг сургуулийн удирдлага болон эцэг эхийн хуралд танилцуулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж чадвал дээрх зохицуулалтын зорилго хангагдаж, эерэг үр дүн гарах боломжтой байна.

Хүнсний тухай хуулийн 9.1.3.-д тусгагдсан “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх” журам батлагдаагүй тул энэ заалт огт хэрэгжээгүй байна. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журам боловсруулах ажлын хэсэг байгуулан, журмын төслийг боловсруулж байгаа боловч

шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс гэдэгт ямар ойлголт орох талаар нэгдсэн ойлголттой болох, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрдэл гэдэгт юуг хамруулах гэсэн асуудлуудыг тодорхой болгох шаардлагатай байна.

Шинэ технологиор үйлдвэрлэсэн буюу Новел фүүд гэсэн ойлголт одоогоор манай үйлдвэрлэгч болон хүнсний салбарын мэргэжилтнүүдэд шинэ ойлголт байна. Түүнчлэн энэ чиглэлээр бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй байна. Бусад орны хүнсний болон эрүүл мэндийн чиглэлээр мэргэжилтнүүдээс авсан зөвлөмжөөр уг журмыг боловсруулан мөрдүүлэх нь манай орны хувьд тулгамдсан асуудал биш бөгөөд эхний ээлжид үйлдвэрлэгч болон мэргэжилтнүүдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хүнсний тухай хуулийн 9.3. дахь заалтад “Хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан боловч 2018 онд зөвхөн “Баяжуулсан хүнсний тухай” хуулийг баталсан. Ингэснээр хүнсний найрлагыг зохицуулах асуудлыг орхигдуулж хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах суурь нөхцөл бүрэн хангагдахгүй, **хүнсний найрлагыг зохицуулах тухай хууль эрх зүйн орчин бүрдээгүй байсаар байна.** Учир нь энэ асуудлыг хариуцаж буй төрийн алба хаагч болон түүний удирдлагын зүгээс хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбоотой мэдлэг мэдээлэл, ойлголт, мэргэжлийн ур чадвар дутсаны улмаас асуудлыг шийдвэр гаргагчдын анхаарлын төвд оруулах, үнэн зөв мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна.

Харин Улсын Их Хурлын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн чуулганаар “Баяжуулсан хүнсний тухай” хуулийг соёрхон баталж, хуулийг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байгаа боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Засгийн газрын 2018 оны 336 дугаар тогтоолоор Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг баталсан.

“Баяжуулсан хүнсний тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д зааснаар албан журмаар хүнс баяжуулах үйл ажиллагаанд тавих хяналтын журмыг хараахан боловсруулаагүй байна.

Хуульд зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг хүний бие махбодод зайлшгүй шаардлагатай биологийн идэвхт хүчин зүйлээр баяжуулах, эсхүл илүүдэл бодисын агууламжийг багасган зохицуулж болно гэж заасан.

Засгийн газрын 2018 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт”-д Улаан буудайн БГ-055, БГ-075, БГ-085, БГТ-075 ангиллын гурилыг аминдэм В1, В2, В3, В9, төмөр, цайр, Д аминдэмээр, Хүнсний давсыг кали йодатаар баяжуулахаар тусгасан. 2019 оны 2 дугаар улиралд багтаан баяжуулах хүнсний бүтээгдэхүүний стандарт батлуулах, БГ-055 ангиллын буудайн гурилыг баяжуулах ажлыг зохион байгуулсан боловч үйлдвэрлэл эрхлэгчдийн зүгээс

нэгж бүтээгдэхүүний өртөг өндөр гарч байгаа, нөгөө талаас төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын тогтолцоо бодит байдал дээр байхгүй байна.

Баяжуулсан хүнсний тухай хууль нь Хүнсний тухай суурь хуулийн хүрээнд хэрэгжих процессын шинжтэй хууль бөгөөд Монгол Улсад баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зохицуулалтыг агуулж байна. Энэ хүрээнд улсын хэмжээнд 2023 оны байдлаар үйл ажиллагаа эрхэлж байгаа 9 гурилын үйлдвэр байгаагаас баяжуулсан гурил одоогоор үйлдвэрлээгүй бол иоджуулсан давс үйлдвэрлэдэг 8 үйлдвэр 2023 онд нийт 0.55 мянган тонн иоджуулсан давс үйлдвэрлэсэн байна.

Ер нь Баяжуулсан хүнсний тухай хууль батлагдсан хэдий ч нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа давснаас бусад хүнсний үйлдвэрүүд тодорхой шалтгааны улмаас хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна. Хүүхдэд зориулсан олон найрлагат бичил тэжээлийн холимгийг нийслэлийн хүүхдийн сувиллууд, Нялхсын клиник сувилалд сувилуулж буй хүүхдийн хоолонд нэмэлтээр тогтмол хэрэглэж байна. Энэхүү олон найрлагат бичил тэжээл нь ДЭМБ-аас батлагдсан найрлагатай байдаг. Гэвч одоохондоо сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэж болно гэж заасан боловч одоогоор **баяжуулсан хүнсийг хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэж эхлээгүй.**

Цаашид Баяжуулсан хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх, хүнсийг баяжуулахад өртөг тодорхой хэмжээгээр нэмэгдэх тул хэрэглэгч, үйлдвэрлэгчид очих ачааллыг бууруулах зорилгоор баяжуулах бэлдмэл, баяжуулах тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх эдийн засгийн орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Баяжуулсан хүнсний тухай хуулийг зайлшгүй боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангахдаа хүн амын тодорхой бүлгүүдийг хамруулах нь зохилтой юм.

Хэрэглэгчдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж, хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи өндөр түвшинд хөгжиж, түүхий эдийн бүтэц, орц найрлага шинэчлэгдэж байгаатай уялдаж сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд дэлхийн улс орнуудаас иргэдийнхээ хоол хүнснээс шалтгаалах, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн арга хэмжээ нь хоол хүнсний зохистой хэрэглээ, эрүүл мэндийг дэмжих үйлчлэл бүхий хүнсийг зөвлөмж болгосоор байна.

Гэтэл Хүнсний тухай хуульд заасан зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар эрх зүйн зохицуулалтыг 2012 оноос хойш бүрдүүлээгүй байна. Иймд зохицуулах үйлчлэлтэй хүнсний талаар нэгдмэл ойлголтод хүрэх, түүний ач холбогдол, хүний бие махбодод үзүүлэх нөлөөний талаар хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл, мэдлэг олгох, мөн судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, худалдаанд тавигдах шаардлагыг тогтоох, баталгаажуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.3. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих шаардлагын хэрэгжилтийн байдал

Хүнсний тухай хуулийн 3 дугаар бүлэгт хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага, хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дараах хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болох талаар, мөн аж ахуйн нэгжүүд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаас бусад шаардлагыг хангах тухай тусгагдсан болно.

Гэхдээ хүнсний сүлжээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгааг хангахтай холбоотой заалтыг бүрэн тусгах ёстой байсан боловч хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, баталгаатай хүнсээр хангахтай холбоотой зарим зохицуулалтыг орхигдуулсан байна. Тухайлбал, хүнсний тээвэрлэлт, хадгалалт, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа нь эрх зүйн зохицуулалтгүй байна.

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлчилгээний дэг, соёлыг дээшлүүлэх, ажиллагсдын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2010 оны А-206 дугаар тушаалаар батлагдсан “Хоолны газрын нийтлэг журам”-ыг мөрдөж байсан боловч 2012 онд шинэчлэн баталсан Хүнсний тухай хууль, 2016 онд мөрдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн дагуу “Хоолны газрын нийтлэг журам”-ыг 2016 онд хүчингүй болгосон. Түүнээс хойш эрх зүйн зохицуулалтгүй болсон.

Энэхүү журам нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж, хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад эрх зүйн гол зохицуулалт болж ирсэн хэдий ч хоолны газрын зэрэглэл тогтоох, хоолны газарт мөрдөх журам батлах тусгайлан эрх олгосон заалт Хүнсний тухай хуульд байхгүй тул журам батлах боломжгүй байгаа юм.

“Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх журам”-тай болох эсвэл хуульд холбогдох зохицуулалтыг нэмснээр хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнснээс шалтгаалах өвчний эрсдэлийг бууруулах, хоолны хордлого, хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх, шударга өрсөлдөөнийг дэмжихэд ихээхэн ач холбогдолтой юм.

Иймд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг олон улсын жишгийн дагуу тодорхой шалгуураар үнэлж зэрэглэл тогтоох, үйлчлүүлэгчдэд ил тод мэдээлэх асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг яаралтай бүрдүүлж, хоолны газрыг зэрэглэх журмыг батлах эрхийг холбогдох байгууллагад хуулиар олгох шаардлагатай байна.

Энэхүү хуулийн 3 дугаар бүлгийн 10 дугаар зүйлийн хэрэгжилтийг гаргахад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд хуулиар тогтоосон ерөнхий шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх, Дотоодын хүнсний үйлдвэрлэлд

хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадсан эсэх, импортын хүнсний хяналтын тогтолцоог боловсронгуй болгож чадсан эсэх мөн хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа буюу практикт нийцэж байгаад шинжилгээ хийлээ.

Үнэлэх хэсэг	- 10.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагыг хангана. - 10.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дараах хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно. - 11.2.Энэ хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаас бусад шаардлагыг хангасан байна.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд хуулиар тогтоосон ерөнхий шаардлага нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Дотоодын хүнсний үйлдвэрлэлд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг хангах удирдлагын тогтолцоог бүрдүүлж чадсан эсэх? - Импортын хүнсний хяналтын тогтолцоог боловсронгуй болгож чадсан эсэх? - Энэхүү хуулиар тогтоосон тусгай шаардлага нь цаг үетэйгээ нийцэж байгаа эсэх буюу практикт нийцэж байна уу?

- **Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлагыг хангаж байгаа байдал 50 хүрэхгүй хувьтай хэрэгжиж байна.**

Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1.-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах”-аар тусгагдсан.

Энэ хүрээнд ХХААХҮЯ-ны салбарын газраас хүнс, хөдөө аж ахуйн хяналт шалгалтын чиглэлээр 2023 онд төлөвлөгөөт нэг, урьдчилан сэргийлсэн 13, төлөвлөгөөт бус 4 шалгалтыг тус тус хийж гүйцэтгэсэн байна. Харин 2024 онд төлөвлөгөөт 8, урьдчилан сэргийлсэн 14, төлөвлөгөөт бус 1 шалгалтыг явуулсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 79 дүгээр тогтоол "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай"-оор ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газар хүнсний чанар, стандарт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын чиглэлээр 3349 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөж 2851 объект буюу 85.1 хувийг хамруулсан. Үүнд их эрсдэлтэй 323, дунд эрсдэлтэй 1205, бага эрсдэлтэй 1324 объект тус тус үнэлэгдэж, шалгалтын явцад 23451 зөрчил илрүүлж, 11627 буюу 49.6 хувийг газар дээр нь арилгуулж ажилласан. Зөрчлийг арилгуулах ажлын хүрээнд 12346 заалт бүхий 1598 улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангаж ажилласан. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа 6641 стандартын 10 орчим хувь нь хүнсний салбарын стандарт байна.

Үүнээс Тариа буудай, буурцаг, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний техникийн шаардлага, шинжилгээний аргатай холбоотой нийт 91 стандарт хүчин төгөлдөр байна.⁵

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан **төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр** Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 08-00-02/10 дугаар удирдамжийн хүрээнд нийт 567 хүнсний худалдааны газраас 479 газар буюу 84.4 хувь нь төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 8.11.1, 8.11.3 кодтой хяналтын хуудсаар хийхэд 76 буюу 16 хувь нь их, 204 буюу 42.9 хувь нь дунд, 199 буюу 41.8 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдлээ. Шалгалтын явцад нийт 5345 зөрчил илрүүлж 3107 буюу 53.4 хувийг газар дээр нь болон хугацаатай үүрэг даалгавар өгч арилгуулсан. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчилд нийт 9 хуулийн этгээдэд 16.500.0 мянган төгрөг, 5 иргэнд 2.100.0 мянган төгрөгийн, нийт 14 зөрчлийг шалган шийдвэрлэж 18.600.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, улсын байцаагчийн 2310 заалт бүхий 244 албан шаардлага, эрх бүхий албан тушаалтны 3 албан даалгавар хүргүүлсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг улсын хэмжээнд 363 объектод хийсэн нь нийт хяналт шалгалтад хамрагдсан объектын 76.4 хувийг эзэлж байна.

ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжийн дагуу явуулж 1950 дээжид шинжилгээ хийж, шаардлага хангаагүй дээжийн хувь/ нян судлал- 9.6 хувь байсан байна. Тус урьдчилан сэргийлэх шалгалтад нийслэл, аймаг, сумдын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 48 гүний худаг, 9 насос станц, 179 зөөврийн ус түгээх байр, 204 шугамаар ус түгээх байр, ус хангамжийн төвлөрсөн сүлжээний хэрэглэгч 510 сумдын худаг 724, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 129 худаг, төвлөрсөн бус ус хангамжтай 75 хэрэглэгч, ус зөөврийн машин 6, гадаргын ус 15 нийт 1950 объектыг хамруулан нийт 3601 усны дээж авч, ХАБҮЛЛ, Стандарт, хэмжилзүйн газрын аймаг, нийслэлийн лабораторид нян судлал, хими, хүнд металлын үзүүлэлтээр шинжлүүлэн үнэлгээ өгөв. Шинжлэгдсэн нийт дээжийн 9.7 хувь нь нянгийн тоо үзүүлэлтээр, 2.8 хувьд e.coli, 8.4 хувь нь магни, 8 хувь нь хар тугалга үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй дүнтэй байв. Хяналт шалгалтын явцад нийт 84 зөрчил илрүүлж, 183 заалттай 26 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, 4 аж ахуйн нэгжид 8,000,000(найман сая) төгрөгийн торгууль ногдуулж, унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 226 дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Усны дээжийн шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй 84 аж ахуйн нэгжийн шугам сүлжээ, усны нөөцийн саванд угаалга, халдваргүйжүүлэлт хийлгэж, давтан шинжилгээ хийж стандартын шаардлага хангуулсан. Увс аймгийн Улаангом сумын 2 гүний худагт зөөлрүүлэх төхөөрөмж, Ховд аймгийн 6 гүний худгийн барилгад засвар

⁵ ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газрын албан мэдээлэл, 2023

үйлчилгээ, 8 ус түгээх байрт эрүүл ахуйн бүсийн хэмжээгээр хашаа хамгаалалт хийлгэсэн.

Стандартын үзлэгийн талаар: Монгол улсын Шадар сайдын 2022 оны 30 дугаар тушаалаар хүнсний салбарт мөрдөж байсан 683 стандартад ХХААХҮЯ, ЭМЯ, ГХЯ, ШӨХТГ, МХЕГ, ГЕГ, ҮИТ, ШУТИС-ҮТС, ХАБҮЛЛ, МҮХАҮТ, МХХ, МХЭАХНҮХ, НЭМҮТ, УМЭАЦТЛ, УХЭШХ, ХХТХ-ийн төлөөллийг оролцуулан шинжлэх ухаан, техникийн түвшний үзлэгийг зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн болон ажлын удирдамжийг баталсан. Шадар сайдын тушаалаар байгуулсан үзлэг зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүний дагуу ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/207 тушаалаар 4 салбар комиссыг байгуулан үзлэгийг зохион байгуулсан. Салбар комиссыг ХХААХҮЯ, МХХ, ҮИТ, СХЗГ ахлан ажилласан. Үзлэгээр 30 стандартыг шинээр боловсруулах, 153 стандартыг дахин хянах, 50 стандартыг хүчингүйд тооцох дүгнэлт гарсан. Үзлэгийн дүнг техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэн хэрэгцээ, шаардлага хангахгүй байгаа 50 стандартыг хүчингүйд тооцсон бөгөөд шинээр боловсруулах болон шинэчлэх шаардлагатай стандартуудыг үе шаттайгаар боловсруулан ажиллаж байна.

Дээрх үзлэгийн дүнгээр “MNS 0097:2010, Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага” стандартыг хэвээр мөрдөх, “MNS 0244:2009, Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага” стандартад нэмэлт өөрчлөлт оруулах дүгнэлт гарсан байна. Хүнсний стандартчиллын 2024-2025 оны төлөвлөгөөнд зориулалтын гурил гэсэн стандартын төсөл боловсруулах саналыг “Милл хаус” ХХК-аас ирүүлснийг төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Стандартыг шинэчлэх ажлын хэсгийн талаар: ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/213 тоот тушаалаар MNS 0246:2010, Үрийн буудай. Сортын болон үрийн чанар”, “MNS 0097:2010, Хүнсний буудай. Техникийн шаардлага” стандартыг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд уг ажлын хэсэг 1 удаа хуралдаад “MNS 0097:2010, Хүнсний буудай. Техникийн ерөнхий шаардлага” стандартад өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж дүгнэсэн байна.

ХАБҮЛЛ-д хүнсний бүтээгдэхүүнд цацрагийн бохирдлын хяналтын шинжилгээг: 2022 онд нийт 753 дээжид 1506 үзүүлэлтээр, 2023 онд нийт 994 дээжид 1990 үзүүлэлтээр, 2024 онд 931 дээжид 1862 үзүүлэлтээр байгалийн болон зохиомол цацраг идэвхт изотопуудыг тодорхойлох шинжилгээ хийсэн байна.

Сургууль, цэцэрлэгүүд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрсдөө хариуцан ажиллаж байна. MNS CAC RCP 39:2011 Нийтээр үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал, MNS 6558:2015. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага 5.6 дахь хэсэг, БСШУ-ны сайд, эрүүл мэндийн сайдын 2006 оны 379/341 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журам, БСШУ-ын сайд, эрүүл мэнд, спортын сайд, Сангийн

сайдын 2015 оны А/253/251/173 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм шаардлагын 6 дугаар бүлэгт заасан Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлагын хүрээнд цэцэрлэг, сургууль гал тогооны үйл ажиллагаанд БСШУ-ны сайдын 2010 оны 45 дугаар тушаалын дагуу орон тооны бус хяналтын зөвлөл байгуулан ажиллаж байна.

2018-2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 656 сургуулийн 288 (43 хувь) нь зориулалтын гал тогоотой бөгөөд урсгал засвар шаардлагатай 157 сургуульд 5,1 тэрбум төгрөг, их засвар шаардлагатай 129 сургуульд 7,5 тэрбум төгрөг, анги танхим болон коридор, вестибюль зэргийг тохижуулсан зориулалтын бус гал тогоотой 262 (40 хувь) сургууль байгаа бөгөөд урсгал засвар шаардлагатай 113 сургуульд 2,0 тэрбум төгрөг, их засвар шаардлагатай 111 сургуульд 3,4 тэрбум төгрөг, зориулалтын болгон засвар шаардлагатай 135 сургуульд 13,8 тэрбум төгрөг, шинээр гал тогоо барих шаардлагатай 123 сургуульд 16,2 тэрбум төгрөг, иж бүрэн тоног төхөөрөмж шаардлагатай 326 сургуульд 5,8 тэрбум төгрөг, нэмэлт тоног төхөөрөмж шаардлагатай 233 сургуульд 2,3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. Харин Хуулийн 8 дугаар зүйлд Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн эрх, үүргийг тодорхой заасны дагуу ерөнхий боловсролын сургуулиудад эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн оролцоотой “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийг байгуулж, ажиллаж эхэлсэн нь сайшаалтай. Гэвч уг зөвлөлд томилогдсон эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл нь хүнсний бус мэргэжилтэй, орон тооны бус учраас хяналтын үйл ажиллагааг тогтмол явуулах оролцоо, чадамж сул, мөн сургууль, хяналтын зөвлөл хоорондын ажлын уялдаа хангалтгүй байгаагаас хүүхдийн хоол, хүнс, түүний түүхий эдэд тавих хяналтыг бодитой хэрэгжүүлэх боломжгүй буюу **хэрэгжилт хангалтгүй (30 хувь) байсан.**

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заагдсан хяналт шалгалтын байгууллагын бүртгэлийн систем буюу IGOV.mn-д бүртгүүлсэн 15758 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч байна. Үүнд: Хүнсний худалдаа-8884, хоол үйлдвэрлэл үйлчилгээний-5426, боловсруулах үйлдвэр-872, бэлтгэн нийлүүлэгч-173, агуулах-253, газар тариалангийн чиглэлээр-150 байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах хуулийн хэрэгжилт нь 65-70 хувьтай хэрэгжиж байна. Тухайлбал, төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан худалдааны газруудын хүнсний аюулгүй байдалтай холбоотой хууль сахин мөрдөлтийн хувь улсын хэмжээнд 71.5 хувь байснаас гүйцэтгэлийн хяналт шалгалтаар 77.2 хувь болж 5.7 хувиар дээшилсэн үзүүлэлттэй байна.

2013-2023 (10 жил) онд улсын хэмжээнд хоолны хордлогот халдварын 1091 дэгдэлт бүртгэгдэж, 5702 хүнд хордлогын шинж тэмдэг илэрсэн ба 1524 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна.

2024 онд 21 удаагийн дэгдэлт бүртгэгдэж, 1108 хүнд хордлогын шинж тэмдэг илэрч, 470 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, 21 дэгдэлтийн 6 дэгдэлт нь цусан суулга, 1 суулгалт халдвар, 13 нь бусад нянгаар үүсгэгдэн хоолны хордлого, 1 нитритийн хордлого байна.

2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объектуудын хүнсний худалдааны газруудад тус заалтын хэрэгжилт 83,7 хувь, хоол үйлдвэрлэлийн газруудад 65,0 хувь, хүнсний үйлдвэрүүдэд 67 хувийн хэрэгжилттэй дүгнэгдэж, дотоод хяналтын нэгж, ажилтны мэдлэг ур чадвар хангалтгүй, хүнсний үйлдвэрүүд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх дотоодын хяналтын лабораторигүй, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох техникийн зохицуулалт, техникийн ерөнхий шаардлагад заасан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй шинжлүүлээгүй, эрүүл ахуйн зохистой дадлын бүртгэл дутуу, үл тохирлыг залруулах арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил, дутагдлыг илрүүлэн арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2.-д заасан заалтын хүрээнд 2024 оны байдлаар нийслэлийн хэмжээнд хүнсний худалдааны газрын 51.3 хувь, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын 49.3 хувь, хүнсний үйлдвэрлэлийн 72.1 хувь нь стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагыг хангаж байна.

Эрүүл мэндийн яамны хяналтын газраас улсын хэмжээнд 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объектын хүнсний худалдааны газруудын 73 хувь, хоол үйлдвэрлэлийн газруудын 71.2 хувь, хүнсний үйлдвэрийн 65.4 хувь нь стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламжтай эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан байна.

Нийслэлийн хэмжээнд хүнсний худалдааны газрын 48.7 хувь, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын 50.7 хувь, хүнсний үйлдвэрлэлийн 27.9 хувь нь эрсдэлтэй буюу стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд мөрдөх хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангалтгүй, зориулалтын бус тээврийн хэрэгсэл суудлын автомашинаар хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа нь хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүсгэж байна. Үүний шалтгаан нь нийтийн орон сууцны зориулалтыг өөрчлөн хүнсний чиглэлийн ялангуяа хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаагаас нийтийн эрх ашиг зөрчигдөж байна.

Хуульд заасан хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай **барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах** ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх гэсэн заалтын хэрэгжилтийн хүрээнд 2013-2018 оны дунджаар

Хүнсний худалдаа үйлчилгээний чиглэлээр 48,8 хувь, үйлдвэрийн чиглэлээр 57,8 хувь, Хоол үйлдвэрийн чиглэлээр 44,5, хувь, Амьтны гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 40 хувь, Ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 76,7 хувь хувьтай гарсан байна. Хүнсний худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зориулалтын байргүй байх гэсэн зөрчил их байдаг. Ялангуяа хоол үйлдвэрлэлийн чиглэлээр, орон сууцны байранд үйл ажиллагаа явуулж байгаа газрын тоо нийслэлд гэхэд л 700 орчим байгаа нь уг зөрчил буурахгүй байгаатай холбоотой байжээ.

2023 онд БСШУ-ны яамнаас хийсэн Төрийн өмчийн сургуулийн 33 хувь нь зориулалтын бус цайны газартай, 32,7 хувь нь ямар нэгэн тоног төхөөрөмжгүй, ихэвчлэн зориулалтын бус хувийн тээврийн хэрэгслээр хүнсний бүтээгдэхүүний татан авалтыг хийж байна.

Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газраас явуулсан 2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан хүнсний худалдааны газруудын 55.4 хувь, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудын 56.2 хувь, хүнсний үйлдвэрүүдийн 75.4 хувь нь барилга байгууламж нь мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу хүнсний зориулалтаар баригдсан, өргөтгөсөн, шинэчилсэн, эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан, эрүүл ахуйн нөхцөл, барилгын норм, нормативын шаардлагыг бүрэн хангасан гэж дүгнэгдсэн байна.

Хүнсний тухай хуулийн 10.1.4.-д зааснаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх гэж заасны дагуу Эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг ХХААХҮ-ийн сайд болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар 2024 оны 02 дугаар сарын 16-нд батлагдсан. Батлагдсан заавар, журмын хэрэгжилтийг хангуулах хүрээнд мөн Хүнсний тухай хуулийн 10.1.1 дэх заалт, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.1.2, 7.1.3 заалтыг үндэслэл болгон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулж зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, сургалтыг жил бүр төлөвлөн зохион байгуулдаг. 2024 онд 3 удаагийн сургалтаар нийт хүнсний чиглэлийн 76 аж ахуйн нэгжийг тус сургалтад хамруулсан.

“Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” нь нэршлийн хувьд тохиромжтой биш, гурилын үйлдвэрлэл, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь өөр өөрийн онцлог бүхий боловсруулалт хийдэг хоёр үйлдвэрлэлийн процесст нэг ижил шаардлага тавьж байгаа нь оновчгүй байна. Зааврын төслийг боловсруулах үед буюу 2023 онд зохих журмын дагуу энэ тухай саналыг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байсан боловч санал тусгагдаагүй.

Нийслэлийн нутаг дэвсгэрт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр зохистой дадлын хэрэгжилт 60.1 хувь, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 62.4 хувь, худалдааны

чиглэлээр 54,5 хувийн хэрэгжилттэй байна. Нийслэлийн хэмжээнд боловсруулах үйлдвэр болон хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд нь мэргэжлийн боловсон хүчинтэй боловч тогтвор суурьшилтай ажилладаггүй мөн энэ мэргэжлээр төгсөгч бага байгаа нь мэргэжлийн боловсон хүчний дутагдал үүсэхэд нөлөөлж байна.

Нийслэлийн хэмжээнд боловсруулах үйлдвэр болон хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд нь мэргэжлийн боловсон хүчинтэй боловч тогтвор суурьшилтай ажилладаггүй мөн энэ мэргэжлээр төгсөгч бага байгаа нь мэргэжлийн боловсон хүчний дутагдал үүсэхэд нөлөөлж байна. Хяналт шалгалтад хамрагдсан боловсруулах чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй газруудад технологич, тогооч нар бичиг баримттай ажилтантай боловч нарийн мэргэжлийн шаардлагыг хангасан хүний нөөц хангалтгүй байна.

“Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангасан зориулалтын байр, гал тогоо, тоног төхөөрөмж ашиглан мэргэжлийн хүний нөөцтэйгөөр явуулна” гэж заасны дагуу үнэлгээний явцад цуглуулсан мэдээллээс харахад ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, хүртээмжийн түвшин анх хууль батлагдсанаас хойш жил бүр дээшилж байгаа хэдий ч тухайн заалтын хэрэгжилт 50 хувьтай байна.

2023/2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 871 ерөнхий боловсролын сургуулийн 50 нь дунд, ахлах сургууль байгаа бөгөөд 821 сургууль бага ангийн 381,481 суралцагчдад үдийн хоолоор үйлчилж байна. Гэвч сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль батлагдсанаар дээрх асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ гэж үзсэн боловч 2023 оны байдлаар тус хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ ерөнхий 30 хувьтай буюу хангалтгүй дүнтэй гарсан.

Хоногт 1-5 дугаар ангийн хүүхэд сургуулийн хоолноос өдөрт авах нийт илчлэгийн хэмжээний 30 хувийг авахаар тооцсон боловч сургуулийн хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээллэг байдлыг тооцсон судалгааны дүнгээр хоногт авах илчлэг, шим тэжээлээ хангалттай авч чадахгүй байна гэж гарсан.

Хуулийн 10.1.4.-д заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэхээр хуульчилсан боловч 2018 оны байдлаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулсан нэг ч аж ахуй нэгж байгууллага байхгүй ба баталгаажуулалтыг хийх тогтолцоо манай улсад хараахан бүрдээгүйтэй холбоотой. Энэ байдал 2023 онд хүртэл дорвитой ахиц дэвшил гараагүй болно. **Энэ заалт огт хэрэгжихгүй байна. Салбарын яам энэ заалтын хэрэгжилтийг хангах ажлыг 13 жилийн туршид орхигдуулсан гэж дүгнэлээ.** Тодруулбал, улсын хэмжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй нийт малчин, тариаланч, хүнс үйлдвэрлэгч, тээвэрлэгч, хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүнийг баталгаажуулж, улмаар монгол хүн эрүүл, баталгаатай хоол хүнс хэрэглэх нөхцөл хараахан хангагдаагүй байна гэж дүгнэж байна. Учир нь энэхүү хүнсний түүхий эд,

бүтээгдэхүүний бүртгэл, баталгаажуулалтын тогтолцоотой хуулийн хэрэгжилтийн үйл явц, үр дүн шууд хамааралтай юм.

Үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлээгүй он удаан жил явсан салбар бол мал аж ахуйн салбар юм. Үйлдвэрлэлийн зохистой дадлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүйгээс үүссэн малын гоц халдварт өвчний гаралт, тархалт буурахгүй байсаар байгаа. Улсын хэмжээнд 2023 онд малын гоц халдварт өвчний 199 тохиолдол бүртгэгдсэний 57.8 хувийг бог малын мялзан, 39.2 хувийг хонины цэцэг, 2.0 хувийг гахайн африкийн мялзан, 0.5 хувийг шүлхий болон үхрийн арьс товруутах өвчний тохиолдол эзэлж байна.

5 дугаар хүснэгт. Малын гоц халдварт өвчний мэдээлэл, 2023 он

Өвчний төрөл	Малын гоц халдварт өвчний тохиолдлын тоо	Өвчилсөн малын тоо	Дүнд хувь эзлэх
Нийт	199	26 615	100.0
Гахайн африкийн мялзан	4	1 286	4.8
Шүлхий	1	46	0.2
Үхрийн арьс товруутах	1	2	0.0
Бог малын мялзан	115	19 836	74.5
Хонины цэцэг	78	5 445	20.5

Эх үүсвэр: ХХААХҮЯ

Гоц халдварт өвчнөөр өвчилсөн 26.6 мянган малын 74.5 хувийг бог малын мялзан, 20.5 хувийг хонины цэцэг, 4.8 хувийг гахайн африкийн мялзан, 0.2 хувийг шүлхий, 0.02 хувийг үхрийн арьс товруутах өвчин эзэлж байна.

ХХААХҮЯ, ЭМЯ-ны 2024.02.16-ны өдрийн А/100, А/68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”, хоёрдугаар хавсралтаар “Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар” батлуулсан.

2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объект 7 эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудасны үнэлгээгээр их эрсдэлтэй 55 (14.5 хувь), дунд эрсдэлтэй 235 (49.1 хувь), бага эрсдэлтэй 197 (41.2 хувь), эрсдэл үүсэх магадлалын дундаж 34.9 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 66.0 хувьтай үнэлэгдэж, холбогдох арга хэмжээ авч, 276 объектод гүйцэтгэлийн хяналт хийж ажилласны дүнд 37 (7.7 хувь) нь их эрсдэлтэй, 217 (45.5 хувь) нь дунд эрсдэлтэй, 233 (47.8 хувь) нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, эрсдэл үүсэх магадлалын дундаж 24.7 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 76.4 хувь болж нэмэгдсэн.

Стандартын шаардлагад нийцээгүй, хязгаарлагдмал зай талбайтай, эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлагыг хангахгүй ажлын байрны орчин нөхцөлд ихэнх сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулсан бөгөөд үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлж, түүнийг баталгаажуулсан нэг ч сургууль улсын хэмжээнд

бүртгэгдээгүй байна. Иймд сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.4-д заасан “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн байна” гэсэн заалт огт хэрэгжээгүй буюу Хүнсний тухай хуулийн **10.1.4. дэх заалт мөн адил хэрэгжээгүй байна.**

Мөн зохистой дадлын нийтлэг зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг ч нэвтрүүлснийг баталгаажуулдаг баталгаажуулалтын зөвхөн хоёр байгууллага байна. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2-т заасан заавар батлагдаагүй. Зохистой дадлыг цаашид нэвтрүүлэх, хөгжүүлэхэд мэргэшсэн баг байхгүй байна. Иймд хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангахын тулд баталгаажуулалтын тогтолцоог бий болгож, баталгаажуулалт олгох аж ахуй нэгжийг итгэмжлэлд хамруулахад нь дэмжих, бойжуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хуулийн 10.1.5.-д боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байхаар заасан. Гэвч салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлого алдагдсан, өнөөдөр салбарын хүний нөөцийн бодлогогүй тул салбарт мэргэжлийн удирдлага 100 хувь алдагдсан байна гэж харж байна. Иймд энэ заалтын хэрэгжилт маш хангалтгүй түвшинд үнэлэгдлээ.

Улсын хэмжээнд боловсруулах үйлдвэр болон хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэд нь мэргэжлийн боловсон хүчинтэй боловч тогтвор суурьшилтай ажилладаггүй мөн энэ мэргэжлээр төгсөгч бага байгаа нь мэргэжлийн боловсон хүчний дутагдал үүсэхэд нөлөөлж байна.

Санхүү, Эдийн засгийн сайд, ХХААСайд, НХХСайд, БСШУСайд нар хамтран 2002 оны 61/А31/31/69 дугаар тушаалаар “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг, нэмэгдэл олгох журам”-ыг мөрдөж байсныг 2016 онд хүчингүй болгосон. Иймд хүний нөөцийн мэргэшсэн байх эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа тул **энэ заалт хэрэгжихгүй байна.**

Хүнсний сүлжээнд оролцогчид нь хүний эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой учраас салбарын хүний нөөцийг тодорхой үе шат, давтамжтай, тасралтгүй сайжруулах, ажил олгогч болон ажилтны эрх, үүргийг тодорхой болгох шаардлагатай хэдий ч нөгөө талаас хүнсний салбарт ажиллагсдыг мэргэшүүлэн, мэргэшлийн зэрэг олгосноор салбартаа хүлээн зөвшөөрөгдөх асуудал мөн хөндөгдөнө.

Энэ заалтын хэрэгжилт 2013-2018 оны дунджаар хүнсний үйлдвэрийн чиглэлээр 76,8 хувь, Хоол үйлдвэрийн чиглэлээр 93,2 хувь, Амьтны гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 60 хувь, Ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 78,1 хувь хувьтай гарсан байна. Уг хуулийн заалт харьцангуй өндөр хувьтай байгаа боловч хоол үйлдвэрлэлийн салбарт бэлтгэгдэж байгаа боловсон хүчний чадамж, чанарын хувьд анхаарах

хэрэгтэй. Хатуухан хэлэхэд энэ өндөр хувь бол зөвхөн үнэмлэхийн тоогоор тооцсон дүн юм.

Сургуулиудын хувьд хоолзүйч, мэргэжлийн тогооч, туслах ажилтан авах сул орон тоог зарласан боловч ачаалал их, цалин бага гэсэн шалтгаанаар мэргэжлийн хүн ирж ажиллахгүйгээс хүний нөөц хомсдолтой байна. Иймд хуулийн 6.5-д “Сургуульд хоолзүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллана” гэж тусгасан заалтын хэрэгжилт 47.8 хувьтай байна.

Цаашид хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлж буй ажилдаа сонирхолтой, хүсэл эрмэлзэлтэй ажилтнуудад зориулсан мэргэшүүлэх болон мэдлэг олгох богино хугацааны сургалтыг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах, тэдгээрийг бүрэн хамруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Хүнсний тухай хуулийн 10.1.6.-д үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байхаар заасан бөгөөд хуулийн хэрэгжилт нь 2013-2018 оны дунджаар хүнсний үйлдвэрийн чиглэлээр 68 хувь, хүнсний худалдаа 41, Ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 58,5 хувь хувьтай гарсан байна. Амьтны гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн дүн байхгүй бөгөөд байгаль орчны хяналтын байцаагчдын хуулиар хүлээсэн үүрэгт хамаардаг тул хяналтын хуудаст ороогүй гаргах боломжгүй байна. Иймд энэ заалт огт хэрэгжээгүй байна.

Орон нутагт хүнсний жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх, шинээр үйлдвэр байгуулах нөхцөлийг шуурхай болгох зорилгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх аргачлал, механизмыг бий болгох шаардлагатай.

Хүнсний тухай хуулийн 10.1.7 дах заалтад тусгай зөвшөөрөл авсан байхаар тусгагдсан боловч 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр энэ хуульд заалтад өөрчлөлт орсон байна. Энэ хүрээнд зөвшөөрөл авах үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байна. Гэхдээ үйл явц нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд ойлгомжгүй, бүрхэг, энэ талаарх мэдээлэл олж авахад хүндрэлтэй гэсэн асуудлыг хөндсөн. Төрийн үйлчилгээг ойлгомжтой байлгах нь холбогдох төрийн албан хаагчийн үүрэг юм.

Иймд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаандаа аливаа зөвшөөрөл, лиценз авах, дэмжлэг, урамшуулал, татааст хамрагдахын тулд тавигдаж буй шаардлагын хүрээнд мэдээллээ цахим системд оруулаад, цахимаар хариугаа авах, хамгийн гол нь ямар нэг эрх бүхий албан тушаалтнаас энэ зөвшөөрөл авах үйлдэл нь хамаардаггүй болгох нь чухал байна.

Энэхүү заалтын хэрэгжилт 2013-2018 оны дунджаар Хүнсний худалдаа үйлчилгээний чиглэлээр 95 хувь, хүнсний үйлдвэрийн чиглэлээр 51 хувь, Хоол үйлдвэрийн чиглэлээр 96,7 хувь, гарсан байна. Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай

хуулийн 11.1.7-д зааснаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх; тамхи худалдахад нийслэлийн засаг даргын саналыг авч, 16.2-д зааснаар тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх; сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архианаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэхэд яам, төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж байна.

Харин “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу “Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн нийслэлийн Засаг дарга олгож, сунгаж, хүчингүй болгож байна. Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архины үйлдвэрлэл эрхлэх төсөл сонгон шалгаруулах үйлдвэрлэлд хяналт тавих журам байхгүй байна.

Сургуулийн цайны газрын түрээслэгчийг шалгаруулахдаа ААНБ-ын тусгай зөвшөөрлийг /үйл ажиллагааны чиглэлд хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх асуудал туссан байх/ үндэслэн шалгаруулдаг.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 151.1.3, 152.1.3 дахь заалтыг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах болон тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.10.3, 7.11.3 дахь заалтын дагуу дүгнэлт гаргуулах хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу тус тус ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газартай хамтран төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, тус заалтын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Энэ хуулийн 10.1.8.-10.1.9. дэх заалтуудыг нь 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хуульд нэмсэн бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан тул хэрэгжилтийг гаргаагүй болно. Хуулиар заасан “нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тохиолдолд Хог хаягдлын тухай хуулийн 10.2.17-д зааснаар үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг түүнийг дахин боловсруулах, сэргээн ашиглах эрх бүхий байгууллагад шилжүүлэх гэрээ байгуулсан байх”, “үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй байх” гэсэн 2 заалт байгаль орчинд ээлтэй, ногоон хүнсний үйлдвэрлэлийг дэмжсэн мөн хүнсний баталгаат байдлыг хангахад чухал зохицуулалт бүхий заалт орсныг дурдах нь зүйтэй.

Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно гэж тусгагдсан байна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаас байгууллагын чанарын удирдлагын тогтолцоонд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн гэрчилгээ олгогдсон буюу Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2010 стандартыг нэвтрүүлсэн хүнсний салбарын 16 ААНБ, Байгаль орчны менежментийн тогтолцоо

MNS 14001:2016 стандартыг нэвтрүүлсэн хүнсний салбарын 1 ААНБ, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS OHSAS 18001:2012 стандартыг нэвтрүүлсэн хүнсний салбарын 2 ААНБ байна.

Энэ хуулийн 10.2.1.-10.2.2.-д заасан заалтын хүрээнд эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 33 ААНБ байгаагаас 17 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 16 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. Харин хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлсэнд баталгаажуулсан нэг ч ААНБ байхгүй нь уг баталгаажуулалтыг хийх тогтолцоо манай улсад хараахан бүрдээгүйтэй холбоотой.

6 дугаар хүснэгт. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Нийт үйлдвэрийн тоо	22	17	27	33	22.2
Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн	12	12	16	17	6.3
Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн	10	5	11	16	45.5

Эх үүсвэр: СХЗГ

Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн 16 ААНБ-ын 2 ААНБ нь 2023 онд шинээр нэвтрүүлсэн бол үйл ажиллагаандаа ISO14000 байгаль орчны менежментийн багц стандартыг нэвтрүүлсэн 3 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААНБ байна. Харин үйл ажиллагаандаа хүнсний хог хаягдлын менежмент нэвтрүүлсэн ААНБ бүртгэгдээгүй байна.

Цаашид хүнсний аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг сайн явуулах шаардлагатай. Байгууллага, ААН-үдийн дотоод боломж бололцооноос шалтгаалан заалтын хэрэгжилт удаашралтай байна.

Энэ хуулийн 10.3. дахь заалтаар химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу баталсан жагсаалтад орсноос бусад пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон. Энэ заалтын хэрэгжилт 95 хувьтай үнэлэгдсэн байна. ХХААХҮС, БОАЖС, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар Монгол улсад ашиглаж болох болох зөвшөөрөгдсөн ургамал хамгааллын бодис, бордооны жагсаалтыг жил бүр шинэчлэн баталдаг.

2019 оны жагсаалтад 162 нэрийн пестицид, 82 нэр төрлийн биобэлдмэл, 23 нэр төрлийн бордоог газар тариалангийн зориулалтаар ашиглахаар тусгагдсан байна. Тухайн жилд хяналт шалгалтаар улсын хилийн боомтоор 2019 онд тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуйн нэгж 80 нэр төрлийн худалдааны нэршилтэй 74 төрлийн үйлчлэх бодис бүхий 1546 тонн ургамал хамгааллын бодис, 13 аж ахуй нэгж 47 нэр

төрлийн 8185 тонн бордоо, 16 нэр төрлийн 156 кг биобэлдмэлийг ХХААХҮЯ-наас ургамал хамгаалах химийн бодис импортлох, худалдан борлуулах тусгай зөвшөөрөл авсны дараагаар БОАЖЯ-наас Химийн хортой болон аюултай бодисыг хил дамжуулан экспортлох, импортлох тусгай зөвшөөрлийг бодисын нэр төрөл тус бүрээр авч импортолсон байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объект 100 хувь БАӨЖС, ХХААХҮС, ЭМС-ын хамтарсан 2023 оны А/34, А/43, А/50 дугаартай “Жагсаалт батлах тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын жагсаалтад бүртгэлтэй ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хэрэглэдэг, дагалдах гарал үүсэл, баталгаажилттай, зориулалтын химийн бодисын агуулах эсхүл тусгай шүүгээнд шошгожуулан хадгалсан объект 77 хувь байна.

Үүний хажуугаар хууль бус импортын асуудал байна, тодруулбал, хувь хүн, зөвшөөрөл аваагүй аж ахуйн нэгж нь хуульд заасан хориотой химийн бодисыг импортолж байгаа нь хяналт тавих тогтолцоог бүрдээгүйтэй холбоотой юм.

Ургамал хамгааллын бодис, бордооны хэрэглээ. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 170 орчим нэр төрлийн ургамал хамгааллын бодис бордооны ургамал хамгаалалтад ашиглах хими болон биологийн гаралтай бодис 1.5 мянган тонн, импортын химийн гаралтай НРК-ийн нийлмэл болон дан бодис нийт 5.2 мянган тонн, био болон органик бодис 0.5 мянган тонн бүртгэгдсэн. Дотоодын үйлдвэрийн биологи, эко, органик 0.5 мянган тонн, компаст 3.0 мянган тонн байна.

Ургамал хамгааллын бодис, бордооны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ. Улсын хэмжээнд ургамал хамгаалахад ашиглах химийн бодис үйлдвэрлэдэггүй ба Шим ХХК ойн хөнөөлт мэрэгчтэй тэмцэхэд зориулж ХХААХҮЯ-нд 167 тонн Бактобромадиолон, ойн хөнөөлт шавжтай тэмцэхэд БОАЖЯ-ны Ойн хүрээлэнд 319 тонн DTMN-01 бактерийн бэлдмэл үйлдвэрлэж хэрэглэсэн байна. 2023 онд 8 үйлдвэр 0.5 мянган тонн бодис үйлдвэрлэж борлуулсан ба гурван ААНБ 3.0 мянган тонн компаст бордоо үйлдвэрлэж үйл ажиллагаандаа хэрэглэсэн байна. Ургамал хамгаалах бодисыг импортлох тусгай зөвшөөрөл бүхий 32 ААНБ нийт 1580 тонн ургамал хамгаалахад ашиглах бодис импортоор оруулсан байна. 2023 онд нийт 5834 тонн бордоо импортолсноос химийн гаралтай 5134 тонн, био болон органик бордоо 700 тонн байна.

Ургамал хамгааллын бодисын хяналт шалгалтын дүн. Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай”, ХХААХҮЯ-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус хангуулж, хяналт шалгалтыг чангатгаж, эрчимжүүлэх зорилгоор Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан “Ургамал хамгааллын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” 2023 оны 08-00-05/04 дүгээр удирдамжийн дагуу газар

тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 283 объектыг хамруулан нийслэл, 16 аймгийн хэмжээнд хяналт шалгалтыг хийсэн.

Тариалсан талбайн нэг га-д ногдох ургамал хамгааллын бодисын хэмжээ. Ургамал хамгаалалд ашиглах бодисыг үйлчлэх бодисын хэмжээнээс хамааруулж 2-4л/га тунгаар хэрэглэдэг. БОАЖС, ЭМС, ХХААХҮС-ын А/96, А-104, А/81 тушаалд нэг га-д ногдох ургамал хамгааллын бодисын хэмжээний тун, норм хэмжээ тодорхойлогдсон. Хилийн боомтууд дээр бодисын чанарын гэрчилгээг шалгаж, шаардлагатай тохиолдолд дээж авч, мэдрэхүйн шинжилгээ хийдэг бөгөөд дээжийг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Төв лаборатори руу илгээдэг. Гэвч тус лаборатори нь пестицидийн үйлчлэх бодисын хэмжээг тоон утгаар тодорхойлох чадамжгүй зөвхөн БТКУС кодоор таньж, пестицидийн ангиллынх мөн эсэхэд л шинжээчийн дүгнэлт гаргаж байна.

Өнөөдөр хувь хүн хүнсийг импортолж байгаа энэ үйлдэл нь хууль бус юм. Иймд **Хүнсний тухай хуулийн 3 дугаар бүлгийн 11.1.-д заасан** “Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно” гэсэн заалт хэрэгжихгүй байгаа. Иргэд хүнсийг импортлохдоо Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар баталсан зорчигчийн хувийн хэрэглээний хүнсийг хилээр нэвтрүүлэхтэй харилцааг зохицуулдаг холбогдох журмыг баталж, энэ журмын хэрэгжилтийн хүрээнд хүнсийг хувь хүн импортолж байна. Гаалийн ерөнхий газрын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний БТКУС кодоор бүртгэдэг бүртгэлийн нэр томьёоны зөрчлийн арилгах замаар энэ асуудлыг цэгцлэх хэрэгтэй.

Хүнсний тухай хуулийн 11.2.-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Албан хаагчдын ажилд түр томилох тухай Б/08 дугаар тушаалаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс нь Улаанбаатар хот дахь гаалийн газарт Гаалийн хорио цээрийн алба болгон нэгтгэснийг 82 дугаар зурагт харуулав. Энэ нь тарифын болон тарифын бус хяналт нэг дор тэгэхдээ тарифын хяналт тавьдаг байгууллагынхаа бүтцийн хувьд 1 нэгж болсон нь тарифын бус хяналт, шалгалтыг бие даасан, хараат бус хийгдэх олон улсын зарчим алдагдаж байна. Хоёр байгууллага нэгдсэнээр дараах давуу болон сул тал байна.

Энэ хуулийн 11.2.1.-д “экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байх”, **тус хуулийн 11.2.2.-д** “импортлох хүнс нь зохистой дадал, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх” гэж тус тус заасны дагуу Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын

хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаас гадна нэмэлт шаардлагыг хангахаар заасан. Энэхүү заалтын хүрээнд “Экспорт, импортын гэрчилгээ, импортын мэдэгдэл, дамжин өнгөрүүлэх мэдэгдэл олгох журам” болон “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам”-ыг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/81 тоот тушаалаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийг 70 хувьтай үнэллээ.

2019 оны байдлаар импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй байх заалтыг мөрдсөнөөр хадгалалтын хугацааг уртасгасан хүнсний бүтээгдэхүүн импортлогдож байгаа хувь хэмжээ 49.2 байсан байна. Энэ хуулийн 11.2.2.-д “импортлох хүнс нь зохистой дадал, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх” гэсэн заалт нь хүнсний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлох үед хүндрэл үүсэж байгаа талаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид ялангуяа Хүнсчдийн нэгдсэн холбооны зүгээс удаа дараа асуудал хөндсөн. Иймд энэ заалтыг өөрчлөх саналыг Монголын хүнсчдийн нэгдсэн холбооноос гаргаж байгаа.

Тухайлбал, импортоор оруулж ирж байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалах хугацааг ялгавартай тогтоох зохицуулалтыг тусгаагүйн улмаас аж ахуйн нэгжүүдэд түүхий эдийг импортлоход хүндрэл бэрхшээл тулгарч байна. Манай улсын хувьд далайд гарцгүй, худалдааны боомт цөөнтэй, Газарзүйн байршлын онцлогийг харгалзалгүй импортын түүхий эдийн хадгалах хугацааг 2/3 гэж заасны улмаас хэд хэдэн дараах хүндрэл бэрхшээлүүд тулгараад байна. Үүнд:

- Хил дээр их хэмжээний түүхий эд амт чанараа алдаагүй боловч тухайн хадгалах хугацааны шаардлагаас хураагдаж, устгагдаж байдаг.
- Хуурай сүү, Жимсний ургац жилд 1 удаа авдаг учраас жимсний өтгөрүүлсэн шүүс, зөөлөн эдийн татан авалт жил нэг удаа хийгдэнэ. Хүнсний үйлдвэрлэлд шинэхэн түүхий эд ашиглах хуулийн анхдагч зорилт биелдэггүй.
- Үйлдвэрлэгчид энэхүү эрсдэлээс зайлсхийж 1 жилийн нөөцийг нэг дор татан авснаар их хэмжээний валютыг гадаадад гуйвуулж, эргэлтийн хөрөнгийг урт хугацаанд түгждэг.
- Үндэсний үйлдвэрлэгчдийг хадгалах хугацаа богинотой шинэхэн түүхий эдийг импортлоход өндөр эрсдэл үүсгэж, хадгалах хугацаа богинотой түүхий эдээр үйлдвэрлэх шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломж хязгаарлагддаг байна.

Нэг талаас импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх заалтыг хэрэгжүүлснээр хадгалах хугацаа дуусах дөхсөн бүтээгдэхүүн импортлогдохгүй байгаа сайн тал байгаа хэдий ч нөгөө талд хадгалалтын хугацааг уртасгагчтай буюу хүнсний нэмэлттэй бүтээгдэхүүн импортлогдож байна. Хүнсний

нэмэлтийг тодорхойлох лабораторийн чадамжгүй, хүн амын хэрэглээнд хэрхэн нөлөөлөхийг тогтоох ямар ч боломжгүй байгаа нь хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүн импортлогдохоосоо илүү аюулыг үүсгэх нөхцөл бүрдсэн.⁶

Хүнсний тухай хуулийн 11.2.4.-д стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байхаар тусгагдсанд **2019 оны байдлаар МХЕГ-аас 40 хувийн хэрэгжилттэй** гэсэн үнэлгээ өгсөн байна. Энэ үнэлгээний дүн 2024 оны байдлаар хэвээр байгаа дараах хяналт шалгалтын дүнгээр батлагдсан болно.

Нийслэлийн хэмжээнд 2024 онд импортын 253 агуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд 50.2 хувь нь стандартын шаардлага хангасан агуулахтай, 60.3 хувь нь шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй байна. Нийслэлийн хэмжээнд хүнс импортлогч аж ахуйн нэгжүүдийн 49.8 хувь нь зориулалтын агуулахгүй, 36.7 тээврийн хэрэгсэлгүй байгаа нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүнсний сүлжээнд нийлүүлэхээс өмнө хадгалалт эрсдэл үүсэж байна. Импортлогч аж ахуйн нэгжүүд нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заагдсан хяналт шалгалтын байгууллагын бүртгэлийн систем буюу IGOV.mn-д бүртгүүлсэн хуудсаар хил, гаалиас бүтээгдэхүүнийг чөлөөлж байна.

Иймд стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, хадгалах агуулахтай байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх гэж өөрчлөх саналтай байна.

Хүнсний тухай хуулийн 11.3.-д импортлогч нь бүртгүүлээгүй, олон улсад хэрэглэдэг таних тэмдэг, тэмдэглэгээгүй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг импортлохыг хориглосон боловч энэ заалт хэрэгжилтийг гаргах боломжгүй юм. Учир нь дээрх хүнсийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх тогтолцоо бүрдээгүй тул бүртгэлийн ажил эхлээгүйтэй холбоотой байна. Иймд энэ заалтын хэрэгжилтийг **10 хувиар үнэллээ.**

Хүнсний баталгаат байдлыг баталгаажуулахын тулд хамгийн эхлээд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн хамт хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэдэг нэгдсэн тогтолцоог бий болгох, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн мэдээллийг хүнсний сүлжээний явцад нэгдсэн санд төвлөрүүлэх, түүнийг хянах улмаар баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход гарч буй хүндрэлүүдээс харахад тээвэрлэлтийн шаардлага хангаагүй болон чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаа хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах шаардлагатай хэдий ч

⁶ ГЕГ-ын албан мэдээ 2025-3-31

байгаль орчинд хор нөлөө үзүүлэх, үйл ажиллагааны нөхцөл, зардлаас шалтгаалах хүндрэлүүд үүсдэг учир буцаах, хурааж устгах шаардлагатай байна. Зөрчил үүссэн тохиолдолд арга хэмжээг заалт тус бүрд тодорхой тусгах хэрэгтэй гэж үзлээ.

2.4. Хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт

Хүнсний тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг нь хүнсний аюулгүй байдлын хяналт, бүртгэл, баталгаажуулалтын үйл ажиллагааг зохицуулж байна. Энэхүү хуулийн хэрэгжилтэд төр бүрэн хяналт тавьж чадаж эсэхэд үнэлгээ өгч, хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлсон байдал нь практикт нийцэж буй эсэхэд оролцогчдын зүгээс үнэлэлт дүгнэлт өгсөн.

Хүнсний аюулгүй байдлыг хангахад хэрэглэгчийн үүрэг хариуцлага, нөгөө талаас тэдний дэмжлэгийг төр хэр хүлээн зөвшөөрдөг байдалд дүн шинжилгээ хийлээ. Эцэст нь хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх энэхүү хуулийн зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэхийг дүгнэсэн. **Хуулийн хэрэгжилт 30 хувьтай байна.**

Үнэлэх хэсэг	- 12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын үйл ажиллагаа, түүний тогтолцоог, мөн аж ахуйн нэгжийн хариуцлагыг тодорхойлсон байна. - 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын үйл ажиллагааг тодорхой томъёолсон. - 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын үйл ажиллагааны оролцоог нэмэгдүүлнэ. - 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад хэрэглэгчийн зүгээс дэмжлэг үзүүлнэ. - 16 дугаар зүйл. Баяжуулсан бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах үйл явцыг тодорхойлсон байна. - 7 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаанд зохистой дадал нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах үйл явцыг сайн дураар хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
Томъёолсон шалгуур үзүүлэлт	- Хуулийн хэрэгжилтэд төр бүрэн хяналт тавьж чадаж буй эсэх? - Хэрэглэгч баталгаатай хүнсийг хэрэглэж чадаж байгаа эсэх? - Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоог тодорхойлсон байдал нь практикт нийцэж буй эсэх? - Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэгийг төр хэр хүлээн зөвшөөрдөг вэ? - Хүнсийг бүртгэх, үйл ажиллагааг баталгаажуулах талаарх хуулийн зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх?

- **Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт**

Хуулиар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хариуцахаар заасан. Холбогдох журмыг боловсруулж батлуулж мөрдөн ажиллахыг хуульчилсан.

Энэ ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд: Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх тухай **Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор журам** батлагдсан.

Хууль хэрэгжсэн 2013-2018 оны дунджаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт хүнсний худалдаа үйлчилгээний чиглэлээр 60.1 хувь, үйлдвэрийн чиглэлээр 73,2 хувь, Хоол үйлдвэрийн чиглэлээр 68.0 хувь, хувьтай гарсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/20 тушаалаар ерөнхий боловсролын сургуулиудад ажиллах “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан байна.

Хэдий үйл ажиллагаандаа дотоод хяналтыг явуулах дүрэм, журам батлагдсан ч хэрэгжилтийн байдалд хяналт тавьдаг мэргэжлийн байгууллага байхгүй байгаагаас энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Хяналт шалгалтаар дотоод хяналтын нэгж, ажилтны мэдлэг ур чадвар хангалтгүй, хүнсний үйлдвэрүүд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийх дотоодын хяналтын лабораторигүй, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториудад түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох техникийн зохицуулалт, техникийн ерөнхий шаардлагад заасан аюулгүйн үзүүлэлтүүдийг бүрэн шинжлүүлээгүй, үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлын бүртгэл дутуу, хүнсний сүлжээнд үл тохирлыг залруулах арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлээгүй зэрэг нийтлэг зөрчлүүд байна.

Тус хуулийн 12.3.-д зааснаар Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолын хавсралтаар “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам” батлагдсан. Гэвч журмын хэрэгжилтийн хувьд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хяналт тавих тогтолцоо алдагдсан, улмаар хяналтын үйл явц хангалтгүй түвшинд байна.

- **Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт**

Хүнсний тухай хуулийн 13.1.1 дэх заалтад тусгагдсан зах зээл дэх хүнсний чанар, шим тэжээллэг байдалд хийх тандалт судалгааг төрийн аль ч байгууллага хийгээгүй байна. Судалгааг хийх субъект нь тодорхой биш тул энэ заалтын хэрэгжилт “0” хувьтай байна гэж үнэлэгдсэн.

Гэхдээ 2023 онд ЭМЯ-ны Салбарын хяналтын газраас “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээг тодорхойлох урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” удирдамж боловсруулж батлуулан /2023.04.07-ны өдрийн 10-00/16/ орон нутагт хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн.

Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2.-д “хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт”-ыг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Энэ хүрээнд дараах арга хэмжээг холбогдох төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 532 сургуулийн дотуур байр үйл ажиллагаа явуулж байгаагаас 296 буюу 55.8 хувь нь хяналт шалгалтад хамрагдсан. Сургуулийн дотуур байрны хүүхдийн мах, гурил, төмс, ургамлын тос, сахарын хэрэглээ БШУС, ЭМС, СС-ын хамтарсан А/166, А/559, 222 дугаар тушаалд заагдсан зөвлөмж хэмжээг хангаж байгаа боловч сүү, цагаан идээ, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хэрэглээ нь зөвлөмж хэмжээг хангахгүй байна. Хоолны илчлэг, уураг, өөх тос, нүүрс усны дундаж хэрэглээ дээрх тушаалд заагдсан 7-10 насны хүүхдүүдийн зөвлөмж хэмжээг хангаж байгаа боловч 11-14, 15-18 насны хүүхдийн зөвлөмж хэмжээг хангахгүй байна. Хоолны илчлэгийн дундаж хэрэглээ 1728.7 ккал байгаа нь 7-10 настай хүүхдийн зөвлөмжийг хангаж байгаа боловч 11-14 насны хүүхдийн зөвлөмжөөс 26 хувь, 15-18 насны хүүхдийн зөвлөмжөөс 30.6 хувиар бага, уургийн дундаж хэрэглээ 61.3 г байгаа нь 7-10 насны хүүхдийн зөвлөмжөөс 9.9 хувь, 11-14 насны хүүхдийн зөвлөмжөөс 30.4 хувь, 15-18 насны хүүхдийн зөвлөмжөөс 37.5 хувиар бага, өөх тосны хэрэглээ 46.9 г байгаа нь 7-10 насны хүүхдийн зөвлөмжийг хангаж байгаа боловч 11-14 насны хүүхдийн зөвлөмжөөс 24.4 хувь, 15-18 насны хүүхдийн зөвлөмжөөс 27.9 хувиар бага, нүүрс усны хэрэглээ 245.5 г байгаа нь 7-10 насны хүүхдийн зөвлөмжөөс 10.8 хувь, 11-14 насны хүүхдийн зөвлөмжөөс 31.1 хувь, 15-18 насны хүүхдийн зөвлөмжөөс 34.9 хувиар тус тус бага байна. Дотуур байрны хоол нь ЭМС-ын 2017 оны А/74 тушаалд заагдсан А, С амин дэмийн зөвлөмж хэмжээг нийт сургуулийн 55.4-67.2 хувь нь хангаж байна. Дотуур байрны 90-ээс дээш хувь нь А/74 тушаалд заагдсан аль ч насны бүлгийн хүүхдийн цайрын зөвлөмж хэмжээг хангаж байна. Харин төмрийн хэрэглээний хувьд 7-10 насны хүүхдийн зөвлөмж хэмжээг хангасан сургууль 91.6 хувь, 11-14 насны хүүхдийн зөвлөмжийг 46.6 хувь, 15-18 насны хүүхдийн зөвлөмжийг 22 хувь нь хангаж байна. Хоолны В2 амин дэм, кальци, магнийн хэрэглээ нь дээрх тушаалд заагдсан зөвлөмж хэмжээг хангахгүй байгаа дүн гарсан.


Энэ хуулийн 13.1.2-т заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт хангалтгүй түвшинд байна. Учир нь зах зээл дээр гарал үүсэл нь тодорхойгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн худалдаасаар байна мөн хүн амын дунд хоол, хүнснээс шалтгаалсан хоолны хордлогот халдварт өвчлөлийн гаралт, тархалт буурахгүй байсаар байгаа нь төрийн хяналт шалгалтын чанартай шууд холбоотой юм.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хүнсний салбарт дараах техникийн зохицуулалтыг мөрдөж байна. Үүнд:

1. Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт, Засгийн газрын 2008 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 159 дүгээр тогтоол;
2. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, худалдааны техникийн зохицуулалт, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 304 дүгээр тогтоол;
3. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохицуулалт, Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 305 дугаар тогтоол;
4. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 224 дүгээр тогтоол;

Хүнсний холбогдолтой үндэсний стандартын тоо 2023 онд 650 болж өмнөх оноос 3 (0.5 хувь)-аар өссөн байна.

6 дугаар зураг. Хүнсний холбогдолтой нийт болон олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн стандартын тоо



Үндэсний 650 стандарт мөрдөж байгаагаас 256 буюу 39.4 хувь нь олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартын түвшинд хүрсэн, 394 буюу 60.6 хувь нь уялдуулсан стандарт байна. Хүнсний салбарын хууль тогтоомж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн зохицуулалтуудын хэрэгжилтэд 2022 оноос өмнө МХЕГ, 2023 оны 01 сараас салбарын хяналтын газраас хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж байна. МХЕГ байх үеийн хяналт шалгалтын тоо одоогийн салбарын хяналтаас хэрэгжүүлж буй хяналт шалгалтын тооноос их байна. Бодит

байдал дээр хүнсний хяналт, шалгалтын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон, хяналтын тогтолцоо гажуудсан, хяналтгүйгээр хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулах эрсдэлт байдал үүссэнтэй холбоотойгоор **хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй** байна.

2023 онд удирдлагаас өгөгдсөн үүрэг чиглэл болон иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Салбарын хяналтын газрын дарга, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 4 удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад нийт 2712 аж ахуйн нэгж, иргэн хамрагдсан ба хяналт шалгалтын явцад 1513 зөрчил илрүүлж газар дээр нь 935 зөрчил арилгуулж 34 зөрчилд улсын ахлах байцаагчийн 48 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, 4 зөрчилд Зөрчлийн тухай хууль болон ЗТХ-н дагуу хялбаршуулсан журмаар 151000 төгрөгийн торгууль ногдуулан, барагдуулж, хэрэг бүртгэлийн материалыг Нийслэлийн Прокурорын газарт хянуулж ажиллажээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан **төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх**ээр Засгийн газрын “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 08-00-02/07 дугаар удирдамжийн хүрээнд бялуу, бялууны бүтээгдэхүүний 146 үйлдвэрт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гүйцэтгэхээс 111 (76 хувь) үйлдвэр хамрагдсан.

Хяналт шалгалтыг удирдамжид тусгагдсан 8.4.1 кодтой хяналтын хуудасны асуумжийн хүрээнд үнэлэхэд хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 69 хувьтай байна. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын /ахлах/ байцаагчийн 858 заалт бүхий 71 албан шаардлагыг хүргүүлж, 57(51.4 хувь) үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт хийж, биелэлтийг хангуулан ажилласан. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр 28 заалт бүхий 3 зөвлөмж боловсруулан 10 үйлдвэрт хүргүүлжээ. Шалгалтад хамрагдсан 61(55 хувь) үйлдвэрийн 83 нэрийн бүтээгдэхүүнээс 63 актаар 109 дээж авч Стандарт хэмжил зүйн газрын ХАБҮЛЛ-ийн хими, хор судлалын лабораторид суурийн болон чимэглэлийн кремийн чихэрлэгийн агууламжийг тодорхойлуулсан байна. Мөн байгууллагын сургалтыг 41 иргэн, аж ахуйн нэгжийн 350 албан хаагчдын дунд зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтаар 12 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 1 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, 8 хуулийн этгээд, 5 иргэнд нийт 17.4 сая/төгрөгийн шийтгэл оногдуулан бүрэн барагдуулан ажилласан байна.

Гүйцэтгэлийн шалгалтыг 57(51.4 хувь) үйлдвэрт хийж, биелэлтийг хангуулсны дүнд эрсдэлийн түвшнийг 6.8 хувиар бууруулан ажилласан. Бялууны төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мөрдөгдөж буй хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 69 хувьтай байна.Стандарт, хэмжил зүйн газрын хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээнд 2023 онд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын хувь хими, нян судлал, хүнд металл, хор судлал, ургамал

хорио цээр, цацрагийн шинжилгээгээр 2.0 хувь, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр тооцсоноор 1.39 хувь, ундны усаар тооцсоноор 3.64 хувь байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 онд баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 579 объект хяналт шалгалтад хамрагдахаас 491 (84.8 хувь) хувь хамрагдсан байна. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг "Хоол үйлдвэрлэлийн газрыг шалгах хяналтын хуудас"-аар их эрсдэлтэй 60, дунд эрсдэлтэй 268, бага эрсдэлтэй 163 байгууллага үнэлэгдсэн байна.

Хоолны газруудыг Хоол үйлдвэрлэлийн газрыг шалгах хяналтын хуудасны бүлэг бүрээр хэрэгжилтийг үнэлэхэд технологи, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага хангасан үзүүлэлт 72.15 хувь, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой шаардлагын биелэлт 49.4 хувь, дотоод хяналт, мэргэжлийн шаардлага хангасан үзүүлэлт 65.06 хувь байна. Шалгалтаар илэрсэн 2455 зөрчил илрүүлж, 1264 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 198 аж ахуйн нэгж, иргэнд 1740 заалт бүхий улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага өгч 1414 заалт буюу 81.3 хувийг хангуулан ажилласан байна.

Мал үржүүлэг, технологийн хяналтын чиглэлээр 2024 онд 223 объект төлөвлөснөөс 121 объектод буюу 54.2 хувийн гүйцэтгэлтэй төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн байна. Хяналт шалгалтыг холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд их эрсдэлтэй 17, дунд эрсдэлтэй 45, бага эрсдэлтэй 57 объект үнэлэгдсэн. Хууль сахин мөрдөлтийн түвшин 45.4 хувиар үнэлэгдсэн ба хяналт шалгалтын явцад 1029 зөрчил илрүүлж, 41.9 хувь буюу 550 зөрчлийг арилгуулсан байна.

Ургамал хамгааллын хяналтын чиглэлээр 2024 онд 359 их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объект хамрагдахаас 292 объект хамрагдаж, 82.0 хувийн гүйцэтгэлтэй төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалт хийгдээгүй 65 объект буюу 18 хувь нь газар тариалангийн үйл ажиллагаа явуулаагүй байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектоос 17 нь их, 104 нь дунд, 171 нь бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн төлөвлөгөөт хяналт шалгалтад 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд нийт 374 мал эмнэлгийн нэгж буюу 91 хувь нь хамрагдаж, 37 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулахаа зогсоосон байна. Нийт хамрагдсан мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 35.6 хувь нь бага эрсдэлтэй, 58.3 хувь нь дунд эрсдэлтэй, 6,1 хувь нь их эрсдэлтэй үнэлэгдсэн дүнтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 420 дугаар "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" тогтоолын дагуу ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газраас хүнсний чанар, стандарт, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын 7 чиглэлээр 2493 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөж 1954 объект буюу 78.3

хувийг хамруулсан. Хяналт шалгалтын явцад 9 хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд их эрсдэлтэй 232, дунд эрсдэлтэй 942, бага эрсдэлтэй 780 объект тус тус үнэлэгдэж, шалгалтын явцад 5670 зөрчил илрүүлж, 4198 буюу 74 хувийг газар дээр нь арилгуулж ажилласан байна.

Энэ тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/487 дүгээр тушаалаар хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 560 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарласнаас 487(87 хувь) объект хамрагдаж, өмнөх 2023 онтой харьцуулахад гүйцэтгэл 17.16 хувиар нэмэгдсэн. Хяналт шалгалтад хамрагдаагүй 73 объектын шалтгаан нөхцөлийг тогтооход үйл ажиллагаа зогссон 43, үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 2, ажлын байрны зориулалт орон сууц болж өөрчлөгдсөн 2, бүртгэлтэй хаяг, байршилд байхгүй 14, барилгад өргөтгөл хийж байгаагаас түр үйл ажиллагаа зогссон 2, улсын байцаагч ажлаасаа гарснаас 9, томилолтын төсөв зардалгүй шалтгаанаар 1 объект тус тус хамрагдаагүй байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 487 объектыг 7 хяналтын хуудасны дагуу үнэлэхэд их эрсдэлтэй 55 (14.5 хувь), дунд эрсдэлтэй 235 (49.1 хувь), бага эрсдэлтэй 197(41.2 хувь), эрсдэл үүсэх магадлалын дундаж 34.9 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 66.0 хувьтай дүгнэгдэж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар хуульд заасан арга хэмжээг авч, 276 объектод гүйцэтгэлийн хяналт хийж ажилласны дүнд 37(7.7 хувь) нь их эрсдэлтэй, 217(45.5 хувь) нь дунд эрсдэлтэй, 233(47.8 хувь) нь бага эрсдэлтэй, эрсдэл үүсэх магадлалын дундаж 24.7 хувь, хууль тогтоомжийн хэрэгжилт 76.4 хувь болж, өмнөх 2023 оноос (68.3 хувь) 8.1 хувиар нэмэгдсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад ундны усны 99, үйлдвэрийн бохир ус 4, хоолны 22, хүнсний бүтээгдэхүүний 74 дээж, эрүүл зүйн арчдас шинжилгээг 781 цэгээс авч, лабораторийн шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг үндэслэн 41 улсын (ахлах) байцаагчийн дүгнэлт гарсан байна.

Улсын хэмжээнд ХХААХҮЯ-ны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу мах, махан /хиам, бууз, банш, хагас боловсруулсан, нөөшилсөн/ бүтээгдэхүүний 161 үйлдвэр, цехийг 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар зарласнаас нийслэл, орон нутаг дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хиамны 36, нөөшилсөн 1, бууз банш, хагас боловсруулсан бүтээгдэхүүний 49, бусад 10, нийт 80 аж ахуйн нэгж, 20 иргэний нийт 100 объект (62.1 хувь)-од хяналт шалгалт хийлээ. Шалгалтад хамрагдсан объектуудаас их эрсдэлтэй 5, дунд эрсдэлтэй 49, бага эрсдэлтэй 49 үнэлэгдсэн байна.

Урьдчилан сэргийлэх шалгалтын дүнгээс дурдахад, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1237 ААН, иргэдийг хамруулан хяналт шалгалтыг хийсэн байна. Баяр наадмын өдрүүдэд зохион байгуулагдсан нийслэл, аймаг орон нутагт наадмын талбайд 553, морь барианы газарт 469, бусад

байрлалд 106 цэг, нийт 1128 хуушуур, шорлог болон үйлдвэрлэлийн цэгт нийт 1237 объектод хяналт тавин ажилласан байна.

Улсын хэмжээнд 281 цэцэрлэг, 224 ерөнхий боловсролын сургууль, 48 дотуур байр, 37 бусад (худалдааны төв, бэлтгэн нийлүүлэгч), нийт 590 объектыг хамруулан хяналт шалгалт хийсэн. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг удирдамжид заагдсан асуумжийг чиглэл болгон шалгаж, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал, дотоод хяналтын үйл ажиллагаа, хүүхдийн хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд хяналт шалгалт хийжээ.

Шалгалтад хамрагдсан газруудын 336 (60,7 хувь) нь барилга байгууламж стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталсан зураг төслийн дагуу баригдсан, 280 (47,4 хувь) хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагыг нэг чигийн урсгалтай, хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахтай байхаар зохион байгуулсан, 392 (70.8 хувь) нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хүрэлцээтэй, 250 (45.2 хувь) нь аяга таваг угаах төхөөрөмжтэй, 436 (78.8 хувь) нь аяга таваг ариутгах төхөөрөмжтэй, 95 буюу 71.4 хувь нь түүхий эд хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын гэрчилгээ, баталгаажилттай, 476 (86.7 хувь) нь хүүхдэд зориулсан иж бүрдэл бүхий хоолны цэстэй, 380 (68.7 хувь) нь хоол тус бүрд боловсруулах технологи ажиллагааг бүрэн тусгаж эрх бүхий албан тушаалтнаар батлуулсан, мөрдөж ажилладаг, 312 (56,4 хувь) нь хоол, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалт, хадгалалтын горимд температурын хяналт хийж, бүртгэл хөтөлж хэвшсэн, цэцэрлэг, сургуулиудын 111 (20 хувь) нь хоол зүйчээр хангагдсан, 364 (65.8 хувь) нь дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулан, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгах арга хэмжээ авч, хэрэгжүүлж хэвшсэн байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 53.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний 62 дугаар асуудал Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу зах зээлд худалдаалагдаж буй дотоодын үйлдвэрийн нөөжилсөн, даршилсан бүтээгдэхүүний худалдаалдаг худалдаа, үйлчилгээ эрхлэгч 214 иргэн, 127 аж ахуй нэгжийг хамруулсан ба хяналтын явцад давхардсан тоогоор 236 зөрчил илрүүлэн, 124 буюу 52.5 хувийг арилгуулсан байна.

Урьдчилан сэргийлэх шалгалтаар хүнсний үйлдвэрт хугацаа дууссан уураг, хүнсний будаг, бэлэн жор, перец, хиамны бүрхэвч хадгалсан, үйлдвэрлэлд хэрэглэсэн, хугацаа дууссан хадгалсан, хугацаа дууссан хадгалсан, агуулахад чийг, температурыг хянаж бүртгэдэггүй, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр бэлэн бүтээгдэхүүн

дэх давсны агууламж стандартад заагдсан хэмжээнээс их гарсан зэрэг зөрчил гаргасан 4 ААН, 1 иргэнд нийт 26800000 (хорин зургаан сая найман зуун мянган) төгрөгийн шийтгэл ногдуулсан байна.

Улсын хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 1085 иргэн, аж ахуйн нэгжээс хяналт шалгалтад 852 (78,56 хувь) хамрагдсан. Үүнээс 166 (40.6 хувь) иргэн, аж ахуйн нэгж ургамал хамгааллын химийн бодис хэрэглэж, үлдсэн 242 (59.4 хувь) иргэн, аж ахуйн нэгж нь биологийн гаралтай (малын өтөг бууц, шувууны цангис) бордоо хэрэглэж байна. Хяналт шалгалтын явцад 430 дээжид пестицид үзүүлэхээр Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжлүүлжээ.

Монгол Улсад тус онд ургамал хамгааллын бодис, бордоо импортлох, борлуулах тусгай зөвшөөрөлтэй 46 аж ахуйн нэгж 1980 тонны квот авсан байна. Ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглаж буй пестицидийн 85 орчим хувийг үр тарианд, 15 орчим хувийг төмс, хүнсний ногоонд хэрэглэж байна. Хяналт шалгалт хийх хугацаанд 96 зөрчил илрүүлж газар дээр 60 зөрчил арилгуулж, 36 зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллажээ.

2024 онд улаан буудай 314000 га талбайд тариалж 386441 тонн ургац хураан авсан. Үүнээс өөрийн үрэнд 39232 тонн нөөцөлсөн. Үлдсэн ургацыг хүнсэнд болон тэжээлд бусад зориулалтаар нийлүүлсэн байна. Хяналт шалгалт хийгдээгүй 65 объект буюу 18 хувь нь газар тариалангийн үйл ажиллагаа явуулаагүй байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектоос 17 нь их, 104 нь дунд, 171 нь бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн байна. Улсын /ахлах/ байцаагчийн нийт 272 албан шаардлага, 38 дүгнэлт, 117 зөвлөмжийг хүргүүлж, хялбаршуулсан журмаар 12 зөрчлийг арилгуулсан байна.

Хөдөө аж ахуйн корпорацаас жил бүр буудайн чанарын үзүүлэлт болох үнслэг, цавуулаг, уналтын тоо, хорио цээрийн микробиологийн үзүүлэлтүүд нь стандартын шаардлага хангагдахгүй тохиолдолд “Улсын нөөцөд хүлээн авах буудайн стандартын шаардлагыг шинэчлэх тогтоох тухай түр журам”-ыг баталж, журмын дагуу стандартын шаардлага хангахгүй буудайг улсын нөөцөд авдаг тогтолцоо хэдийн бий болсон. Хууль болон стандартаас давсан тушаалыг Хөдөө аж ахуйн корпорацын дарга гаргаж, хэрэгжүүлж байгаа нь эрх зүйг ноцтой зөрчиж байна. Тухайлбал, улаан буудайн үр болон хүнсний чанарын стандартын шаардлагыг хангахгүй тохиолдолд түр журам гарган, тус журмын дагуу стандартын шаардлага хангахгүй үр, хүнсний улаан буудайг хүлээн авдаг жишиг тогтжээ. Улаан буудайг стандартын шаардлагад тэнцүүлэх, тэнцүүлэхгүйг тухайн удирдлага шийдэж тэжээлд тэнцэх байсан улаан буудайг хүнсний ангилалд шилжүүлдэг болсон нь энэ салбарт мэргэжлийн удирдлага алдагдсаны нэг тод жишээ юм. Үүний үр дагавар нь хүнсний үйлдвэрүүдэд чанарын шаардлага хангахгүй түүхий эдийн хангалт бий болж нөгөө талаас үйлдвэрлэгчид түүхий эдээ голон импортын буудай авах сонирхол бий болдог байна. Энэ нь жил бүр гардаг асуудал болсон. Стандартын шаардлага хангахгүй буудайг улсын нөөцөд хүлээн авсны дараагийн жил нь үрийн буудайн хомсдолд ордог болсон. Учир нь үрийн

бодлого алдагдаж гурилын татааст өгдөг тул жил бүрийн хавар үр байхгүй, үрийн хэмжээ дутдаг болсон. Мөн ОХУ-аас үр авах асуудлаар жил бүр гэрээ хэлэлцээр хийж үрийг хилээр оруулж ирэхэд импортын үрийн дээжид лабораторийн шинжилгээ хийхэд мөн чанарын шаардлага хангахгүй, элит биш 2 дугаар ангиллын үрийг импортолдог асуудал хил дээр үүсдэг. ОХУ-аас чанарын шаардлага хангахгүй үрийг импортолж байна. Үүнд тавих хяналт байхгүй байна. Энэ бүгдийн салбарын яамнаас зохион байгуулж буй арга хэмжээ юм. Иймд яам өөрөө өөрийнхөө үйл ажиллагаанд хяналт тавих асуудал бол тогтолцооны, мөн үйл ажиллагааны гажуудалд орсныг илтгэж байна. Энэ бүгдээс дүгнэхэд улсад эдийн засгийн асар их хохирлыг учруулж байна гэж дүгнэхээр байна. Иймд 2010 оноос хойш дээр дурдсан түр журмаар авсан улаанбуудайн тоо хэмжээг ирүүлэх тусгайлан хянан шалгах шаардлагатай байна гэж үзэж байна. Хяналтын чиг үүрэг яамны харьяа салбарын хяналтад шилжсэнээс хойш энэ чиглэлийн хяналт шалгалтын дүн мэдээ хангалтгүй байна.

Цаашид салбарын сайд, агентлагийн удирдлагаас хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, баталгаат байдалтай холбоотой дүрэм, журам, заавар батлахгүй байхыг анхаарах хэрэгтэй. Иймд хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, түүхий эд, бүтээгдэхүүнд зөвхөн стандартыг мөрдлөг болгосноор хүнсний чанар, эрүүл ахуйн үзүүлэлтүүд нь зөвхөн стандартын шаардлагад нийцсэн байх учиртай. Улмаар салбарын түвшинд мэргэжлийн удирдлагаар хангагдах нэг нөхцөл бүрдэнэ.

Бэлчээрийн ургамал хамгааллын үйл ажиллагаанд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 2024 онд 8 аймгийн 52 сумын хэмжээнд 141500 га талбайд 283тн бактобромадпионы өгөөшөөр нийт 67.3 хувьд хийсэн байна. Энгийн механик биологийн аргаар тэмцсэн үр дүн 76 хувь хийгдсэн 9 зөрчил илрүүлж, 9 заалт бүхий 4 албан шаардлага, 42 зөвлөмж өгч ажиллажээ. Таримал ургамлын үр сортын хяналтын чиглэлээр 2024 онд 327 объектоос 295 объектод буюу 90.2 хувийн гүйцэтгэлтэй урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, стандартын шаардлага хангасан үрээр тариалалтыг хийсэн байна.

Таримлын үр сортын хяналтын чиглэлээр 2024 онд 359 их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объект хамрагдахаас 292 объект хамрагдаж, 82.0 хувийн гүйцэтгэлтэй төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. 442 объектод улаан буудайн үрийн чанар, үрийн нөөцийн бүрдүүлэлтийн чанарт хяналт шинжилгээ хийж, таримлын үрийн нөөцийг бүрдүүлсэн.

Таримал ургамлын үрийн импорт, худалдаа эрхлэгчдэд гарал үүсэл тодорхой, тарих үр, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан, Үр сортын зөвлөлийн хурлаар батлагдсан нутагшсан болон ирээдүйтэй, шинэ сортын жагсаалтад багтсан үрийг худалдан борлуулах, тариалах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 20 албан бичиг, улсын /ахлах/ байцаагчийн 209 заалт бүхий 26 зөвлөмж, 57 заалт бүхий 11

дүгнэлт, 19 заалт 5 албан шаардлагыг гарган ХХААХҮЯ-д хүргүүлж ажилласан боловч энэ зөрчил жил бүр гардаг болсон.

Хууль эрх зүйн орчин бүрдээгүй буюу Эрчимжсэн аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, ариун цэврийн нийтлэг журам батлагдаагүй, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт ороогүй тул урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдээгүй. Мал эмнэлгийн салбарт УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төсөв санхүүжилт хангалттай хэмжээнд шийдэгдсэн. Гэтэл Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн хэрэгжээд 3 жилийн хугацаа өнгөрч байхад энэ чиглэлийн хяналт шалгалт хийгдээгүй гэдэг нь салбарын хяналтын газрын зүгээс хариуцлагагүй үйлдэл болсон байна гэж дүгнэж байна.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны удирдамжийн дагуу хяналт шалгалт хийхэд улсын хэмжээнд өвс 18,796 тонн бэлтгэхээс 94,5 хувь, тэжээл 12,420 тонн бэлтгэхээс 79,1 хувь буюу дунджаар 86,8 хувийн гүйцэтгэлтэйгээр бэлтгэсэн нь тогтоогдсон байна.

Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-нд туссан 7 сэдвийн хүрээнд Салбарын хяналтын газрын даргын баталсан 8 удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Хяналт шалгалтад нийслэл, 18 аймагт (Архангай, Өвөрхангай, Дундговь аймгийн ЭМГ-т улсын байцаагчгүй) нийт давхардсан тоогоор 7678 ААН, иргэн хамрагдаж, 14339 зөрчил, дутагдал илрүүлж зөрчлийг арилгуулах шаардлагыг өгч ажилласан байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулсан дүнгээс дурдахад салбарын хяналтын газар, 18 аймаг, нийслэлийн ЭМГ-ын Хяналт шалгалтын хэлтсээс 2024 онд иргэний өргөдөл гомдлоор 349 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, зөрчлийн шинжгүй үйлдэлд илэрсэн дутагдлыг 1094 заалттай 121 албан шаардлага хүргүүлэн тайлант хугацаанд 76.7 хувийг арилгуулж, 1 гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзан, илэрсэн зөрчилд 60-г хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 17 зөрчлийн хэрэг үүсгэн, 2 зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 2 зөрчлийг харьяаллын дагуу шилжүүлэн ажилласан байна.⁷

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавхыг одоо шинжилж байгаа аюулгүйн үзүүлэлт нь нийт баталсан аюулгүйн үзүүлэлтэд эзлэх хувиар тооцсон ба улсын хэмжээнд 2023 онд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадавх 70.17 хувь байна.

⁷ ЭМЯ-ны салбарын хяналтын газрын мэдээ, 2024 он

7 дугаар хүснэгт. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадавх

Үзүүлэлт	2021	2022	2023
Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн хувь ¹	70.17	70.17	70.17
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй нэр төрлийн тоо ²	108	129	188
Пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувь ²	42.86	51.19	74.6


Эх үүсвэр: ¹ХАБҮЛЛ, ²ХАБҮЛЛ, УХЭШХ, УМЭАЦТЛ, Демо лаборатори

Пестицидийн үлдэгдлийг хянах үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан нийт пестицидийн үлдэгдэлд эзлэх хувиар улсын хэмжээнд хэдэн нэр төрлийн пестицидийн үлдэгдлийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж буй хувийг тооцоход 0.81 хувь байна.

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүнсний үйлдвэрлэлд хэрэглэж буй хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох лаборатори 35 нэр төрлийн хүнсний нэмэлтийг шинжлэн тодорхойлох чадамжтай байгаа бол хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд транс тосыг шинжлэн тодорхойлох чадамжтай лаборатори бүртгэгдээгүй байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн шинжилгээнд хүнсний бүтээгдэхүүний нийт 46.5 мянган дээж хамрагдаж, 99.2 мянган сорьц хийгдсэнээс эерэг сорьц 4.3 хувь, эерэг үзүүлэлт 2.1 хувь илэрсэн байна. ХАБҮЛЛ-ийн шинжилгээнд дотоодын хүнсний бүтээгдэхүүний 31.6 мянган дээж хамрагдаж, 57.6 мянган сорьц хийгдсэнээс эерэг сорьц 6.8 хувь, эерэг үзүүлэлт 2.8 хувь илэрсэн байна.

7 дугаар зураг. Лабораторийн шинжилгээнд хамрагдсан хүнсний бүтээгдэхүүний бохирдлын түвшин, 2023 он



СХЗГ-ын Итгэмжлэгдсэн сүлжээ лаборатори болон ХАБҮЛЛ-ийн нийт шинжилгээний дүнгээс дурдвал, 2023 оны байдлаар ХАБҮЛЛ болон итгэмжлэгдсэн сүлжээ лабораторид нийт 66952 дээж 335499 үзүүлэлтээр шинжлэгдсэн байна. Үүний 2,1 хувь буюу 7144 үзүүлэлт шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна. ХАБҮЛЛ-д

2023 онд хүнсний бүтээгдэхүүнд чанар аюулгүй байдлын хяналтын шинжилгээг нийт 29660 дээжид хими, микробиологи, ургамлын эрүүл ахуйн хорио цээр, цацрагийн хяналтын чиглэлээр 164314 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс 1627 үзүүлэлт шаардлага хангаагүй дүнтэй гарсан нь нийт үзүүлэлтийн 1 хувийг эзэлж байна.⁸

2024 оны байдлаар ХАБҮЛЛ болон итгэмжлэгдсэн сүлжээ лабораторид нийт 75564 дээж 372888 үзүүлэлтээр шинжлэгдсэн байна. Үүний 2,5 хувь буюу 9498 үзүүлэлт шаардлага хангаагүй дүнтэй гарсан байна. ХАБҮЛЛ-д 2024 онд 28143 дээжид хими, микробиологи, ургамлын эрүүл ахуйн хорио цээр, цацрагийн хяналтын чиглэлээр 157180 үзүүлэлтээр шинжилгээ хийснээс стандартын шаардлагад нийцээгүй үзүүлэлт 1544 байгаа нь нийт үзүүлэлтийн 0,98 хувийг эзэлж байна.⁹

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын болон аюулгүйн үзүүлэлтээр Үндэсний MNS/ISO 17025 стандартын дагуу эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн төрийн өмчит 25 лаборатори хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд: 21 аймаг тус бүрд 1, нийслэлд 4 лаборатори үйл ажиллагаа явуулж байна.

ХХААХҮЯ-ны хяналт шалгалтаар, итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторийн шинжилгээнд нийт 830 дээж хамрагдсанаас хими, нян судлал, хүнд металл, хор судлал, ургамал хорио цээр, цацрагийн шинжилгээгээр хүнсний бүтээгдэхүүний бохирдол 32 буюу 0.038 хувь, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр тооцсоноор мах, махан бүтээгдэхүүний 132 дээж хамрагдсанаас бохирдол 14 буюу 10.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний 51 дээж хамрагдсанаас бохирдол 4 буюу 0.08 хувь байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шалгалтаар 2023 онд 402.8 килограмм, 29.0 литр, 12.3 мянган ширхэг бүтээгдэхүүн хураасан байна. Хяналт шалгалтаар буцаасан бүтээгдэхүүн 300.0 килограмм болж, өмнөх оноос 291.0 килограмм (33 дахин)-аар, 755.0 литр болж, 605.0 литр (5 дахин)-ээр, 1.7 мянган ширхэг болж, 1405 ширхэг (6 дахин)-ээр өссөн байна. Татан авсан бүтээгдэхүүний хэмжээ 2.6 тонн (98.3 хувь)-оор, 108.0 литр (95.6 хувь)-ээр, 4.7 мянган ширхэг (97.9 хувь)-ээр тус тус буурсан байна.

ХАБҮЛЛ-ийн шинжилгээнд импортын хүнсний бүтээгдэхүүний 14.9 мянган дээж хамрагдаж, 41.6 мянган сорьц хийгдсэнээс эерэг сорьц 0.9 хувь, эерэг үзүүлэлт 0.5 хувь илэрсэн байна.

8 дугаар хүснэгт. Хяналт, шалгалтаар хураасан, буцаасан, татан авсан, устгасан хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Хураасан бүтээгдэхүүн	килограмм	14 782.2	1 470.7	-	402.8 ²	-
	литр	1 343.0	369.1	-	29.0 ²	-
	ширхэг	55 077	16 910	-	12 251 ²	-
	килограмм	198.8	957.6	9.0	300.0 ²	33 ¹

⁸ ХАБҮЛЛ-ийн 2023 оны шинжилгээний дүнгээс

⁹ ХАБҮЛЛ-ийн 2024 оны шинжилгээний дүнгээс

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Буцаасан бүтээгдэхүүн	литр ширхэг	- 2 222	44.0 4 225	150.0 306	755.0 ² 1 711 ²	5 ¹ 6 ¹
Татан авсан бүтээгдэхүүн	килограмм литр ширхэг	60.0 66.5 1 593	85.6 63.5 4 287	2 609.9 113.0 4 816	43.1 ² 5.0 ² 99 ²	-98.3 -95.6 -97.9
Устгасан бүтээгдэхүүн	килограмм литр ширхэг	3 058.4 1 267.0 63 764	1 317.1 193.9 17 717	666.3 127.0 6 504	15.0 ³ 36 088.0 ³ 11 674 ³	-97.7 284 ¹ 79.5

Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар 2023 онд 15.0 килограмм, 36.1 мянган литр, 11.7 мянган ширхэг бүтээгдэхүүн тус бүр устгасан байна. ХХААХҮЯ-ны хяналт, шалгалтаар 2023 онд 943 төрлийн 89.3 мянган ширхэг хүнсний бүтээгдэхүүн хураасан бол 98 төрлийн 1.6 мянган ширхэг хүнсний бүтээгдэхүүн татан авсан байна.

INFOSAN мэдээллийн санд 2023 онд буцаан татсан хүнсний 9075 бүтээгдэхүүн бүртгэгдсэний 6465 (71.2 хувь) бүтээгдэхүүн Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

ХХААХҮЯ-наас явуулсан хяналт, шалгалтад нийт 7.0 мянган ААНБ, 5.1 мянган иргэд хамрагдаж, өмнөх оноос зөрчил гаргаж үйл ажиллагааг нь түр зогсоосон ААНБ-ын тоо 38-аар, иргэдийн тоо 5-аар өссөн байна.


9 дүгээр хүснэгт. Хяналтад хамрагдсан, үйл ажиллагааг зогсоосон, сэргээсэн ААНБ, иргэдийн тоо

Үзүүлэлт	2020		2021		2022		2023	
	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд	ААНБ	Иргэд
Хяналтад хамрагдсан	15 179	6 711	4 075	3 661	8 313	-	6957	5064
Үйл ажиллагааг түр зогсоосон	31	49	35	37	6	-	44	5
Үйл ажиллагааг сэргээсэн	20	38	24	29	3	-	-	-

Эх үүсвэр: ХХААХҮЯ

ХХААХҮЯ-наас хүнсний салбарт явуулсан хяналт, шалгалтаар нийт 34.8 мянган зөрчил илрүүлснээс 66.7 хувь буюу 23.2 мянган зөрчлийг арилгуулсан байна. Илрүүлсэн зөрчлийн 40.1 хувийг дотоодын хяналтын, 30.0 хувийг барилга, байгууламжийн норм дүрмийн, 10.0 хувийг технологийн үйл ажиллагааны мөн түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын, 7.0 хувийг сав, баглаа, боодол, хаяг, шошгын, 3.0 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн зөрчил эзэлж байна. Харин эдгээр зөрчил тус бүрийн 50.2-73.8 хувийг арилгуулжээ.

8 дугаар зураг. Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн зөрчил, салбараар, дүнд эзлэх хувиар



9 дүгээр зураг. Хяналт, шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн хувь, салбараар




ЭМЯ-наас эрүүл ахуйн чиглэлээр явуулсан хяналт, шалгалтаар нийт 9.4 мянган зөрчил илрүүлснээс 64.6 хувь буюу 6.0 мянган зөрчлийг арилгуулсан байна.

Илрүүлсэн зөрчлийн 20.5 хувийг ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн, 20.2 хувийг ариун цэвэр, эрүүл ахуйн, 13.7 хувийг дотоодын хяналтын, 11.7 хувийг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын, 11.1 хувийг хадгалалт, тээвэрлэлтийн, 10.0 хувийг барилга, байгууламжийн норм дүрмийн, 8.2 хувийг сав, баглаа, боодол, хаяг, шошгын, 4.6 хувийг технологийн үйл ажиллагааны зөрчил эзэлж байна. Харин эдгээр зөрчил тус бүрийн 41.5-77.3 хувийг арилгуулжээ.


10 дугаар зураг. Хяналт, шалгалтын явцад илрүүлсэн болон арилгуулсан зөрчил

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан



Эх үүсвэр: ЭМЯ

11 дүгээр зураг. Хяналт, шалгалтын явцад арилгуулсан зөрчлийн хувь, салбараар



Эх үүсвэр: ЭМЯ

Энэ хуулийн 13.1.3-д заасан заалтын хэрэгжүүлэх хяналтыг тодорхой болгох шаардлагатай байна. Учир нь МХЕГ-ын бүтцэд өөрчлөлт орж, хяналтын чиг үүрэг салбарт шилжсэнтэй холбоотойгоор энэ чиг үүрэг аль хяналтын байгууллагад байхгүй болсон байна. Энэ мэт зарим хяналтын чиг үүрэг бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн үед хоцорсон, үлдсэн байна. Тухайлбал, Гаалийн тухай хуульд хорио цээрийн хяналт гэсэн утга байхгүй болно.

Тодруулбал, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Албан хаагчдын ажилд түр томилох тухай Б/08 дугаар тушаалаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт,

хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс нь Улаанбаатар хот дахь гаалийн газарт Гаалийн хорио цээрийн алба болгон нэгтгэснийг 82 дугаар зурагт харуулав. Энэ нь тарифын болон тарифын бус хяналт нэг дор тэгэхдээ тарифын хяналт тавьдаг байгууллагынхаа бүтцийн хувьд 1 нэгж болсон нь тарифын бус хяналт, шалгалтыг бие даасан, хараат бус хийгдэх олон улсын зарчим алдагдаж байна. Хоёр байгууллага нэгдсэнээр дараах давуу болон сул тал байна.

ХХААХҮЯ-аас олгосон квотын дагуу **Хүнсний тухай хуулийн 13.1.4. дэх** заалтад тусгагдсан стратегийн хүнс экспортлох, импортлох тохиолдолд энэ хуулийн 6.8-д заасан зөвшөөрөл олголтын үйл явцад хяналт шалгалтыг 2022 он хүртэл МХЕГ хийдэг байсан бол 2022 оноос хойш ХХААХҮЯ-ны харьяа салбарын хяналтын газраас явуулдаг болсон. Салбарын хяналтын газрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтын удирдамжид энэ чиглэлээр хяналт хийгээгүй байна.

Хүнсний баталгаат байдалд тавих хяналтыг Хяналт шалгалтын тухай хуулиар хэрэгжүүлэх тухай **энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д зааснаар** харилцааг зохицуулж байна.

Хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах тогтолцоо чухал үүрэгтэй. Өмнөх бүлгүүдэд тодорхойлсноор хүнсний аюулгүй байдал гэдэг бол хүнсний хангамж, хүртээмж, хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал болон хүнсний шимт байдал гэсэн ойлголтыг нийгмийн гурван түвшинд өөр өөр тодорхойлж болох хэдий ч эдгээр түвшин хоорондын хамаарал маш их байгаа тул нэгийг нөгөөгөөс салган томьёолох, салангид авч үзэх нь учир дутагдалтай гэж үзэж байна. Харин хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хүнсний сүлжээний нэг ч үе шатыг орхигдуулахгүйгээр үндэсний түвшинд удирдах, зохицуулах, хяналтыг хүнсний сүлжээг тасалдуулахгүйгээр хэрэгжүүлэх зэрэг чиг үүргийг Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр зааж өгөх учиртай. Төрийн бодлого тодорхойлох дотоод хүчин зүйлс нь бодлого боловсруулах улс төрийн үйл явцын өрнөл байх бөгөөд Засгийн газрын бүтэц зохион байгуулалт, яам, агентлагийн чиг үүргийн зохицуулалт нь чухал хэрэгсэл болдог.¹⁰

Манай улсын хувьд хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр бодлого гарсан боловч хэрэгжилт бүрэн хангагдах зохион байгуулалтын хэвтээ тогтолцоо буюу үйл ажиллагааны уялдааг хангах нөхцөл бүрдээгүй, дунд болон анхан шатны нэгж дээр төрийн үйлчилгээг чанартай хүргэж чадахгүй байна. Иймд бодлогын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын хэвтээ тогтолцооны эрх зүйн болон бодлогын баримт бичиг гаргах нэн шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл

¹⁰ Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн, О.Цэрэнчимэд бусад, Төрийн бодлого, УБ.,2021, х.22

ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Албан хаагчдын ажилд түр томилох тухай Б/08 дугаар тушаалаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс нь Улаанбаатар хот дахь гаалийн газарт Гаалийн хорио цээрийн алба болгон нэгтгэснийг 82 дугаар зурагт харуулав. Энэ нь тарифын болон тарифын бус хяналт нэг дор тэгэхдээ тарифын хяналт тавьдаг байгууллагынхаа бүтцийн хувьд 1 нэгж болсон нь тарифын бус хяналт, шалгалтыг бие даасан, хараат бус хийгдэх олон улсын зарчим алдагдаж байна. Хоёр байгууллага нэгдсэнээр дараах давуу болон сул тал байна.

Малын эмийн хэрэглээнээс үүдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд илрэх эмийн үлдэгдлийг хянах тогтолцоо хангалтгүй байна. Мах махан бүтээгдэхүүн болон сүү, өндөг, зөгийн бал гэх мэт мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд ялангуяа антибиотикийн үлдэгдлийг шалгах механизмыг улам боловсронгуй болгох шаардлага байсаар байна. Малын эмийн хэрэглээ болон ард иргэдийн эмийн зохисгүй хэрэглээнээс олон эмд тэсвэртэй нян ихсэж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна нянгийн дасал үүсгэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал юм.

Эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрсөн ч мэдэгдэхүйц үр ашигтай байдалд хүрэхгүй байгаа нь үйл ажиллагааны доголдол төдийгүй хүнс болон эм хангамжийн сүлжээнд тавих хяналтыг сулруулсан. Хяналтын байцаагчийн ёс зүйн хяналт сул байгаа нь нийгэмд сөрөг уур амьсгал бий болгосон. Хяналт шалгалтын объектын хуваарилалт оновчгүй, өргөдөл гомдлын дагуу хяналт хийхэд тодорхой шалгуургүй тул зөрчил дутагдлын үндсэн шалтгааныг илрүүлэх боломжгүй гэж үзэж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын босоо тогтолцоо нь орон нутгийн түвшинд алдагдаж хяналт шалгалт үр нөлөөгүй байх нөхцөл бүрдсэн байсан. Тухайлбал Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлагийн бүтэцтэй, дүүрэг тус бүрд 1 байцаагч ажиллуулж хүний нөөцийг тарамдуулсан, захиргааны зардлыг хэт нэмэгдүүлсэн зохисгүй тогтолцоотой байна. Мөн хяналт шалгалт нь зохицуулалтын бусад үйл ажиллагаатай өдөр тутамд нягт улдаагүй байгаагаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж хүн амын аюулгүй амьдрах баталгааг хангах хүн төвтэй хяналт зохицуулалт хийх боломжгүй байдалд хүргэжээ.

Хэдийгээр хууль эрх зүйн орчин бүрдсэн ч хүнс болон эмийн бүтээгдэхүүний савлалт, хаяглалтын нэгдсэн хяналт, зохицуулалт сул байсаар байна. Үл ойлгогдох, хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөөгүй хэл дээр бичсэн шошго бүхий бүтээгдэхүүн зах зээлд байсаар байна. Биологийн идэвхт бүтээгдэхүүн нь эм, хүнсний хооронд олон жилийн туршид хаягдсанаас зохицуулалт, хяналтгүйгээр зах зээл дээр газар авсан, эдгээр бүтээгдэхүүний талаар үнэн зөв баталгаажсан мэдээлэл хангалтгүй, бодит бус мэдээлэл сурталчилгаанаас иргэд төөрөлдөж, сүлжээгээр, өндөр үнэтэйгээр,

мэргэжлийн бус хүнээс авч хэрэглэн санхүүгийн хямралд ороод зогсохгүй зохисгүй хэрэглэж эрүүл мэндээрээ хохирч байна.

Монгол Улсад нийлүүлэлтийн сүлжээний тогтолцоо бүрдээгүй. Цаашид хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд цахим бүртгэлийн нэгдсэн системийг нэвтрүүлж, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогчид уг цахим бүртгэлийн нэгдсэн санд өөрийн ерөнхий болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол оруулдаг, шинэчилдэг болж хэвшсэнээр хүнсний сүлжээнд тавих байнгын хяналт, шалгалтын тогтолцоо бүрдэнэ, улмаар иргэдийн зүгээс эрүүл мэнддээ хандах хандлага, мөн өдөр тутмынхаа хоол, хүнсээ худалдан авахад хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдалд итгэх итгэл, үнэмшил нэмэгдэх эерэг үр дагаврыг бий болгоно.

Олон улсын эдгээр систем нь улс төрийн дээд түвшинд парламент, засгийн газар, яамдаас, дунд түвшинд хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог төрийн захиргааны байгууллага буюу агентлагуудаас, доод түвшинд хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас бүрдэж байна. Ихэнх улс оронд хүнсний аюулгүй байдлын асуудлыг дээд түвшинд зөвлөлдөх чиг үүрэг бүхий Зөвлөл, Комисс ажиллаж байна. Уг Зөвлөл, Комисст хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог нийт төрийн захиргааны байгууллагын сайд нараас гадна сангийн сайд оролцдог байна. Хүнсний хяналтын үйл ажиллагааг хамгийн үр дүнтэй явуулж байгаа жишгээс харахад сүүлийн 10 гаруй жилийн өмнөөс улс орнууд Хүнс, эмийн агентлаг байгуулах болсон байна. Тус агентлаг нь хүнсний бодлогын хэрэгжилтийг хангах, тусгай зөвшөөрөл олгох, стандартыг боловсруулж батлуулах, хяналт тавих, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг мэдээллээр хангах, хэрэглэгчийн хоол, хүнсний талаарх боловсролыг дээшлүүлэх, аливаа асуудалд шинжлэх ухаанд үндэслэн шийдвэр гаргахын тулд лабораторийн шинжилгээ хийх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг явуулахад чиглэн ажиллаж байна.


Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Ази Номхон далайн бүсийн салбараас 2017 онд гаргасан Монгол Улсын хүнсний хяналтын удирдлагын тогтолцооны үнэлгээний тайланд “Хүнсний хяналтын удирдлагын институтцийн орчин: хүнсний аюулгүй байдал ба чанарын бодлого, стратеги, засаглал”-ын талаар дурдсан болно. Ингэхдээ одоогийн институтцийн бүтэц зохион байгуулалтыг авч үзэхэд хүнсний хяналтын албан ёсны тогтолцоонд оролцохдоо харилцан адилгүй чадамжтай, яамд, агентлагууд нь хоорондоо нэлээд бие даасан шинжтэй, тус тусдаа үйл ажиллагаа явуулж байгаа талаар тусгасан байна. Харин Монгол Улсын хүнсний тухай хуульд зааснаар Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хүнсний аюулгүй байдлын удирдлагын уялдаа зохицуулалтыг

хариуцах чиг үүрэгтэй ч, одоогоор тус зөвлөл нь тогтвортой үйл ажиллагаатай болоогүй байна гэжээ.¹¹

Хүнсний баталгаат байдалд тавих хяналттай холбоотой харилцааг Хяналт шалгалтын тухай хуулиар хэрэгжүүлэх зохицуулж байна. Одоогийн хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт болон тогтолцооны гажуудалд орсон.

МХЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрыг нийт 19 улсын байцаагчтайгаар байгуулж, тус газарт үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын газар болон хөдөө аж ахуйн хяналтын газартайгаар бүтэц, орон тоог баталсан байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын газарт хүнсний чанар, стандартын хяналтын хэлтэс, үүн дотор хүнсний үйлдвэрийн хяналт, худалдаа, үйлчилгээний хяналт, хоол үйлдвэрлэлийн хяналт, хүнсний биоаюулгүй байдлын хяналт гэсэн 4 чиг үүргийг хариуцан хяналтын үйл ажиллагааг эрхэлдэг байсан байна. Харин хөдөө аж ахуйн хяналтын газарт мал эмнэлгийн хяналт, ургамал хамгааллын хяналтын чиг үүрэг байсан байна.

12 дугаар зураг. Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын бүтэц зохион байгуулалт, 2022 он




Ингээд Засгийн газрын 2022 оны "Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 469 дүгээр

¹¹ Шаши Сари, Атиш Кумар Сен, Петер Лиени, Д.Энхмаа, Л.Гэрэлмаа, Б.Энхтуяа, Г.Нямжаргал, НҮБ-ын ХХААБ-аас 2017 онд гаргасан Монгол Улсын хүнсний хяналтын удирдлагын тогтолцооны үнэлгээний тайлан, Ази Номхон далайн бүсийн салбар, 2017, х.17


тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналт шилжин ирсэн. Ингэхдээ хүнсний аюулгүй байдлын хяналтын чиглэлийн 4 улсын байцаагчийн орон тоог хасаад, нэг хөнгөн үйлдвэрийн хяналтыг нэмж тусгасан байна. Хөнгөн үйлдвэрийн хяналт нь хүнсний чанар, эрүүл ахуйтай ямар ч хамааралгүй хяналт болно.

13 дугаар зураг. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын бүтэц зохион байгуулалт, 2023 он



Энэ үед Засгийн газрын 2023 оны 112 дугаар тогтоолоор Салбарын хяналтын газрын бүтэц, чиг үүргийг нийт 16 улсын байцаагчтайгаар баталсан байна. Харин Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналт шилжин ирэхдээ 16 бүтэц орон тоотойгоор ирсэн боловч 2025 оны байдлаар 9 болгон цомхотгосон байна. Цомхотголд хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагчийн орон тоог 2-оор багасгаж, ургамал хорио цээрийн нэг улсын байцаагчийг шинээр байгуулагдсан Ургамал хамгааллын газарт шилжүүлээд, мал эмнэлгийн хяналтын нэг байцаагчийн орон тоог хасаад, мөн хөнгөн үйлдвэрийн хяналтыг хасаж орон тоог баталжээ. Ингээд улсын хэмжээнд хүнсний хяналтын бодлогыг хариуцах нийт 9 улсын байцаагчтай болсон байна. Энэ газарт нийтийн хоол, хоол үйлдвэрлэл үйлчилгээний хяналт, хүнсний худалдааны хяналт, хорио цээрийн хяналт, мал эмнэлгийн хяналт, тээвэр логистик, агуулах, хадгалалтын хяналт, үр сортын хяналтын бодлого хариуцсан улсын байцаагч байхгүйгээр хяналтын үйл ажиллагааны бодлого хийх гээд, түүнийг хэрэгжүүлэх гээд ажиллаж байна.

14 дүгээр зураг. ХХААХҮЯ-ны Салбарын хяналтын газрын бүтэц, зохион байгуулалт, 2025 он



Улсын хэмжээнд хорио цээрийн хяналтыг Гаалийн ерөнхий газар, мал эмнэлгийн хяналтыг Улсын мал эмнэлгийн газар, Нийслэл аймаг ороон нутагт хүнс, хөдөө аж ахуйн хяналтыг хэвтээ тогтолцоонд хэрэгжүүлж байгаа боловч хүнсний хяналтын бодлого, удирдлагаар хангах байгууллага нь бүтэц зохион байгуулалт, тогтолцооны хувьд алдаатай байна гэж үзэж байна.

Хүнсний хяналтын удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааны уялдаа холбоо алдагдснаас үүдэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт нь давхардал ихтэй, албан шаардлага, торгууль давхардах шинжтэй, тус тусдаа удирдлагатай, хяналт шалгалтын удирдэмж тусдаа, нэгдсэн удирдлага байхгүйгээс илэрсэн зөрчлийг арилгуулах, торгууль оногдуулахад ААН-д ачааллыг бий болгож байгааг онцгой анхаарах нь зүйтэй байна.

Байгаль орчин, хүн ам, ургамал, мал амьтны харилцан шүтэлцээ, эрүүл аж төрөхөөс эхлэх бөгөөд хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэж вирүс, нянгууд ч хувьсаж, урьд хожид байгаагүй шинэ халдварт өвчин үүсэж байгаа төдийгүй бичил биетийн тэсвэржилт үүсэх эрсдэл нүүрлээд байна. 2019 оны байдлаар дэлхий дахинаа 5 сая гаруй хүн тэсвэржсэн нянгийн халдварын шалтгаантай холбоотойгоор амь насаа алдсан бөгөөд үүнээс 1,3 сая нь шууд тэсвэржсэн нянгийн халдвараас шалтгаалан нас барсан. Энэ тоо 2050 он гэхэд 10 сая хүн эмчилгээнд хэрэглэх антибиотикийн сонголтгүй болж нас барна гэж ДЭМБ тооцоолсон байна.

Нэг улс орон, нэг салбар дангаараа шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнүүдтэй /Зика вирүс, Эбола г.м/ тэмцэж чадахгүй учраас дэлхийн улс орнууд, нийгмийн бүх салбарууд “Нэг эрүүл мэнд” үзэл санаан дор нэгдэж байна. Нутагшмал, шинэ болон сэргэж буй халдварт өвчнүүд болон нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул, эрсдэл нэмэгдэж өнөө үед үр дүнтэй хариу арга хэмжээ авах, түүнчлэн хүн, мал, амьтан, ургамал, ус, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна.

Иймд хүнсний хяналтын тогтолцоог хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, тээвэр логистик, хүнсний импорт, дотоодын хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд хяналт тавихаар бүрдүүлэх учиртай.

Харин хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төрийн бодлого, түүний үйл хэрэг өөр хоорондоо чиг үүрэг нь давхардсан, зарим чиг үүргийг тодорхойлоогүй, орхигдсон, зарим чиг үүргийг сааруулсан шинжтэй байна. Засгийн газрын тухай хуулиар ХХААХҮ-ийн сайд Монгол улсын хүнсний аюулгүй байдлыг хангах асуудлыг хариуцах үүрэгтэй. Гэтэл ХХААХҮЯ-ны өнөөдрийн үйл ажиллагааны чиглэлийг харахад зөвхөн хүнсний хангамжийн асуудлыг тавьж, түүнийг шийдвэрлэж байгаа нь энэ хуулийн анхны зорилт хангагдахгүй байна. Хүнсний аюулгүй байдлын бусад бүрэлдэхүүн хэсэг болох хүнсний хүртээмж буюу хүн амын хүнсний бодит хэрэглээний асуудлыг ер дурдахгүй байгааг онцгой анхаарах хэрэгтэй байна. Үүнтэй нэг адил хүнсний баталгаат байдал, хүнсний шимт байдлын зохистой байдлыг ер хөндөж ярихгүй байна.

Өнөөгийн тогтолцооны алдааг жишээ болгоод тайлбарлая. ХХААХҮЯ нь хүнсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг хүнсний хангамжтай холбоотой төрийн бодлогыг боловсруулж, түүний хэрэгжилтийг яам өөрөө ханган, улмаар хэрэгжилтдээ мөн яам хяналт тавьж байгааг бодлого судлалын онолоор тайлбарлахад төрийн удирдлага, төрийн тогтолцооны чиг үүргийн хуваарилалт алдагдсан гэж дүгнэж болохоор байна. Иймд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д заасан хяналтын зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна.

15 дугаар зураг. Засгийн газрын түвшинд хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны өнөөгийн байдал



Хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцоо буй болсон боловч бүхэл бүтэн систем байх шаардлагын үүднээс авч үзвэл зарим чиг үүрэг орхигдсон,

давхцалтай, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаа нэг газар төвлөрсөн, тогтолцооны бүрдэл хэсгүүдийн уялдаа холбоо сул зэрэг доголдолтой байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны гажуудлаас үүдээд, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлээгүй, түүнийг баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй, хүнсний хяналтын оновчгүй тогтолцоотой, хэрэглэгчийн хоол хүнсний талаарх мэдлэг дутмагаас болж хоол, хүнсээ буруу сонгон хэрэглэдэг зэрэг шат шатны алдаатай үйл ажиллагаанаас үүдэн хүнсний баталгааг байдал алдагдсан гэж дүгнэхэд хүргэж байна. Монгол Улсад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавих хяналт, түүний үйл ажиллагаа хангалтгүй түвшинд байна. Өнөөдрийн байдлаар хоол, хүнсний аюулгүй байдлын үзүүлэлт, найрлага, бүтцийн шинжилгээг улсын хэмжээнд бүрэн шинжилж чадахгүй байгаагаас бид хүнсийг хяналтгүй хэрэглэж байна.

Эдгээр эрсдэлт хүчин зүйлийг тооцон одоогийн байгаа хүнсний салбарын бодлогын хэрэгжилт, хяналтын тогтолцоо, түүний үйл ажиллагаанд давхардал, хийдэл, үл ойлголцол их байгааг засаж залруулах шаардлагатай гэж үзээд хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог өөрчлөх санал дэвшүүлж байна.

Энэ хуулийн 13.3.-д заасан “мэргэжлийн холбоо болон бусад төрийн бус байгууллага, иргэн хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно” гэж заасан боловч хүнсний чиглэлийн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд тавих мэргэжлийн холбоо болон бусад төрийн бус байгууллага, иргэн хүнсний аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавих тогтолцоо бүрдээгүй тул хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаа огт хэрэгждэггүй.

Засаглал нь хариуцлагын тогтолцоо, ил тод байдал, тайлагнал, хууль дээдлэх байдал, оролцоо, улс төрийн удирдах чадвар хэмээх тулгуур багануудаас бүрдэнэ. Хариуцлагын тогтолцоо нь хяналтаар илэрч буй буруу үйлдлийн төлөө хариуцлага хүлээлгэх механизм хэдий ч шийтгэл болон урамшууллын хэм хэмжээг агуулж байх учиртай. Улс төрийн удирдагчид болон төрийн албан хаагчид иргэдийн өмнө улс төр, хууль, эдийн засаг, ёс суртахуун, нийгмийн хариуцлага хүлээх үүрэгтэй. Төр, төрийн байгууллагын мэдээлэл иргэдэд нээлттэй байх учиртай. Ил тод байдал нь мэдээллийг тэгш хүртэх боломж, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дагаж мөрдөх хууль, дүрэм журам юм.¹² Хууль дээдлэх нь хүн бүрийн үүрэг бөгөөд тэдэнд хууль тэгш үйлчлэх ёстой. Иргэдийн оролцоо бол үйл ажиллагааны үнэн байдлыг нягтлах хариуцлага байдаг.

- **Хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоо**

Хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1.-д “хүнсний тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгахыг

¹² Н.Бурмаа, Төрийн хяналт, хариуцлага, У6.,2018, х.142

шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу ХХААХҮЯ-наас Монголын хүнсчдийн нэгдсэн холбоо, Монголын махны холбоо, Гурил үйлдвэрлэгчдийн холбоо зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монголын хүнсчдийн холбоотой санамж бичгийг 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан. Энэ хүрээнд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих төсөл арга хэмжээг зохион байгуулдаг боловч холбогдох төрийн байгууллагаас шаардлагатай **мэдээ, мэдээллээр хангах тогтолцоо бүрдээгүйтэй** холбоотойгоор энэ **заалтыг хэрэгжүүлэх боломж хангалтгүй** байна.

Сүүлийн үед ХХААХҮЯ болон ЭМЯ-наас хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээ, мэдээллээр төрийн байгууллага, олон нийтийг хангах асуудал хүндрэл бэрхшээлтэй, мэдээллээр хангахгүй, нуун дарагдуулах шинжтэй үйлдэл илэрч байна.

Энэ хуулийн 14.1.2.-д заасны дагуу ХХААХҮЯ-ны дэргэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөл 2017 онд байгуулагдсан. Энэ зөвлөлөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, энэ чиглэлд хэрэглэгч, үйлдвэрлэгчдэд чиглэсэн зорилтот арга хэмжээг зохион байгуулдаг. Эдгээр арга хэмжээнд салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг татан оролцуулах боломжтой. Гэвч зөвлөлийн үйл ажиллагаа түр зогсонг байдалтай байна. Иймд уг зөвлөл хуульд заасны дагуу үйл ажиллагаа явуулахгүй байгаа тул цаашид үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай.

Удирдлагын хувьд ХХААХҮЯ захиргааны удирдлагыг л хийж байна. Харин **ХХААХҮЯ-д мэргэжлийн удирдлага алдагдсан гэж дүгнэж** байна. Учир нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нь үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах асуудлыг хариуцан ажиллах үүрэгтэй боловч өнөөдрийн байдлаар хүнсний аюулгүй байдлын зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүнсний хангамжийн асуудлыг л хариуцан ажиллаж байгаа нь мэргэжлийн салбарын яамны хувьд хуулийн хэрэгжилтийг биелүүлэхгүй байгаа дүр зураг харагдаж байна. Иймд төрийн бодлого боловсруулах чиг үүрэг бүхий хүнсний аюулгүй байдлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага өөрийн үйл ажиллагаагаа мэргэжлийн удирдлагаар тэр бүр хангаж чадахгүй байгаа нь энэ заалтад тусгагдсан “хэрэглэгч болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн эрхийг хамгаалах асуудлаар саналаа төрийн болон нутгийн захиргааны байгууллагад уламжлах” гэсэн **заалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж чадахгүй** байна. Иймд хүнсний аюулгүй байдлыг хангахад мэргэжлийн удирдлагын эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй байна.

Гэвч ХХААХҮЯ-наас хүнсний бодит хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлын судалгааг хийдэггүй. **Хүнсний аюулгүй байдлыг цогц байдлаар хангах бодлого боловсруулахад судалгааг чиглүүлдэггүй.** ХХААХҮЯ нь хүнсний

салбарын мэргэжлийн хүний нөөцийн чадавхыг төрийн үйл хэрэгт оролцуулдаггүй. Зөвхөн газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой хөдөө аж ахуйн түүхий эдийн тооцоолол, өртгийн сүлжээний судалгааг хийлгэсэн байна.

Нийслэлийн хэмжээнд Монголын Хүнсчдийн нэгдсэн холбоо, Монголын хоол зүй, шим судлалын нийгэмлэг, Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо, Монгол ногоо төсөл, Жимс жимсгэнийн холбоо БНСУ-ын “WITH” зэрэг ТББ-ууд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн боловсролын газар зэрэг төрийн захиргааны байгууллагуудтай хамтран сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулдаг. Тухайлбал, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн хоол шим тэжээлийн боловсрол олгох төвүүд нь 542 удаагийн сургалтаар 16478 иргэний хамруулсан байна. Хүн амын зохистой хооллолтын чиглэлээр сурталчилгааны материал гарган тарааж Хүн амд чиглэсэн Зохистой хооллолт сэдвээр ТВ нэвтрүүлэг гарган олны хүртээл болгож байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хооллолтын төлөвшүүлэх, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг түгээх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн. Тухайлбал, “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээний хүрээнд жил бүр хэрэглэгчдэд чиглэсэн салбарын өдөрлөгүүдийг зохион байгуулж, мэдээлэл түгээж, сурталчилж байна.

Хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх замаар хүнсний сүлжээнд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх асуудал нь олон улсад шинэ тутам хандлага юм. Цөөхөн хүн амтай, гэхдээ хүн амын 37 хувийг нь 0-18 насны хүүхдүүд бүрдүүлж байгаа манай орны хувьд энэ хандлагыг төлөвшүүлэх нь чухал байна. Хэрэглэгчийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг ерөнхий биш харин хэрэглэгчийн тодорхой зорилтот бүлэгт чиглүүлж зохион байгуулах нь үр дүнтэй байна.

Хүн амд эрүүл зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдлын чиглэлээрх боловсролыг дээшлүүлэх зорилгоор иргэн, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус, байгууллагаас зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлж, дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

- 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн газрын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт (зохион байгуулсан сургалт-30, хамрагдсан эмч, мэргэжилтний тоо-3013);
- Өрх, сумдын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт (Зохион байгуулсан сургалт-5, хамрагдсан эмч, мэргэжилтний тоо-770);
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийт рүү чиглэсэн сургалт (Зохион байгуулсан сургалт-114, хамрагдсан хүний тоо-11631).

“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний дугаар судалгааг 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдөр судалгааны үр дүнг танилцуулж, хүлээлгэн өгсөн ба үр дүнд

үндэслэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг шат дараатайгаар зохион байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Боловсролын яамнаас бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хооллолтыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг төрийн болон олон улсын байгууллагатай хамтран үе шаттай нийт 10 удаагийн сургалт зохион байгуулж давтагдсан тоогоор 2051 албан хаагч танхим болон цахимаар хамрагдсан. Үүнд:

1. Хүүхдийн хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах” нь сэдэвт сургалтыг 2024. 04.05-ны өдөр 70 тогооч 42 хоол зүйч нийт 112 албан хаагч,

2. “Малын дотор мах ашиглан хүүхдийн хоолны шинэлэг жор, технологи боловсруулах” ур чадварын уралдааныг 2024.03.02-ны өдөр 123 хоолзүйч, тогооч,

3.СБД-ийн цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хүүхдийн хоол, хүнсний чанарыг сайжруулах зорилгоор 2024. 03.28-ны өдөр захирал, эрхлэгч, хоол зүйч нийт 115 албан хаагч,

4.Жайка ОУБ-ын төслийн хүрээнд 2024. 08.20-ны “Хүнсний ногоог боловсруулах, ашиглах технологи”-ийн талаарх сургалтыг Өвөрхангай аймгийн төвийн цэцэрлэг, сургуулийн 22 хоолзүйч, тогооч,

5.“Хүүхдийн хоол шим тэжээлийн байдлыг сайжруулах сургалт 2024.08.28-ны өдөр цахимаар нийт 650 албан хаагч,

6.ХУД-ийн төрийн болон ТБӨ-ийн цэцэрлэг, сургуулийн 180 хоол зүйч, тогооч ажилтан, албан хаагч,

7.Цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлын 1000 төгрөгийг хуульд заасны дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хариуцах арга хэмжээний талаар нийслэлийн 9 дүүргийн цэцэрлэгийн 274 Нягтлан бодогч,

8. “Шим тэжээлийн тэнцвэртэй цэс” онол болон дадлага хэлбэрээр 2024.11.12-ны өдөр ХҮҮ хариуцсан мэргэжилтэн, хоол зүйч, тогооч, эмч нийт 126 албан хаагчд,

9.ХХААХҮЯ, ТХААГ-тай хамтран Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүн ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын сургалт 2 удаа 173 албан хаагч, 10. “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн менежмент” цахим сургалтыг 276 хоол зүйч, тогооч нарт сургалтыг тус тус зохион байгуулсан.

ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн дараагийн үе шатыг хүнсний хангамж, хоолны чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дундын гал тогоо” байгуулах чиглэлээр тус байгууллагад хүсэлт хүргүүлсний дагуу урьдчилсан

судалгааг эхлүүлээд байна. Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Өмнөговь, Булган 6 аймгаас судалгааг авч төслийн нэгжид хүргүүлэн эхний байдлаар Дархан-Уул аймагт 2025 оны 01 дүгээр сарын 13,14-ны өдөр төслийн зохицуулагч тус аймагт ажиллаж аймгийн засаг дарга болон аж ахуй нэгжтэй уулзалт зохион байгуулсан. Судалгааны ажил үргэлжилж байна.

Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2.13 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах "Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж тусгагдсан. Улсын хэмжээнд 9 аймгийн ерөнхий боловсролын 124 сургуулийн 64049, 103 цэцэрлэгийн 17915 хүүхэд сүү хөтөлбөрт хамрагдаад байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, зохистой хооллолтыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдох судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүнсний чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагагүй Монгол Улс 2025 он хүртэлх байсан нь энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4. дэх заалт хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан болсон.

Монгол улс 1992 оноос эхлэн Хүн амын хоол тэжээлийн үндэсний 5 удаагийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Эдгээр судалгааны үр дүнд үндэслэн Засгийн газраас хоол тэжээлийн талаар баримтлах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүн амын хоол тэжээлийн байдлыг сайжруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гол үндэслэл болсоор ирсэн. 2023-2024 онд "Хүн амын хоол тэжээлийн байдал" үндэсний дугаар судалгааг Монгол улсын эдийн засгийн 4 бүс, 21 аймгийн 112 сум, нийслэлийн 8 дүүрэгт санамсаргүй түүвэрлэлтээр сонгогдсон судалгааны анхан шатны 200 түүврийн нэгжийг хамруулан амжилттай зохион байгуулж, үр дүнг танилцуулсан.

ХХААХҮЯ-наас хүнсний бодит хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлын судалгааг хийдэггүй. Хүнсний аюулгүй байдлыг цогц байдлаар хангах бодлого боловсруулахад төсөл, хөтөлбөр, судалгааг чиглүүлдэггүй. Өнөөдрийн байдлаар энэ чиглэлийн судалгаа байхгүйгээс хүнсний аюулгүй байдлын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд мэргэжлийн бус байдлаар салбарын яам хандаж байна.

ХХААХҮЯ-ны одоогийн удирдлагууд нь хүнсний аюулгүй байдлыг хангах зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг хүнсний хангамжид чиглэсэн судалгааг хийлгэсэн байна. Тодруулбал, зөвхөн газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжихтэй холбоотой хөдөө аж ахуйн түүхий эдийн тооцоолол, өртгийн сүлжээний судалгааг л хийлгэжээ. Энэ нь ХХААХҮЯ-нд хүнсний салбарын мэргэжлийн чадавх сул, салбарын яаманд мэргэжлийн бус хүний нөөцтэй, мэргэжлийн удирдлага алдагдсан байна.

УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс Монгол Улсад Хүнсний эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэнтэй болсон нь

Хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдэж байна.

Цаашид мэргэжлийн байгууллага болох шинээр байгуулагдсан Хүнсний эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэн дараах төрийн захиалгат судалгааг тодорхой давтамжтайгаар хийдэг болох нь зүйтэй. Үүнд:

1. Хүнсний хангамж, бодит хэрэглээний судалгаа;
2. Хүнсний баталгаат байдлын судалгаа;
3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;
4. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн байдлын судалгаа;
5. Молекул биологи, бичил биетний тэсвэржилт хүнсний нэмэлт, баяжуулалт зэрэг зохицуулах үйлчлэлийн тандалт судалгаа;

Эдгээр судалгааг 5 жил тутамд хийлгэж, гарсан үр дүнд үндэслэн хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг мэргэжлийн удирдлага, арга зүйтэйгээр боловсруулах, төлөвлөхөд чиглүүлж ажиллах нэн шаардлагатай байна.

- **Хүнсний тухай хуулийн 15 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлыг хангахад үзүүлэх хэрэглэгчийн дэмжлэг**

Хүнсний тухай хуулийн 15.1.1-д гарал үүсэл нь тодорхой, баталгаатай хүнс сонгон хэрэглэж, эрүүл мэндээ хамгаалах нь хэрэглэгчид хандсан заалт орсон. Гэвч өнөөдрийн байдлаар манай хүн амын дунд гарал үүсэл нь тодорхой, баталгаатай хүнс сонгон хэрэглэж, **эрүүл мэндээ хамгаалах мэдлэг боловсрол дутмаг** байна. Иймд энэ хуулийн заалт хангалтгүй түвшинд үнэлэгдлээ.

Хоол тэжээлийн хомсдолын тархалт нь хоногийн хоол хүнсээр авч буй илчлэгийн дундаж хэмжээ нь эрүүл, идэвхтэй амьдрахад шаардлагатай түвшинд хүрч чадахгүй байгаа хүн амын хувиар илэрхийлдэг. Судалгаанд хамрагдсан 2789 өрхийн мэдээлэл, 5 хүртэлх насны 2786 хүүхэд, төрөх насны 2513 эмэгтэй, 15–49 насны 1950 эрэгтэйчүүдийн бие махбодын хэмжилтийн дүн, хоол тэжээлийн байдлын үзүүлэлтийг харгалзан хоол тэжээлийн дутал (тураал, туранхай)-тай хүн амын тархалтыг тооцсон. Тухайлбал өрхийн 1 гишүүн тураалтай, эсвэл туранхай байгаа тохиолдолд тухайн өрхийг хоол тэжээлийн дуталтай бүлэгт хамруулсан байна. Эндээс харахад хэрэглэгч баталгаат хүнсийг өдөр тутамдаа сонгон хэрэглэж эрүүл мэндээ хамгаалж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

2023 оноос өмнө Мэргэжлийн хяналтын байгууллагаас иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, зөвлөмж сэрэмжлүүлгийг төлөвлөгөөт ажлын нэгж хэсэг болгож тогтмол хүргэж ажиллаж байсан. Тухайлбал, өрхийн түвшинд хүнсний хангамж, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг эхчүүд, эмэгтэйчүүд түлхүү

хариуцдаг тул энэ зорилтот хэсэгт чиглэсэн хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллолтыг төлөвшүүлэх “Ээжийн сонголт” өдөрлөгийг зохион байгуулдаг байсан байна. Энэ хүрээнд сургуулийн өмнөх боловсролын түвшинд өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амаа зайлах, хамраа цэвэрлэх, нүүр гараа угаах, идэж буй бохь, чихэр дамжуулахгүй байх, бохирдсон хүнс хэрэглэхгүй, түүхий ус уухгүй байх, хооллох зөв дадал хэвшилтэй болох /хоолоо тайван олон удаа зажилж идэх зан үйл, дадалд сургаж байна. Бага боловсролын түвшинд эрүүл ахуйн дэглэм мөрдөх, хэвшил болгох, эрүүл, зөв дадал хэвшилтэй байх нь эрүүл мэндээ хамгаалах ад чухал болохыг мэдэх /аюулгүй, эрүүл мэндэд ач тустай хүнс хэрэглэх/, гал тогоо, гэр ахуйн цахилгаан хэрэгсэлтэй болгоомжтой харьцах, орчин тойрны аюулгүй байдлыг үнэлэх, улирлын ялгаанаас хүмүүс, нийгмийн үзэгдэл хэрхэн хамаардгийг таньж мэдэх улмаар улирлаас хамаарсан хоол хүнсээ зохицуулах гэх зэргээр мэдлэг олгодог байжээ.

Одоо ерөнхий боловсролын сургуулийн IV-XII ангийн “Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр”-ийн агуулгад “Хооллолт ба хөдөлгөөн” нэгж хичээлийн агуулгын хүрээнд бие махбодод зайлшгүй шаардлагатай шим тэжээллэг бодисыг зохистой харьцаагаар агуулсан хүнс хэрэглэх талаар мэдлэг эзэмшүүлж байна. Сургалтын үр дүнг сайжруулах, шим тэжээлийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Шим тэжээлийн боловсрол” нөлөөллийн аяны хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд зориулсан жишиг сургалтын материал бэлтгэн нэгж байгууллагыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ангийн суралцагчдын хоол шим тэжээлийн байдлын орчин, нөхцөлийг судлах, зохистой хооллолтын дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран “Fix my food” арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажлын хэсгийг БЕГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 12-н ы өдрийн А/65 тоот тушаалаар байгуулагдсан. Энэ хүрээнд олон нийтийн хоол шим тэжээлийн боловсролыг сайжруулах ажлын хүрээнд зохистой хооллолтын зөвлөмж, постерыг үе шаттай бэлтгэн байгууллагын цахим сайт, пэйж хуудсаар дамжуулж хэвшээд байна.

НЭМГ-аас хүн амд зориулан баяр ёслол болон улирлын онцлогт тохируулан хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, бэлтгэх, хоол хүнсээр дамжих халдварт өвчин, хоолны хордлогын талаар мэдээлэл сургалт сурталчилгааг хэвлэлийн бага хурал, яриа ярилцлага, зөвлөмж мэдээлэл, хэвлэлийн мэдээлэл, сайт, сонины нийтлэл, постер, гарын авлага, цахим сүлжээгээр мэдээлэл хангалттай хүргэгдэж байна. Хувь хүнд суусан дадал хэвшлийг үнэлэх боломжгүй байна.

Бүх нийтийн хоол, хүнсний боловсролыг дээшлүүлэх зорилгоор дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

Боловсролын байгууллагын орчинд: Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн, ЕБС-ийн эмч, хоол зүйч, эрүүл мэндийн хичээл заадаг багш, МУБИС,

Этүгэн анагаахын сургууль, Политехникийн коллеж, БШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, Монголын улаан загалмайн нийгэмлэг, 21 аймаг, 9 дүүргийн ЕБС-ийн тогооч, нийслэлийн 113, 50-р цэцэрлэг, 126-р сургууль, нийслэлийн СӨБ-ийн байгууллагын эрхлэгч, аймаг, нийслэлийн боловсролын газар зэрэг боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын ажилтан албан хаагч болон суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч нарт “Зохистой хооллолт, хүүхдийн дархлаа дэмжих аргууд”, “Цэцэрлэгийн тогооч бэлтгэх сургалт”, “Сүү, тараг уухын ач холбогдол”, “Гэрийн нөхцөлд тараг хэрхэн бүрэх вэ?”, “Хүүхдийн хооллолт – эрүүл мэнд”, “Цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах нь”, “Эрүүл бус хүнсний хэрэглээ ба хүүхдийн эрүүл мэнд”, “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй”, “Хүүхдийн зөв, зохистой хооллолт”, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн ажилтнууд, үйлчлүүлэгчдийн асран хамгаалагч нарт “Хоол яагаад чухал вэ?”, “Хүнсний харшлаас хэрхэн сэргийлэх вэ?”, “Бага насны хүүхдийн хоол тэжээлийн байдал” зэрэг сэдвээр хоол, шим тэжээлийн чиглэлээр сургалтуудыг давтамжтай зохион байгуулсан байна.

АНЭМГ, ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдэд: “Эмнэлзүйн хоолны тогооч” бэлтгэх сургалт, “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй”, “Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчин”, “Хүүхдийн хооллолт-эрүүл мэнд”, “Ахмад настны эрүүл зохистой хооллолт”, Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал”, “Эрүүл хооллолтын зөвлөгөө, аргачлал”, “Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн зөвлөгөө”, “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам” үндэсний сургагч багш бэлтгэх зэрэг сургалтуудыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, өрх, сумдын эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор зохион байгуулжээ.

Төрийн байгууллагуудад: ЭМХТ, ЦЕГ, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, ОБЕГ, Зэвсэгт хүчний 310 дугаар анги, Соёлын яам, Хилийн цэргийн 088-р анги, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Нийслэлийн хүнс хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн захирагчийн ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги судалгааны хүрээлэн, Тагнуулын ерөнхий газар, Баянхонгор аймгийн “Эрчим хүч цахилгаан түгээх газар, Батлан хамгаалах яамны харьяа Ахмадын төв, Дотоод хэргийн их сургууль, Орхон аймгийн ЗДТГ, ГЕГ зэрэг байгууллагуудын ажилтан албан хаагчдад “Эрүүл хооллолт”, “Хооллолт эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх вэ”, “Давсны зохистой хэрэглээ”, “Хоол, шим тэжээл”, “Хүнсний аюулын ноцтой байдлын үеийн мэдээлэл солилцоо, хариу арга хэмжээ”, “Зөв, зохистой хооллолт”, “Хүнсний аюулгүй байдал ба нийгмийн эрүүл мэнд”, “Нийтийн хоолны стандарт, эрүүл зохистой хооллолт” зэрэг хоол, шим тэжээлийн чиглэлээр сургалтуудыг зохион байгуулсан байна.

Гэвч Хоол тэжээлийн үндэсний VI судалгаагаар нийт 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 4.9 хувь хоол тэжээлийн дуталтай бүлэгт хамаарч байгаа гэсэн дүн гарсан. Эндээс дүгнэхэд хэрэглэгч өөрийн бие махбодод зайлшгүй шаардлагатай шим тэжээллэг бодисыг зохистой харьцаагаар агуулсан хүнс хэрэглэх талаар мэдлэг олж

аваагүй, арга барил эзэмшээгүй мөн **эрүүл мэндээ хамгаалах, зөв дадлыг өөртөө болон гэр бүлийнхэндээ хэвшүүлж чадаагүй байна** гэж дүгнээд хуулийн хэрэгжилтэд хангалтгүй үнэлгээ өглөө.

Олон нийтэд гарал үүсэл нь тодорхой, баталгаатай хүнс сонгон хэрэглэх, эрүүл мэндээ хамгаалах, хоолны шим тэжээл, зохистой хооллолтын талаарх боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол явуулж, шаардлагатай санхүүжилтийг төсөвт суулгаж хэвших шаардлагатай байна. Мөн боловсролын байгууллагаар дамжуулж дээрх мэдлэгийг өсвөр үеийнхэнд системтэй олгох нэн шаардлагатай байгаа.

Хүнсний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасан “хүнсийг зориулалт, зааврын дагуу хадгалах, бэлтгэх, боловсруулах, өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ хоол хүнснээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх зөв дадалд хэвшүүлэх” гэж заасан.

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд суурь хүнсний хангамжийн тогтолцооноос эхлэх учиртай. Хувь хүн хүнсийг хадгалах, бэлтгэх процесс нь дээрх ерөнхий өгөгдлөөс шууд хамааралтай юм. Гэтэл улсын хэмжээнд хүнсний хангамжийн тогтолцоо бүрэн бүрдээгүйтэй холбоотойгоор зарим нэг хүндрэлүүд үүсэж байна. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг ерөнхий гэрээгээр шалгарсан аж ахуйн нэгж байгууллагын хувьд тээвэр түгээлт, логистикийн асуудал хүндрэлтэй /түгжрэл/ байна. Үндэсний хэмжээнд хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх зохицуулалтыг хуульд нэмж оруулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хувь хүн, өрхийн түвшинд гэр бүлийн гишүүдээ хоол хүнснээс шалтгаалах өвчлөлөөс сэргийлэх зөв дадалд хэвшүүлэх тал дээр **хангалтгүй байна** гэж дүгнэж байна. Учир нь “Монгол хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний 6-р судалгаанд өрхийн түвшинд илчлэг, шим тэжээллэг, олон нэр төрлийн хоол хүнсний хүртээмж хангалтгүй байхыг “өрхийн хүнсний баталгаат байдлын алдагдал” гэж тооцдог бөгөөд хүнсний баталгаат байдал (ХББ) алдагдах нь хоол тэжээлийн дутал үүсэх шалтгаан, нөхцөл болдог. Судалгааны дүнгээр тав хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 78.3 хувь нь ХББ хангагдсан эсвэл хөнгөн зэргийн алдагдалтай, 19.0 хувь ХББ дунд зэрэг алдагдсан, 2.7 хувь нь ХББ хүнд буюу ноцтой алдагдсан байна.

• **Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйл. Бүртгэл**

Хүнсний тухай хуулийн 16.1-д баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын бүртгэлд бүртгэхээр заасны дагуу “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам” батлах тухай ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-515 дугаар тушаал батлагдсан боловч бүртгэл эхлээгүй байна. **Энэ заалт огт хэрэгжихгүй байна.**

Дээрх бүтээгдэхүүнийг бүртгэх, түүнд тавих хяналттай холбоотой тулгамдаж буй асуудал бол хүнсний бүртгэл мэдээлэл, хяналтын тогтолцооны гажуудалд орсон, хүнсний хяналтын улсын байцаагчдын үйл ажиллагааны чиглэлийг хязгаарлагдсан холбоотой.

Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.-д “Хүнсэн дэх цацрагийн түвшнийг тодорхойлох, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулна” гэж заасны дагуу хүнсэн дэх цацрагийн түвшнийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид тодорхойлж байна. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бүтэц зохион байгуулалт өөрчлөлт орсонтой холбоотойгоор энэ чиглэлийн хяналтын үйл ажиллагаа буурсан байна.

Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг баталж хэрэгжүүлэхээс өмнө эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журмыг баталж мөрдүүлэх шаардлагатай байна. Дээрх бүтээгдэхүүнийг бүртгэх, түүнд тавих хяналттай холбоотой тулгамдаж буй асуудал бол хүнсний бүртгэл мэдээлэл, хяналтын тогтолцооны гажуудалд орсон, хүнсний хяналтын улсын байцаагчдын үйл ажиллагааны чиглэлийг хязгаарлагдсан холбоотой.

Цаашид Монгол Улсын хүнсний хяналтын тогтолцоог нарийвчлан судалж олон улсын сайн жишгээс санаа авч сайжруулах шаардлагатай байна. Одоогийн мөрдөгдөж байгаа хүнсний хяналтын тогтолцоогоор аливаа хяналт, шалгалтыг явуулахын өмнө хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд урьдчилан мэдэгдэж байгаа нь эрсдэлийг тогтооход бодит нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байгаа.

Энэ хуулийн 16.4.-д “Органик хүнстэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан. Органик хүнсний тухай хуулийг УИХ-аас 2016 онд баталсан. Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-180 дугаар тушаалаар баталсан. Органик хүнсийг бүртгэх мэдээллийн цахим санг НҮБ-ын ХХААБ-ын дэмжлэг, мөн яамны төсвийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулсан. Бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам;
2. Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам;
3. Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулахад тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам;
4. Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлал;

5. Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд хэрэглэх бодисын жагсаалт.

Гэхдээ органик хүнсийг бүрэн бүртгэж чадахгүй байгаа. Иймд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийг бодитоор гаргаж төрийн байгууллагууд өөр хоорондоо мэдээллээ солилцдог болох, үйл ажиллагаа нь зогссон тохиолдолд тухайн аж ахуй нэгжийг бүртгэлээс хасалт хийлгэдэг болох, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж үнэн зөв, бодит эх сурвалжийг бий болгоход анхаарах нь зүйтэй байна.

- **Хүнсний тухай хуулийн 17 дугаар зүйл. Баталгаажуулалт**

Олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ баталгаажуулах ажил хийгдэж байна. Энэ хүрээнд Засгийн газрын 196 тогтоолын дагуу тус газраас Бүс нутаг болон олон улсын итгэмжлэлийн байгууллага PAC, IAF-ын MLA-ын үнэлгээнд амжилттай хамрагдсан. Цаашид CX3Г-ын Бүтээгдэхүүн, тогтолцоо баталгаажуулалтын газраас гэрчилгээжсэн аж ахуйн нэгжүүд IAF-ын лого, тэмдэг хэрэглэх эрхтэй болсноор худалдаан дахь техникийн саад тотгор арилж, зах зээлд өрсөлдөх чадвар нь нэмэгдэх ач холбогдолтой.

2012 оноос хойш Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд хүнсний сүлжээнд тавих шаардлага MNS ISO 22000:2007 стандартыг нэвтрүүлсэн /8/ аж ахуйн нэгжид баталгаажуулах I, II шатны аудитыг явуулж гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах тогтолцоо” /ЭЦАБШХТ/-ны олон улсын MNS CAC RCP1:2003, MNS 5998:2009 стандартыг нэвтрүүлсэн /7/ аж ахуйн нэгжид баталгаажуулах үнэлгээг явуулж гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан. Цаашид GMP, GAP тогтолцоо болон органик бүтээгдэхүүний баталгаажуулалтыг хийхээр журам, холбогдох баримт бичгүүдийг боловсруулах ажил хийгдэж байна. Байгууллага, ААНБ-уудын дотоод боломж бололцооноос шалтгаалан заалтын хэрэгжилт удаашралтай байна.

2023 оны байдлаар эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 33 ААНБ байгаагаас 17 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 16 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. Харин энэ тоо нь үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлж, түүнийг баталгаажуулсан ААНБ-ын тоонд хамаарахгүй бөгөөд, дээрх 33 ААНБ-аас бусад ААНБ-уудаас одоогоор нэг ч байгууллага үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлээгүй байна.

10 дугаар хүснэгт. Үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн үйлдвэр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	Өөрчлөлт, хувиар
Нийт үйлдвэрийн тоо	22	17	27	33	22.2
Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн	12	12	16	17	6.3
Эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн	10	5	11	16	45.5

Эх үүсвэр: СХЗГ

Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандарт болон эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нь зохистой дадлын стандартад тавигддаг шалгуур үзүүлэлтээс дээгүүр түвшинд байдаг тул энэ 2 төрлийн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн ААНБ-д зохистой дадлын шаардлага тавигдахгүйг анхаарах нь зүйтэй.

Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн 16 ААНБ-ын 2 ААНБ нь 2023 онд шинээр нэвтрүүлсэн бол үйл ажиллагаандаа ISO14000 байгаль орчны менежментийн багц стандартыг нэвтрүүлсэн 3 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч ААНБ байна. Харин үйл ажиллагаандаа хүнсний хог хаягдлын менежмент нэвтрүүлсэн ААНБ бүртгэгдээгүй байна.


Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хүрээнд итгэмжлэлийн бие даасан байгууллага баталгаажуулалт хийх байгууллагуудыг итгэмжлэх зохицуулалт тусгагдсан боловч энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчийг бойжуулах ажил удаашралтай байна.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүнсний сүлжээний өөрт хамааралтай үе шатанд тохирох зохистой дадлыг заавал мөрдөж, нэвтрүүлэхээр хуульчилсан. Улсын хэмжээнд нийт 220 мянга гаруй аж ахуйн нэгж, иргэн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хэдий ч энэхүү зохистой дадлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснийг баталгаажуулдаг албан ёсны төрийн болон төрийн бус байгууллага одоогоор зөвхөн нэг л байгаа энэ заалтын хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан юм.

Энэ хуулийн 17.1.-д “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болно” гэж заасан хүнс үйлдвэрлэгч, худалдаа үйлчилгээ эрхлэгчид заавал биш гэж ойлголт өгөхөөр эрх зүйн зохицуулалт байгаа тул **хэрэгжилт маш**

хангалтгүй түвшинд байна. Иймд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд зохистой дадлыг нэвтрүүлснээ заавал баталгаажуулдаг болох эрхзүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Энэ тогтолцоо бий болоогүйгээс үүдэн хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тавигдах эрүүл ахуй, үйлдвэрлэл, менежмент, худалдаа, үйлчилгээний, тээвэр, хадгалалтын зөвшөөрөгдөх доод хэмжээний шаардлага хангагдах нөхцөл бүрдэхгүй юм. Иймд Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадлыг нэвтрүүлснээ магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулахаар эрх зүйн зохицуулалтыг тусгаж хүнсний баталгаат байдлыг хангах суурь нөхцөл бүрдэх юм.

16 дугаар зураг. Тохирлын үнэлгээнд хамрагдсан ААНБ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл



Тайлбар: Үндэсний тохирлын тэмдгийг 2019 оноос ашиглахаа больж “Аюулгүйн тэмдэг” ашигладаг болсон.
Эх үүсвэр: СХЗГ

Хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 172 ААНБ тохирлын үнэлгээнд хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 38 (28.4 хувь) ААНБ-аар өссөн байна.

Тохирлын үнэлгээнд хамрагдаж баталгаажуулалт хийгдсэн нийт 124 бүтээгдэхүүн байна. Үүний 12.9 хувьд нь импортын бүтээгдэхүүний баталгаажуулалт, 84.7 хувьд нь дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний баталгаажуулалт, 2.4 хувьд нь “Аюулгүйн тэмдэг”-ийн баталгаажуулалт хийгджээ.

Энэ хуулийн 17.1-д заасан “магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага болон баталгаажуулалт авсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтын хэрэгжилт огт хийгдээгүй. Учир нь үйл ажиллагаандаа зохистой дадал нэвтрүүлснээ баталгаажуулсан нэг ч ААН байхгүй байгаа тул баталгаажуулалт авсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн жагсаалт гараагүй.

Иймд салбарын яамнаас энэ заалтын хэрэгжилтийн хангах хүрээнд эхний ээлжинд хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар аж ахуй нэгж, байгууллагуудад сургалтыг зохион байгуулах, зохистой дадлыг заавал нэвтрүүлэх ёстой талаар хууль эрх зүйн мэдлэгийг олгох, зохистой дадлыг нэвтрүүлэнг баталгаажуулах байгууллагыг бойжуулах, итгэмжлэлд хамруулах, итгэмжлэгдсэн тухайн байгууллага нь баталгаажуулалтыг хийх зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

2.5. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилт

Одоогийн хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт болон тогтолцооны гажуудалд орсон. Үүний нэг жишээ бол ХХААХҮЯ нь хүнсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг хүнсний хангамжтай холбоотой төрийн бодлогыг боловсруулж, түүний хэрэгжилтийг яам өөрөө ханган, улмаар хэрэгжилтдээ мөн яам хяналт тавьж байгааг бодлого судлалын онолоор тайлбарлахад төрийн удирдлага, төрийн тогтолцооны чиг үүргийн хуваарилалт алдагдсан гэж дүгнэж болохоор байна. Энэ тохиолдолд Төрийн бодлогоор төрийн тогтолцооны зарим чиг үүргийг дахин хуваарилалт хийж шинийг бий болгох, зарим тохиолдолд хуучин институцийг халах үйл ажиллагаа тасралтгүй явагдана. Энэ нь төрийн зохицуулалт нь төрийн бодлогын асуудал болдог. Мөн төрийн бодлого хэрэгжүүлэгч институциудын хооронд давхардал, хийдэл, эсрэгцлийг бий болгож болно. Энэ бүх учир шалтгаан нь зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг нийгмийн харилцаанд үүсгэдэг.¹³

Үнэлэх хэсэг	- 18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл, 18.5. Үндэсний зөвлөлийн чиг үүрэг
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл байгуулснаар хуулийн зорилгыг хангаж байгаа эсэх? - Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн чиг үүрэг, тогтолцоо нь оновчтой эсэх? - Хүнсний аюулгүй байдлын удирдлага, түүний тогтолцоог бүрдүүлэх боломжтой юу?

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн чиг үүрэг, түүний үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгаа, хэр оновчтой байгаа талаар мэдээлэл өгч улмаар уг зөвлөл нь хуулийн зорилгыг хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж оролцогчдын зүгээс үнэлгээ өгсөн.

¹³ Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн, О.Цэрэнчимэд бусад, Төрийн бодлого, Уб.,2021, х.119

- **Хүнсний тухай хуулийн 18 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл**

Өнөөдрийн байдлаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл нь хуулиар заасан орон тооны нарийн бичгийн даргагүй ажиллаж байна. Тус зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, салбар дундын зохицуулалтыг хангахад учир дутагдалтай байна.

Хүнсний тухай хуулийн 5 дугаар бүлгийн 18.1-д Монгол Улсад хүнсний аюулгүй байдлыг хангах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл Засгийн газрын дэргэд ажиллах бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга Монгол Улсын Ерөнхий сайд байна. Хуульд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн удирдлага, түүний чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг тодорхой тусгасан боловч өнөөг хүртэл хүнсний аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөх үйл ажиллагаа нь жигдрээгүй байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн орон тооны Нарийн бичгийн даргын албан томилгоог хийгээгүйгээс хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх байсан хүнсний аюулгүй байдлын удирдлага, салбар дундын зохицуулалт, зохион байгуулалтын ажил доголдож, төр хувийн хэвшлийн түншлэл, тэдний хамтын ажиллагаа хангалттай хэмжээнд сайн явагдахгүй байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагааг зохицуулах, хяналтыг хэрэгжүүлэх тухай хуулийн төслийг боловсруулах нь эрх зүйн орчныг бүрдүүлэхэд тустай гэж үзэж байна.

Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас оруулж хуралд зөвлөлийн гишүүд, бусад мэргэжлийн хүмүүсийг оролцуулж байна. Мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багтай байж болох зохицуулалтыг одоогоор ашиглаагүй байна.

Монгол Улсын тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг бэлтгэж Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хэлэлцүүлж, зөвлөмж гаргуулан ажиллаж байна. Зөвлөмжийн хүрээнд хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр захиргааны хэм хэмжээний акт гарган, стратегийн хүнсийг экспортлох, импортлох зохицуулалтыг журмын дагуу хэрэгжүүлж байна. Энэ журам нь хууль давсан зохицуулалттай байна гэж үзсэн тул журмын зохицуулалтыг шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж дүгнэж байна.

Хүнсний тухай хуулийн 18.5.2-т хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахаар хуульчилсан бөгөөд хэрэгжилт **хангалтгүй явагдаж байна**. Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын чиг үүргийг Үндэсний зөвлөлийн шууд бус оролцоог ханган холбогдох төрийн бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Энэ нь эрхэлсэн байгууллага, хариуцсан албан тушаалтнуудаас субъектив шууд хамааралтай байна.

Эрүүл мэндийн яам, чиг үүргийн хүрээнд Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны танилцуулгыг жил бүрийн эхний улиралд Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хүргүүлдэг боловч өнөөг хүртэл хуралдаанаар Эрүүл мэндийн яамнаас мэдээлэл нэг ч хийгээгүй байна.

Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар жил бүрийн 01 дүгээр улиралд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар хуульчилсан боловч өнгөрсөн 13 жилийн хугацаанд 2 удаа л Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд холбогдох танилцуулгыг хүргүүлсэн болно.

Энэ нь салбар дундын уялдааг хангасан цогц арга хэмжээ тул Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийг ажлын албаны үйл ажиллагааг хуулийн хүрээнд эхлүүлэх, тус зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын томилж ажилд нь оруулах, улмаар зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог төрийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, удирдлагаар хангадаг болох, тус албанаас Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй шууд харилцдаг байх зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын талаарх танилцуулгыг Улсын Их Хуралд нэг ч удаа танилцуулаагүй байна.

Иймд энэ хуулийн 18 дугаар зүйлийн заалтыг огт хэрэгжээгүй гэж дүгнэсэн бөгөөд цаашид Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилон, хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог бүх төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлүүдийг ажиллуулж эхлүүлэх зэрэг хуулиар заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний дүнгээс дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

➤ Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд үнэлгээний **нэгдсэн үнэлгээ 32.5 хувьтай** гарсан. Энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалсан гэж үзсэн. Тухайлбал, хүнсний салбарын бодлого төлөвлөлт нь нэгдмэл, цогц байдлаар тодорхойлогдоогүй, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй, хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын, эрсдэлийн, хяналтын тогтолцоо гажуудсан, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь харилцан уялдаагүй, салбарын хүний нөөцийн бодлогогүй байгаа нь мэргэжлийн удирдлага алдагдах шалтгаан болсон, бодлогын төлөвлөлт нь үр дүнд чиглэж чадаагүй, бүх талын оролцоог хангаагүй зэрэг бодлогын үндсэн зарчмуудыг баримтлаагүйтэй холбоотойгоор тайлбарлаж байна.

➤ 2010 оноос хүнсний салбарын эрх зүйн орчин бүрэлдэж, төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлагдаж хэрэгжсэн хэдий ч Монгол Улс хүнсний хараат байдал алдагдсан, импортын хамааралтай хэвээр байсаар байгаа нь салбарын бодлого, түүний хэрэгжилтийн үр дүн хангалттай байж чадаагүй гэсэн дүгнэлтийг хийж байна. Төрийн бодлогын залгамж чанар, уялдааг харгалзан үзэхгүйгээр олон жилийн турш салбарын шинэ, шинэ бодлого гарч, өмнөх бодлогоо үгүйсгэж, дутуу хэрэгжүүлж, бодит бус үнэлж, шийдвэр гаргагчид бодит мэдээлэл өгөөгүй олон жил явсны үр дагавраар Монгол Улсын хүнсний аюулгүй байдал жилээс жилд улам доройтож ирсэн. Үүний уршгаар Монгол Улс хүнсний хараат байдлаа алдаж, импортын хамааралтай улс болсон байна.

➤ Манай улсын хувьд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Өнөөдрийн байдлаар хүнсний салбарт нийт 200 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй, зохистой дадал нэвтрүүлсэн баталгаажуулдаг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тоо улсын хэмжээнд зөвхөн хоёр байгаа зэрэг тоон үзүүлэлтүүд нь хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл, шалтгаан болж байгааг илтгэж байна.

➤ Хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдлыг илэрхийлдэг гол үзүүлэлт бол хүнсний аюулгүйн үзүүлэлтүүд байдаг. Тэгвэл Монгол Улс хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн шинжилж чадахгүй байна.

➤ "Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж, хүнсний аюулгүй байдлын хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжсэн байна. Уг тогтоолын 1.8-д "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 50 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт "2.9.Салбарын хяналтын газар"-ыг нэмж,

орон тоо "105" гэснийг "121" гэж өөрчлөхөөр заажээ. Ийнхүү МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын 19 орон тооноос хүнсний чанар, стандартын хяналтын газар, мал эмнэлгийн хяналтын газар, ургамал хамгаллын хяналтын газрын даргын 3 орон тоо хасагдаж, нийт 16 улсын байцаагч салбарын яаманд шилжсэн байна. Өнөөдрийн байдлаар яамны салбарын хяналтын газрын "хүнсний аюулгүй байдлын хяналт"-ын чиглэлийн 4 улсын байцаагчийн орон тоог хасагдаж, хөнгөн үйлдвэрийн 1 хяналтын улсын байцаагч нэмэгдсэн байна. Хөнгөн үйлдвэрийн хяналт нь хүнсний чанар, эрүүл ахуйтай ямар ч хамааралгүй хяналт болно.

➤ Хэрэглэгчийн эрх зүйн болон хүнсний талаарх ерөнхий мэдлэг, боловсрол туйлын хангалтгүйгээс хэрэглэгч хариуцлагагүй байна. Мөн хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч буюу үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн мэдлэг, боловсрол, ёс зүй, хариуцлагын ухамсар дутмаг байна. /Ялангуяа малчин хүн малынхаа эрүүл мэндийн асуудлыг хариуцахаар хуульчилсан боловч малчид хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байна.

➤ Хүнсний талаарх мэдээлэл ил тод, үнэн зөв, бодит байж чадахгүй байна. Тухайлбал хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, байгууллага тус бүрдээ өөрийн мэдээллийн сантай, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох тогтолцоо бүрдээгүй, зөрчил гаргасан ХЧҮАЭ-ийн талаарх мэдээлэл олон нийтэд хаагдмал, зах зээл дээр хуурамч хүнсний бүтээгдэхүүн худалдаалсаар байгаа талаарх мэдээлэл хэрэглэгчдэд хүрч очихгүй байна гэж дүгнэж байна.

➤ Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуульд заасны дагуу ажиллахгүй байна. Хуульд зааснаар уг Зөвлөл нь хүнсний аюулгүй байдлыг хангахад салбар дундын уялдаа холбоог хангах, хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргах, шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэх орон тооны нарийн бичгийн дарга томилогдоогүйгээс зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаа идэвхгүй байгаа.

➤ Эцэст нь дүгнээд хэлэхэд хүнсний хангамж, хүртээмж, хүнсний шим тэжээллэг байдал, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зохицуулалтыг суурь хууль болох Хүнсний тухай хуульд тусгасан боловч хүнсний хэрэглээ, хүнсний сүлжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын тогтолцооны зарим нэг бүрэлдэхүүн хэсгийг тусгаагүй байна гэж үзлээ. Мөн хуулийг даган гарах зарим нэг эрх зүйн зохицуулалт дутуу, хяналт, шалгалт явуулах үйл ажиллагаа, хүнсний аюулгүй байдлыг хангах дэд системийн доголдол, удирдлагын тогтолцооны гажуудал, зохистой дадлыг нэвтрүүлснийг баталгаажуулах тогтолцоо бүрдээгүйн улмаас хуулийг хэрэгжүүлэх нөхцөл хангагдаагүй байдал байна. Хүнсний сүлжээнд оролцдог хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид, хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалтыг хийдэг улсын байцаагчид мөн хэрэглэгчийн мэдлэг, боловсрол, хандлага зэрэг хүний хүчин зүйл, үйлдлээс шууд хамааралтай хариуцлагын тогтолцоо бас бүрдээгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд цаашид анхаарах асуудал, арга хэмжээний санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

➤ Анх 1798 онд Томас Мальтус гэж эрдэмтэн “Хүнсний хангамж” гэсэн ойлголтыг гаргаж ирснээр хүнсний аюулгүй байдлын онолын үндэс тавигдсан гэж үздэг. Үүнээс хойш эрдэмтэн судлаачид мөн олон улсын байгууллагаас хүнсний аюулгүй байдлын тодорхойлолтыг янз бүрээр тодорхойлж ирсэн. Хамгийн сүүлд 2002 онд НҮБ-ын Дэлхийн хүнсний бага хурлаар “Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүнсний хангамж, хүртээмж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал ба шимт байдал, хүнсний тогтвортой байдал гэсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ гэж томъёолсон байдаг. Хүнсний аюулгүй байдлын чиглэлийн олон улсын гэрээ хэлэлцээр нь хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалын дагуу батлагдаж түүнийг дагаж мөрддөг. Иймд манай улс хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлал мөн олон улсын конвенцид тусгагдсаны зорилт, арга хэмжээний дагуу хүнсний аюулгүй байдлыг хангах цогц бодлого, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

➤ “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээ”-ний тухай УИХ-ын 36 дугаар тогтоолыг баталснаар манай улсын хүнсний аюулгүй байдлыг хангах (2022-2026 он) дунд хугацааны бодлого хэрэгжиж эхэлсэн. Энэ бодлогод тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар УИХ-ын 36 дугаар тогтоолд тусгасан. Иймд энэ бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг тус хууль нэмж тусгах нь зүйтэй.

➤ Хүнсний хяналтын тогтолцоог хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, тээвэр логистик, хүнсний импорт, дотоодын хүнсний худалдаа, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд хяналт тавихаар бүрдүүлэх учиртай.

➤ Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, түүхий эд, бүтээгдэхүүнд зөвхөн стандартыг мөрдлөг болгосноор хүнсний чанар, эрүүл ахуйн үзүүлэлтүүд нь зөвхөн стандартын шаардлагад нийцсэн байх учиртай. Иймд салбарын сайд, агентлагийн удирдлагаас хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, баталгаат байдалтай холбоотой дүрэм, журам, заавар батлахгүй байхыг анхаарах хэрэгтэй. Ингэснээр салбарын түвшинд мэргэжлийн удирдлагаар хангагдах нэг нөхцөл бүрдэнэ.

➤ Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийг бодитоор гаргаж төрийн байгууллагууд өөр хоорондоо мэдээллээ солилцдог болох, үйл ажиллагаа нь зогссон тохиолдолд тухайн аж ахуй нэгжийг бүртгэлээс хасалт хийлгэдэг болох, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж үнэн зөв, бодит эх сурвалжийг бий болгоход анхаарах нь зүйтэй байна.

➤ Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар аж ахуй нэгж, байгууллагуудад сургалтыг зохион байгуулах, зохистой дадлыг заавал нэвтрүүлэх ёстой талаар хууль эрх зүйн мэдлэгийг олгох, зохистой дадлыг нэвтрүүлсэнд баталгаажуулах байгууллагыг итгэмжлэлд хамруулах, итгэмжлэгдсэн тухайн байгууллага нь баталгаажуулалтыг хийх зэрэг цогц арга хэмжээ авах шаардлагатай байна.

➤ Нэн түрүүнд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэлжүүлэлт, баталгаажуулалтын тогтолцоотой болох, газар тариалан, мал аж ахуйн түүхий эдийн тогтвортой нийлүүлэлтийг бий болгох хадгалалт тээвэрлэлтийн логиستيкийг хөгжүүлэх хэрэгтэй байна. Улмаар Хүнсний тухай хуульд "хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд хадгалалт, тээвэрлэлтийн стандартыг мөрдлөг болгоно" гэж тусгах нь зүйтэй.

➤ Хүн амын өдөр тутмын хүнсний хэрэглээний нэр төрлийг нэмэгдүүлж хүнсний шим тэжээлийг дутлыг бууруулах, цаашилбал далд өлсгөлөн буюу амин дэм, эрдэс бодисын дуталд өртөх эрсдэлийг багасгах чиглэлээр дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй. Тухайлбал сүүн бүтээгдэхүүний хэрэглээг 20-иар, буурцагт ургамал, жимс жимсгэнийн хэрэглээг эрс нэмэгдүүлж, мах, махан бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, зохистой хооллолтын талаар сургалт сурталчилгааг олон нийтэд хүргэх, ялангуяа салбарын яамны зүгээс зөвхөн газар тариалангийн үйлдвэрлэлийн бодлого ярьж, хэрэгжүүлдгээ хязгаарлах, хүнсний аюулгүй байдлыг цогц байдлаар хангахад мэргэжлийн удирдлагатай болох хэрэгтэй.

➤ Ядуу эмзэг өрхийн хүн амын хүнсний хангамжийн баталгаат байдал алдагдахаас хамгаалах, далд өлсгөлөнг бууруулах, ялангуяа улирлын чанартай хүнсний хомсдол, байгаль, цаг уурын гамшиг бэрхшээлийн үед тэдгээр иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг авах шаардлагатай байна.

➤ Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхийн тулд Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилон, хүнсний аюулгүй байдлыг хангахад оролцдог бүх төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлүүдийг ажиллуулж эхлүүлэх зэрэг хуулиар заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.

➤ Хүнсний аюулгүй байдлыг хангах цогц бодлогыг жигд хүртээмжтэйгээр хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, удирдлагын тогтолцоог бий болгох, ялангуяа хүнсний аюулгүй байдлын бодлогыг мэргэжлийн удирдлагаар чиглүүлэх, салбарын хүний нөөцийн бодлоготой болох, хүнсний эрдэм шинжилгээний байгууллагаар хүнс судлалын чиглэлийн судалгаа, туршилтыг явуулах, төрийн үйл хэрэгт хүнд суртлыг бууруулах, арилгах зорилгоор цахимжуулах, олон нийтийн хяналт, оролцоог хангах, бодлогын хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллахад хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын хууль тогтоомж

- 2010-07-15 ҮАБ-ын Үзэл баримтлал
- 2012-12-20 Хүнсний тухай хууль
- 2012-12-20 Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль
- 2016-04-07 Органик хүнсний тухай хууль
- 2017-05-12 Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль
- 2017-05-11 Зөрчлийн тухай хууль
- 2017-12-08 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- 2017-12-14 Малын генетик нөөцийн тухай хууль
- 2018-05-03 Баяжуулсан хүнсний тухай хууль
- 2019-05-30 Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль
- 2017-05-18 Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай
- 2015-10-26 Гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөө
- 2015-11-13 Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги 2016-2021,
- 2015-11-16 “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр
- 2015-11-26 Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
- 2023-12-25 Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

2. Төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааны тайлан, танилцуулга мэдээ, тоон мэдээлэл

- Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2015-2023
- Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний тавдугаар судалгааны дүн 2017
- Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн үндэсний зургаадугаар судалгааны дүн 2024
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал үндэсний статистикийн мэдээ 2019, 2023
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн тайлан мэдээ 2018, 2019, 2023

- Эрүүл мэндийн яамны статистикийн мэдээ-2018, 2019, 2023
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны тайлан мэдээ -2018, 2019, 2023
- Ядуурлын дүр төрх, Үндэсний статистикийн хороо, 2018-2024
- Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, Дэлхийн банкны ядуурал ба тэгт байдлын дэлхийн туршлага 2018-2024
- Ажиллагчдын сарын дундаж цалин, 2018, 2019, 2023
- Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо 2019, 2023
- Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Үндэсний статистикийн хороо 2019, 2023
- МХЕГ-ийн Хяналт шалгалтын үр дүнгээс 2019-2022
- ХХААХҮЯ-ны салбарын хяналтын газрын хяналт шалгалтын дүн, бусад мэдээлэл 2023, 2024
- ЭМЯ-ны салбарын хяналтын газрын хяналт шалгалтын дүн, бусад мэдээлэл 2023, 2024
- ХНХЯ-ны хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний талаар 2019, 2023
- Гаалийн ерөнхий газрын хил хорио цээрийн хяналтын талаарх мэдээ 2019, 2023
- Боловсролын яамны албаны мэдээлэл 2023, 2024

3.Олон улсын тайлан мэдээ

- Global Report on Food Crises 2019, 2023
- Food security and Nutrition around the World in 2019, 2023
- The State of Food and Agriculture 2019, 2023
- Asia and the Pacific regional overview of Food security and Nutrition 2018, 2023

4.Вөб хуудас

- www.legalinfo.mn
- www.parliament.mn
- www.fao.org
- www.ifpri.org
- www.unicef.org
- www.who.int

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ.УДИРТГАЛ

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН
БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН
БАЙДАЛ

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хуулийн дагуу
үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд дагуу
үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.3."Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг,
заалт

3.4."Зардал" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт

3.5."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэгдэх зүйл, хэсэг,
заалт

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

4.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.4. "Зардал" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

4.5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ.УДИРТГАЛ

Хүн бүр эсэн мэнд амьдарч, хөдөлмөрлөх, эрүүл бие, саруул оюун ухаантай байх үндсэн нөхцөлийн нэг бол хоол хүнс бөгөөд эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаатай хоол хүнсийг сонгон хэрэглэх нь хүн бүрийн жам ёсны эрх.

Өнөөдөр манай улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (1948), “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пактад (1966): “Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж, “хүн бүр . . . зохистой хоол хүнсээр хангагдах эрх”, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрх”-ийг онцлон заажээ. Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн дээрх эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүрэгтэй.

Монгол Улс Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж “зохистой хоол хүнсээр хангагдах эрх”-ийг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний аюулгүй байдлын бодлого, түүнийг хангах арга замыг тодорхойлж, эрх зүйн орчны шинэчлэл хийсэн. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.1-д “Хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, **физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах** нөхцөлийг бүрдүүлнэ” хэмээн хүнсний аюулгүй байдлыг хангах стратегийг тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.5-д “Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж **баталгаат хүнсээр хангана**” гэж заасан ба 2021-2030 онд хүрэх үр дүнг “4.хүнсний сүлжээний бүх үе шатанд **бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ**” гэж, 2021-2040 онд хүрэх үр дүнг “3.баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон ... **эрүүл хүнсний хэрэглээтэй болно**” гэж тус тус тодорхойлсон байна.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3-т Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Дээр дурдсан үндэслэлээр хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгох, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог сайжруулах, баталгаатай, шимт байдлын зохистой харьцаатай хүнсний хэрэглээг

хэвшүүлэх эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-ийг боловсруулжээ.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал /цаашид "Аргачлал" гэх/"-ын дагуу тус Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд оршино. Ийнхүү үнэлэхдээ Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт, агуулга нь төслийн үзэл баримтлал, зорилгод нийцэж буй эсэх, өөрчилж буй зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, шинээр тусгагдсан зарим нэг зохицуулалт төсөвт ачаалал үүсгэж байгаа эсэх, хуулийн төсөл нь хууль зүйн техникийн хувьд хуульд заасан нийтлэг шаардлагад нийцсэн эсэхд үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар үнэллээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа холбоо

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төслийн зорилт, хуулийн үйлчлэх хүрээ болон хуулийн төслийн бүтэц нь өөрчлөлтийн үзэл баримтлал, зорилго, хууль батлагдах хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх;

2. Хуулийн төсөлд өөрчлөн найруулсан болон нэмж оруулсан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;

3. Хуулийн төсөлд тусгагдсан нэр томъёонууд нь ойлгомжтой эсэх, мөн хууль зүйн техникийн алдаатай эсэх;

4. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх зэргийг шалгах.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий хуулийн төслийн зохицуулалтуудыг сонгож авлаа. Өөрөөр хэлбэл, тухайн хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс шинээр орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож үр нөлөөг үнэлнэ.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрээр тус бүрд нь авч үзье.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт
1	Олон улсын жишигт нийцүүлэн хүнсний аюулгүй	1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй: 2/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт: 4.1.5.хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах.

	байдлын тогтолцоог иж бүрэн тусгах	3/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг: 4.2.Төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах бодлогын чиглэлийг баримтална: 4.2.1.хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах; 4.2.2 хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгаат байдлыг бүрэн хангах; 4.2.3.шим тэжээллэг, чанартай хоол, хүнсийг хэрэглэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, уламжлалт соёл дадлыг төлөвшүүлэх; 4.2.4.эрсдэлийн удирдлага, хяналт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх; 4.3.Энэ хуулийн 4.3-т заасан хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг энэ хуулийн 13.1.5, 13.1.6-д заасан тандалт, судалгааны үр дүн, зураглалд үндэслэн тодорхойлно. 7/13 дугаар зүйлийн 13.1.5, 13.1.6 дахь заалт: 13.1.5.хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэлт; 13.1.6.хүнсний баталгаат байдал, шим тэжээл, молекул биологи, бичил биетний тэсвэржилт, хүнсний нэмэлт, баяжуулалт зэрэг зохицуулах үйлчлэлийн тандалт судалгаа;
--	--	--

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслөөр шинээр бий болгож байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг сонгон авдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөх боломжтой эсэх	1 дүгээр зүйл.Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй: 5/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг: “10.4.Хүнсний чиглэлийн дараах үйл

		ажиллагаанд стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө. 10.4.1.хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, үйлчилгээнд тавигдах холбогдох стандарт, техникийн зохицуулалт; 10.4.2.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалт.”
	Зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулах заалт практикт хэрэгжих боломжтой эсэх	3 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай 3/17 дугаар зүйл: “17.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна. 17.2.Энэ хуулийн 17.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээдийн жагсаалтыг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага нийтэд мэдээлнэ. 17.3.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болно.”

3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг

шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томьёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл заалт
1	Төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх	1 дүгээр зүйл.Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:
		1/3 дугаар зүйлийн 3.1.14-3.1.16 дахь заалт: “3.1.14.“хүнсний баталгаат байдал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасныг;” 3.1.15.“зохицуулах үйлчилгээтэй хүнс” гэж хүний бие махбодод бүхэлд нь, эсхүл тодорхой нэг эрхтний үйл ажиллагааг дэмжих шимт бодисын найрлагатай, биологийн үйлчлэл, үнэт чанартай бүтээгдэхүүнийг;” 3.1.16.“хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан түүхий эд, туслах материал ашиглаж, эрх бүхий этгээдийн баталсан жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол бэлтгэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг;”
		3 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай: 1/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт: “3.1.3.“хүнсний эрүүл ахуй” гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, бохирдоогүй, хортой нэгдэл, өвчин үүсгэгч бичил биетэн агуулаагүй байхыг;” 2/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэг:

		“3.1.11."хүнсний сүлжээ" гэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, хүнсийг тусламжаар авах, өгөх, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсийг буцаан татах, устгах үйл ажиллагааг;”
--	--	--

3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална.

№	“Зардал”	Сонгосон зүйл заалт
1	Төрд үүсэх зардлын ачааллыг аль болох багасгах	1 дүгээр зүйл.Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй: 8/13¹ дүгээр зүйл: “13¹ дүгээр зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт 13¹.1.Хүнсний баталгаат байдалд хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан нэгжийн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учраас шалгах хэсгээ сонгохдоо хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд бид тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Тус хуулийн төслийн хүрээнд биржийн холбогдох үйл ажиллагаа нь бусад хуулийн

зохицуулалттайг нийцэж буй эсэх талаар шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх нь ач холбогдолтой гэж үзлээ.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ өгөхөөр тогтлоо.

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Зардал	төрд үүсэх ачааллыг тооцоолох
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтсон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	1 дүгээр зүйл. 2/4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт: 3/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг: 7/13 дугаар зүйлийн 13.1.5, 13.1.6 дахь заалт:	1.Хуулийн төслийн зорилго, үзэл баримтлал, хууль боловсруулах хэрэгцээ, шаардлага болон тус хуулийн хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтын зорилго, үзэл баримтлалд дүн шинжилгээ хийх 2.Холбогдох хууль, олон улсын гэрээтэй тай харьцуулан судлах 3.Ном, хэвлэл, судалгааны материал судлах
2	Практикт хэрэгжих боломж	1 дүгээр зүйл. 5/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг: 3 дугаар зүйл. 3/17 дугаар зүйл:	1.Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах 2.Хуулийн хэрэгжилтийн практикт дүн шинжилгээ хийх

3	Ойлгомжтой байдал	1 дүгээр зүйл. 1/3 дугаар зүйлийн 3.1.14-3.1.16 дахь заалт: 3 дугаар зүйл 1/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт: 2/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх хэсэг:	1.Тодорхойлоогүй нэр томъёог ойлгомжтой тайлбарласан эсэх 2.Нэр томъёо нь хуулийн төсөл боловсруулах нийтлэг шаардлагад нийцсэн эсэх
4	Зардал	1 дүгээр зүйл. 8/13¹ дүгээр зүйл: 13 ¹ .1 дэх хэсэг	1.Хүн, хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэг, түүнтэй холбогдох зардлын үр дагавар 2.төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь энэхүү шалгуур үзүүлэлтээр үнэлэх	Харилцан уялдааг судлах, ингэхдээ холбогдох хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

4.1.“ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал¹”-ын 3.4.2 дэх заалт, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого²-ын Зорилт 2.5, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай”³ Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3 дахь заалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний тайланд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нь импортоос хамааралтай, хүртээмж нь газар зүйн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа, ядуурлын түвшин буурсан ч ядууралд ойрхон байгаа хүмүүс аливаа сөрөг хямрал (эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт) үүсэхэд эргээд ядууралд өртөх эрсдэлтэй байгааг дурдсан байна.

¹ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

³ Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохистой болгох зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд энэхүү хуулийн зорилго нь олон улсын жишигт нийцүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангах удирдлагын болон хяналтын тогтолцоог оновчтой болгоход чиглэжээ.

Хуулийн төслийн дээр дурдсан зорилгын хүрээнд 1-рт олон улсын жишигт нийцүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог иж бүрэн тусгаж, түүнтэй холбогдох зохицуулалт хийх, 2-рт хяналт, баталгаажуулалтын тогтолцоог оновчтой болгох, 3-рт хүнсний сүлжээ дэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах, 4-р хуулийг нэр мөр хэрэгжүүлэх дэд зорилгыг тодорхойлсон байна.

2002 онд НҮБ-ын Дэлхийн хүнсний бага хурлаар “Хүнсний аюулгүй байдал гэдэг нь хүнсний хангамж, хүртээмж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал ба шимт байдал, хүнсний тогтвортой байдал гэсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ гэж томъёолсон байдаг. Хүнсний аюулгүй байдлын чиглэлийн олон улсын гэрээ хэлэлцээр нь хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалыг тусгасан байдаг.

Үүнтэй холбоотойгоор хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлал, олон улсын гэрээний үзэл санааг тусгасан зорилт, арга хэмжээний дагуу хүнсний аюулгүй байдлыг хангах цогц бодлого, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорилго болгожээ.

~~Хүнсний аюулгүй байдал гэдэг бол хүнсний хангамж, хүртээмж, хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал болон хүнсний шимт байдал хэрэглээ гэсэн ойлголтуудыг саяган томъёолох, салангид авч үзэх нь учир дутагдалтай юм.~~

Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг буюу Хүнсний тухай хуулийн 4.2 дэх хэсэгт төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын чиглэлийг тодорхойлсон байх бөгөөд энэхүү чиглэлд 1/хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах;, 2/ хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний баталгаат байдлыг бүрэн хангах;, 3/шим тэжээллэг, чанартай хоол, хүнсийг хэрэглэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, уламжлалт соёл дадлыг төлөвшүүлэх;, 4/эрсдэлийн удирдлага, хяналт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх асуудлыг хамааруулсан байна. Энэ 4 чиглэлийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний найрлагын судалгаа, хүнсний баталгаат байдал, шим тэжээл молекул биологи, бичил биетний тэсвэржилт, хүнсний нэмэлт, баяжуулалт зэрэг зохицуулах үйлчлэлийн тандалт судалгааг явуулах, уг судалгааг үндэслэн төрийн бодлогыг тодорхойлох, хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт уг судалгааг эрдэм шинжилгээний байгууллага 5 жил тутам явуулж, үр дүнг ХАБҮЗ-д тайлагнаж байхаар заасан байна.

Мөн олон улсын чиг хандлагад нийцүүлэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг буюу Хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйлд “хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах” зарчмыг тусгаж, , үүнтэй холбоотой тандан судалгаа, түүний үр дүнг тайлагнах,

тэсвэржсэн бичил биетэн агуулаагүй эрүүл ахуйн шаардлага хангасан хүнс байхтай холбогдсон зохицуулалтыг тусгажээ.

Хүнсний тухай хуулийн зорилго нийгмийн түүхэн хөгжлийн явцад тухайн үеийн нөхцөл байдалтай уялдан хүнсний аюулгүй байдлыг хангах⁴, хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах⁵, хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй баталгаат хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах⁶ хэмээн тухайн нөхцөл байдалтай уялдуулан томьёолж байжээ.

Монгол Улсын Их Хурал 2012 онд баталсан Хүнсний тухай (Шинэчилсэн найруулга) хууль⁷-ийн зохицуулалт тухайн цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн хүнсний хангамжийн асуудалд түлхүү анхаарч, хүнсний сүлжээний баталгаат байдал, хүн амын хүнсний бодит хэрэглээтэй холбоотой зарим зохицуулалт орхигдуулсан байдаг.

Ийнхүү 1995, 1999, 2012 оны Хүнсний тухай хуулиуд хүнсний аюулгүй байдлын эрх зүйн үндсийг тогтооход чиглэж байсан бол Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хүнсний аюулгүй байдлын тогтолцоог иж бүрнээр нь тусгаж, хүнсний хүртээмж, баталгаат байдал, хяналтын тогтолцоотой холбогдох шинэлэг зохицуулалтыг тусгажээ.

Хэрвээ хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжвэл хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварт эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Дэлхийн улс орнууд, нийгмийн бүх салбарууд “Нэг дэлхий, нэг эрүүл мэнд” үзэл санаан дор нэгдэж, байгаль орчин, нийгмийн эрүүл мэндэд учирч байгаа аюулыг багасгахын төлөө хамтын хүчин чармайлт гаргаж байна. Энэхүү олон улсын чиг хандлагыг дэмжиж, “хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах” зарчим, үүнтэй холбоотой зохицуулалтыг тусгасан шинэлэг болжээ.

Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бодлого тодорхойлох, бодлогын уялдаа холбоог хангах, хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, эрсдэлийг удирдах, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг зорилгодоо хүрэхэд чиглэсэн байна. Ингэснээр хүнсний баталгаат байдалд итгэх хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлж, зах зээлээс эргэлзээгүйгээр хүнс худалдан авах нөхцөл бүрдэх эерэг нөлөөтэй байна.

Олон улсын чиг хандлага, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Алсын хараа-2050” хөгжлийн урт хугацааны бодлогод нийцүүлэн хуулийн төсөлд холбогдох заалтыг тусгаснаар хүний “зохистой хоол хүнсээр хангагдах”, “өлсгөлөнгөөс ангид байх” жам ёсны эрхийг хангах эрх зүйн орчин

⁴ Хүнсний тухай хууль 1995 он

⁵ Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль 1999 он

⁶ Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ 2012

⁷ 1995 онд Хүнсний тухай хууль баталж, 1999, 2012 онд Хүнсний тухай (Шинэчилсэн найруулга) -ыг баталжээ.

сайжрахаар байна. Хүний эрүүл мэндийг дэмжих, хоол хүнснээс гаралтай халдварт бус өвчлөлийг бууруулах, монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт байх тул зорилгодоо хүрнэ үзэж байна.

Дээр дурдсанаар бүх талаас авч үзэхэд хуулийн төсөл нь зорилгоо тодорхойлон тусгасан, үндэслэлтэй, олон улсын хандлагад нийцсэн, хэрэгжих боломжтой зохицуулалт багтсан тул **зорилгод хүрэх байдал хангагдсан** гэж үнэлж байна.

Ийнхүү хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжсэнээр хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэх эерэг нөлөө үзүүлэхээр байна.

4.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтэд мөрдөх хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангалтгүй, зориулалтын бус тээврийн хэрэгсэл суудлын автомашинаар хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа нь хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл үүсгэж байна. Үүний шалтгаан нь нийтийн орон сууцны зориулалтыг өөрчлөн хүнсний чиглэлийн ялангуяа хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаагаас нийтийн эрх ашиг зөрчигдөж байна.

Хуульд заасан хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай **барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах** ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх гэсэн заалтын хэрэгжилтийн хүрээнд 2013-2018 оны дунджаар Хүнсний худалдаа үйлчилгээний чиглэлээр 48,8 хувь, үйлдвэрийн чиглэлээр 57,8 хувь, Хоол үйлдвэрийн чиглэлээр 44,5, хувь, Амьтны гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 40 хувь, Ургамлын гаралтай бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлийн чиглэлээр 76,7 хувь хувьтай гарсан байна. Хүнсний **худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зориулалтын байргүй байх гэсэн зөрчил** их байдаг. Ялангуяа хоол үйлдвэрлэлийн чиглэлээр, орон сууцны байранд үйл ажиллагаа явуулж байгаа газрын тоо нийслэлд гэхэд л 700 орчим байгаа нь уг зөрчил буурахгүй байгаатай холбоотой байжээ.

2023 онд БСШУ-ны яамнаас хийсэн Төрийн өмчийн сургуулийн 33 хувь нь зориулалтын бус цайны газартай, 32,7 хувь нь ямар нэгэн тоног төхөөрөмжгүй, ихэвчлэн зориулалтын бус хувийн тээврийн хэрэгслээр хүнсний бүтээгдэхүүний татан авалтыг хийж байна.

Монгол Улс зохистой хоол, хүнсээр хангагдах эрхийг тусгасан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт, Хүүхдийн эрхийн конвенцийг соёрхон баталснаар

дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ⁸.

Монгол Улс Үндсэн хуульдаа “зохистой хоол, хүнсээр хангагдах эрх”-ийг тусгайлан тусгаагүй ч “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгуулах⁹”, “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрх¹⁰”-д хамаарч эрүүл хооллолт, эмзэг бүлэгт хоол хүнсний дэмжлэг үзүүлэх санаа агуулагдсан.

“Зохистой хоол, хүнсээр хангагдах эрх” нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, үл ялгаварлах¹¹ зарчмын хүрээнд хөдөлмөрлөх эрх¹², хувийн аж ахуй эрхлэх¹³ бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх¹⁴ эрхэд мөн хамааралтай байна..

“Зохистой хоол, хүнсээр хангагдах эрх”-ийн талаар Хүнсний тухай хуульд тусгаж байсан эсэхийг судалж үзэхэд “Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүн бүр эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, бие махбодынхоо хэвийн үйл ажиллагаа, өсөлт төлжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөх хоол, хүнс хэрэглэх эрх”¹⁵-ийг хуульчилж байжээ. Гэвч 1999 оны 10 дугаар сарын 07-ны өдөр баталсан Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд “хоол, хүнс хэрэглэх эрх” тусгагдаагүй, 2012 онд баталсан Хүнсний тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд ч мөн тусгагдаагүй.

Хүн бүрийн “зохистой хоол, хүнс сонгон хэрэглэх эрх” нь жам ёсны эрх нь нэг талаас Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн дээрх эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүрэгтэй, нөгөө талаас талдаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэгтэй холбоотой билээ.

Иймд хуулийн төсөлд “Зохистой хоол, хүнс сонгон хэрэглэх эрх”-ийг баталгаажуулж, үүнтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг нэмж тусгах.

Хүнсний тухай хуулийн 10.1.2 дахь заалтад стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх” гэж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтад “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэх, хадгалах,” гэж, хүнсний сүлжээний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хувьд Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах нийтлэг шаардлагаас өөр зохицуулалт байхгүй байсныг өөрчилж, ийнхүү дутуу зохицуулсан харилцаатай холбогдсон заалтыг хуулийн төсөлд оруулсан байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, үйлчилгээнд тавигдах холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 2

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 5

¹¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйл

¹² Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 4

¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 4

¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 14

¹⁵ Хүнсний тухай хууль 1995 он

чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалт"-ыг дагаж мөрдөхөөр заажээ.

Ингэснээр хүн бүрийн хэрэглэх хоол хүнс нь эрүүл ахуйн шаардлага хангасан, шим тэжээллэг, баталгаатай байж, хүний эрүүл мэндийг дэмжих нөхцөл бүрдэх эерэг үр нөлөөтэй байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөхийг үүрэг болгосноор хүнсний сүлжээний шат бүрд тавих шаардлага иж бүрэн зохицуулагдаж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн үүрэг хариуцлага дээшлэх эерэг нөлөөтэй байна. Хуулийн төсөлд шинээр оруулсан энэхүү заалтыг практикт хэрэгжиж боломжтой эсэхийг холбогдох хуульд шинжилгээ хийх замаар үнэллээ.

Зөрчлийн тухай хуулийн 6.14 дүгээр зүйл буюу Хүнсний тухай хууль зөрчих зөрчлийн бүрэлдэхүүнд 1/хуульд заасан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх шаардлагыг зөрчсөн бол, 2/Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй бол, 3/хуулиар зөвшөөрсөн дээд хэмжээнээс хэтрүүлж пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтлийн бодисыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хэрэглэсэн бол захиргааны хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Мөн Эрүүгийн хуулийн 20.12 дугаар зүйлд зүйлд "Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх" гэмт хэргийн шинжийг хуульчилж, шаардлага хангаагүй хүнс худалдах, түгээхийг хориглосон байна. Эндээс үзэхэд хүнс худалдах түгээхээр хүлээн авахдаа эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг шалган авах, өөрийн худалдах, түгээхдээ мөн холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөхийг үүрэг болгосон байна.

Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүлээлгэсэн үүрэг бусад хууль тогтоомжоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүлээлгэсэн үүрэгтэй холбоотой тул практикт хэрэгжих боломжтой үзлээ.

Гэхдээ Зөрчлийн тухай хуульд "хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаа, үйлчилгээнд тавигдах холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалт"-ыг мөрдөөгүй бол хариуцлага хүлээлгэхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай байгааг анхаарах.

2/Хүнсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал байдаг. Тэгвэл манай улсын хувьд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Өнөөдрийн байдлаар хүнсний салбарт нийт 200 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй, зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулдаг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тоо улсын хэмжээнд зөвхөн нэг байгаа зэрэг тоон үзүүлэлтүүд нь хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл, шалтгаан болж байгааг илтгэж

байна.

Хүнсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаат байдал байдаг. Тэгвэл манай улсын хувьд хүнсний чанар, эрүүл ахуйн баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байгаа. Өнөөдрийн байдлаар хүнсний салбарт нийт 200 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй, зохистой дадал нэвтрүүлснийг баталгаажуулдаг итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тоо улсын хэмжээнд зөвхөн нэг байгаа зэрэг тоон үзүүлэлтүүд нь хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл, шалтгаан болж байгааг илтгэж байна.

Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтад “үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх” шаардлагыг тавьж үүрэгжүүлснээс гадна 10.2 дахь хэсэгт хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно гэж заасан. Гэвч хуулийн 17 дугаар зүйлд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болно, магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага болон баталгаажуулалт авсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, нийтэд мэдээлнэ гэж заасан.

2023 оны байдлаар эрх бүхий байгууллагаас хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдлыг үнэлж, гэрчилгээ олгосон нийт 33 ААНБ байгаагаас 17 ААНБ хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000 стандартыг, 16 ААНБ эгзэгтэй цэгийн аюулгүй байдлыг хянан шинжлэх тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн байна. Энэ нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зарим байгууллага нь зохистой дадлын дараагийн шатны чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж баталгаажуулсныг харуулж байна.

Зохистой дадал гэдэг бол хүнсний сүлжээний үйл ажиллагаанд тавигдах чанар, эрүүл ахуйн зөвшөөрөгдөх доод хэмжээ / үзүүлэлтийг / учраас Хүнсний тухай хуулийн 10.1.4-т заавал биелүүлэх шаардлага болгон хуульчилсан байдаг.

Гэвч энэхүү заавал биелүүлэх шаардлагыг нэвтрүүлснээ баталгаажуулж болно гэж сонголттойгоор хуулийн 17 дугаар зүйлд зааж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлагыг сулруулжээ. Үүний тод жишээ бол 2018 оны байдлаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй, мэргэшсэн хүний нөөц, лабораторийн хүчин чадал, итгэмжлэгдсэн байгууллагын хүрэлцээ дутмаг байсан, салбарын яам 13 жилийн хугацаанд зохистой дадлыг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой дорвитой арга хэмжээ аваагүй явдал юм.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болохоор байсныг өөрчилж, үндэсний баталгаажуулалтын байгууллагаар заавал баталгаажуулахыг үүрэг болгож, баталгаажуулалт хийлгэсэн этгээдийн жагсаалтыг итгэмжлэгдсэн

баталгаажуулалтын байгууллага нийтэд мэдээлэх, өөрсдөө хүсвэл зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болохоор заасан нь дэвшилттэй зүйл болжээ.

Гэвч баталгаажуулалт хийдэг байгууллагын тоо хязгаарлагдмал, эрх зүйн зохицуулалт (заавар, стандарт) дутмаг байгаа нь нь хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд баталгаажуулалтын тогтолцоог нутагшуулахад хүндрэл учруулж болзошгүй байгааг анхаарах.

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаандаа зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ баталгаажуулах нь хүнсний баталгаат байдлыг хангахад чухал ач холбогдолтой төдийгүй хэрэглэгчид хоол хүнсээ айх аюулгүйгээр, эргэлзээгүйгээр итгэлтэйгээр сонгон хэрэглэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтад “үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх” шаардлагыг тавьж үүрэгжүүлсэнтэй уялдуулан энэхүү зохистой дадлыг нэвтрүүлснээ баталгаажуулахыг үүрэг болгох нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид дарамт үүсэхгүй. Ийм учраас хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3 дэх хэсэгт заасан баталгаажуулалттай холбогдсон зохицуулалтыг практикт хэрэгжих боломжтой гэж үнэллээ.

4.3. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДЛЫГ СУДЛАХ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Ойлгомжтой байдлыг судлахдаа Аргачлалын 4.7.2-т заасан “хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг шалгав. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал¹⁶-ыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад хүнсний салбарын зарим нэр томьёоны агуулга өргөжиж, зарим шинэ нэр томьёо гарч байна. Үүнтэй холбогдуулан хуулийн төсөлд хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалд үндэслэн “хүнсний эрүүл ахуй”, “хүнсний сүлжээ” гэсэн нэр томьёог өөрчлөн найруулж, “зохицуулах үйлчилгээтэй хүнс”, “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, “хүнсний худалдаа” гэсэн нэр томьёог нэмж тайлбарлажээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүнсний баталгаат байдал”, “зохицуулах үйлчилгээтэй хүнс”, “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэсэн нэр томьёог шинээр тайлбарласныг нэг бүрчлэн шалгахад дараах зүйл ажиглагдлаа. Үүнд:

¹⁶ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

- Хуулийн төсөлд “хүнсний баталгаат байдал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасныг;” ойлгоно гэж заажээ.

Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд туссан “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршил нь хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа төдийгүй эрдэмтэн судлаачдын дунд маргаан үүсгэсэн. Тухайлбал, “food security” болон “food safety” гэсэн англи нэр томъёог монгол хэлэнд аль аль нь “хүнсний аюулгүй байдал” хэмээн буруу хэрэглэснээс хууль хэрэглээнд хүндрэл учруулж байна.

“Хүнсний баталгаат байдал” гэсэн үгийг англиар “food security” гэж ойлгох бөгөөд монголоор “хүнсний аюулгүй байдал” гэж бичих байсан. Англи хэлнээ бичигдсэн хүнсний аюулгүй байдлын талаарх ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэлд “food security” болон “food safety” гэсэн утга агуулгын хувьд хоёр өөр үгийг монголын зарим эрдэмтэн, судлаачид хоёуланг нь хүнсний аюулгүй байдал гэж орчуулдаг байсан. Орчуулгын энэхүү зөрүүтэй ойлголтыг засаж залруулах зорилгоор хүнсний 20 гаруй эрдэмтэд хамтран Хүнсний нэр томъёоны толийг 2018 онд бүтээсэн. Ингэснээр хүнсний салбарын шинжлэх ухаан, үйлдвэрлэл, практик үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг хүнсний нэр томъёоны тодорхойлолтыг тодорхой болгон цэгцэлж, ижил утгыг илэрхийлсэн олон үгсийн тайллыг гаргасан байна.

Хуулийн төсөлд “хүнсний баталгаат байдал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасныг” хэлнэ гэж тодорхойлж, “хүнсний аюулгүй байдал” гэж хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, баталгаат хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршлаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байхыг” ойлгоно хэмээн зааг ялгааг нь гаргаж тайлбарлажээ.

Гэвч Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн нэр өөрчлөгдөөгүй, тус хуульд байгаа “4.1.4. “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй байхыг;” гэсэн заалт хэрхэх нь тодорхой үлдсэнээр хууль хэрэглээнд хүндрэл учруулж болзошгүй байна.

Иймд “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хуулийг нэрийг “Хүнсний баталгаат байдлын тухай” хууль гэж өөрчилж, нэр томъёог жигдлэх зорилгоор Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бэлтгэх шаардлагатай байна.

- Хуулийн төсөлд “зохицуулах үйлчилгээтэй хүнс” гэж хүний бие махбодод бүхэлд нь, эсхүл тодорхой нэг эрхтний үйл ажиллагааг дэмжих шимт бодисын найрлагатай, биологийн үйлчлэл, үнэт чанартай бүтээгдэхүүнийг;” ойлгоно гэж

заасан нь хэт ерөнхий байна. Иймд энэхүү нэр томьёоны тайлбарыг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд буцаан татсан Зохицуулах үйлчлэлтэй хүнсний тухай хуулийн төсөлд заасан нэр томьёотой уялдуулан дахин нягталж үзэх шаардлагатай байна.

- Хуулийн төсөлд “хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан түүхий эд, туслах материал ашиглаж, эрх бүхий этгээдийн баталсан жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол бэлтгэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг,” ойлгоно гэж тусгажээ.

Гэвч энэ нэр томьёонд “эрх бүхий этгээд” гэдэг ямар субъект байх, “жор” гэдэг нь эмийн жор уу, эсхүл хоолны цэс үү гэдэг нь ойлгомжгүй байна. Иймд энэхүү нэр томьёо нь хуулийн хэрэглээнд хүндрэл учруулж болзошгүй байх тул нэр томьёоны тайлбарыг нягтлах шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн 3 дугаар зүйлд “хүнсний эрүүл ахуй”, “хүнсний сүлжээ” гэсэн нэр томьёог ойлгомжтой болгох зорилгоор өөрчлөн найруулсан байх бөгөөд үүнийг Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох нэр томьёотой харьцуулан үнэлэв.

Хүнсний тухай хуульд томьёолсон байдал	ХБАБХтХуульд	Хуулийн төсөлд томьёолсон байдал
3.1.4."хүнсний эрүүл ахуй" гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.5-д заасныг;	4.1.5."хүнсний эрүүл ахуй" гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүхий л нөхцөл, шаардлагыг;	"3.1.3."хүнсний эрүүл ахуй" гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, бохирдоогүй, хортой нэгдэл, өвчин үүсгэгч бичил биетэн агуулаагүй байхыг;"
3.1.11."хүнсний сүлжээ" гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.6-д заасныг;	4.1.6."хүнсний сүлжээ" гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх	" 3.1.11."хүнсний сүлжээ" гэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, хүнсийг тусламжаар авах, өгөх, чанар, эрүүл ахуйн

	үйл ажиллагааг; 4.1.7."анхан шатны үйлдвэрлэл эрхлэх" гэж ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг тариалах, хураах, бэлтгэх, мал, амьтан, загас өсгөх, үржүүлэх, мал бэлтгэх, төхөөрөх, түүхий сүү бэлтгэх, боловсруулах, байгалийн гаралтай жимс жимсгэнэ, ургамлыг түүх, тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг;	шаардлага хангаагүй хүнсийг буцаан татах, устгах үйл ажиллагааг;
--	--	---

-“Хүнсний эрүүл ахуй” гэсэн нэр томъёоны тухайд Хүнсний тухай хуулийн 3.1.4-т “хүнсний эрүүл ахуй” гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.5-д заасныг гэж эшлэл татсан бөгөөд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.5."хүнсний эрүүл ахуй" гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангахад **шаардагдах бүхий л нөхцөл, шаардлагыг** ойлгоно гэж сүлжээн дэх орчинтой холбон тайлбарласан байна.

Харин хуулийн төсөлд “3.1.3.“хүнсний эрүүл ахуй” гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, бохирдоогүй, хортой нэгдэл, өвчин үүсгэгч бичил биетэн агуулаагүй байхыг;” гэж тайлбарласнаас үзэхэд хүнсний эрүүл ахуйг сүлжээний гадаад орчин төдийгүй хүнсний бүтээгдэхүүн дотоод агууламжийн бохирдолтой холбон тайлбарласан нь шинэлэг зүйл болжээ.

-Хүнсний сүлжээ гэсэн нэр томъёоны тухайд Хүнсний тухай хуулийн 3.1.11."хүнсний сүлжээ" гэж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.6-д заасныг гэж эшлэл татсан бөгөөд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.6-д "хүнсний сүлжээ" гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг ойлгоно гэж хуульчлаад 4.1.7-д "анхан шатны үйлдвэрлэл эрхлэх" гэж ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг тариалах, хураах, бэлтгэх, мал, амьтан, загас өсгөх, үржүүлэх, мал бэлтгэх, төхөөрөх, түүхий сүү бэлтгэх, боловсруулах, байгалийн гаралтай жимс жимсгэнэ, ургамлыг түүх, тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг ойлгоно гэж хүнсний үйлдвэрлэлийг нарийвчлан тодорхойлсон байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.6-д "хүнсний сүлжээ" гэсэн нэр томъёонд “баяжуулах” гэсэн технологи, улсын болон орон нутгийн хэмжээнд нөөц бүрдүүлэхтэй холбоотой “нөөцлөх” гэсэн ойлголтыг хүнсний сүлжээний үе шатанд хамааруулсан нь учир дутагдалтай байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсийг “нөөцлөх” гэхээсээ илүү хуульд заасан хугацаанд

стандарт, техникийн зохицуулалтын “хадгалах” үүрэгтэй. Харин “нөөц бүрдүүлэх” гэдэг хүнсний хангамжтай холбоотой стратегийн хүнстэй холбоотой гэж үзэж байна.

Харин хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хүнсний сүлжээ” гэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, хүнсийг тусламжаар авах, өгөх, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсийг буцаан татах, устгах үйл ажиллагааг,” ойлгоно гэж өөрчлөн найруулжээ. Эндээс үзэхэд 1-рт хүнсний анхан шатны үйлдвэрлэлийг өргөжүүлж, хөдөөд аж ахуйн үйлдвэрлэл гэж заасан нь оновчгүй байна, 2-рт “баяжуулах” гэсэн технологи, улсын болон орон нутгийн хэмжээнд нөөц бүрдүүлэхтэй холбоотой “нөөцлөх” гэсэн ойлголтыг хүнсний сүлжээний үе шатанд хэвээр үлдээсэн байна.

Иймд “хүнсний сүлжээ” гэсэн нэр томъёог дахин нягтлан үзэх шаардлагатай байна.

Хэдийгээр Хуулийн хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангаж байгаа боловч зарим нэр томъёо нь “Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хуулиудын хооронд логик зөрүү үүсгэж болзошгүй тул тэдгээрийг нэг мөр ойлголттой болгож цэгцлэх, эрх зүйн нэр томъёоны уялдаа холбоог хангах шаардлагатай байна.


Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хууль зүйн логик дараалал, бүтэцтэй уялдаа сайн байна. Мөн хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.

4.4. “ЗАРДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

Хүнсний баталгаат байдалд тавих хяналттай холбоотой харилцааг Хяналт шалгалтын тухай хуулиар хэрэгжүүлэх зохицуулж байна. Одоогийн хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт болон тогтолцооны гажуудалд орсон.

МХЕГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрыг нийт 19 орон тоотой байгуулж, тус газарт үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын газар болон хөдөө аж ахуйн хяналтын газартайгаар бүтэц, орон тоог баталсан байна. Үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтын газарт хүнсний чанар, стандартын хяналтын хэлтэс, үүн дотор хүнсний үйлдвэрийн хяналт, худалдаа, үйлчилгээний хяналт, хоол үйлдвэрлэлийн хяналт, хүнсний биоаюулгүй байдлын хяналт гэсэн 4 чиг үүргийг хариуцан хяналтын үйл ажиллагааг эрхэлдэг байсан байна. Харин хөдөө аж ахуйн хяналтын газарт мал эмнэлгийн хяналт, ургамал хамгааллын хяналтын чиг үүрэг байсан байна.


37 дугаар зураг. Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын бүтэц зохион байгуулалт, 2022 он



"Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 469 дүгээр тогтоолоор мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж, хүнсний аюулгүй байдлын хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжсэн байна. Уг тогтоолын 1.8-д "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 50 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт "2.9.Салбарын хяналтын газар"-ыг нэмж, орон тоо "105" гэснийг "121" гэж өөрчлөхөөр заажээ. Ийнхүү МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын 19 орон тооноос хүнсний чанар, стандартын хяналтын газар, мал эмнэлгийн хяналтын газар, ургамал хамгааллын хяналтын газрын даргын 3 орон тоо хасагдаж, нийт 16 улсын байцаагч салбарын яаманд шилжсэн байна. Өнөөдрийн байдлаар яамны салбарын хяналтын газрын "хүнсний аюулгүй байдлын хяналт"-ын чиглэлийн 4 улсын байцаагчийн орон тоог хасагдаж, хөнгөн үйлдвэрийн 1 хяналтын улсын байцаагч нэмэгдсэн байна. Хөнгөн үйлдвэрийн хяналт нь хүнсний чанар, эрүүл ахуйтай ямар ч хамааралгүй хяналт болно.

Аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын тогтолцоо оновчгүй байгаагаас эрүүл мэндийн болон хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын ажил өөр хоорондоо уялдаа холбоогүй, цаг хугацааны хувьд ойр ойрхон хийдгээс гадна хяналт шалгалтын удирдамж нь давхардсан агуулгатай, нэг зөрчилд өөр өөр хариуцлагыг давхардуулан оногдуулах зэрэг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд дарамт үүсгэж, тухайн хуулийн этгээд хяналт шалгалтад цаг их зарцуулснаас бүтээмж буурах хандлагатай байна.

Энэ нь төрийн захиргааны төв байгууллагууд салбарын хяналтын нэгж орон нутгийн хяналтын байгууллагыг мэргэжлийн удирдлагаар бүрэн хангаж, уялдаа холбоотойгоор ажиллаж чадахгүй байгааг харуулж байна.



Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэд, хуулийн этгээдээс зардал гарахгүй гэж тооцсон. Харин төрийн байгууллагаас жилд гарах зардлын тооцоог хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.2.5.төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх. гэж заасан тул уг тооцооллыг 2026 оноос хэрэгжихээр хийлээ. Төсөвт тодотгол хийхээс бусад тохиолдолд 2025 оны дундуур энэ агентлагийг шинээр зохион байгуулах замаар шинэ зардал үүсгэх

боломжгүй байна.

Төрөөс гарах зардал, агентлагийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой гарах зардлын тооцоог хийсэн. Агентлагийн чиг үүрэгт одоо ажиллаж байгаа ХХАХҮЯ-ны салбарын хяналтын газрыг чиг үүргийг шилжүүлнэ. Мөн ХАБҮЛЛ-ыг уг агентлагийн доор ажиллуулахаар байна. Агентлаг нь бүтцийн хувьд ХАБҮЛЛ ажиллагсадтай нийлээд 319 ажилтантай ба үүнээс шинэ ажилтан нэмж авахгүй, чиг үүргийн дагуу ХХААХҮЯ дээр ажиллаж буй салбарын хяналтын орон тоог агентлагт шилжүүлнэ.

Иймээс төсөвт үзүүлэх зардлын тооцооллыг хийхдээ цалингийн зардлыг шинээр нэмэгдэхгүй байхаар тооцлоо. Харин шинээр агентлаг байгуулахтай холбоотойгоор ажлын байр, тавилга хэрэгсэл, компьютер техник хэрэгслийг лабораторос тусад нь үйл ажиллагаа явуулах 28 хүний орон тоогоор тооцож гаргасан.

Зардлыг нэгтгэн авч үзвэл, нийтдээ агентлагийн 2026 оны үйл ажиллагааны урьдчилсан төсөв нь 12.9 тэрбум төгрөгийн зардал ба үүнээс хамгийн өндөр зардал болох 10.7 тэрбум төгрөгийн зардал нь цалингийн зардал эзэлж байна. Гэвч, агентлагт хамаарах 319 ажилтан нь одоо ажиллаж байгаа ажилчид тул шинээр орон тоо бий болгохгүй болно. Иймд хуулийн төслийн хүрээнд цалингийн зардал, бичиг хэргийн зардал болон томилолтын зардал нэмэлтээр бий болохгүй.

Харин, шинэ байгуулагдах агентлагийн 28 ажилтанд хамаарах байрны түрээс, тавилга, компьютер хэрэгслийн зардал нь нийтдээ 422 сая төгрөг зардал гарахаар байна. Үүнээс байрыг түрээслэхгүй төрийн өмчийн байрыг ашиглах тохиолдолд 156 сая төгрөг хэмнэх боломжтой ба улмаар тавилга, компьютер хэрэгслийг төрийн өмчийн хөрөнгөөс ашиглах бол төрөөс ямар ч зардал гаргахгүйгээр агентлагийн үйл ажиллагааг шийдвэрлэх бүрэн боломжтой байна.

Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, хүнсний импорт, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна. Ингэснээр хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна. Мөн хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаат байдал сайжирна.

Төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

4.5. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай

уялдах уялдаа холбоог сайжруулах юм.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэх асуудлыг тогтоох юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд (1948): “Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эруул мэнд, аж амьдралыг тэтгэхэд хуралцэхуйц амьжиргаатай байх эрхтэй” гэж заасан байдаг. Тэгвэл “Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай” олон улсын пактад (1966) эдгээр асуудлыг улам боловсронгуй болгож: “хүн бүр . . . зохистой хоол хүнсээр хангагдах эрх”-ийг цохон тэмдэглээд, нэн тэргүүнд “өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрх”-ийг онцлон заасан байдаг. Өлсгөлөнгөөс ангид байх эрх нь амьдрах эрхтэй салшгүй холбоотой байдгаараа хүний үндсэн эрх юм.

Оролцогч улсуудын хүлээх хууль ёсны үүргийн мөн чанарын талаар ЭЗНСЭОУП-ын 2 дугаар зүйлийн 1-д: “Энэхүү Пактад оролцогч улс бүр ганцаар болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар дамжуулан, нэн ялангуяа эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэх явдлыг аажмаар хангахын тулд хууль, тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг байгаа бүх бололцооныхоо хирээр авах үүрэгтэй.” хэмээн зааж, үүнийг Оролцогч улсууд хүлээн зөвшөөрсөн билээ.

Мөн Пактын 11 дүгээр зүйлийн 1-д: “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний гэр бүлийн хуралцээтэй хоол хунс ... оролцуулан, амьдралын хуралцээтэй түвшинд аж амьдрах, амьдралынхаа нөхцөлийг байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө.” хэмээн заасан байдаг. Тус хорооны Ерөнхий зөвлөмж 12-т Пактын хүнсний эрхийг хэрэгжүүлэх Оролцогч улсуудын үүргийг дэлгэрэнгүй тодорхойлсон байдаг. 15-д Зохистой хоол хүнсээр хангагдах эрх нь хүний эрхийн бусад хэлбэрийн адилаар улс орон бүрд “дагаж мөрдөх”, “хамгаалах”, “биелүүлэх” гэсэн 3 түвшний үүргийг оноодог.

Хуулийн зүйл, заалтууд нь бусад холбогдох хуулиудтай уялдаатайгаар боловсруулагдсан. Хуулийн төсөлд хэрэгжүүлэгч субъектууд тодорхой тусгагдсан, төрийн байгууллагын чиг үүрэг давхардаагүй, мөн шинэ татвар, төлбөр, тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт агуулаагүй байна. Энэ нь хууль зүйн хэм хэмжээний нийцлийг хангаж, хэрэгжилтийн орчинг ойлгомжтой, зохицуулалттай болгох нөхцөлийг бүрдүүлж байна.

Түүнчлэн жендерийн эрх тэгш байдал, шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгохуйц заалт хуулийн төсөлд тусгагдаагүй нь төсөлд суулгасан зарчим, зорилт нь нийгмийн шударга байдал, ил тод байдалд чиглэснийг илэрхийлж байна.

Иймд хуулийн төслийн харилцан уялдаа хангагдсан бөгөөд энэ нь эрх зүйн тогтолцоонд нийцтэй, үр нөлөөтэй шинэчлэл байхаар дүгнэгдэж байна.

Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тэдгээр зорилтуудад хүрэх шууд утга бүхий заалтуудыг нэмэлтээр оруулсан тул зорилтдоо хүрсэн гэж үзлээ.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байна. Тухайлбал, хууль гэх мэт бусад хуулиудын зохицуулалттай нийцэж байна.
Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зүйл тогтоогдоогүй.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан зүйл тогтоогдоогүй
Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төсөлд Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зүйл тогтоогдоогүй.

Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд ямар нэг албан татвар, төлбөр хураамж тогтоосон зүйл заалт тусгаагүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалттай холбоотой ямар нэгэн зүйл заалт тусгаагүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жендерийн эрх тэгш байдал хөндөгдөөгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Төсөлд хориглосон хэм хэмжээ тусгаагүй тул ямар нэг хариуцлага хүлээлгэх талаар Зөрчлийн хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэгт хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болохоор заасан боловч Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэрийг өөрчлөх талаар зохицуулалт байхгүй байгааг анхаарах.

ТАВ.НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ, САНАЛ

“Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл нь хүнсний аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын чиг хандлагад нийцүүлэх, хүний зохистой хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц зохицуулалтыг тусгасан байна.

Төсөлд туссан зохицуулалтууд нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа нь үнэлгээний явцад

тогтоогдсон тул шалгуур тус бүрээр нь дараах үнэлгээг өглөө.Үүнд:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь зорилгоо тодорхойлон тусгасан, үндэслэл сайтай, олон улсын жишигт нийцсэн зохицуулалттай.
- **Практикт хэрэгжих боломж:** Шинэчлэн найруулсан болон нэмэлт заалтууд нь одоогийн эрх зүйн орчин, бодит нөхцөлд нийцэж, хэрэгжих боломжтой.
- **Ойлгомжтой байдал:** Нэр томьёо, найруулга, хэл зүйн хувьд ихэнх хэсэг нь ойлгомжтой, хууль зүйн техникийн шаардлагад нийцсэн хэдий ч тодорхой нэр томьёонд нарийвчилсан тодорхойлолт шаардлагатай.
- **Зардал.**Хуулийг хэрэгжүүлснээр хүн, хуулийн этгээдэд зардал үүсэхгүй. Харин хяналтын тогтолцоог өөрчилсөнтэй холбоотойгоор төрд зардлын ачаалал үүсэх боловч энэ хоол хүнснээс гаралтай халдварт бус өвчлөлтэй холбоотой нийгмээс гарах зардлаас бага байна.
- **Харилцан уялдаа:**Хуулийн төсөл нь холбогдох хууль тогтоомжтой харьцангуй нийцтэй боловч Хүнсний тухай хууль болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсч байна.

Дээр дурдсан хуулийн төслийн үр нөлөөний дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1.Зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцооны баталгаажуулалтыг практикт бүрэн хэрэгжүүлэх зорилгоор холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг шинэчлэх, шинээр боловсруулж батлах.

2.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д заасан “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” зарчмыг баримтлан хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс даган мөрдөхөөр заах.

3.Хуулийн төсөлд тусгагдсан хүнсний сүлжээн дэх зарим үйл ажиллагаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх, зохистой дадал, хяналт, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ баталгаажуулахыг үүрэг болгосон заалтыг зөрчсөн тохиолдол хариуцлага хүлээлгэхээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар хуулийн хэрэгжилтийг хангуулах.

4.Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд **зөвхөн** хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нэрээр боловсруулж батлах бөгөөд хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгахаар заасан.

5.Хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд байсан “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршлийг “хүнсний баталгаат байдал” гэж өөрчлөн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулж байгаа.

Иймээс Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, уг хуулийн зүйл, заалт дахь томъёоллын “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн бичвэрийг өөрчлөх шаардлага гарч байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь хэсэгт “хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно” гэж, ийнхүү хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно гэж заасныг үндэслэн суурь хууль болох Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой.

Харин Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тус хуулийн нэрийг өөрчлөх зохицуулалт Хууль тогтоомжийн тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй. Мөн энэ талаар практик байхгүй байна.

Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг тусад нь боловсруулах замаар хуулийн нэрийг өөрчлөн, хууль хоорондын уялдаа холбоог хангах, эдгээр хуулиудыг Улсын Их Хуралд хамтад өргөн мэдүүлэхийг санал болгож байна.

**ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

ГАРЧИГ

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД

ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН..... 3

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ..... 3

1. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО..... 6

2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО..... 7

ДҮГНЭЛТ 15

АШИГЛАСАН МАТЕРИАЛ..... 16

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

Зардлын тооцоо хийсэн аргачлал:

Сонгон авсан хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр бичигдсэн байх ба тус хуулийн төсөлд хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад хэрэгжүүлэх нэмэлт чиг үүрэг бий болгож байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд “хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог оновчтой болгох, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог сайжруулах, эрүүл хүнсний хэрэглээг хэвшүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.” гэж заасны дагуу уг зорилтыг хангахад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад ямар төрлийн шинэ чиг үүрэг бий болж, үүнтэй холбоотой гарч болох зардлын тооцоог хийхийг зорилоо.

Хуулийн төсөлд шинээр бий болсон бүтэц, төрийн байгууллагын нэмэлт чиг үүргийн бүтэц гэсэн агуулгаар зардлын ерөнхий тооцоог гаргана. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр нэмж буй 13¹ дугаар зүйл, 14¹ дүгээр зүйлээр хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “агентлаг” гэх), аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт хариуцсан нэгж, эрдэм шинжилгээний байгууллагын чиг үүргийг хөндсөн байна.

Хуулийн төслийн зардлын тооцоог гаргах зорилгоор Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаж, судалгааг боловсруулсан, хуулийн төслийг боловсруулсан мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийлээ.

Хуулийн төсөлд заасан шинэ бүтэц болох агентлагийн чиг үүргийг тодорхойлж, холбогдон гарах зардал, тоон үзүүлэлтийг тооцож, нийт зардлыг гаргалаа. Үүнд:

Агентлаг нь хуулийн төсөлд заасны дагуу хүнсний хууль тогтоомж, стандартын хэрэгжилт, дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол,

шошгололт, шошго дох тэмдэг, тэмдэглэгээ, хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлын хэрэгжилт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадлын хэрэгжилт, үйлдвэрлэлийн шат дамжлага дахь аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авалт; хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлд тус тус хяналт тавих чиг үүрэгтэй байна. Энэхүү агентлагийн чиг үүргийг одоо хүчин төгөлдөр хуулийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (цаашид “ХХААХҮЯ”)–ны салбарын хяналт хариуцсан газар, нэгж хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү бүтцийг шинээр байгуулах агентлагт шилжүүлнэ. Мөн агентлагийн доор одоо үйл ажиллагаа явуулж байгаа Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (цаашид “ХАБҮЛЛ” гэх)-ийг мөн ажиллуулна.

Агентлагийг байгуулж байгаатай холбоотойгоор нэмэлт шинэ орон тоог үүсгэхгүй бөгөөд агентлагийн албан хаагчдыг ХХААХҮЯ болон ХАБҮЛЛ-аас шилжүүлэн авах замаар бүрдүүлнэ. Дээрх агуулгаар агетлаг нь нийтдээ 319 хүний бүрэлдэхүүнтэй байх ба үүнд агентлагийн үндсэн орон тооноос гадна, ХАБҮЛЛ-ийг хамруулна.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдох боломжтой тул бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Зардлын тооцоонд ашигласан үзүүлэлт, тоо баримтыг хуулийн төсөл боловсруулагчтай зөвлөсний дагуу доор дурдсан асуулт, хариултын хүрээнд хийлээ. Үүнд:

№	Асуулт	Хариулт
1	Төслийн 4.2-т заасан бодлогыг хэрэгжүүлэхэд зардал гарах уу? Ямар төрлийн зардал яаж гарах боломжтой вэ?	Хуулийн төслөөр төрөөс гарах дэмжлэг, урамшууллын асуудлыг хөндөөгүй.
2	Төслийн 10.4, 10.5-д заасан стандартыг мөрдөхөд зардал гарах уу? Ямар зардал гарах боломжтой вэ? Зардал тооцох үзүүлэлтийг хэлнэ үү? Энэ зардлыг хэн гаргах вэ?	Гарахгүй. Аж ахуйн нэгжүүд угаасаа хийгээд явж байгаа, дотоод хяналтаар дамжуулаад хэрэгжүүлэх боломжтой, байхгүй бол энэ тал дээр зардал гарна
3	Төслийн 13.4-т заасан судалгааг хийхэд зардал гарах уу? Жилд дунджаар тооцоход ямар зардал гарах боломжтой вэ? Зардал тооцох үзүүлэлтийг хэлнэ үү. Энэ төрлийн өмнө гарч байсан зардлын жишиг байгаа юу?	Тандалт судалгаан дээр зардал гарна. Олон улсын байгууллагаас өнөөдрийг хүртэл гаргаж ирсэн.
4	Төслийн 13 ¹ -т заасан байгууллагад ажиллах нийт ажилтны	Задаргааг өгсөн. 319

	тоо, албан тушаалын ангилал тус бүрээр, бүтцийн задаргаатай өгнө үү.	хүнтэй байна.
5	Төслийн 13 ¹ -т заасан байгууллагад ямар ямар байгууллагаас ямар албан тушаалын ангилал бүхий хэдий тооны ажилтан шилжүүлэн ажиллуулах талаарх мэдээлэл. Тухайлбал, ХХААХҮЯ-ны бүтцийн бүдүүвчид энэ чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ямар газар, хэлтэс, алба, мэргэжилтэн шилжих талаарх мэдээлэл	Яамны салбарын хяналтын газрын чиг үүргийг шилжүүлнэ. Анх салбарын хяналтаар шилжүүлсэн 16 ажилтныг буцаан татна. Эдгээр албан хаагчид нь албан тушаалын ангиллын хувьд буурахаар байна. Мөн ХАБҮЛЛ үйл ажиллагааг шилжүүлэхтэй холбоотой зарим нэг албан хаагчийг ХАБҮЛЛ-аас шилүүлнэ.
6	Төслийн 13 ¹ -т заасан байгууллагын үйл ажиллагаа явуулах байр сав, техник хэрэгслийг одоо байгаа нөөцөөр хангах боломжтой эсэх?	Энэ талаар тодорхой мэдээлэлгүй байна. Байрны хувьд 28 албан тушаалтантай оффис, тавилга, компьютер шаардлагатай. Харин бусад ажилтан буюу ХАБҮЛЛ ажилчдын хувьд одоо байгаа байр, ажлын байр дээр үйл ажиллагаа хэвийн явагдана.
7	Төслийн 14 ¹ дугаар зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын нь одоо байгаа байгууллага уу? чиг үүрэг нэмэгдэж байна уу? нэмэгдэх бол ямар чиг үүрэг, үүнийг хэрэгжүүлэх ажилтны тоо нэмэгдэх эсэх нэмэгдэх бол ямар албан тушаалаар ажиллах ажилтан, хэдэн хүн нэмэгдэх вэ?	Эрдэм шинжилгээний байгууллагад одоо байгаа хүрээлэн, сургууль гэх мэт орно. Зардал гарахгүй, шинээр бий болгоогүй чиг үүрэгт багтана.
8	Төсийн 17.1-д заасан баталгаажуулалтыг ямар байгууллагаар хийлгэх вэ? Давтамж нь хэр байх вэ? Баталгаажуулалтын	Баталгаажуулалтад зардал төрөөс

	зардал хэд байх вэ? Одоо энэ төрлийн баталгаажилт байгаа юу? Гардаг эсэх?	гарахгүй, ААН-эс тодорхой зардал гарна, гэхдээ бид энэ зүйл, заалтыг хөндөөгүй гэж бодож байна.
9	Төслийн 17.2-т заасан баталгаажуулалтын байгууллага нь ямар байгууллага вэ? Нийтэд мэдээлэхдээ яаж мэдээлэх вэ? Ямар нэг зардал гарах уу? одоо байгаа байгууллага уу? шинэ байгууллага уу? шинэ ажилтан бий болох уу? тийм бол албан тушаалын ангиллыг хэлнэ үү.	Энэ зүйл заалтыг хөндөөгүй.
10	Төслийн 18.6.5-д заасан чиг үүрэгтэй холбоотой шинэ албан тушаалтан ажиллах уу? Тийм бол уг албан тушаалтны албан тушаалын ангилал, зэрэглэл, ажлын байрны шаардлага? Үүнээс цалингийн хэмжээг тодорхойлох юм.	Шинээр ажлын байр бий болгохгүй, чиг үүргийн дагуу өмнө шилжүүлсэн орон тоог буцаан татна

1. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх нэмэлт чиг үүргийг бий болгоогүй. Иргэн, хуулийн этгээдээс хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдож болох хуулийн төслийн зохицуулалт нь:

10.4.Хүнс, хөдөө аж ахуй, хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тээвэрлэлт, хадгалалтын стандартыг дагаж мөрдөнө.

10.5.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд чанар, эрүүл ахуйн стандартыг дагаж мөрдөнө.

17.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна.

Дээр дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээдийн хувьд нэмэлт ажлын байр бий болгох шаардлага байхгүй. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд заасан чиг үүрэгтэй ижил чиг үүрэгтэй байна.

Энэхүү хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. гэж заасан. Иймээс ч энэхүү зорилтыг хангах хүрээнд дээрх хуулийн төслийг боловсруулж байх тул иргэн, хуулийн этгээдээс энэхүү чиг үүрэгтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй.

2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн дараах нэмэлт чиг үүргийг төр өөртөө хүлээсэн байна. Үүнд:

1. Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг байгуулах;
2. Агентлагийн дэргэд хяналтын лаборатори ажиллуулах;
3. Агентлагийн чиг үүрэгт нийцүүлж аймаг, нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт хариуцсан нэгжийг ажиллуулах;
4. Эрдэм шинжилгээний байгууллагын чиг үүргийг бий болгох;
5. Хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний баталгаат байдал, бичил биетний тэсвэржилт, шим тэжээлийн болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол, хүнсний нэр төрөл, найрлагын судалгааг хийх зэрэг болно.

Эдгээрийг хуулийн төсөлд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

ХҮНСНИЙ ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АГЕНТЛАГ БАЙГУУЛАХ:

13¹ дүгээр зүйл. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт

13^{1.1}. Хүнсний хууль тогтоомж, хүнсний чанар, стандартын хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

13^{1.1}. Энэ хуулийн 13^{1.1}-д заасан байгууллага, нэгж нь дараах чиглэлээр хяналт хэрэгжүүлнэ:

13^{1.2.1}. хүнсний хууль тогтоомж, стандартын хэрэгжилт;

13^{1.2.2}. дотоодын болон импортын хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошгололт, шошгодох тэмдэг, тэмдэглэгээ;

13^{1.2.3}. хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадлын хэрэгжилт;

13^{1.2.4}. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадлын хэрэгжилт;

13^{1.2.5}. үйлдвэрлэлийн шат дамжлага дахь аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт;

13^{1.2.6}. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авалт;

13^{1.2.7}. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл.

АГЕНТЛАГИЙН ДЭРГЭД ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ АЖИЛЛУУЛАХ:

13^{1.2}.Энэ хуулийн 13^{1.1}-д заасан төрийн захиргааны байгууллагын дэргэд хяналтын лабораторитой ажиллана.

13^{1.3}.Энэ хуулийн 13^{1.2}-д заасан лаборатори тухайн шинжилгээний үзүүлэлтээр стандартын дагуу итгэмжлэгдсэн байна.”

АГЕНТЛАГИЙН ЧИГ ҮҮРЭГТ НИЙЦҮҮЛЖ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ ХАРИУЦСАН НЭГЖИЙГ АЖИЛЛУУЛАХ:

13^{1.1}.Хүнсний хууль тогтоомж, хүнсний чанар, стандартын хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг хүнсний хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙГ БИЙ БОЛГОХ:

14¹ дүгээр зүйл.Эрдэм шинжилгээний байгууллагын оролцоо

14^{1.1}.Эрдэм шинжилгээний байгууллага нь хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14^{1.1.1}.Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын суурь судалгаа явуулах, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлыг үнэлж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг зураглах, холбогдох судалгааны арга зүйг боловсронгуй болгох;

14^{1.1.2}.Хүнсний шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр үйлдвэрлэлийн технологийн туршилт, судалгаа явуулах, мониторинг хийх;

14^{1.1.3}.Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд чиглэгдсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, ноу-хауг судалж, нутагшуулах талаар санал, зөвлөмж боловсруулах;

14^{1.1.4}.Өндөр хөгжилтэй орнуудад нэвтэрч буй хүнсний түүхий эд бүтээгдэхүүний савлагаа, хадгалалт, тээвэрлэлтийн шинэ технологийг нутагшуулах, нэвтрүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, олон нийтэд түгээх;

14^{1.1.2}.Хүнсний салбарт ажилладаг мэргэжлийн байгууллага болон бусад хуулийн этгээдийг мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах;

14^{1.1.6}.Хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, энэ чиглэлээр судлаач, мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийг чадавхжуулах;

14^{1.1.7}.хуульд заасан бусад.”

ХҮНСНИЙ ХАНГАМЖ, БОДИТ ХЭРЭГЛЭЭ, ХҮНСНИЙ БАТАЛГААТ БАЙДАЛ, БИЧИЛ БИЕТНИЙ ТЭСВЭРЖИЛТ, ШИМ ТЭЖЭЭЛИЙН БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮҮХДИЙН ХООЛ, ХҮНСНИЙ НЭР ТӨРӨЛ, НАЙРЛАГЫН СУДАЛГААГ ХИЙХ ЗЭРЭГ БОЛНО.

13.1.5.хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний баталгаат байдал, бичил биетний тэсвэржилт, шим тэжээлийн болон ЕБС-ийн хүүхдийн хоол, хүнсний нэр төрөл, найрлагын судалгаа;

Хуулийн дээрх зохицуулалтаас харахад доор дурдсан чиглэлээр төрөөс нэмэлт зардал гарахаар байна. Үүнд:


1. Агентлагийн чиг үүргийн хүрээнд нийт 319 албан хаагчийн зардал;

Дээрх чиг үүрэг, зардлыг тодорхойлж үзвэл:

2.1. Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг:

Тус шинээр байгуулагдах агентлаг нь дараах бүтэцтэй ажиллана. Үүнд:

Зураг 1



Хүнсний хяналт, зохицуулалтын агентлаг нь нийт 319 ажилтнаас бүрдэх ба үүнээс улсын байцаагч 20, захиргааны 8, ХАБҮЛЛ-ийн 111, ХАБҮЛЛ-ийн харьяа орон нутгийн хүнсний лабораторийн 180 албан хаагчтай байна. Үүнээс 2022 оны 12 сард МХЕГ-аас ХХААХҮЯ-руу шилжсэн 16 улсын байцаагчийг ХХААХҮЯ-наас, захиргааны 8 албан хаагчийг ХАБҮЛЛ-оос шилжүүлэн ажиллуулахаар байна. Иймд агентлагтай холбоотой шинэ орон тоо бий болгоогүй болно. Үүнээс ХАБҮЛЛ-ын хувьд харьяалах газар өөрчлөгдөж байгаагаас бусдаар ажилтны цалингийн ангилалд өөрчлөлт оруулахгүйгээр тооцно.

Дээрх бүтцийн дагуу гарах хүний нөөц буюу зардлын тооцооллыг хийхдээ ажиллах хүний тоо, үндсэн цалин нэмэгдэл зэргийг тооцож үзвэл:

Үндсэн цалингийн хувьд: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг авч үзнэ. Үүнд:

Хүснэгт 1

Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн ХЭМЖЭЭ

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ /сард, төгрөгөөр/
T3-1	2,586,000
T3-2	2,301,000
T3-3	2,171,000
T3-4	2,049,000
T3-5	1,862,000
T3-6	1,693,000
T3-7	1,539,000
T3-8	1,399,000
T3-9	1,283,000
T3-10	1,166,000

Нэмэгдэл: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол (цаашид “Тогтоол” гэх)-оор төрийн үйлчилгээний албан тушаалтны нэмэгдлийг тогтооно:

Албан тушаалд тавигдах шаардлага: Төрийн албанд 10-аас дээш жил ажилласан байх шаардлага тавих тохиолдолд Тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл: **10 хувь байна.**

Ур чадварын нэмэгдэл: Үйлчилгээний албан хаагчийн хувьд олгогдоно. Тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-т зааснаар ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан

шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно. гэж заасан. Үүнээс хамгийн дээд хэмжээгээр тооцож үзвэл **25 хувиар** ур чадварын нэмэгдэл тооцно.

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл: Тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан журмын 2. Эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны хувьд: Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

- Тэргүүлэх 20 хувь
- Ахлах 15 хувь
- Дэд 10 хувь

Докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл: Тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу олгоно. Үүнд:

- Шинжлэх ухааны доктор зэрэг 20 хувь
- Профессор цол 10 хувь
- Боловсролын доктор зэрэг 15 хувь
- Дэд профессор цол 5 хувь

Дээрх тоон мэдээллээр дундчилан тооцвол, нэмэгдлийг дунджаар 60 хувиар тооцлоо.

Хүснэгт 2

АГЕНТЛАГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРДАЛ

Сая төгрөг

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын ангилал зэрэглэл	Орон тоо	Үндсэн цалин	Сарын үндсэн цалин	Нэмэгдэл (дундажаар 60 хувь)	Унаа хоолны хөнгөлөлт (10000 төг)	Нийт цалингийн дүн
Хүнсний хяналтын Ерөнхий байцаагч	T3-1	1	2,586	2,586	1,552	220	4,358
Газрын дарга	T3-2	5	2,301	11,505	6,903	1,100	19,508
Хэлтсийн дарга	T3-3	18	2,171	39,078	23,447	3,960	66,485
Албан хаагч	T3-(4-10)	295	1,767,000	521,265,000	312,759,000	64,900	834,088,900
Албан хаагч		-					
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Албан хаагч				-	-	-	-
Сарын дүн		319	443,515	521,318,169	312,790,901	70,180	834,179,250
Дүн (2026.01.01-12.31)			5,322,174	6,255,818,028	3,753,490,817	842,160	10,010,151,005
Нийт дүн				6,255,818,028	3,753,490,817	842,160	10,010,151,005

Агентлаг нь байнгын үйл ажиллагаатай бүтэц болохын хувьд үйл ажиллагааны төсвийг дараах байдлаар тооцлоо:

Хүснэгт 3
Мянган төгрөг

Үзүүлэлт	2026 оны төсвийн санал
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,996,704.6
УРСГАЛ ЗАРДАЛ	12,996,704.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,996,704.6
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,756,293.9
Үндсэн цалин	6,196,333.7
Нэмэгдэл	3,717,800.2
Унаа хоолны хөнгөлөлт	842,160.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,355,293.0
Тэтгэврийн даатгал	925,041.3
Тэтгэмжийн даатгал	107,562.9
ҮОМШ-ний даатгал	53,781.5
Ажилгүйдлийн даатгал	53,781.5
Эрүүл мэндийн даатгал	215,125.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,000.0
Байрны түрээс	156,000.0
Хангамж, бараа материалын зардал	92,280.0
Бичиг хэрэг	38,280.0
Тээвэр, шатахуун	48,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000.0
Эд хогшил, урсгал засварын зардал	266,000.0
Багаж, техник, хэрэгсэл	224,000.0
Тавилга	42,000.0
Томилолт, зочны зардал	277,945.0
Гадаад албан томилолт	62,475.0
Дотоод албан томилолт	215,470.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,740.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,740.0
Мэдээлэл технологийн үйлчилгээ	60,000.0
Бараа үйлчилгээний бусад зардал	25,152.6
Бараа үйлчилгээний бусад зардал	20,723.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,429.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,996,704.6
Улсын төсвөөс санхүүжих	12,996,704.6
Улсын төсвөөс санхүүжих	12,996,704.6
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	353
Удирдах албан тушаалтан	24
Гүйцэтгэх албан тушаалтан	329
Үйлчилгээний албан тушаалтан	-

Дээрх зардлын хүрээнд зардлыг нарийвчлан харуулбал:

Хүснэгт 4

ХАНГАМЖ, БАРАА МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. БИЧИГ ХЭРГИЙН ЗАРДАЛ /2*3/	1	төгрөг	38,280,000
1.1 Бичгийн ажилтны тоо	2	тоо	319
1.2 Бичгийн нэг ажилтанд жилд ногдох зардал	3	төг	120,000
2.ТЭЭВЭР, ШАТАХУУНЫ ЗАРДАЛ /5*6*7/	4	төгрөг	48,000,000
2.1.5 Дуудлагын автомашины тоо (орон нутагт томилолтоор ажиллах)	5	ширхэг	3
2.1.6 Жилийн гүйлт норм	6	км	10,000
2.1.7 ЗГАБ-ын тариф	7	төг	1,600
3. БАГА ҮНЭТЭЙ, ТҮРГЭН ЭЛЭГДЭХ ЗҮЙЛС ХУДАЛДАН АВАХ ЗАРДАЛ /9*10/	8	төгрөг	6,000,000
3.1 Бараа бүтээгдэхүүний тоо	9	тоо	300
3.2 Бараа бүтээгдэхүүний нэгжийн үнэ	10	төгрөг	20,000

ЭД ХОГШИЛ, УРСГАЛ ЗАСВАРЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. Багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардал	1	төгрөг	224,000,000
Бараа материалын тоо	2	төгрөг	28
Бараа материалын нэгжийн үнэ (Компьютер, принтер)	3	төгрөг	8,000,000
2. ТАВИЛГА	4	төгрөг	42,000,000
Тавилгын тоо	5	төгрөг	28
Тавилгын нэгж үнэ (Ширээ, сандал)	6	төгрөг	1,500,000

ТОМИЛОЛТ, ЗОЧНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	2
1. ДОТООД АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ /6+8+9/	1	төгрөг	215,470,000.0
1.1 Албан томилолтоор ажиллагчдын тоо	2	тоо	177
1.2 Нэг ажилтны томилолтын дундаж хугацаа*давтамж	3	хоног	10
1.3 Албан томилолтын нийт хvн хоног (2*3)	4	хvн/хоног	1,765
1.4 Нэг ажилтны хоногт ногдох томилолтын зардал	5	төг	28,000
1.5 Томилолтын зам хоногийн бvх зардал (4*5)	6	төгрөг	49,420,000
1.6 Нэг ажилтны хоногт ногдох байрны зардал	7	төг	90,000
1.7 Томилолтын байрны бvх зардал (6*7)	8	төгрөг	158,850,000
1.8 Томилолтын унааны бvх зардал	9	төгрөг	7,200,000
2. ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ /16+18+19/	10	төгрөг	62,475,000
2.1 Гадаадад албан томилолтоор ажиллагчдын тоо	11	тоо	7

2.2 Нэг ажилтны томилолтын дундаж хугацаа*давтамж	12	хоног	5
2.3 Гадаад албан томилолтын нийт хүн хоног (12*13)	13	хүн/хоног	35
2.4 Нэг ажилтны хоногт ногдох томилолтын зардал	14	төг	175,000
2.5 Томилолтын зам хоногийн бүх зардал (14*15)	15	төгрөг	6,125,000
2.6 Нэг ажилтны хоногт ногдох байр, зочид буудлын зардал	16	төг	560,000
2.7 Томилолтын байрны бүх зардал (16*17)	17	төгрөг	19,600,000
2.8 Томилолтын унааны бүх зардал	18	төгрөг	36,750,000

БУСДААР ГҮЙЦЭТГҮҮЛСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, ажил, үйлчилгээний зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1	төгрөг	67,740,000
1.1. Бусдаар гүйцэтгүүлэх ажлын төлбөр	2	төгрөг	7,740,000
1.1.1 Үйлчилгээний тоо	3	тоо	3
1.1.2 Үйлчилгээний нэгжийн үнэ	4	төгрөг	2,580,000
2. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР	5	төгрөг	60,000,000
2.1 Программ хангамж, лицензийн тоо	6	тоо	3
2.2 Бүтээгдэхүүний нэгжийн үнэ	7	төгрөг	20,000,000

БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨСӨЛ, ТӨСӨӨЛӨЛ

Бараа, үйлчилгээний бусад зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
1. Бараа үйлчилгээний бусад зардал	1	төгрөг	20,723,000
Хэлэлцүүлэг зохион байгуулах тоо	2		2
Нэг удаагийн хэлэлцүүлгийн зардал	3		10,361,500

Бараа, үйлчилгээний бусад зардлын төрөл	Мерийн №	Хэмжих нэгж	2026 оны төсвийн төсөл
А	Б	1	4
2. ХИЧЭЭЛ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ЗАРДАЛ	1	төгрөг	4,429,600
Сургалт зохион байгуулах тоо	2		2
Ажлын албаны чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах	3		2,214,800

Дээрхийг нэгтгэн дүгнэвэл, агентлагийн нийт бүтцийн хүрээнд жилийн төсөв нь 12.9 тэрбум төгрөгийн зардал гарахаар байна. Үүнээс 10.7 тэрбум төгрөгийн зардал нь нийт ажилтны цалингийн зардалд хамаарах хэдий ч энэ зардал нь хуулийн төсөлтэй хамааралгүйгээр гарах бодит зардал болно. Хуулийн төсөлтэй холбоотойгоор нэмэлт зардал нь агентлагийн шинэ байрны түрээсийн зардал, 28 ажилтны тавилга, техник хэрэгслийн зардлыг тооцлоо. ХАБҮЛЛ-ын хувьд одоо байгаа байр, тавилга, техник хэрэгслийг ашиглах тул хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт зардал гарахгүй.

Түүнчлэн, агентлагт хамаарах ажилтнууд нь бүгд төрийн бусад байгууллагаас шилжүүлэн томилогдох тул шинээр цалингийн зардал үүсгэхгүй, төсөв дотроо

зохицуулалт хийх замаар зохион байгуулагдаж, одоо байгаа төсвийн хүрээнд шийдвэрлэгдэхээр байна. Үүнээс бодитоор тооцож үзвэл, хуулийн төсөлтэй холбоотой нэмэлт зардал нь 422 сая төгрөгийн зардал гарахаар байна. Үүнээс байрыг түрээслэхгүй төрөөс гаргах боломжтой гэж үзвэл 156 сая төгрөгийг нэмж хэмнэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэд, хуулийн этгээдээс зардал гарахгүй гэж тооцсон. Харин төрийн байгууллагаас жилд гарах зардлын тооцоог хийлээ.

Төсвийн тухай хуулийн 6.2.5.төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх. гэж заасан тул уг тооцооллыг 2026 оноос хэрэгжихээр хийлээ. Төсөвт тодотгол хийхээс бусад тохиолдолд 2025 оны дундуур энэ агентлагийг шинээр зохион байгуулах замаар шинэ зардал үүсгэх боломжгүй байна.

Төрөөс гарах зардал, агентлагийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой гарах зардлын тооцоог хийсэн. Агентлагийн чиг үүрэгт одоо ажиллаж байгаа ХХАХҮЯ-ны салбарын хяналтын газрыг чиг үүргийг шилжүүлнэ. Мөн ХАБҮЛЛ-ыг уг агентлагийн доор ажиллуулахаар байна. Агентлаг нь бүтцийн хувьд ХАБҮЛЛ ажиллагсадтай нийлээд 319 ажилтантай ба үүнээс шинэ ажилтан нэмж авахгүй, чиг үүргийн дагуу ХХААХҮЯ дээр ажиллаж буй салбарын хяналтын орон тоог агентлагт шилжүүлнэ.

Иймээс төсөвт үзүүлэх зардлын тооцооллыг хийхдээ цалингийн зардлыг шинээр нэмэгдэхгүй байхаар тооцлоо. Харин шинээр агентлаг байгуулахтай холбоотойгоор ажлын байр, тавилга хэрэгсэл, компьютер техник хэрэгслийг лабораториос тусад нь үйл ажиллагаа явуулах 28 хүний орон тоогоор тооцож гаргасан.

Зардлыг нэгтгэн авч үзвэл, нийтдээ агентлагийн 2026 оны үйл ажиллагааны урьдчилсан төсөв нь 12.9 тэрбум төгрөгийн зардал ба үүнээс хамгийн өндөр зардал болох 10.7 тэрбум төгрөгийн зардал нь цалингийн зардал эзэлж байна. Гэвч, агентлагт хамаарах 319 ажилтан нь одоо ажиллаж байгаа ажилчид тул шинээр орон тоо бий болгохгүй болно. Иймд хуулийн төслийн хүрээнд цалингийн зардал, бичиг хэргийн зардал болон томилолтын зардал нэмэлтээр бий болохгүй.

Харин, шинэ байгуулагдах агентлагийн 28 ажилтанд хамаарах байрны түрээс, тавилга, компьютер хэрэгслийн зардал нь нийтдээ 422 сая төгрөг зардал гарахаар байна. Үүнээс байрыг түрээслэхгүй төрийн өмчийн байрыг ашиглах тохиолдолд 156 сая төгрөг хэмнэх боломжтой ба улмаар тавилга, компьютер хэрэгслийг төрийн өмчийн хөрөнгөөс ашиглах бол төрөөс ямар ч зардал гаргахгүйгээр агентлагийн үйл ажиллагааг шийдвэрлэх бүрэн боломжтой байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Хүнсний тухай хууль;
3. Хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан;
4. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал;
5. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;
6. Төрийн албаны тухай хууль;
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;
8. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол;
9. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол;
10. Төсвийн тухай хууль.

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁГ

2025.06.04.

Улаанбаатар хот

№	Санал ирүүлсэн байгууллага	Саналын агуулга	Төсөлд тусгасан үндэслэл	Төсөлд тусгаагүй үндэслэл
1	Боловсролын яам	НЭГ. АГУУЛГЫН ХУВЬД ДАВХАРДААГҮЙ САНАЛУУД		
		Сургуулийн хүүхдийн хоол хангамжийн нөөцийг нэн түрүүнд бэлтгэж, тогтвортой хүртээмжтэй хангах асуудлыг тусгах	1.Хүүхдийн хоол, хүнсний нөөц бүрдүүлэх асуудал нь хүнсний хангамжийн бодлогод хамаарна. Иймд хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг нийслэлийн Засаг дарга улсын болон орон нутгийн хэмжээнд хүнсний хангамжийг тодорхойлохдоо хүүхдийн хоол, хүнсний хангамжийн асуудлыг эн тэргүүнд тусгаахаар төсөлд оруулав.	
		3.Хүүхдийн хоол, үйлдвэрлэлд хамгийн үнэтэй, баталгаагүй мах нийлүүлэгддэг тул нэн түрүүнд хүүхдийн хоол хүнсийг тогтвортой үнээр бэлтгэн нийлүүлэх асуудлыг нэмж тусгах.	Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах зорилгоор 1/ хүүхдийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний урт хугацаанд төлөвлөгөөний дагуу тогтвортой үнээр нөөц бүрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга үүрэг болгох 2/ Хүүхдийн хоол, үйлдвэрлэлд хүнсний түүхий эд бэлтгэх нийлүүлсэн бол дэмжлэг үзүүлэх, 3/Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, хангамж бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцогчдын хүрээг өргөжүүлж, уялдаа холбоог сайжруулахаар тусгав.	
		4.Сургуулийн хүүхдийн хоол хүнсний хангамж, хяналт, үнэлгээний тогтолцоог нэмж тусгах.	Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтыг хуулийн төслийн 13 ¹ дүгээр зүйлд тусгаахаар болов.	Дараах үндэслэлээр тусгаагүй: 1/Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол хүнсийг бэлтгэн нийлүүлэхтэй холбогдсон харилцааг ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулиар зохицуулах боломжтой. 2.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Засгийн газрын хяналт тухай хуулиар ХШҮ-тэй холбоотой харилцааг зохицуулж байгаа тул ХШҮ-ний асуудлыг тусгах боломжгүй..

	Мэдээллийн санд юу юу байх вэ? Хамгийн том асуудал хэнээс дамжиж юугаар дамжин сургуулийн гарт ирж байгааг шөйлрлэж мэдээллээ хуваалцмаар байна. Хангамжинд сургууль захиалагч тендер хяналтыг энэ төв байгуулмаар байна. Ложистик төв Олон улсын туршлагаар энэ зохицуулалт явмаар байна. Хууль болгон дээр татварын хөнгөлөлт хуулинд ороод явах уу? Малгай хуулинд ороод явах уу? Хууль зүй дотоод хэргийн болон хөдөө аж ахуйн сайдын баталсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулан санал авч өргөн мэдүүлэхээр бэлтгэж байсан хуулийн төслөөс “зохицуулах үйлчлэлтэй хүнс, тээвэрлэлтэд тавих шаардлага, хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэлд тавих шаардлагыг төсөлд тусгаагүй байна, үүнийг тусгах.	1.“Мэдээллийн сан” -д мэдээлэл оруулах байгууллагын талаар тусгав	Үндсэн хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу УИХ-ын гишүүн өөүзэл баримтлалаа тодорхойлж, хуулийн төслөө боловсруулсан Хүнсний тухай хууль нь ... хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон ерөнхий харилцааг зохицуулж байгаа. Хүнсний тухай хуулийн 9.3 дахь хэсэгт “Хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан байдаг. Үүнийг тодруулан төслийн 2 дугаар зүйлд 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлан” гэж нэмэхээр тусгасан. Иймд төсөлд тусгасан “зохицуулах үйлчлэлтэй хүнс” гэсэн нэр томьёог хассан. Хууль зүй дотоод хэргийн болон хөдөө аж ахуйн сайдын баталсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан хуулийн төслөө УИХ-д өргөн мэдүүлэх боломжтой.
2 ХХААХҮЯ /референт Онон/	Хууль зүй дотоод хэргийн болон хөдөө аж ахуйн сайдын баталсан үзэл баримтлалын хүрээнд стратегийн хүнсний үйлдвэрлэлийг гадаадын хөрөнгө оруулалтаас хамгаалсан заалтыг хуулийн төсөлд нэмж тусгах шаардлагатай байна.		
3 Монголын хүнсдийн холбоо	Дотоодын хүнсний үйлдвэрүүдийг боломж бололцоогоор нь дэмжиж ажилламаар байна.	Хүүхдийн хоол, үйлдвэрлэлд хүнсний түүхий эд бэлтгэх нийлүүлсэн, эсхүл үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махыг зах зээл	

		нийлүүлсэн тохиолдолд дэмжлэг үзүүлэхээр тусгав.	Эрүүл мэгдийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/74 дүгээр тушаалын хавсралтаар “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ” баталсан. Батлагдсан нормоор нэг хүний хоногт хоол, хүнснээс авах хэмжээг заасан байдаг тул энэ норматив хэмжээнд үндэслэн улсын хэмжээний хүнсний хангамж, нөөц бүрдүүлэлт, хувь хүний хүнсний хэрэглээг тооцон гаргадаг. Иймд энэ норматив хэмжээг шинэчлэн тогтоох нь ЭМС-ын эрхлэх асуудалд хамаарах бөгөөд энэ чиглэлээр ЭМЯ-ны НЭМҮТ болон Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд ажиллах үүрэгтэй. Хуульд эрдэм шинжилгээний байгууллагын чиг үүрэг, судалгааны чиглэлүүдийг тодорхойлсон болно
4	ХАА тэргүүн Даваадорж	Хүнсний бүтээгдэхүүнээ импортлох гэж байгаа бол заавал экспортлоно. Тэгж байж гадны оронд гаргана. Заавал тахиа, гахай, шувуу идэх ёстой юу? Хүн хоногт 127гр мах идэх ёстой гэж заасан байдаг. Иймд цэвэр хүнсийг нь яаж тооцох вэ? Энэ талаар тусгах	Хуулийн төслийн 10.5-д “Хүнсний худалдаанд үйл ажиллагааг тусгаснаас гадна стратегийн хүнсийг импортлох, экспортлохтой холбогдсон зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөн найруулсан болно.
5	Стандарт хэмжилзүйн газар Тулгаа:	1.Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хүнсний баталгаат байдалд хяналт тавих байгууллагууд ямар байгууллага байгааг тодорхой болгох. 3.Стандарт мөрдүүлнэ гэж 2022 онд 126 стандарт мөрдүүлнэ гэсэн 25 нь мөрдөгдөж байна. Энэ хуулинд хэр тусгагдаж байгаа вэ?	Хүнсний баталгаат байдалд тавих хяналтын бодлогыг боловсруулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хүнсний хяналт зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн улсын байцаагчид хэрэгжүүлнэ. ХБАБХТХ-иар хяналтын процессын асуудлыг зохицуулж байгаа, Хүнсний тухай хуулиар хүнсний баталгаат байдалд хяналт тавих хяналтын чиглэлийг тусгасан. Мөн импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээрийн хяналтыг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар, хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл дэх мал, амьтан, ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн хяналтыг Мал, амьтны

		эрүүл мэндийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулахаар төсөлд тусгасан.” Хүнсний сүлжээнд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхчлэгчид өөрт хамаарах үйл ажиллагаандаа зохистой дадлын стандартыг нэвтрүүлэх гэдэгт үйлдвэрлэлийн, эрүүл ахуй болон чанарын удирдлагын стандартын хамгийн наад захын шаардлага хангагдах нөхцлийг бүрдүүлэхийг хэлнэ. Иймд энэхүү зохистой дадлыг нэвтрүүлж, баталгаажуулахыг ХЧҮАЭ-дэд үүрэг болгосон. Харин хяналт удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхийг тухайн ХЧҮАЭ өөрөө сонгохоор хэвээр үлдээсэн болно. Стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, шинэчлэн боловсруулах, батлагдсан стандартын талаар мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх, мөрдүүлэхтэй холбогдсон харилцааг ХБАБХТХ-иар зохицуулахаар тусгасан.	1/Бүтцийн шинжилгээ хийдэг болёё, хамтын ажиллагааны хувьд нарийвчилж юу идэж байгаагаа сайн судална гэсэн санаа юм. Хуурамч хүнсийг Монгол улсад тодруулж чадахгүй байна. Үүнийг тодруулна гэсэн санаа байна. 2/Молекул болон биологийн тандалтыг хүнсэнд хийх нь чухал бөгөөд ялангуяа бичил биетний тэсвэржилтийн (ББТ) илрүүлэлт, хяналт, үнэлгээ зайлшгүй хамаарна. 3/ББТ-ийн тандалт нь нотолгоонд суурилсан бодлого, эрх зүйн зохицуулалт, эрсдэлийн удирдлагын арга хэмжээг боловсруулах үндэслэл болно. Иймд хуулийн төсөлд “молекул биологи” гэсэн ерөнхий нэрээр тусгаад ХБАБХТХ-д ББТ-ийн асуудлыг тусгасан болно.
6	ХАБҮЛЛ: төсөлд молекул биологийн тандалтыг ямар зорилгоор хийх вэ? Үүнийг тодорхой болгох		

7	НҮБ ХАА хүнсний аюулгүй байдал Батчулуун:	Аймгийн түвшинд ихэнх нь ихэнх төрийн захиргааны байгууллага босоо тогтолцоотой байгаа учраас Засаг даргаасаа хол хөндий байгааг өөрчлөх, тогтолцоог хянах шаардлагатай байна. Баруун талаар орж ирж байгаа гуриланд бага зэрэг шинжилгээ хийж байна. Үүнийг анхаарч өгнө үү.		
ХОЁР. АГУУЛГЫН ХУВЬД ОЙРОЛЦОО САНАЛУУД				
1/“Хүнсний аюулгүй байдал”, “Хүнсний баталгаат байдал” гэсэн нэр томъёо болон бусад нэр томъёоны талаар				
1	ХХААХҮЯ	төсөлд туссан “хүнсний баталгаат байдал”, “хүнсний аюулгүй байдал” гэсэн нэр томъёог өөрчлөх		Дараах үндэслэлээр Food security, Food safety-ийн нэр томъёоны нэршлийг олон янзаар орчуулж ирснээс төөрөгдөл үүсч байна гэж үзээд дараах үндэслэлээр уг саналыг тусгаагүй. Үүнд:
2	НҮБ ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	1..Food safety гэдгийг Хүнсний аюулгүй байдал гэж ойлгоод хэрэглэж байгааг өөрчлөхгүй байх. 2.“хүнсний баталгаат байдал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасныг,” гэж тусгасныг FAO and WHO and SAC –ын тодорхойлолтоотой нийцүүлэх	“хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй, чанар, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байхыг” ойлгоно гэж тодорхойлов. Үүнтэй холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэр томъёоны хэсэгт эшлэл татсан	1/ Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “хүнсний аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг” учраас өргөн утгаар авч үзсэн. 2/ “Хүнсний баталгаат байдал” нь хүнсний аюулгүй байдлын нэг хэсэг гэж үзсэн. 3/Хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх шаардлагын үүднээс хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр томъёоны нэршлийг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2018 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний нэр томъёоны тайлбар” толийг үндэслэл болгов
3	Монголын Хүнсчдийн холбоо	FOOD SAFETY- хүнсний аюулгүй байдал FOOD SECURITY- хүнсний баталгаа байдал гэсэн 2 ойлголтыг хэрхэн ойлгохыг яам, ----УИХ-ын хуулийн санаачлага 1 талдаа гармаар байна.		
4	3.Эрүүл хүнс, Эрүүл хүн ТББ гүйцэтгэх захирал Б.Баярчимэг	.FOOD SAFETY- хүнсний аюулгүй байдал FOOD SECURITY- хүнсний баталгаат байдал		
5	Инно Хими Лаб ХХК 2024.04.21. №03/09	1.Төсөлд Food security гэдгийг “Хүнсний баталгаат байдал” юм Гэтэл Food safety гэдгийг “хүнсний аюулгүй байдал” гэж тусгасан байна. Үүнтэй холбоотойгоор	“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” бичвэртэй бүх хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, төсөл бэлтгэсэн болно.	

		хүнсний баталгаат байдлыг оруулсан бүх заалтууд өөрчлөгдөхөөр байгааг анхаарах.		
6	АХБ-ны 10099 төслийн багийн ахлагч Г.Энхтүвшин	Хүнсний аюулгүй байдла-FOOD SECURITY Хүнсний баталгаат байдла-FOOD SAFETY Энэ нэр томъёог одоогийн төсөлд байгаагаар нь хадгалах	Төсөлд туссан саналыг хүлээн авав.	
7	Монголын Хүнсчдийн холбоо	"Хүнсний түүхий эд" болон "Хүнс" гэдэг нэр томъёог тусад нь ялгаж оруулах саналтай байна - Хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах хувийн лабораторуудыг дэмжих тэдгээрийн тоног төхөөрөмжийн нэмэлт татваргүй болгох тухай санал тусгах.		Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.1-т "хүнсний бүтээгдэхүүн", 4.1.2-т "хүнсний түүхий эд" гэсэн нэр томъёог хуульчлан тодорхойлсон тул энэ хуульд өөрчлөлт хийх шаардлагагүй. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой харилцааг татварын багц хуулиар зохицуулдаг. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.3-т заасны дагуу "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх" заасны дагуу энэ саналыг хүлээн аваагүй.
	2/Хүнснийг "буцаан авах", "татан авах" талаар			
8	Фүүд Легал ХХК	Буцаан авах нь үйлдвэрлэгч, нийлүүлэгч өөрийн санаачлагаар авах талаар, харин татан авах нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр хийгддэг тул "хүнсний сүлжээ" гэдэгт "буцаан авах", "татан авах" ойлголтыг хамтад нь оруулах,	Хүнснийг буцаан авах, татан авахтай холбоотой зохицуулалт HACCP, ISO9001, ISO22000, FSSC22000 гэсэн хүнсний чанар, аюулгүй байдлын тогтолцооны стандартад Withdrawal, Recall гэдэг нэршлээр туссан байдаг тул энэ 2 үйл ажиллагааг стандартын дагуу явуулна.	1/ Хүнсний сүлжээнд хамааралгүй технологийн шинжтэй, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хүсэл зоригоос хамаарахгүй үйл ажиллагаа байсныг өөрчилж, зөвхөн

9	Анхтуяа	хүнсний сүлжээнд чанар аюулгүй байдал хангаагүй хүнсийг буцаан авах, устгах үйл ажиллагааг тусгажээ. Гэтэл Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд Хүнсийг буцаан авах, татан авах гэсэн 2 ойлголт байна. HACCP, ISO9001, ISO22000, FSSC22000 гэх хүнсний чанар, аюулгүй байдлын тогтолцооны стандартад Withdrawal, Recall гэдэг нэршлээр туссан байдаг. Олон улсын хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нэр томьёо, ойлголтыг бүрэн зөв тусгах шаардлагатай.	Хуулийн төслийн “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан бүртгэл”-д хяналт тавихаар байсныг “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авалт” гэж өөрчлөв.	хүнсний чиглэлийн үндсэн үйл ажиллагааг тусгаж товч тодорхой тусгав. Иймд хүнсний сүлжээнээс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг өөрийн санаачлагаар болон албадлагаар гаргаж байгаа арга хэмжээ үзэн тодорхойлолтоос хасав.
10	НҮБ ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	Хүнсний сүлжээ гэсэн ойлголт “чанар аюулгүй байдал хангаагүй хүнсийг буцаан авах, устгах”-аар заасан, харин татан авахыг орхигдуулсан байгааг анхаарах.		
11	Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ	4.Хүнсний сүлжээ гэсэн тодорхойлолтод “буцаан татах” гэсэн шинэ нэр томьёо оруулсан байгааг өөрчилж, “буцаан авах”, “татан авах” гэж оруулах. 3.Хүнсний сүлжээ гэсэн тодорхойлолтын “бүтээгдэхүүн үйлдвэрлэх” гэсний ард “дахин боловсруулах” нь зохимжгүй байх тул “буцаан татах” гэсний ард оруулбал үйлдвэрлэлийн процесс, дарааллын хувьд зөв болохыг анхаарна уу		Хүнсний сүлжээ гэсэн нэр томьёог олон улсын нэр томьёотой нийцүүлэн шинээр тодорхойлсон. Ингэхдээ хүнсийг дахин боловсруулахгүй, хэрэв хүнсийг дахин боловсруулбал хүнс биш болно. Хүнсний сав баглаа боодлыг дахин боловсруулж болно.
12	Анхтуяа	Зохихуулах үйлчилгээтэй хүнс гэсэн нэр томьёог оруулсан ч хуулинд тусгайлсан шаардлагыг тусгаагүй. Тусгайлсан шаардлага тусгаагүй бол ийм нэр томьёо оруулах хэрэг байна уу? Эсхүл зохицуулах үйлчилгээний хүнсэнд ердийн хүнсэнд тавигдах шаардлагуудыг хангах бол ингэж тусдаа нэр томьёо гаргах хэрэг байна уу?	Хүнсний тухай хуулийн 9.3 дахь хэсэгт “Хүнсийг баяжуулах, найрлагыг нь зохицуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан байдаг. Үүнийг тодруулан төслийн 2 дугаар зүйлд 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлсан” гэж нэмэхээр тусгасан тул “зохицуулах үйлчилгээтэй хүнс” гэсэн нэр томьёог хасах саналыг хүлээн авав.	

	Фүүд, Лөгал ХХК	Төсөлд “Зохицуулах үйлчилгээтэй хүнс” гэсэн нэр томъёог оруулсан боловч тусгай шаардлага нь тодорхойгүй байна. Энэ нэр томъёог тусгах шаардлага байна уу?	Хүнсний тухай хуулийн 9.5 дахь хэсэгт	
	4/ Эрдэм шинжилгээний байгууллагын талаар			
13	АНХТУЯА	Эрдэм шинжилгээний байгууллага гэдэг нь ямар байгууллага хамаарах вэ?, шалгуур шаардлагаа хэрхэн тогтоох вэ?, хуулинд журам гаргахаар тусгаагүй бол хуулиас давсан шаардлага тавьж болохгүй.	1/3.1.16. “Эрдэм шинжилгээний байгууллага” гэж Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.15-д заасныг” ойлгоно гэж төсөлд тусгаж ЭШБ-ыг тодорхой болгов.	
14	Фүүд Лөгал ХХК	1.Эрдэм шинжилгээний байгууллага гэдэгт төрийн байгууллагууд, эсхүл хувийн хэвшлийн байгууллагыг хамтад нь ойлгож уу? 2. Энэ эрдэм шинжилгээний байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санхүүжилт нь хаанаас хийгдэх вэ? Санхүүжилтгүй бол тунхагийн шинж чанартай, хэрэгжилтгүй болохыг анхаарна уу?	2/хуульд заасан судалгаа хөгжүүлэлтийн ажлын санхүүжилтийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар зохицуулахаар тусгав.	
15	нармандах	Төслийн 15 1 дүгээр зүйлд заасан ЭШБ-ын чиг үүрэг нь Энэ заалтаар мэргэжлийн чадамжтай, одоо дээрх чиглэлээр үйл ажиллагааг явуулж буй мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, итгэмжлэгдсэн лаборатори, мэргэжлийн төрийн бус байгууллага, их дээд сургууль гэх мэт бусад байгууллагын эрх хязгаарлагдах талтай. Иймд заавал деталчилж оруулах шаардлагатай эсэх?	3/ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлд зааснаар Эрдэм шинжилгээний байгууллагыг шинжилгээний байгууллагыг төрийн, хувийн, хамтарсан өмчийн хэлбэрээр байгуулж болох бөгөөд энэ үүнд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, төв, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэгтэлд хамаарах дээд боловсролын байгууллага, шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл, төрийн болон орон нутгийн музей хамаарна. Иймд ямар нэг хязгаарлалт үүсэхгүй. Дээрх хуульд заасныг эшлэл татна.	
16	Стандарт хэмжилзүйн газар Тулгаа:	2.хүнсний хяналт зохицуулалтын байгууллагын дэргэд эрдэм шинжилгээний байгууллага байх уу гэдгийг тодруулах		
17	АНХТУЯА	Эрдэм шинжилгээний байгууллага гэдэг нь ямар байгууллага хамаарах вэ?, шалгуур шаардлагаа хэрхэн тогтоох вэ?, хуулинд журам гаргахаар тусгаагүй бол		

	хуулиас давсан шаардлага тавьж болохгүй.		
5/Тэсвэржсэн бичил биетийн талаар			
18	ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	5.Хуулийн нэр томъёо хэсэгт “Бичил биетний тэсвэржилт” гэдэг тодорхойлолтыг оруулах, түүнчлэн “Хүнсээр дамждаг бичил биетний тэсвэржилтийг илрүүлэх идэвхтэй, идэвхгүй тандалтыг жил бүр хүнс, мал эмнэлгийн лаборатори, эрдэм шинжилгээний байгууллагын эрх бүхий байгууллагууд гүйцэтгэх, эрсдэлийн дүн шинжилгээг эрх бүхий байгуулага, лаборатори 3 жил тутам хийж гүйцэтгэхээр нэмж тусгах.	1/Малын эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 18.1, 18.2 дахь хэсгийн тайлбар болгож, "бичил биетний тэсвэржилт" гэж ижил зүйлийн мэдрэмтгий бичил биетэнтэй харьцуулахад бичил биетний эсрэг эмийн тунг ихэсгэн хэрэглэсэн тохиолдолд үржсээр байх, эсхүл тогтвортой орших бичил биетний чадварыг ойлгоно" гэж тодорхойлсон байх тул энэ нэр томъёог хуульд тусгах шаардлагагүй
19	Худалдаа аж үйлдвэрийн газрын дарга Энхмандах:	Төсөлд тэсвэртэй нянгийн талаар тусгасан байна. Хавдрын шалтгаан нь химийн гаралтай бүтээгдэхүүнээс гадна бохирдлоос үүссэн, үүсгэгч нь тэсвэртэй нян байдаг Архаг болон архаг хүнд гэж 2 хувааж үздэг. Гишүүний багт том лабораториудыг оруулж өгвөл зүгээр юм гэж бодож байна.	2/1/2025.5.5-ны өдрийн эрдэмтдийн дунд явуулсан хэлэлцүүлгээр “хүнсээр дамждаг бичил биетний тэсвэржилтийн тандалт” молекули биологийн тандалтад хамаарна гэдэг шүүмжлэлийг хэлсэн тулд Хүнсний тухай хуулийн төсөлд тусгасан 5 жил тутам хийх заалтыг хасав.
20	НҮБ, ХХААБ	1. Хуулийн нэр томъёоны хэсэгт бичил биетний тэсвэржилт (ББТ) гэдэг тодорхойлолтыг оруулах 2. Хүнсээр дамждаг ББТ-ийн 13.4-тандалтыг жил бүр хүнсний чиглэлийн үндэсний хэмжээний лаб-ууд, сургалт хийдэг байх талаар оруулах 3. Хүнсээр дамждаг ББТ-д эрсдлийн дүн шинжилгээг 3 жил тутам хийдэг байх тухай тусгах.	3/“хүнсээр дамждаг бичил биетний тэсвэржилт”-ийг лаборатори шинжилгээгээр илрүүлдэг тул энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй гэж үзсэн.
21	НҮБ бичил биетний тандалт судалгаа Энхтуяа:	Тандалт судалгаа бол эрдэм шинжилгээ дан ганц биш юм. Лабораториудын өдөр дутам хийж байх шинжилгээ юм. Хавдарт бактер авсан хүнд таарах антебиотек олдоогүй.Энэ бактериуд аль хэдийн	

		хяналтаас гарсан гарахаас өмнө бид шинжилж барилт хийж баймаар байна.	Харин /УИХ-ын гишүүний С.Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнсээр дамждаг бичил биетний тэсвэржилтийн тандалтыг жил бүр хийж байхаар тусгасан болно.
22	ХАА тэргүүн Даваадорж	Мал амьтны, болон ургамлын гаралтай бичил биетний тандалт тандалт бас хийх, хүнсний чиглэлийн лабораторууд, сургууль бүх газар тандалт хийж, нэгдсэн 1 дататай болох, стандарт хэмжил зүйгээр гарч ирсэн эрсдлийн үнэлгээ хийх.	4/УИХ-ын гишүүний Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаа Ажлын хэсэгт энэ саналыг шилжүүлэв.
6/ Ул мөр мөдөн тогтоох тогтолцооны талаар			
23	Баярчимэг	2.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл - Энэ хэсгийг найруулах Хүнсний сүлжээнд ул мөрийг мөрдөн нь зүгээр нэг бүртгэл биш мөшгих тогтолцоог бүрдүүлсэн байхыг ойлгодог. Тиймээс ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог бий болгосон байдалд хяналт тавих гэдэг агуулгаар оруулах нь тохиромжтой	УИХ-ын гишүүний Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаа Ажлын хэсэгт энэ саналыг шилжүүлэв
		2.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл - Энэ хэсгийг найруулах Хүнсний сүлжээнд ул мөрийг мөрдөн нь зүгээр нэг бүртгэл биш мөшгих тогтолцоог бүрдүүлсэн байхыг ойлгодог. Тиймээс ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог бий болгосон байдалд хяналт тавих гэдэг агуулгаар оруулах нь тохиромжтой	УИХ-ын гишүүний Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаа Ажлын хэсэгт энэ саналыг шилжүүлэв
		5.Ул мөр буюу ISO22000, HACCP, ISO9001 стандартад тусгаснаар Traceability (Мөшгилт) гэдэг нь зөвхөн	

	бүртгэлийн асуудал биш, бүртгэл бол тогтолцоо хэрэгжиж байгааг нотолсон баримт бичиг. Иймд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үл мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог бий болгосон байдлыг хянах гэсэн агуулгаар оруулах.			Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах гэсэн 8 дугаар зүйлээр зохицуулсан байгаа. Энэ хуулийн хамрах хүрээний асуудал биш байна гэж үзэж саналыг аваагүй.
24	НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	HACCP, ISO9001, ISO22000, FSSC22000 гэх хүнсний чанар, аюулгүй байдлын тогтолцооны стандартад Withdrawal, Recall гэдэг нэршлээр туссан байдаг. Олон улсын хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нэр томъёо, ойлголтыг бүрэн зөв тусгах, тухайлбал, Food safety гэдгийг Хүнсний аюулгүй байдал гэж ойлгоод хэрэглэж байгааг өөрчлөх шаардлагагүй.		
7/ Хүнс экспортлох, импортлох, импортын хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй талаар				
			Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалтай холбоотой асуудлыг салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас мөн эрсдэлийн үнэлгээг хийж дүгнэлт гаргах байдлаар шинжлэн судалж зайлшгүй өөрчлөх шаардлага байгааг тогтоосны дараа өөрчлөлт оруулахаар болсон. Маш богино хугацаанд хийсэн хүнсний импортлогчдын өөрсдийнх хийсэн судалгаанд үндэслэх боломжгүй гэж үзсэн. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, онцлог шинж чанар, хүний биед нөлөөлөх байдал, хоруу чанар, аюулгүйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байх тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл гээд маш олон хүчин зүйл байдал тул цаг хугацаа гарган энэ асуудлыг судлах шаардлагатай.	1/ Олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн “Зохистой хоол хүнсээр хангагдах” эрх болон Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхүүдийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг төр
25	Монголын хүнсдийн холбоо	Импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байхаар заасан. Гэвч 2/3 хугацаатай хүнсийг тээвэрлэхэд 3-4 сар болдог нь бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулж байна. Иймд 1/2 болгож, богиносгох.		

26	ХОНГОРЗУЛ	Импортлох хүнсний түүхий эдийн хадгалах хугацаа нийт хадгалах хугацааны 50%-с багагүй байхаар зохицуулах	Манай улсын хувьд далайд гарцгүй, худалдааны боомт цөөтэй зэрэг шалтгааны улмаас хадгалах хугацаа богино түүхий эдийг импортлох нөхцөл тун хязгаарлагдмал байдаг. Тиймээс газарзүйн байршлын онцлогийг харгалзан үзэж, шаардлагатай өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. 11.2.3-т заасан заалтыг “Импортын хүнсний түүхий эдийн хадгалах хугацаа нь нүүлүүлэлтийн үед тухайн бүтээгдэхүүний нийт хадгалах хугацааны дор хаяж 50 хувьтай тэнцүү байна” гэж өөрчлөх	Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалтай холбоотой асуудлыг салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас мөн эрсдэлийн үнэлгээг хийж дүгнэлт гаргах байдлаар шинжлэн судалж зайлшгүй өөрчлөх шаардлага байгааг тогтоосны дараа өөрчлөлт оруулахаар болсон. Маш богино хугацаанд хийсэн хүнсний импортлогчдын өөрсдийнх хийсэн судалгаанд үндэслэх боломжгүй гэж үзсэн. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, онцлог шинж чанар, хүний биед нөлөөлөх байдал, хоруу чанар, аюулгүйн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй байх тэвэрлэлт, хадгалалтын нөхцөл гээд маш олон хүчин зүйл байдал тул цаг хугацаа гарган энэ асуудлыг судлах шаардлагатай.	бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн. Иймд импортын хүнсний хадгалалтын хугацааг богиносгох нь оновчтой эсэх талаар судалж, үндэслэл, үр дүн, үр нөлөөг тооцох шаардлагатай байна.
27	ЛХАГВА-ЭРДЭНЭ	Манай улсын хувьд далайд гарцгүй, худалдааны боомт цөөтэй зэрэг шалтгааны улмаас хадгалах хугацаа богино түүхий эдийг импортлох нөхцөл тун хязгаарлагдмал байдаг. Тиймээс газарзүйн байршлын онцлогийг харгалзан үзэж, шаардлагатай өөрчлөлтийг оруулах нь зүйтэй. 11.2.3-т заасан заалтыг “Импортын хүнсний түүхий эдийн хадгалах хугацаа нь нүүлүүлэлтийн үед тухайн бүтээгдэхүүний нийт хадгалах хугацааны дор хаяж 50 хувьтай тэнцүү байна” гэж өөрчлөх	Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн баталгаат байдалтай холбоотой асуудлыг салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас мөн эрсдэлийн үнэлгээний нэгж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шинж чанараас хамаарч хадгалалтын хугацааг өөр өөрөөр тогтоох эсэхийг эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр шийдвэрлэхээр туссан байх тул уг саналыг хүлээн аваагүй.		
28	СҮҮ ХХК	Хүнсний хууль дах “ импортлох хүнсний хадгалах хугацаа 2/3 гэдгийг “импортлох түүхий эд 1/2, импортлох органик хүнсний 1/2 байна гэж өөрчлөх	Хүнсний хууль дах “ импортлох хүнсний хадгалах хугацаа 2/3 гэдгийг “импортлох түүхий эд 1/2, импортлох органик хүнсний 1/2 байна гэж өөрчлөх		
29	НАНДИНЧИМЭГ	11.2.3-т “импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх” гэсэн заалт нь Монгол улсын эдийн засаг, тээвэр ложистикийн нөхцөл, газар зүйн байршил зэргийг бодитойгоор харгалзан үзээгүй, хэт хатуу шаардлага тул “Импортын хүнсний түүхий эдийг хадгалах хугацааны 50% хүчинтэй хугацаа байх” гэж өөрчлөх саналтай байна.	Учир нь хүн амын эрүүл мэнд, амь настай шууд холбоотой хүнсний баталгаат байдлын асуудалтай шууд холбоотой байгаа тул нухацтой судалгаа хийх шаардлага гэж дүгнэж байна		
30	ХАХИДСҮРЭН	11 дүгээр зүйлд Хүнс экспортлох, импортлоход тавих шаардлагыг тодорхойлсон бөгөөд уг зүйлийн 11.2.3-т “импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх”			

		гэж заасан байдаг. Монгол улсын эдийн засаг, газар зүйн байршлын онцлогийг харгалзалгүйгээр хэт чанга хадгалах хугацааны шаардлагыг "импортлох хүнсний түүхий эдийн хадгалах хугацаа нийт хадгалах хугацааны 50%-с багагүй байна" гэж өөрчлүүлэх "Импортын хүнсний түүхий эдийг хадгалах хугацааны 50% хүчинтэй хугацаа байх" гэж өөрчлүүлэх саналтай байна.	1/ Олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн "Зохистой хоол хүнсээр хангагдах" эрх болон Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхүүдийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг төр бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн. Иймд импортын хүнсний хадгалалтын хугацааг богиносгох нь оновчтой эсэх талаар судалж, үндэслэл, үр дүн, үр нөлөөг тооцох шаардлагатай байна.
31	ЭНХЖАРГАЛ	11 дүгээр зүйлийн 11.2.3.-т заасан "Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалах хугацааны 2/3 нь хүчинтэй хугацаа байх" гэсэн заалтыг өөрчлүүлж, "Импортын хүнсний түүхий эдийг хадгалах хугацааны 50% хүчинтэй хугацаа байх" гэж өөрчлүүлэх саналтай байна.	2/УИХ-ын гишүүн Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хүнсний хяналт зохицуулалтын ТЗБ-ын дэргэд ажиллах эрсдэлийн үнэлгээний нэгж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шинж чанараас хамаарч хадгалалтын хугацааг өөр өөрөөр тогтоох эсэхийг эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр шийдвэрлэхээр туссан байх тул уг саналыг хүлээн аваагүй.
32	АНХТУЯА	Энэ хуулид дараах өөрчлөлт хийхийг нэмэлтээр санал болгож байна. Хуулийн 11.2.3-д импортлох хүнсний хадгалах хугацааны 2/3 хүчинтэй байх гэдгийг хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн гэдгээр нь салгах Хүнсний түүхий эдийн 1/2, бүтээгдэхүүний 2/3 нь хүчинтэй байх гэсэн агуулгаар өөрчлөх	
33	УЯНГА	Манай улсын хувьд далайд гарцгүй, худалдааны боомт цөөнтэй, Газарзүйн байршлын онцлогийг харгалзалгүй импортын түүхий эдийн хадаглах хугацааг 2/3 гэж заасан нь тун өрөөсгөл гэж харж байна. Иймд импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалах хугацааны 2/3 нь хүчинтэй хугацаа байх дээр анхаарал хандуулж өгнө үү!! Баярлалаа.	
	Найм.Лабораторийн талаар		

34	БАЯРЧИМЭГ	хувийн одоо байгаа лабораторийн чадавхыг сайжруулах, төр хувийн лабууд аль алиуд хяналтын лаб үүрэг гүйцэтгэх	Төсөлд 4 ² .2.Энэ хуулийн 11 ¹ .1-д заасан байгууллага, албан тушаалтан хүний нөөц бэлтгэх, давшан сургах, мэргэшүүлэх чиглэлээр боловсролын асуудал эрхэлтсэн төрийн захиргааны төв байгууллага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, лаборатори болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана. Гэж тусгасан.	
35	Хүнсчдийн холбоо Нармандах	- Хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах хувийн лабораторуудыг дэмжих тэдгээрийн тоног төхөөрөмжийн нэмэлт татваргүй болгох тухай санал тусгах.	Татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудал нь энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн 29.1.3-т заасныг үндэслэл болгон энэ саналыг хүлээн аваагүй.	
36	НҮБ ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	4.Төсөлд зөвхөн төрийн статустай лабораториуд хүнсний хяналтын шинжилгээг хийхээр тусгасныг хасах, эсхүл төрийн болон хувийн өмчит лаборатори нь тухайн шинжилгээний үзүүлэлтээр олон улсын холбогдох стандартын дагуу итгэмжлэл авч лавлагаа лабораторийн чиг үүргийг гүйцэтгэж болно гэж өөрчлөх	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 зүйлд лабораторитой холбоотой харилцааг зохицуулсан тул энэ хуулиар лабораторитой холбоотой ямар нэг заалт төсөлд тусгаагүй болно.	
37	Инно Хими Лаб ХХК 2024.04.21. №03/09	2.Төслийн 13 ¹ дугаар зүйлд төрийн захиргааны байгууллагын дэргэд хяналтын лаборатори ажиллахаар заасан байх бөгөөд төрийн лабораторийн амжилтгүй ажилладаг түүх давтагдахаар байна. Иймд ТЗБ төрийн болон хувийн лабораторитой гэрээгээр ажиллана гэж өөрчлөх.	УИХ-ын гишүүн Лүндэгийн санаачлан боловсруулж байгаа Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ТЗБ төрийн болон хувийн лабораторитой урт хугацаатай гэрээ байгуулж хамтран ажиллахаар туссан байх тул Хүнсний тухай хуулийн төслөөс лабораторитой холбоотой заалтуудыг хасав.	
	8/Баталгаажуулалтын талаар			

38	Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ /20255.13 №25/05/09/	1.Хуулийн төсөлд зохистой дадал нэвтрүүлснээ баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна гэжээ. Баталгаажуулалтын байгууллага гэдэг нь хувийн байгууллагад эрх олгосон болно. Харин баталгаажуулалтыг олж авсан байгууллага нь гэрчилгээжүүлэлтийн байгууллага болно. Олон улсын түвшинд баталгаажуулалтын байгууллага, гэрчилгээжүүлэлтийн байгууллагыг ялгаатай нэрлэдэг. Иймд орчуулгыг оновчтой хийж, ялгаатай байдлаар хуульчлах нь зохимжтой.	Төсөлд хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн хуулийн этгээдэд зохистой дадлыг нэвтрүүлэх үүрэг хүлээлгэсэн заалт хамаарахгүй байхаар тусгав.	1/Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 14 дүгээр зүйлд “итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага” гэж, 15 дугаар зүйлд “Тохирлын үнэлгээний байгууллагад лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын байгууллага хамаарна” гэж заасан байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулахгүйн тулд уг саналыг хүлээн аваагүй болно.
39	Анхтуяа	2.Зохистой дадлыг нэвтрүүлснээ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч заавал баталгаажуулахаар заасан нь хяналт удирдлагын тогтолцоогоо баталгаажуулсан хуулийн этгээд дахин зохистой дадлыг баталгаажуулна гэж ойлгогдож, бизнес эрхлэгчдэд дарамт үүсгэхээр байгааг анхаарах,		1/Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 14 дүгээр зүйлд “итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага” гэж, 15 дугаар зүйлд “Тохирлын үнэлгээний байгууллагад лаборатори, техникийн хяналт болон баталгаажуулалтын байгууллага хамаарна” гэж заасан байна. Иймд хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулахгүйн тулд уг саналыг хүлээн аваагүй болно.
		1.“хяналт, удирдлагын тогтолцоо” гэдгээс “хяналт” гэснийг, “итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага” гэдгээс “итгэмжлэгдсэн гэснийг хасах/ учир хяналт нь баталгаажуулалт хийдэггүй/		НАССР болон ISO 22000 нь ерөнхийд нь авч үзвэл хяналт ба удирдлагын тогтолцоонууд гэж нэрлэгдэх боломжтой. • НАССР нь хүнсний үйлдвэрлэл дэх аюулыг тодорхой цэгүүдэд хянахад чиглэсэн хяналтын тогтолцоо • ISO 22000 нь НАССР-ийг багтаасан, мөн байгууллагын удирдлага, харилцаа, баримтжуулалт, тасралтгүй сайжруулалт зэрэг өргөн хүрээг хамарсан удирдлагын тогтолцоо

			Харин баталгаажуулалтын байгууллага эдгээрийг баталгаажуулах үүрэгтэй
2. Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь зөвхөн MNS ISO/IEC 17025-р лабораторт итгэмжлэлийн гэрчилгээ олгодог “баталгаажилтын байгууллагаар” гэж өөрчлөх.	“Үндэсний итгэмжлэлийн байгууллага” гэснийг “баталгаажуулалтын байгууллага” гэж өөрчлөв.	Хүнсний үйлдвэрлэлийн чиглэл бүрд тохирох стандарт байдаг тул энэ заалтыг Хүнсний тухай хуульд биш, харин Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Ажлын хэсэгт шилжүүлэв,	
2.5.үйлдвэрлэлийн шат дамжлага дахь аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт; - НАССР нэвтрүүлэх нь сайн дурын шинжтэй стандарт юм. Энэ хэсэгт заавал хэрэгжүүлэх гэсэн агуулгаар нь тусгаж болохгүй.	Заавал хяналт тавихгүй, хасаж болно. Гэхдээ энэ НАССР ын стандартыг хүнсний үйлдвэрлэгчид үйл ажиллагаандаа нэвтрүүлбэл тухайн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортлогдох магадлал маш өндөртэй байдаг. Иймд энэ стандартыг нэвтрүүлэхэд ХХААХҮЯ болон Хяналт зохицуулалтын агентлагаас мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, нөлөөллийн ажил хийхээр тусгаж болно.		
Мөн нэр томьёоны хувьд энэ шалгаж байгаа газар бол Certification body буюу гэрчилгээжүүлэлтийн байгууллага Харин Certification body-д тухайн стандартыг баталгаажуулж болох зөвшөөрөл олгож байгаа байгууллагыг Accreditation body буюу баталгаажуулалтын байгууллага гэж ойлгодог. Нэр томьёогоо харна уу.	Үндэсний итгэмжлэлийн төвөөс баталгаажуулах зөвшөөрлөө аваад хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд тухайлбал, зохистой дадал нэвтрүүлсэн байдлыг шалгаад хэрэв зохистой дадал нэвтэрсэн бол гэрчилгээ олгохоор тусгав.		
Мөн нэр томьёоны хувьд энэ шалгаж байгаа газар бол Certification body буюу гэрчилгээжүүлэлтийн байгууллага Харин Certification body-д тухайн стандартыг баталгаажуулж болох зөвшөөрөл олгож байгаа байгууллагыг Accreditation body буюу баталгаажуулалтын байгууллага гэж ойлгодог. Нэр томьёогоо харна уу.			
Итгэмжлэгдсэн олон улсын болон дотоодын байгууллагаар баталгаажуулна гэж тусгах.	Стандартчилал, тохирлын үнэлгээний зохицуулалт, техникийн итгэмжлэлийн		

		Экспортлогч улс больё гэсэн зорилготой бол олон улсын итгэмжлэгдсэн байгууллага байх хэрэгтэй. Ямар үзэл баримтлал, судалгааны дагуу олон улсын гэдгийг хасаж байгаа нь ойлгомжгүй байна. Бид хуулиндаа ингэж оруулсан оруулаагүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаажуулалтын байгууллагууд болон байгаа.	тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн, эсхүл бүртгүүлсэн баталгаажуулалтын байгууллага гэж өөрчлөв.	
40	Сүү ХХК	2.Үндэсний итгэмжлэлийн байгууллага нь зөвхөн MNS ISO/IEC 17025-р лабораторт итгэмжлэлийн гэрчилгээ олгодог “баталгаажилтын байгууллагаар” гэж өөрчлөх.		Хүнсний үйлдвэрлэлийн чиглэл бүрд тохирох стандарт байдаг тул энэ заалтыг Хүнсний тухай хуульд биш, харин Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Ажлын хэсэгт шилжүүлэв,
	9/Хяналт шалгалтын талаар			
41	Баярчимэг	Төслийн 13¹ дүгээр зүйлийн тухайд хяналт шалгалт гэхээсээ илүүтэй зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх талаар төсөлд оруулах	HACCP ISO22000 ISO22002 стандартыг мөрдөхөд зөвлөн туслах саналыг дэмжиж байна. Хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран үйл ажиллагааных нь чиглэлээр мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, зөвлөгөө, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулахаар төсөлд тусгав.	энэ хуулийн зохицуулах харилцаа биш тул ХБАБХтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн Ажлын хэсэгт шилжүүлэв.
		төслийн 13¹.2.2-т шошгоноос гадна, сав баглаа боодол нь хүнсний зориулалттай орц найрлагатай эсэхийг баталгаажуулалтанд хяналт тавихаар оруулах 2.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл - Энэ хэсгийг найруулах Хүнсний сүлжээнд ул	ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог бий болгосон байдалд хяналт тавих” гэснийг саналыг дэмжиж төсөлд тусгав	

		мөрийг мөрдөн нь зүгээр нэг бүртгэл биш мөшгих тогтолцоог бүрдүүлсэн байхыг ойлгодог. Тиймээс ул мөрийг мөрдөн тогтоох тогтолцоог бий болгосон байдалд хяналт тавих гэдэг агуулгаар оруулах нь тохиромжтой		
42	Фүүд Лепал ХХК	4. Аюулын дүн шинжилгээ буюу MNS SAC RCP 1:2024 стандарт нь бидний нэрлэдгээр НАССР-ын стандарт бөгөөд энэ нь сайн дурын шинжтэй тул төслийн 13'2.5-д үйлдвэрлэлийн шат дамжлага дахь аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгт хяналт тавихаар тусгасан байгааг эргэж харах.	ЗААВАЛ ХЯНАЛТ ТАВИХГҮЙ, ХАСАЖ БОЛНО, гэхдээ энэ НАССР ын стандартыг хүнсний үйлдвэрлэгчид үйл ажиллагаандаа нэвтрүүлбэл тухайн хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн экспортологдох магадлал маш өндөртэй байдаг. Иймд энэ стандартыг нэвтрүүлэхэд ХХААХҮЯ болон Хяналт зохицуулалтын агентлагаас мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх, нөлөөллийн ажил хийхээр тусгах болно Хяналт удирдлагын тогтолцоо сайн дурынх учраас төрөөс хянах шаардлагагүй тул 13'2.5 дахь заалтыг хасав.	
10/Хүний нөөцийн удирдлагын талаар				
43	Монголын хүнсдийн холбоо	Хоол хүнсний болон бүтээгдэхүүний нэршил импортын хүнсний ногоо дотоодод ургуулж буй хүнсний нарийн ногоог нэгдсэн нэг нэршилтэй болгохыг дэмжиж байна. Хөдөө орон нутагт бол бүр нэршилээ мэдэхгүй! Мэргэжлийн сургуулиудын багш нарыг чадавхижуулж хоол үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдал зэргийг хуучны Орос улсын соц сургалтаа эргэж харж үзэж байж өөрчлөлч гарах болов уу. Орон нутаг руу илүү чиглүүлэх хэрэгтэй. Орон нутгийн өрхийн үйлдвэрлэл (хүнсний) хуулийн заалтанд байгаа юу?	Орон нутгийн өрхийн үйлдвэрлэлийг дэмжих заалт өмнө ч байсан одоо ч хэвээр үлдсэн байгаа.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр томьёог жигдлэх хүрээнд гаалийн ВITKУC кодын нэршилээс эхлэн жигдлэх хэрэгтэй байгаа. Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч болон тэдгээрийн бүтээгдэхүүнийг бүртгэхдээ анхаасаа нэршлийг жигдлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул хуульд мэдээллийн дэд системийг ажиллуулах, ингэхдээ төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэх, шийдвэр гаргагчдыг мэдээллийн төөрөгдөл оруулахгүй

			байх, нөгөө талдаа хэрэглэгчдийг мэдээллийн нэг урсгалыг бий болгохоор хуульд тусгасан болно.		1/Яамны нэршлийн асуудлыг Засгийн газрын бүтцийн тухай хуулиар зохицуулдаг. 2/Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн нөхцөл цалин хөлстэй холбоотой харилцааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Хүнсний тухай хуулийн зохицуулалтаас хальсан асуудлыг тусгах боломжгүй.
44			Монголд 85000 тогооч байдаг хоол хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн яам гэдэг нэгдсэн нэртэй болгон тогооч нарт анхаармаар байна. 2. Тогооч мэргэжлийг хөдөлмөрийн хүнд нөхцөлд оруулж өгнө үү.		Салбарын хүний нөөцийн удирлагын асуудлыг ХХААХҮЯ хариуцна.
45	3.Эрүүл хүнс, Эрүүл хүн ТББ гүйцэтгэх захирал Б.Баярчимэг:	1.Боловсролын систем- Мэргэжлийн байгууллага болон Мэргэжилтэнд өөрчлөлт хийх 2. 3. боловсруулах болон шимтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх, түүнд хяналт тавих.	Мэргэжлийн хүн хоол_ хүнс үйлдвэрлэх асуудал хуулийн төсөлд тусгагдсан байгаа.		1/Хүнсний тухай хуулийн 10.1.5-д “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх,”-аар хуульчилсан байдаг. Төслөөр “10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж тусгасан байгаа.
46	Монголын Тогооч нарын холбоо Долгор:	MNS 4946-г мөрдөж явдаг. Хоолны салбарт мөрдөгддөг стандарт маань хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Мэргэжлийн үнэмлэх, чадамжын гэрчилгээ гэж байгаа нэгтгэж оруулж өгнө үү. Мэргэшлийн зэргийг хүчингүй болгох гэдэг нь ойлгомжгүй байгааг анхаарах.			Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хуулийн 8.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан тул энэ саналыг хүлээн авах боломжгүй.
47	Фүүд Легал ХХК	1.Салбарын 1-6-р зэрэгтэй ажилтныг бэлтгэх талаар “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль”-д тусгагдсан тул Мэргэшүүлэх			Хуулийн төсөлд дээд боловсролтой, инженер, технологичдийг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан тул хасахгүй.

		сургалт, мэргэшлийн зэрэг олгох зохицуулалтыг хасах.		
48		2.Хүнсний салбарын ажилтан, албан хаагчдад сайд зэрэг олгож байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй, төрийг хэт данхайлгах эрсдэлтэй байгааг анхаарах	Саналыг хүлээн авч, Ажлын хэсэг дүгнэлт гаргаж, түүнийг үндэслэн ТЗТБ мэргэшлийн зэрэг олгохоор тусгав.	
11/Хүнсний үйлдвэрлэлийн зураг төслийн талаар				
49	3.Эрүүл хүнс, Эрүүл хүн ТББ гүйцэтгэх захирал Б.Баярчимэг:	2.Зураг төсөлд хүнс, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зөвлөх үйлчилгээ барилга байгууламж дээр хийх, тогооч нарт зөвлөгөө өгөх талаар бодлогын бичиг баримт дээрээ тусгаж өгөөрэй. 4.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх эрх бүхий байгууллага нь ямар байгууллага байх вэ? Гэдгийг тодруулах Хоол үйлдвэрлэл гэж оруулах.	Хууль хоорондын уялдаа холбоог хангах үүднээс “10.7.Энэ хуулийн 10.1.3-т заасан ажлыг Барилгын тухай хуульд заасны дагуу дагуу хийж гүйцэтгэнэ” гэсэн заалт нэмсэн..	Хүнсний тухай хуулийн 10.1.3.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх шаардлага тавигдсан байгаа.. Барилгын тухай хуульд зааснаар Барилгын зураг төсөл боловсруулах, зураг төсөлд магадлал хийхж, барилгын ажил гүйцэтгэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд хэрэгжүүлдэг. Мөн барилгын үйл ажиллагаанд оролцогч талууд болох захиалагч, зураг төсөл зохиогч, зураг төслийн магадлал хийх эксперт, барилгын ажил гүйцэтгэгч, барилгын материал үйлдвэрлэгч, ханган
50	Доктор, профессор Оюун:	Өнөөдөр үйлдвэрлэл явуулах зураг төсөл хийдэг байгууллага байхгүй, хяналт байхгүй, тогтолцоо нь байхгүй болсон. Иймд үйлдвэр анх байгуулахаасаа эхлээд бүх стандартаа хангаж шинээр байгуулагдмаар байна. Үүнийг байгуулахаас нь өмнө шалгадаг баймаар байна.		

51	Хүнсчдийн холбоо Нармандах	-Зөв үйлдвэрийн урсгал зохион байгуулалтыг хийдэг мэргэжлийн үйлчилгээг төр үзүүлэх хэрэгтэй байна.	нийлүүлэгчийн үүргийг хуульчилсан байна. Иймд хүнсний үйлдвэрлэлийн барилгын зураг төсөл болон барилга барихтай холбогдсон харилцааг Хүнсний тухай хуулиар зохицуулах боломжгүй тул саналыг хүлээн аваагүй болно. Барилгын тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд үйлдвэрлэлийн барилгын зураг төсөл зохиож, хяналт тавьж ажилладаг тул төр оролцох шаардлагагүй
12/хууль хоорондын уялдаа холбоог хангах талаар			
52	Инно Хими Лаб ХХК 2024.04.21. №03/09	1.Төсөлд Food security гэдгийг “Хүнсний баталгаат байдал” юм Гэтэл Food safety гэдгийг “хүнсний аюулгүй байдал” гэж тусгасан байна. Үүнтэй холбоотойгоор хүнсний баталгаат байдлыг оруулсан бүх заалтууд өөрчлөгдөхөөр байна.	Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд харилцан уялдаатай хэрэгждэг учраас Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэрийг зайлшгүй өөрчилж, уг хуулийн зүйл, заалт дахь томъёоллын “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн бичвэрийг өөрчлөх шаардлага гарсан. Мөн салбарын хууль тогтоомж дахь “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал”, “тэжээлийн аюулгүй байдал” гэсэн үг хэллэг, бичвэрийг жигдлэх шаардлага үүссэн.
53	Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд аль аль нь тусгагдсантай зөрчилдсөн байна.	
54	НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар	“Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулий төсөл “хүнсний “эрүүл ахуй”, “хүнсний сүлжээ” тусгасан нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль хоорондын зөрчил, давхардлыг үүсгэхээр байна. Иймд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд холбогдох өөрчлөлтийг хийх, энэ хуулийн нэр өөрчлөгдөх үү?	Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.12 дахь хэсэгт хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулахдаа хуулийн нэрийг өөрчлөх бол энэ талаар үзэл баримтлалын төсөлд тусгана гэж заасан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг
55	Фүүд Легал ХХК	1.Төслийн “3.1.3 дахь заалтын “хүнсний эрүүл ахуй”, “3.1.11 дэх заалтын “хүнсний сүлжээ” гэдэг нь ХБАБХ хуулийн 4.1.5	

	дахь заалтын "хүнсний эрүүл ахуй", 4.1.6 дахь заалтын "хүнсний сүлжээ" гэсэнтэй давхардал зөрчил үүсгэхээр байна. Иймд ХБАБХТХуульд нэмэлт, өөрчлөлт оруулах уу?	
	2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай гэсэн хуультай. Энэ хуулийн нэршил Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах тухай хууль гэж өөрчлөгдөхүү?	
	Гэтэл хуулийн өөрчлөлтөнд олон улсад Food safety гэдэг ойлголтонд хамаарах асуудлыг Хүнсний баталгаат байдал гэсэн агуулгаар тусгасан байна. 1. Хэрэв Food safety гэдгийг баталгаат байдал гэж орчуулан хэрэглэвэл Монгол улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартууд HACCP, ISO22000 зэрэг стандартуудын орчуулга өөрчлөгдөхүү?	
56	Хуулийн төслийн 13 ¹ .2.1-д зөвөхн стандартын хэрэгжилтэд хяналт тавихаар байгааг өөрчилж, техникийн зохицуулалт гэж нэмж, үг хэллэгийг жигдлэх. 1.Төсөлд Food security гэдгийг "Хүнсний баталгаат байдал" юм Гэтэл Food safety гэдгийг "хүнсний аюулгүй байдал" гэж тусгасан байна. Үүнтэй холбоотойгоор хүнсний баталгаат байдлыг оруулсан бүх заалтууд өөрчлөгдөхөөр байна. Иймд нэр томьёог өөрчлөх эсэхийг нягтлан үзэх	Инно Хими Лаб ХХК 2024.04.21. №03/09
57	Стандарт, эрүүл ахуйн шаардлага хангана гэдэг нь Food safety - Хүнсний аюулгүй байдал Food security - Хүнсний хангамж, хүрэлцээ талаасаа тодорхойлдог гэсэн агуулгаар манай стандартууд бичигдсэн байдаг. Энэ өөрчлөлт орсон тохиолдол манай стандартууд өөрчлөгдөхүү?, Хүнсний	Анхтуяа

дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болохоор заасан.

Иймд Хүнсний тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хангах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж хуулийн нэрийг өөрчлөх, зарим нэр томьёог эшлэл татах, зарим зүйл, заалтын "хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал" гэсэн бичвэрийг өөрчлөх. Салбарын 18 хууль дахь "хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал" гэснийг "хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдал" гэж, "хүнсний түүхий эдийн аюулгүй" гэснийг "хүнсний түүхий эдийн баталгаат байдал" гэж, "тэжээлийн аюулгүй байдлыг" гэснийг "тэжээлийн баталгаат байдлыг" гэж тус тус өөрчлөхөөр тусгав.

		бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн нэршил бас өөрчлөгдөхүү? Хүнсний сүлжээ гэдгийг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 4.1.6-д арай өөрөөр тодорхойлсон. Энэ өөрчлөлт орсон тохиолдолд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн дээрх заалт өөрчлөгдөхүү?		
58	Нармандах	Хүнсний нэр томьёог Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт хэсэгтэй нийцүүлэх		

-oOo-



УИХ-ын гишүүн

Мэндбаярын МАНДХАЙ

Боловсруулж буй

Өргөн баригдсан

Хэлэлцэх эсэх

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 4-Р САРЫН 9 ӨДӨР

УЛААНБААТАР

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуульд доор
дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт
нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.14-3.1.16 дахь заалт:

“3.1.14.”хүнсний баталгаат байдал” гэж
хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь
чанар, эрүүл ахуйн стандарт, техникийн
зохицуулалтын шаардлага хангасныг;”

гэснийг “баталгаат байдлыг” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний нөөц” гэснийг “Стратегийн хүнс” гэж, мөн зүйлийн 6.12 дахь хэсгийн дугаарыг “6.13” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалтын “түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй” гэснийг “хүнсний баталгаат байдлын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “зээл,” гэснийг хассугай.

Гарын үсэг

📁 ТӨСЛИЙН ФАЙЛУУД

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ТӨСЛИЙН ДОКУМЕНТ ФАЙЛ /DOC



(ХҮНСНИЙ_ТУХАЙ_ХУУЛЬД_НЭМЭЛТ^J_ӨӨР
ЧЛӨЛТ_ОРУУЛАХ_ТУХАЙ_2025_04_10.pdf)



d.parliament.mn





МОНГОЛЫН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО ТББ

Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 6-р хороо, 13-р хороолол, К-5 байр, А/1 тоот. TEL:77177707,88082381, 99188007
E-mail: moracoopmora@gmail.com

№ 25/05/09

2025 оны 05 сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ М.МАНДХАЙ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Монголын Жижиглэн Худалдаа Эрхлэгчдийн Холбоо /MORA/ нь 2015 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар 20.000 гаруй гишүүн, дэмжигчдийг эгнээндээ нэгтгэж худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийнхээ нийтлэг эрх ашгийг илэрхийлэн дэмжих чиглэлээр ажиллаж байна.

Тус холбоо нь Монгол улсын худалдаа, үйлчилгээний салбарын хөгжил, шинэчлэлийг дэмжин ажиллахын зэрэгцээ гишүүн дэмжигч худалдаа эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор төрөл бүрийн сургалт, семинар, хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж, гишүүдээс ирсэн худалдаа үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэлтэй холбоотой хууль тогтоомжид тусгах саналыг нэгтгэн, холбогдох Төрийн байгууллагуудад уламжлан, хамтарч ажилладаг юм.

“ Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-тэй танилцаж, бөөний болон жижиглэн худалдааны салбарт үүсэж болзошгүй хүндрэл, зохицуулалтын давхардлын талаарх дараах саналыг хүргүүлж байна.

Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт оруулах өөрчлөлтөд өгөх санал

Хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанаар хүнсний тухай хуульд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч нь үйл ажиллагаандаа зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо нэвтрүүлснээ баталгаажуулж болохоор заасан буюу заавал баталгаажуулахыг үүрэгдээгүй нь хүнсний баталгаат байдлыг хангахгүй байхад нөлөөлж байна хэмээн дурдаад 2018 оны байдлаар нэг ч аж ахуй нэгж, байгууллага баталгаажуулалт хийлгээгүй нь үүнийг нотолж байна гэжээ. Ингээд Хуулийн төслийн 3 дахь хэсэгт дурдсанаар Хүнсний тухай хуулийн 17 дугаар зүйлд “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна.” хэмээн өөрчлөлт оруулахаар төсөл бэлтгэсэн байна.

Гэвч хуулийн төслийн үзэл баримтлал болсон тоо баримт нь 7 жилийн өмнөх статистик байх бөгөөд үүнийг одоогийн бодит нөхцөл хэмээн үзэж хууль өөрчлөх нь оновчтой биш байгааг дараах үндэслэлийн улмаас эсэргүүцэж дэмжихгүй байна.

1. Худалдааны салбар дахь олон улсын стандарт, зохистой дадлын хэрэгжилт ба хувь эрх зүйн давхардлын асуудал: Монгол Улсад 2018 оноос хойш бөөний болон

жижиглэн худалдааны олон аж ахуйн нэгж шинээр бий болж, худалдааны салбар төдийгүй, хоол хүнс үйлдвэрлэлийн салбарт ч мөн үсрэнгүй хөгжил, өөрчлөлт, хувьсал гарсан.

Тухайлбал, олон улсын франчайзууд болох Си Юү, Жи Эс 25 гэх мэт ая тухтай дэлгүүрүүд Монголд үйл ажиллагаа явуулах болж, эдгээр нь хоол болон, бэлэн бүтээгдэхүүнийг дэлгүүрээрээ худалдаалж, эхэлсэн. Ингэхдээ хүнсний аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчдэд эрүүл аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх үүднээс өөрийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжийн болон стандартын бүх төрлийн зохистой дадлыг хэрэгжүүлж үүнийгээ төрийн хяналт шалгалтаар баталгаажуулахын сацуу олон улсын ISO стандартуудаар давхар баталгаажуулалт хийлгэж ирсэн. Тухайлбал, зөвхөн манай компанийн тухайд гэхэд хоол, бэлэн бүтээгдэхүүн нийлүүлдэг 13 нийлүүлэгч байгаагаас одоогийн байдлаар 11 байгууллага HACCP стандарт хэрэгжүүлж, гэрчилгээжсэн буюу зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Үүнээс гадна компанийн дэргэдэх өөрийн хоол үйлдвэрлэлийн компани нь ISO 9001 – Чанарын менежментийн тогтолцоо, ISO 2200-Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, HACCP-Аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналт, ISO 14001-Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг цогцоор нь хэрэгжүүлсэн буюу Нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлж, баталгаажилтын гэрчилгээ авч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Энэ мэтчилэн аж ахуйн нэгжүүд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, олон улсын стандартыг ханган, баталгаажилт авч ажилласан байна. Иймд хуульд үүрэгдүүлж, заагаагүй тохиолдолд аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлэхгүй байна хэмээн тооцох нь үндэслэл муутай бөгөөд зохистой дадал, хяналт удирдлагын тогтолцоог заавал үүрэг болгоогүй ч аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлж байгааг харах боломжтой байна. Нэгэнт олон улсын стандартын шаардлагыг хангаж баталгаажуулалт авсаар байхад хуульд итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажилт хийлгэнэ хэмээн заах нь оновчгүй байна. Учир нь итгэмжлэгдсэн байгууллага нь төрийн байгууллагаас олгосон эрхийн дагуу итгэмжлэгдэж баталгаажуулалт хийнэ.

Иймд өөрсдийн сайн дураар олон улсын стандартыг хэрэгжүүлсэн, зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог бий болгосон аж ахуйн нэгжүүд заавал дахин итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулалт хийлгэх шаардлага үүсэж байгаа нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэх юм.

2. Хяналт шалгалт, баталгаажуулалтын давхардал бий болох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжид хүндрэл учрах: Зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсанчлан улсын хэмжээнд зөвхөн ганц байгууллагын хяналт шалгалтаар баталгаажуулдаггүй. Үүнийг тухайн чиглэлийн үйл ажиллагааг хариуцсан яамны Улсын байцаагч нарын үзлэг шалгалтаар мөн баталгаажуулдаг. Тодруулбал, хүнсний чиглэлийн аж ахуйн нэгжүүд бизнесээ өргөжүүлэхийн тулд аливаа тусгай зөвшөөрөл авахаар хүсэхэд заавал Улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлтийг авдаг бөгөөд дүгнэлтээр тухайн аж ахуйн нэгжийг хууль, стандартын шаардлагын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй эсэхийг шалган баталгаажуулдаг. Жишээлбэл ая тухтай дэлгүүрт гэхэд согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл авахын тулд улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлтийг авах болдог. Тус дүгнэлтийг Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний чанар стандартын Улсын байцаагч, Эрүүл мэндийн яамны Эрүүл ахуй халдвар хамгааллын Улсын байцаагч нар сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, стандарт болон зохистой дадлыг шалгаж олгодог. Ингэхдээ 5 стандарт, 7 хууль тогтоомжийн хүрээнд хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлийн 6 агуулгаар, эрүүл ахуй халдвар хамгааллын 5 агуулгаар шалгаж дүгнэлт өгдөг болно.

- Барилга, байгууламж, гадаад, дотоод орчинд тавих шаардлага
- Худалдааны тоног төхөөрөмж, технологи ажиллагаа, бараа бүтээгдэхүүний шаардлага
- Ажиллагсдад тавигдах шаардлага
 - Дотоод хяналтын тогтолцоо, хүний нөөцийн шаардлага
 - Буцаан болон татан авалт, ул мөрийн бүртгэл хөтлөлтөд тавих шаардлага
 - Ая тухтай дэлгүүрт тавигдах шаардлага
 - Гадна орчинд тавигдах эрүүл ахуйн нөхцөл шаардлага
 - Барилга байгууламжид тавигдах эрүүл ахуйн нөхцөл шаардлага
 - Ажиллагсад тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага
 - Угаалга цэвэрлэгээ, хортон шавж, мэрэгчгүйтгэлд тавигдах эрүүл ахуйн шаардлага
 - Согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын баталгаажилт, тээвэрлэлтэд тавих шаардлага

Үүнээс харахад зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхийг Хүнсний тухай хуулиар үүрэг болгоогүй ч, аж ахуйн нэгжүүд өмнөх хэсэгт дурдсанчлан сайн дурын үндсэн дээр стандартын хүрээнд хэрэгжүүлж байгаагаас гадна хууль тогтоомжийн шаардлагын хүрээнд ч мөн хэрэгжүүлж байна. Гэвч үүнийг заавал “итгэмжлэгдсэн байгууллага”-аар баталгаажуулсан байхыг шаардах нь хууль хоорондын уялдаа холбоог хангахгүйгээс гадна, хяналт шалгалтын давхардлыг ихээр үүсгэхээр байгааг анхаарах нь зүйтэй.

3. Тохирлын гэрчилгээ ба хяналт шалгалтын давхардал: Стандарт хэмжил зүйн газар болон тус газраас эрх олгосон компаниуд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо аж ахуйн нэгжид байгаа эсэхийг MNS 5021 стандартын хүрээнд шалган баталгаажуулж тохирлын гэрчилгээг олгодог. Тохирлын гэрчилгээгээр “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2024” стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг шалгадаг ба бизнес эрхлэгчид өөрсдийн сайн дурын үндсэн дээр болон хуулийн шаардлагын дагуу тохирлын гэрчилгээг авдаг.

Тухайлбал, эдийн засаг, нийгмийн хөгжил, хувьсалтай уялдан аж ахуйн нэгжүүд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагаас ялгарах, хэрэглэгчийн итгэлийг хүлээхийн тулд өөрсдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн болон үзүүлж буй үйлчилгээндээ хууль, стандартын шаардлага хангасан, зохистой дадлыг нэвтрүүлсэн болохоо баталгаажуулахыг зорьж эхэлсэн. Ингээд аж ахуйн нэгжүүд сайн дураараа өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээнд “тохирлын гэрчилгээ”-г авах болсноос гадна худалдааны салбарын аж ахуйн нэгжүүд шөнийн цагаар бизнес эрхлэх боломж нээгдэж, 24 цагаар үйл ажиллагаа явуулах хүсэлтэй аж ахуйн нэгжүүд хуулийн шаардлагын дагуу тохирлын гэрчилгээг заавал авах болсон. Сүлжээ дэлгүүр бүрд Тохирлын гэрчилгээ авдаг бөгөөд тохирлын гэрчилгээ авах хяналт шалгалтын цар хүрээ нь өмнөх хэсэгт дурдсан Ажлын байрны дүгнэлтийн хяналт шалгалттай агуулгын хувьд ижил байдаг.

Мөн Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт”-ыг баталсан бөгөөд үүнд хүнсний дэлгүүр, хүнсний бөөний худалдаа чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд заавал Тохирлын гэрчилгээ авахаар заасан.

агуулгын хувьд давхацдаг болохыг дахин дурдъя. Ийнхүү зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоотой эсэхийг хууль тогтоомж, стандартын шаардлагын хүрээнд олон байгууллагаас хяналт, шалгалт давхардуулан хийж байгаа нь нэг талаараа төрийн байгууллагын ачааллыг ихэсгэж давхардсан хяналт, шалгалтыг бий болгож Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасан “хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх” хэмээн заасан зарчмыг зөрчиж байгаа болно.

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогоос хамааран олон төрлийн хууль тогтоомжийн шаардлага байдаг тул Хүнсний тухай хуульд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог заавал “итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулна” хэмээн заах нь хяналт шалгалтын давхардлыг ихээр бий болгож байна.

Одоогийн эрх зүйн зохицуулалт, төрийн хяналт шалгалт, олон улсын болон үндэсний стандартын шаардлагын хүрээнд аж ахуйн нэгжүүд зохистой дадлыг сайн дураараа болон үйл ажиллагааныхаа онцлогоос хамаарч заавал хэрэгжүүлж, баталгаажуулалтад хамрагдаж байна. Зөвхөн хүнсний дэлгүүр, худалдааны чиглэлээр хавсарсан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид гэхэд хуулийн шаардлагын дагуу зохистой дадлыг 3-н өөр байгууллагаас шалгалт хийж, баталгаажуулдаг. Мөн бизнес эрхлэгчид өөрсдийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн итгэлийг хүлээсэн эрүүл, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд сайн дураар стандарт хэрэгжүүлдгийг анхаарах нь зүйтэй. Хүнсний тухай хуульд зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог заавал итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулахыг үүрэг болгож заах нь хавсарсан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтын давхардлыг нэмэгдүүлж, ихээхэн хүндрэл учруулахаар байгааг анхаарч хууль хоорондын уялдаа холбоог хангах, хавсарсан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хувьд заавал итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулуулахгүйгээр одоогийн хууль тогтоомжийн хяналт шалгалтын хүрээнд баталгаажуулалт хийлгэхээр зохицуулах, эсхүл одоогийн давхардсан хяналт шалгалтыг болиулж, Хүнсний тухай хуулийн дагуу итгэмжлэгдсэн байгууллагаар баталгаажуулалт хийлгэдэг байх шаардлагатай байна. Өмнө дурдсанчлан төрийн байгууллага өөрсдийн хяналт шалгалтын үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрдөггүй, давхардсан хяналт шалгалт хийдгээс үүдэн аж ахуйн нэгжүүд их хэмжээний цаг хугацаа, эдийн засгийн хохирол амссаар байгаагаас гадна төрийн байгууллагын үр ашиггүй зардлыг нэмэгдүүлж, ачааллыг ихэсгэсээр байна. Иймд Хүнсний тухай хуулийн дээрх өөрчлөлтийг оруулахаасаа өмнө бодит нөхцөл байдал, давхардлыг харгалзан үзэж, хавсарсан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд учрах хүндрэл, төрийн байгууллагын хяналт шалгалтын давхардал зэргийг олон хууль тогтоомж, хяналт шалгалтын байгууллагын шалгах хуудас, стандартын хүрээнд судлан үзэж, хяналт шалгалтыг давхардуулахгүйгээр ялган зохицуулах нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 17.1-т “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч энэ хуулийн 10.1.4, 10.2-т заасан зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна.” хэмээсэн байна. Энэ хэсэгт дурдсан “баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулна” гэсэн нь “certification body” буюу зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо нэвтэрсэн эсэхийг төрийн байгууллагаас олгосон эрхийн дагуу шалгаж, гэрчилгээжүүлж буй байгууллагыг хэлнэ хэмээн ойлгож байна. Учир нь зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоо нэвтэрсэн эсэх баталгаажуулалтыг дан ганц төрийн байгууллага бие даан хийхэд нөөц хүрэлцэхгүй

“баталгаажуулалтын байгууллага” биш “гэрчилгээжүүлэгч байгууллага” байх бөгөөд тухайн хувийн байгууллагад эрх олгосон байгууллага нь “accreditation body” буюу баталгаажуулалтын байгууллага болно. Олон улсын түвшинд болон стандартуудын хүрээнд баталгаажуулалт хийх/баталгаажуулалт хийх эрх олгох болон гэрчилгээ олгох байгууллагыг ялгаатай нэршиж заншсан тул хуулийн өөрчлөлтийг оруулахдаа орчуулгыг оновчтой хийж ялгаатай байдлаар хуульчлах нь зүйтэй болов уу.

Хуулийн төслийн 3.1.11 дэх хэсэгт өгөх санал: “Буцаан татах” нэр томъёоны тухай

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар “хүнсний сүлжээ”-г тодорхойлсон байдаг. Гэвч энэ удаагийн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд “хүнсний сүлжээ” гэдгийг өөрчлөн тодорхойлж Хүнсний тухай хуульд оруулахаар тусгажээ. Энэ тодорхойлолт өөрчлөгдөж, Хүнсний тухай хуульд тусгагдсанаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн “хүнсний сүлжээ”-г тодорхойлсон хэсэг хүчингүй болно хэмээн ойлгож байна. Ингээд уг тодорхойлолтод дараах саналтай байна.

Хуулийн төсөлд “хүнсний сүлжээ” гэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, хүнсийг тусламжаар авах, өгөх, чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсийг буцаан татах, устгах үйл ажиллагааг хэлэхээр заажээ. Уг тодорхойлолтын “дахин боловсруулах”, “буцаан татах” гэх нэр томъёонд дараах саналыг хүргүүлж байна.

1. Дахин боловсруулах – Засгийн газрын 2013 оны 172 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журам”-д зааснаар “татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь ямар нэгэн аюултай үр дагавар үүсэхгүй нь батлагдсан тохиолдолд шинж чанар, зориулалтыг өөрчлөн, мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар дахин боловсруулалт хийж хоёрдогч түүхий эд байдлаар хэрэглэж болно.” хэмээн дахин боловсруулалтын тухай заасан байдаг. Хуулийн төсөлд бичигдсэн тодорхойлолтоор “дахин боловсруулах” гэсэн үг нь “бүтээгдэхүүн үйлдвэрлэх” гэсэн үгний араас залгаж орсон байгаа нь үйлдвэрлэсний дараа угсран шууд хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн /жишээ нь сандвич, хотдог/ бэлтгэхийг хэлж буй мэт утга санааг агуулж болохоор байна. Дахин боловсруулах гэх нэр томъёог тодорхойлолтын төгсгөл хэсэгт буюу “буцаан татах” гэсэн үгний араас оруулах нь үйлдвэрлэлийн процесс, дарааллын хувьд зөв байна.

2. Буцаан татах – Хуулийн төсөлд тодорхойлсон хүнсний сүлжээний тодорхойлолтод “буцаан татах” гэсэн нэр томъёо орсон байна. Гэвч Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд “буцаан авах”, “татан авах” гэх хоёр ойлголтыг хуульчилсан байдаг. Ингэхдээ “буцаан авах” гэж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч өөрийн санаачилгаар бүтээгдэхүүнээ буцаан авахыг, “татан авах” гэж хяналтын байгууллагын шийдвэрээр хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хүнсний сүлжээнээс татан авахыг хэлэхээр хуульчилсан байдаг. Үүнээс гадна олон улсын стандартууд болох ISO 22000, 9001-ийн хүрээнд “withdrawal” болон “recall” гэсэн нэр томъёог одоогийн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасантай агуулга нэгээр тайлбарлаж хэрэглэдэг болно. Тодруулбал, “withdrawal” нь байгууллага өөрийн санаачилгаар тухайн бүтээгдэхүүн хэрэглэгчийн гарт очихоос өмнө буцаан татах тухай агуулгыг хэлдэг бол “recall” нь эрх бүхий байгууллагын хяналт шалгалтаас үүдэн хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй бүтээгдэхүүнийг татан авахыг ойлгодог.





"ИННО ХИМИ ЛАБ" ХХК

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р
хороо, Бага тойруу, Б.Алтангэрэлийн гудамж,
Сити центр, 12 давхар, 1202 тоот
Утас: 7705 1414
И-хаяг: info@innocchem.mn

УИХ-ЫН ГИШҮҮН М.МАНДХАЙ

ТАНАА

2025.04.21 № 03/29

танай _____ -ны № _____ -т

Хуулийн төсөлд санал өгөх тухай

Инно Хими Лаб ХХК нь лабораторийн өндөр хүчин чадалтай багаж, тоног төхөөрөмж, урвалж бодис болон бусад хэрэгслүүдийг Монголын зах зээлд ханган нийлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулсан 16 жилийн туршлагатай байгууллага юм. Бид лабораторийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулахад өөрсдийн хувь нэмрийг оруулах үүднээс сургалтын төв байдлаар компанийнхаа харьяа "Инно Лаборатори" төслийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хүнсний шинжилгээний чиглэлд сул буюу хийгддэггүй химийн төрлийг сонгон пестицидийн үлдэгдэл, органик бохирдуулагч болон хүнсний витаминуудын шинжилгээг хийж чадахуйц хүчин чадалтайгаар, шаардлагатай итгэмжлэлийг авч ажиллаж байна.

Бид энэхүү төслийг нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй чухал санаачилга гэж үздэг. Учир нь төрийн өмчит лабораториуд өндөр хүчин чадалтай багаж, тоног төхөөрөмжийг тогтвортой ажиллуулах, урсгал зардлыг даах, мэргэжлийн баг бүрдүүлэхэд хүндрэлтэй тулгарч байгаа өнөөгийн нөхцөлд, бид өөрсдийн боломжоор шийдлийг санал болгож, олон улсын стандартуудыг лабораторидоо нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын лабораторийн төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш бид хүнсний аюулгүй байдлын тогтолцоог олон улсын түвшинд судалж, түүний дотор амжилттай хэрэгжүүлж чадсан улс орнуудын туршлагатай танилцан, өөрийн орны асуудлуудтай харьцуулан, тухайн мэдээллүүдээ нээлттэйгээр салбарын мэргэжилтнүүдтэйгээ хуваалцаж ирсэн. Энэ судалгаанаас үндэслэн, Монгол Улсад хэрэгжиж чадаагүй хоёр чухал жишээг онцлон дурдмаар байна. Үүнд:

1. Хүнсний аюулгүй байдлын шинжилгээний үзүүлэлтүүд олон төрөлтэй, үүнийгээ дагалдан шинжлэх аргачлал нарийн төвөгтэй болсон өнөө үед лабораториудад өндөр үнэтэй тоног төхөөрөмж, урсгал зардлыг даах шаардлага үүсэж байна. Олон улс энэ асуудлыг зөвхөн төрийн өмчит бус, хувийн хэвшлийг оролцуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, итгэмжлэгдсэн лабораториудын хүчин чадлыг бүрэн ашиглаж иржээ.

000011

Хэрвээ 13¹.1-д заасан төрийн захиргааны байгууллагын дэргэд хяналтын лаборатори ажиллана гэсэн заалт энэ байдлаар орсон тохиолдолд яг л өмнөх жилүүдэд тохиолдож байсан, 2021 онд Үндэсний аудитын газрын Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд (https://audit.mn/wp-content/uploads/2022/01/%D0%A5%D0%90%D0%91_last.pdf) дурдсан амжилтгүй ажилласан түүх давтагдан оршсоор байх өндөр эрсдэлтэй гэж үзэж байна.

Манай компанийн хэрэгжүүлж буй Инно лаборатори төсөл нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглан шинжилгээний орчин үеийн, нарийвчилсан үзүүлэлтүүдийг Монгол Улсад нэвтрүүлж буй жишиг болсон бөгөөд энэ нь Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, экспортын чадамжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулж байна. Бид лабораторийн шинжилгээний үр дүнгээс танилцуулах бүрэн боломжтой.

Хүнсний шинжилгээний салбарт шинэлэг, үр дүнтэй шийдвэр гарч, энэ салбар нэг алхам урагшлах боломж бүрдэх болно гэдэгт итгэж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М. ЭНХМАНДАХ

M. Enkhmandakh
enkhmandakh@innocchem.mn

88881643



МОНГОЛЫН ХҮНСЧДИЙН НЭГДСЭН ХОЛБОО MONGOLIAN FOOD INDUSTRY UNION

Огноо: 2025-05-09
Дугаар: 029

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Энхтайваны өргөн чөлөө-50
Азмон төвийн байр, 305 тоот
Утас: 7016-0086 ш/х-16
Улаанбаатар- 15160-0026
e-mail: mfood.ngo@gmail.com

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН М.МАНДХАЙ ТАНАА

Судалгааны дүнг танилцуулах тухай

Манай улс Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-той худалдааны түр хэлэлцээр байгуулахаар ажиллаж байгаа хэдий ч холбогдох бүх талаас санал аваагүй, тооцоо, судалгаа үндэслэл муутай, саналын зөрүүтэй байгаан улмаас манай улсад эдийн засгийн үр ашиггүй хэлэлцээрийг яарч сандран байгуулах гэж байна.

Ийм учраас манай холбооноос захиалан “Монгол улс, Евроазийн Эдийн Засгийн Холбоотой худалдааны түр хэлэлцээр хийснээр гарах эдийн засгийн үр нөлөөний үнэлгээ”-ний судалгааг МУИС-ийн Бодлогын судалгааны лабораториор хийлгэн үр дүнг ЭЗХЯ, ХХААХХҮЯ, УИХ-ын зарим гишүүдэд хүргүүлсэн билээ. ЭЗХЯамнаас энэхүү судалгааг хэлэлцээрийн эцэслэн тохироогүй хувилбарт үндэслэн хийлгэсэн байна гэж үзсэний дагуу хэлэлцээрийн сүүлийн хувилбараар “Монгол улс, Евроазийн Эдийн Засгийн Холбоотой худалдааны түр хэлэлцээр хийснээр гарах эдийн засгийн үр нөлөөний үнэлгээ”-ний судалгааг дахин хийлгэсэн бөгөөд судалгааны үр дүнгийн хураангуйг хүргүүлж байна.

Иймд МУИС-ийн Бодлогын судалгааны лабораторийн гүйцэтгэсэн энэхүү судалгааны үр дүнг анхааран үзэж, ЕАЭЗХ-той худалдааны түр хэлэлцээр байгуулахыг хойшлуулан зогсоож, энэхүү хэлэлцээрт нухацтай хандах, мөн Монголын Хүнсчдийн Нэгдсэн Холбооны төлөөлөлтэй уулзалт хийж дэмжин ажиллахыг хүсье.

Судалгааны хураангуйг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




М.НАРМАНДАХ

МОНГОЛ УЛС ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО (ЕАЭЗХ)-ТОЙ ХУДАЛДААНЫ ТҮР ГЭРЭЭГ ЗУРСНААР ГАРАХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ШИНЖИЛГЭЭ

Шинэчилсэн судалгааны үр дүн

ЕАЭЗХ-той хийсэн гурав дахь шатны хэлэлцээрийн дагуу Монгол Улс ЕАЭЗХ-ны орнуудаас импортолж буй 367 нэр төрлийн барааны нийт импорт дахь эзлэх хувийн өөрчлөлтийг 2015–2024 оны хооронд шинжилж үзэхэд импортын барааны эзлэх хувь 2015 онд 23.8% байсан бол 2016 онд 22.6% болж буурсан байна. Харин 2017 оноос эхлэн уг үзүүлэлт өсөх хандлагатай болж, 2018 онд 26.8%-д хүрсэн нь судлагдаж буй хугацааны анхны оргил цэг болсон байна. Энэхүү өсөлт нь тухайн хугацаанд ОХУ болон Казахстан зэрэг ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас Монгол Улсад нийлүүлэгдэж буй түлш, шатахуун, барилгын материал зэрэг стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм.

Зураг 1. ЕАЭЗХ-ны орнуудаас Монгол Улс руу импортолж буй 367 барааны нийт импортод эзлэх хувь (2015–2023 он)



Эх сурвалж: WTO/UNCTAD ITC Trademap 2023-д тулгуурласан судлаачийн тооцоолол

2019–2022 оны хооронд импортын хувь дунджаар 25–26 хувийн хооронд хэлбэлзэж, харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдсан ч 2022 онд 28 хувьд хамгийн оргил үедээ хүрсэн байна. Энэ нь дэлхийн геополитикийн нөхцөл байдал, тэр дундаа ОХУ-ын эсрэг тавигдсан олон улсын хориг арга хэмжээ, тээвэр логиستيкийн өөрчлөлт, бараа бүтээгдэхүүний хомсдол зэрэг хүчин зүйлсийн улмаас Монгол Улс ЕАЭЗХ-ны орнуудаас илүү их бараа импортлох шаардлагатай болсон байж болзошгүйг харуулж байна.


Харин 2023 оноос эхлэн ЕАЭЗХ-ны импортын хамаарал эрс буурсан хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, 2023 онд 24.3%, 2024 онд 22.6% болж, 2022 оныхтой харьцуулахад нийтдээ 5.4 нэгж хувиар буурсан нь сүүлийн арван жилд хамгийн огцом уналт болсон үзүүлэлт юм. Геополитикийн нөхцөл байдал, ялангуяа ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээнүүдийн улмаас тээвэр логиستيкийн хүндрэл, гүйлгээ хийхэд тулгарч буй санхүүгийн саад бэрхшээлүүд ЕАЭЗХ-ны орнуудын экспортын урсгалыг бууруулахад нөлөөлсөн байж болно.

ЕАЭЗХ-ны орнуудаас импортолж буй 367 нэр төрлийн барааны гишүүн орнуудтай хийж буй нийт импортод эзлэх хувь 2015–2024 оны хооронд хэрхэн өөрчлөгдөж буйг шинжилсэн бөгөөд импортын бүтцэд ЕАЭЗХ-ны орнууд тогтвортой өндөр хувь эзэлж ирсэн бөгөөд 2015 онд 84.4% байсан бол 2017 оноос хойш тогтмол 88–90 хувийн түвшинд хадгалагдаж байна. Тухайлбал, 2017 онд 88.2%, 2018 онд 89.3%, 2020 онд 90.1%, 2022 онд 90.8%, 2024 онд 90.5% байгаа нь

Манай орон ЕАЭЗХ-ны таван гишүүн орноос 2015–2024 оны хооронд импортолж буй 367 нэр төрлийн барааны нийлүүлэлтийн улсын хуваарийг жил бүрийн хувиар харуулсан байна. Энэхүү график нь ЕАЭЗХ-ны дотоод бүтэц дэх Монгол Улсын худалдааны хамаарлын төвлөрлийг илүү гүнзгий тодотгож байгаа бөгөөд дараах үндсэн чиг хандлагууд илэрч байна.

Монгол Улсын ЕАЭЗХ-ны орнуудтай хийх импортын дийлэнх хэсгийг ОХУ бүрдүүлж ирсэн нь шинжилгээнээс харагдаж байна. Тухайлбал, 2015 онд 95.3% байсан ОХУ-ын эзлэх хувь 2024 онд 97.5%-д хүрч, бүх хугацаанд хамгийн өндөр байр сууриа хадгалсан хэвээр байна. Хамгийн өндөр хувийг 2022 онд (97.3%) болон 2024 онд (97.5%) эзэлсэн нь сүүлийн жилүүдэд тус оронтой хийж буй импорт улам бүр төвлөрч, өөр гишүүн орнуудаас хамаарах хамаарал харьцангуй буурсан байгааг илтгэнэ. Энэ хамаарал нь түлш, шатахуун, эрчим хүч, машин тоног төхөөрөмж зэрэг Монгол Улсад стратегийн ач холбогдолтой бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт ОХУ-аас шууд хамаарч байна (Зураг 7).

Зураг 3. Монгол Улс руу ЕАЭЗХ-аас импортолж буй 367 бараа /улсуудын эзлэх хувиар/ (2015-2023 он)



Эх сурвалж: WTO/UNCTAD ITC Trademap 2023-д тулгуурласан судлаачийн тооцоолол

Казакстан улсын хувьд 2015 онд 2.9%, 2016 онд 3.5%-тай байсан бол 2020 оноос хойш 1–2% орчим болж буурсан үзүүлэлттэй байна. 2024 онд 1.7% байсан нь Казахстанас Монголд нийлүүлэгдэж буй барааны эзлэх хувь дунд болон богино хугацаанд буурч, ОХУ-ын худалдааны давамгайл байдал их байгааг харуулж байна.

Беларусь улсын эзлэх хувьд 2020 онд 3.8% хүртэл өссөн нь тус онд Беларусийн гаралтай зарим бараа Монголын зах зээлд илүүтэйгээр орж ирсэнтэй холбоотой байж болох юм. Гэсэн хэдий ч дараа дараагийн жилүүдэд энэ үзүүлэлт тогтмол буурч, 2024 онд ердөө 0.8 хувь болсон байна. Түүнчлэн, Киргизстан болон Армени улсын хувьд нийт импортод эзлэх хувь маш бага, тогтмол 1 хувиас доош түвшинд хэлбэлзэж байгаа нь эдгээр орнуудын экспортын чадавхи, Монгол руу чиглэсэн барааны урсгалын цар хүрээ хязгаарлагдмал байгааг илтгэж байна.


Шинжилгээнээс үр дүнгээс үзэхэд Монгол Улс ЕАЭЗХ-ны хүрээнд гишүүн орнуудын дотроос ОХУ-д бараг бүрэн хамааралтай байгааг харуулж байна. Энэ төвлөрөл нь гадаад худалдааны эрсдэлийг нэмэгдүүлдэг бөгөөд геополитикийн болон зах зээлийн савлагаа нь Монгол Улсын дотоод зах зээлд шууд нөлөөлөх суурь нөхцөл болж байна. Тиймээс ЕАЭЗХ-ны доторх түншлэлийг төрөлжүүлэх, Казакстанд түшиглэсэн логистикийн гарц, Беларуситай хийх

Гэсэн хэдий ч эдгээр боломжийг бүрэн ашиглахын тулд Монгол Улс экспортын бүтэц, төрөлжилтөө сайжруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг дагалдуулан хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнд, аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний салбарын экспортыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх, бизнесийн орчинг сайжруулж, хөрөнгө оруулалтыг татах стратегиуд хамаарна.

Дараагийн хэсэгт, Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн орнууд, дэлхийн бусад орнуудын импортын бүтцийг эдийн засгийн салбаруудаар нь бүтцийн шинжилгээг хийж үзэв. Монгол Улсын импортын бүтцээс харвал нийт импортоос хамгийн өндөр хувийг олборлох үйлдвэрлэл (26.58%), барилгын салбар (15.84%), нийтийн үйлчилгээ (7.66%), эрчим хүч, ус, дулаан (7.43%), болон тээвэр, харилцаа холбоо (9.92%) эзэлж байгаа нь дотоодын эдийн засгийн бүтцэд гадаад хамаарал өндөр байгааг харуулж байна. Монгол Улс нэмүү өртөг багатай түүхий эд болон дэд бүтцийн материал, үйлчилгээний хамаарал ихтэй, өөрөөр хэлбэл дотоод үйлдвэрлэл дутмаг, импортоос хараат эдийн засагтайг илтгэж байна. Ялангуяа барилгын салбарын импортын хэмжээ 15.84 хувьтай байгаа нь ЕАЭЗХ-ны дундаж (8.92%) болон бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь Монголын дотоодын барилгын материалын үйлдвэрлэл сул, хамааралтай байгааг тодорхой харуулж байна (*Зураг 5*).

Импортын бүтцийн хувьд ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын дийлэнх нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд илүү өндөр хамааралтай байгааг харж болно. Тухайлбал, Беларусь, Кыргызстан, Армени зэрэг орнуудад аж үйлдвэрийн импортын эзлэх хувь 30-60 хувийн хооронд хэлбэлзэж байгаа бол ЕАЭЗХ-ны дундаж нь 30.12 хувьтай байна. Монголын хувьд аж үйлдвэрийн импортын хувь 9.66 хувьтай байгаа нь үндэсний үйлдвэрлэл сул хөгжсөн, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, дэд бүтэц, бэлэн бүтээгдэхүүнд гадаад хамааралтай гэдгийг илэрхийлж байна.

Зураг 5. Монгол Улс болон ЕАЭЗХ-ны гишүүн орнууд, дэлхийн бусад орнуудын импортын бүтцэд салбаруудын эзлэх хувийн жин



Эх сурвалж: GTAP11-ын дата баазын өгөгдөлд суурилсан судалгааны багийн тооцоолол

Цаашлаад Монгол Улсын эрчим хүчний импорт ч 7.43 хувийг эзэлж байгаа нь ОХУ болон ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас эрчим хүч импортлох хамаарлыг илэрхийлж, энергийн аюулгүй байдал болон хэлэлцээрийн үед стратегийн эмзэг байдал үүсгэх эрсдэлийг харуулж байна. Жишээлбэл, Беларусь болон Кыргызстан зэрэг оронд эрчим хүчний импорт өндөр хувьтай байгаа нь үйлдвэрлэлийн эрчим хүчний хангамжид чухал нөлөө үзүүлж болохоор байна.

Экспорт, импортын нийт хэмжээний өөрчлөлт нь хоёр хувилбарт ижил төстэй чиг хандлагатай байна. Экспорт 3.92%-иас 3.86% хүртэл бага зэрэг буурч, импорт 4.56%-иас 4.52% болж байгаа нь шинэчилсэн хувилбарын үед гадаад худалдааны тэнцэлд үзүүлэх сөрөг нөлөө бага зэрэг саармагжиж байгааг харуулж байна. Гэвч нийт импорт экспортын өсөлтөөс илүү өндөр хурдаар нэмэгдэх нь худалдааны алдагдлыг гүнзгийрүүлэх эрсдэлтэй хэвээр байна. Ялангуяа үйлдвэрлэлийн импортын хамааралтай салбаруудад дарамт нэмэгдэх магадлалтай.

Үнийн түвшний хувьд, үйлдвэрлэгчийн үнэ, дотоодын барааны үнэ, экспортын болон импортын үнэ бүх салбарын түвшинд буурах хандлагатай байгаа нь өрсөлдөөн нэмэгдэж буйг илтгэж байна. Жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2.25% буурч, аж үйлдвэрийн салбарын үнэ 1.77%-иар буурах хандлагатай байна. Энэ нь хэрэглэгчдэд ашигтай боловч дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд ашигт ажиллагаа, хөрөнгө оруулалт, өрсөлдөх чадвар буурах сөрөг нөлөөтэй байна.

Нийт үйлдвэрлэлийн түвшинд бууралт ажиглагдаж байгаа бөгөөд эхний хувилбарын тохиолдолд нийт үйлдвэрлэл 0.66%, шинэчилсэн хувилбарын тохиолдолд 0.57%-иар тус тус буурахаар байна. Үүнийг салбар тус бүрээр авч үзвэл, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, үйлчилгээний салбаруудад үйлдвэрлэл буурах бөгөөд, жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарт 0.99%, аж үйлдвэрийн салбарт 1.10%, үйлчилгээний салбарт 0.66%–0.67% бууралт гарч байгаа нь эдийн засгийн тулгуур салбаруудын өсөлтөд шууд саад учруулж буйг харуулж байна.

Цаашлаад, дотоод хэрэглээ болон завсрын хэрэглээний түвшинд мөн төстэй сөрөг өөрчлөлт гарч байна. Дотоодын хэрэглээ эхний хувилбараар 1.73%, шинэчилсэн хувилбараар 1.72% буурах хандлагатай байгаа бөгөөд энэ нь өрхийн бодит орлогын бууралтаас үүдэлтэй. Түүнчлэн, үйлдвэрлэлийн хүчин зүйлс болох капитал ба хөдөлмөрийн зардал бүх салбарт буурах хандлагатай байна. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын капиталын зардал 1.09%, хөдөлмөрийн зардал 1.17%-иар буурч байгаа нь дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хумигдаж байгааг харуулж байна.

Эдийн засгийн дотоод бүтэцтэй холбоотойгоор экспорт, импортын бүтэц, тэдгээрийн үнийн түвшинд тодорхой нөлөөлөл ажиглагдсан. Экспортын үнэ бүх салбарт буурах хандлагатай байгаагийн зэрэгцээ импортын үнэ ч мөн буурч байгаа нь Монгол Улсын худалдааны нөхцөл (terms of trade)-д хоёрдмол нөлөө үзүүлж байна. Гэхдээ экспортын үнийн уналт илүү гүнзгий байгаа нь экспортлогч аж ахуйн нэгжүүдийн орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Үүний зэрэгцээ нийт цэвэр орлого (өрхийн болон аж ахуйн нэгжийн) 1.73%–1.81%-иар буурахаар тооцоологдож байгаа нь бодит хэрэглээний бууралтад нөлөөлж байна.

Төсвийн орлого ч мөн эдгээр өөрчлөлтөөс сөргөөр нөлөөлөгдөж, эхний хувилбараар 0.94%, шинэчилсэн хувилбараар 0.90%-иар тус тус буурах тооцоолол гарчээ. Энэ нь гаалийн орлогын бууралтаас шалтгаалах бөгөөд үүнийг нөхөхийн тулд дотоод татварын ачаалал нэмэгдэх, зарим салбаруудад татварын бүтэц шинэчлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Бодлогын хувьд, ЧХХ хэрэгжсэн тохиолдолд дотоодын салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, татварын алдагдлыг зохицуулах, ялангуяа өрхийн орлого буурахтай холбоотой нийгмийн хамгааллын арга хэмжээг багтаасан цогц бодлогын хариу арга хэмжээ шаардлагатай байна. Шинэчилсэн хувилбар нь зарим сөрөг нөлөөг зөөлрүүлж буй ч, нийт эдийн засгийн тэнцвэрт байдал, орлогын түвшинд дорвитой доройтол бий болж байгааг судалгааны тооцоолол илтгэж байгаа тул, зөвхөн тарифыг тэглэх замаар үр өгөөж хүртэх боломж хязгаарлагдмал байна.

Иймээс ЧХХ-ний хүрээнд Монгол Улс экспортын төрөлжилтийг дэмжих, инновац, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын тэгш бус нөлөөллийг тэнцвэржүүлэх, татварын орлогын алдагдлыг нөхөх үр дүнтэй механизм хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энэ нь урт хугацаанд тогтвортой өсөлтөд хүрэх бодлогын үндэс болох юм.